Sendly

# НЭЭЛТТЭЙ

# БОНД

2022

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР:

ULZII & Co CAPITAL

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР:

Golomt Capital
Delivering diversity

RHINOS Investment

СЗХ
2023.01.13
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# АГУУЛГА


АГУУЛГА ..... 1
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ..... 6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ..... 6
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ..... 7
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ..... 8
ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 9
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ ..... 10
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 15
1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 15
1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 16
1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХАЯГ ..... 19
1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ ..... 20
1.1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ..... 21
1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ..... 22
1.2.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ ..... 22
1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОЛГОЙ КОМПАНИ ..... 23
1.2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭРГЭЛДЭЭ КОМПАНИУД ..... 24
1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 30
1.3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ..... 30
1.3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД ..... 30
1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 35
1.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ..... 35
1.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА ..... 48
1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ ..... 51
1.5.1 2022.10 САРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ ..... 51
1.5.2 СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ..... 51
1.5.3 АШИГТ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ ..... 54
1.5.4 ЗЭЭЛИЙН АКТИВЫН ЧАНАР БА ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ ..... 56
1.5.5 ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ БА САНХҮҮГИЙН ХӨШҮҮРЭГ ..... 57
1.5.6 МӨНГӨН УРСГАЛ БА ХӨРВӨХ ЧАДВАР ..... 59
1.5.7 САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ..... 60
1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ..... 62
1.7 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ..... 63
1.8 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО ..... 67
ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 69


СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ 02

2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ ..... 70
2.1.1 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ ..... 70
2.1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, НӨХЦӨЛ БАЙДАЛ ..... 71
2.1.3 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ..... 79
2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА ..... 81
2.2.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 81
2.2.2 МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 88
2.2.3 ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 97
2.2.4 НИЙТ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ ..... 108
2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА ..... 110
2.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨРСӨЛДӨГЧИД ..... 110
2.3.2 МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨРСӨЛДӨГЧИД ..... 112
2.3.3 SWOT ШИНЖИЛГЭЭ ..... 116
2.4 САНХҮҮГИЙН ТААМАГЛАЛ ..... 118
2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 124
ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ..... 130
3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ..... 130
3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 131
3.1.1 БОНДЫН НЭРЛЭСЭН ҮНЭ, ХУГАЦАА НӨХЦӨЛ ..... 131
3.2 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ ..... 132
3.3 БОНДЫН БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТ ..... 133
3.4 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ..... 135
3.5 ӨРИЙН БИЧГЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ ..... 135
3.6 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ ..... 137
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД ..... 140
4.1 ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 141
4.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 143
4.3 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ ..... 146
4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ ..... 147
ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ ..... 149
АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ ..... 149
АУДИТЫН ДҮГНЭЛТ ..... 159
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, НЭМЭЛТ ТОДРУУЛГА ..... 230
ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ..... 281
ХАВСРАЛТ-1 Бондын гэрээ ..... 347
ХАВСРАЛТ-2 Барьцаа, батлан даалт гаргагчийн тогтоол, гэрээ ..... 353
ХАВСРАЛТ-3 Улсын бүртгэлийн гэрчилгээ ..... 362

ХАВСРАЛТ-4 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ........ 364
ХАВСРАЛТ-5 "Монголын финтек групп" хаалттай ХК-ийн санхүүгийн тайлан.... 370
ХАВСРАЛТ-6 Батлах хуудас........ 408

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл........ 21
Хүснэгт 2: Хувьцаа эзэмшигчид........ 22
Хүснэгт 3 Зээлийн багц........ 35
Хүснэгт 4: Мерчант зээл........ 36
Хүснэгт 5: Зээлийн бүтээгдэхүүний хүртээмж........ 37
Хүснэгт 6: Зээлийн эрх ба багцад эзлэх хувь........ 37
Хүснэгт 7: 2022.10.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц, бүтээгдэхүүний төрлөөр, сая төгрөг........ 45
Хүснэгт 8: Санхүү байдлын тайлан........ 51
Хүснэгт 9: Орлого үр, дүнгийн тайлан........ 52
Хүснэгт 10: Мөнгөн гүйлгээний тайлан........ 53
Хүснэгт 11: Өр төлбөрийн харьцаа үзүүлэлт........ 58
Хүснэгт 12: Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд........ 60
Хүснэгт 13: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт........ 64
Хүснэгт 14: Монгол Улсын зээлжих зэрэглэл........ 70
Хүснэгт 15: Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд........ 71
Хүснэгт 16: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл........ 73
Хүснэгт 17: Уул уурхайн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүний экспорт........ 74
Хүснэгт 18: Инфляцыг өдөөж болзошгүй эрсдэлүүд........ 75
Хүснэгт 19: Уламжлалт ба финтек ББСБ........ 82
Хүснэгт 20: ББСБ-ын тоо, хөрөнгийн хэмжээ........ 83
Хүснэгт 21: ББСБ-ын салбарын харилцагчдын хүн ам зүйн шинж байдал........ 85
Хүснэгт 22: ББСБ ба банкны салбарын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт........ 86
Хүснэгт 23: Аппликейшнээр зээл олгож буй компаниуд........ 87
Хүснэгт 24: Гадаадад оршин суугаа Монгол иргэд, хүйсээр........ 95
Хүснэгт 25: Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж........ 96
Хүснэгт 26: Банк болон ББСБ-ын худалдааны салбарт олгосон зээл, (2021 он)........ 97
Хүснэгт 27: Жижиглэн худалдааны газруудын тоо, (2020)........ 103
Хүснэгт 28: Худалдааны газрын ангилал, (2020 он)........ 103
Хүснэгт 29: Худалдаа үйлчилгээний төвийн түрээслэгчдийн тоо........ 104
Хүснэгт 30: Сэндли ББСБ компанийн мерчантын зээл авах боломжит зах зээл........ 106
Хүснэгт 31: Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд........ 107
Хүснэгт 32: Сэндли ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нийт багтаамж 108
Хүснэгт 33: Сэндли ББСБ-ын зорилтот зах зээлийн нийт багтаамж........ 109
Хүснэгт 34: ББСБ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өрсөлдөгчдөөр........ 111
Хүснэгт 35: Цахим үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудын үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт........ 111
Хүснэгт 36: Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгч компаниудын мэдээлэл........ 112
Хүснэгт 37: ББСБ-уудын орон нутаг дахь тархац........ 113
Хүснэгт 38: Санхүү байдлын тайлангийн төсөөлөл........ 118
Хүснэгт 39: Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл........ 120
Хүснэгт 40: Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл........ 121
Хүснэгт 41: Зохистой харьцааны үзүүлэлт........ 122
Хүснэгт 42: ATL, BTL, TTL арга замуудын харьцуулалт........ 129

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## ЗУРАГ

Зураг 1: Сэндли ББСБ ХК-ийн хамт олон........16
Зураг 2: “SENDLY” мөнгөн гуйвуулгын үйлчилгээний түүх........21
Зураг 3: Хувьцаа эзэмшигчдийн бүтэц........22
Зураг 4: Толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц........24
Зураг 5: Бүтэц зохион байгуулалт........30
Зураг 6: Сэндли ББСБ ХХК салбар нэгжийн байршил........45
Зураг 7: Мерчантын зээлийн хэрэгцээ, зах зээл........106
Зураг 8: Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц........110

## ГРАФИК

График 1: Зээлийн үзүүлэлтүүд........35
График 2: Зээлдэгчийн хүйс........35
График 3: Зээлийн бүтээгдэхүүн........36
График 4: Төгрөгийн гуйвуулга........38
График 5: Ам.долларын гуйвуулга........38
График 6: Автрали долларын гуйвуулга........39
График 7: Япон иенийн гуйвуулга........39
График 8: Еврогийн гуйвуулга........39
График 9: Гуйвуулгын тоо........39
График 10: 2022.10.31-ний өдрийн байдлаарх зээлийн багцын бүтээгдэхүүний төрөл 46
График 11: Нийт харилцагч ба зээлдэгчдийн тоо........46
График 12: Нийт зээлийн үлдэгдэл, сая төгрөг........47
График 13: Зээлийн багцын чанар........47
График 14: Үндсэн үйл ажиллагааны нийт цэвэр орлогын бүтэц........54
График 15: Цэвэр ашиг ба нийт цэвэр орлогын харьцуулалт........55
График 16: Нийт хөрөнгийн өгөөж ба өөрийн хөрөнгийн өгөөж, хувиар........55
График 17: Цэвэр хүүгийн орлогын маржин........56
График 18: Зээлийн активын чанар........56
График 19: Зээлийн эрсдэлийн сан........57
График 20: Өрийн эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлт........57
График 21: Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас........58
График 22: Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ........59
График 23: Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний задаргаа, (сая төгрөг)........59
График 24:Бодит ДНБ-ий өсөлт, (2015 оны зэрэгцүүлэх үнээр)........72
График 25: Гадаад худалдааны нөхцөл, (тэрбум ам.доллар)........73
График 26: Инфляцын түвшин........75
График 27: Мөнгөний нийлүүлэлт, (тэрбум төгрөг)........76
График 28: Төлбөрийн тэнцэл, (сая ам.доллар)........77
График 29: Гадаад валютын албан нөөц, (сая ам.доллар)........78
График 30: Валютын сарын дундаж ханш, (төгрөг)........78
График 31: Зах зээлийн үнэлгээ ба ЗЗҮ/ДНБ харьцаа........79
График 32: Үнэт цаасны гүйлгээ ба ТОП-20 индекс........80
График 33: Арилжааны үнийн дүн, (тэрбум төгрөг)........80
График 34: ББСБ-ын салбарын ийт хөрөнгө ба нийт зээл........81
График 35: ББСБ-ын тоо, харилцагчдын тоо........81
График 36: Зээлийн жигнэсэн дундаж хүүгийн харьцуулалт........82
График 37: ББСБ-ын салбарын зээлийн багцын чанар........83

СЗХ
он .сар 13 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 38: Хуулийн этгээдэд олгосон зээл, бүтээгдэхүүний төрлөөр, (хувиар)........... 84
График 39: Иргэдэд олгосон зээл, бүтээгдэхүүний төрлөөр, (хувиар) ........................ 84

График 40: ББСБ-ын салбарын эх үүсвэрийн бүтэц, (тэрбум төгрөг)........................... 84
График 41: ББСБ-ын салбарын ашигт ажиллагаа ба нийт орлого, зардал (тэрбум төгрөг) ..... 85
График 42: ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа, төрлөөр ..................................... 86
График 43: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ, (тэрбум ам.доллар)........................... 88
График 44: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ, тэрбум ам.доллар ............................ 89
График 45: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч бага, дунд орлоготой улс..... 89
График 46: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч бага, дунд орлоготой улс, ДНБ-д эзлэх хувиар..... 89
График 47: Мөнгөн гуйвуулгын өсөлт, хувиар.................................................... 90
График 48: 200 ам.доллар шилжүүлэхэд гарах зардал, (2021-2022) ........................... 90
График 49: Дэлхийн мөнгөн гуйвуулгын төсөөлөл ................................................ 91
График 50: Хүлээн авсан мөнгөн гуйвуулга, (мянган ам.доллар)............................... 92
График 51: Шилжүүлсэн мөнгөн гуйвуулга, (мянган ам.доллар) ................................ 92
График 52: Гадаад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тархалт............................. 93
График 53: Гадаадад оршин суугаа хүн амын тоо ................................................ 93
График 54: Гадаад улсад оршин суугаа иргэдийн хувь, насны бүлгээр, (2020 он)........ 94
График 55: Дотоод мөнгөн гуйвуулгын хэмжээ.................................................... 94
График 56: Гадаадад суугаа Монгол иргэдийн тоо, насны бүлгээр............................. 96
График 57: Худалдаан салбарын борлуулалт, (их наяд төгрөг)................................. 98
График 58: Банкны салбарын зээлийн бүтэц, хувиар ............................................ 98
График 59: Банкны системийн зээлийн чанаргүйдэл, харьцуулалт ............................ 99
График 60: Банкны салбарын зээлийн чанаргүйдэл, салбараар................................. 99
График 61: ББСБ-ын салбарын шинээр зээл олголт, салбараар ................................. 99
График 62: Мерчантуудын санхүүжилтийн эх сурвалж ба санхүүжилтийн зарцуулалт ..... 100
График 63: Мерчантуудад шаардлагатай зээлийн хэмжээ........................................ 100
График 64: Мерчантууд банкнаас зээл авахад тулгардаг асуудал ............................ 101
График 65: Улсын дундаж цалин...................................................................... 107
График 66: Нийт өр төлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, хувиар ............................ 119
График 67: Цэвэр зээлийн багц, (тэрбум төгрөг)................................................. 119
График 68: Нийт цэвэр орлого, цэвэр ашгийн төсөөлөл........................................ 120
График 69: Нийт хөрөнгийн өгөөж ба Өөрийн хөрөнгийн өгөөж .............................. 123
График 70: Санхүүгийн хөшүүргийн харьцаа....................................................... 123
График 71: Төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү................................. 133

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Үнэт цаасаа олон нийтэд худалдахаар санал болгож буй компани |
| Финтек | Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн загвар |
| Бичил зээл | Бага хэмжээтэй хэрэглээний зээл |
| Аппликейшн | Гар утсанд суулгаж ашигладаг программ |
| Андеррайтер | Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулагч компани |
| Их хэмжээний хэлцэл | Компанийн өөрийн хөрөнгийн 25 хувиас дээш хэмжээтэй гэрээ, хэлцэл |
| Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг ойлгоно. |
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд үнэт цаасаа худалдаж байгаа арилжаа |
| Арилжаа | Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа |
| Мерчант | Жижиглэнгийн худалдаа эрхлэгч |
| Хиймэл оюун ухаан | Өөрийгөө хөгжүүлж байдаг программ |
| Лиценз | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх |
| Корпораци | Хувь нийлүүлсэн байгууллага; эвлэл, нэгдэл |
| Синержи | Хамтын ажиллагаа |
| 4G интернэт | Өндөр хурд, их хэмжээний багтаамж бүхий, чанарын түвшинг сайжруулсан хөдөлгөөнт холбооны дараа үеийн технологи |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ХК | Хувьцаат компани |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ААНОАТ | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| IT | Information Technology (Мэдээллийн технологи) товчилсон үг |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| МБ | Монгол банк |
| ГВАН | Гадаад валютын албан нөөц |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ҮЦТХТ | Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв |
| ХБҮЦ | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |

СЭНДЛИ ББСБ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

"Сэндли ББСБ" ХК /цаашид "Үнэт цаас гаргагч", "Компани" гэх/ нь Монгол улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Санхүүгийн Зохицуулах Хороо" болон "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн холбогдох журмын дагуу олон нийтэд өрийн хэрэгсэл (цаашид "бонд" эсхүл "өрийн бичиг" гэх) нээлттэй санал болгон гаргаж байгаа болно.

"ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН БОНДЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ ХОРОО БОЛОН БИРЖ ХАРИУЦАХГҮЙ! ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БОНДЫН ТАНИЛЦУУЛГА, БОНД ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА."

Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны бонд худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах нэмэлт зүйл гарвал Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК болон Андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК, "Райнос инвестмент ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК-д хандана уу.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### АНДЕРРАЙТЕР

**"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 25 давхар, 2506 тоот
info@ucc.mn
+976 7777 6377
www.ucc.mn

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

**"РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1308Б тоот
info@rhinosinvest.mn
+976 7510 0575
www.rhinosinvest.mn

### ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

**"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК " ХХК**

Монгол улс, Улаанбаатар 14200, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 403 тоот
info@golomtcapital.com
+976 7012 1530
www.golomtcapital.com

### ХУУЛИЙН ФИРМ

**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН**

Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
www.mdsa.mn
+976 11 330048
+976 11 330049

### АУДИТЫН КОМПАНИ

**"ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК**

Монгол улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Метро бизнес төв, 6 давхар, 603 тоот
shonkhor.mn@gmail.com
+976 8011 0088

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Сэндли ББСБ ХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хүүтэй бонд |
| Бондын арилжаа | Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Биржид бүртгүүлэх бондын тоо ширхэг | 85,000 (наян таван мянга) ширхэг |
| Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг) | 100,000 (зуун мянга) төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ | 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөг |
| Бондын хугацаа | 18 сар |
| Бондын хүү | 19.2 (арван ес аравны хоёр) хувь, жилийн |
| Хүүгийн төлөлт | Улирал тутам |
| Үндсэн төлбөр төлөлт | Хугацааны эцэст |
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй. |
| Бондыг эргүүлэн худалдан авах үнэ | Бонд гаргагч нь бондын үндсэн төлбөрийг нэрлэсэн үнээр худалдан авч, хуримтлагдсан хүүг төлнө. (Бондыг эргүүлэн худалдан авах дэлгэрэнгүй нөхцөлийг энэхүү үнэт цаасны танилцуулгын "Үнэт цаас гаргах тухай тогтоол" хэсгээс харна уу.) |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. |
| Үнэт цаасны хүүгийн орлогын татвар | 5.0 хувь |
| Бондын барьцаа, батлан даалт | Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулж, батлан даалт гаргасан болно. |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДЭЭС ГАРГАСАН ШИЙДВЭР

"Сэндли ББСБ" ХК-ийн 2022 он 12 дугаар сарын 22-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн №22/07 тоот тогтоолоор Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох замаар хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Мөн тус тогтоолыг шинэчилж үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр №01 тогтоолоор нөхцөл, татан төвлөрүүлэх хөрөнгийг шинэчлэн тогтоожээ.

СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

Сэндли
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 22-ны өдөр  № 22/04  Улаанбаатар хот

*Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсгүүд, 41 дүгээр зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, "Сэндли ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.23 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нийт 10'000'000'000.0 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийг (цаашид "Бонд" гэх) Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан 2023 оны 1 дүгээр улиралд багтаан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар гаргасугай.

2. Бондын нөхцөлийг дор дурдсанаар батлсугай.

| | |
|---|---|
| Бондын арилжаа | Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Бондын төрөл | Энгийн хүүтэй бонд |
| Бондын нийт үнийн дүн | 10'000'000'000.0 /Арван тэрбум/ төгрөг |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100'000.0 /Нэг зуун мянга/ төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 100'000.0 /Нэг зуун мянга/ ширхэг |
| Бондын хугацаа | 18 сар |
| Бондын жилийн хүүгийн түвшин | 19.2 /Арван ес аравны хоёр/ хувь |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутам |
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сараас хойш Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй |
| Бондын барьцаа | Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулна |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
20__ оны __ сарын __ өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

3. Энэхүү тогтоолын дагуу нээлттэй хүрээнд Бонд гаргахтай холбоотойгоор "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийг Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-ийг Үндсэн Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, "Голомт Капитал ҮЦК" ХХК, "Райнос инвестмент ҮЦК" ХХК-ийг Туслах Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх байгууллагаар, "Шонхор үнэлгээ аудит" ХХК-ийг аудитын дүгнэлт гаргах байгууллагаар тус тус сонгосугай.

4. Энэхүү тогтоолын дагуу Бондыг олон нийтэд санал болгож, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай гэрээ байгуулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

СЭХ
өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Сэндли
Банк бус санхүүгийн байгууллага

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 06-ны өдөр № 01 Улаанбаатар хот

***Тогтоолд өөрчлөлт оруулах тухай***

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсгүүд, "Сэндли ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай" 22/07 тоот тогтоолын Бондын нийт үнийн дүн, бондыг эргүүлэн худалдан авах үнэ, нөхцөл, бондын барьцааны хэсэгт өөрчлөлт оруулан, хавсралт 1-ээр баталгаажуулсугай.

2. Энэхүү тогтоолын 1-д заасны дагуу Бонд гаргахтай холбоотойгоор "Бонд эргүүлэн худалдан авах нөхцөл"-ыг хавсралт 2-оор баталсугай.

3. Бондын нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Бондын гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Одгэрэл/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоолын Хавсралт 1

**БОНДЫН НӨХЦӨЛ**

| | |
|---|---|
| Бондын арилжаа | Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Бондын төрөл | Энгийн хүүтэй бонд |
| Бондын нийт үнийн дүн | 8'500'000'000.0 /Найман тэрбум таван зуун сая/ төгрөг |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100'000.0 /Нэг зуун мянга/ төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 85'000.0 /Наян таван мянга/ ширхэг |
| Бондын хугацаа | 18 сар |
| Бондын жилийн хүүгийн түвшин | 19.2 /Арван ес аравны хоёр/ хувь |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| Хүүгийн төлбөр тооцоолох аргачлал | Жилийн хүүг 365 хоногоор тооцох ба бондын хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 3 сарын дараах мөн өдөр төлнө. Хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх бөгөөд энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй ба дараагийн хүүг мөн өдрөөс эхлэн тооцно |
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй |
| Бондын эргэн төлөлт хийгдэх | Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 18 дахь сарын мөн өдөр төлнө. Хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө |
| Бондыг эргүүлэн худалдан авах үнэ | Бондын үндсэн төлбөр (нэрлэсэн үнээр) болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүн байна |
| Бондын барьцаа | Бондын эргэн төлөлтийн баталгаа тус компанийн толгой компани "Монголын финтек групп" ХК-ийн эзэмшиж буй 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг буюу 16.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцаагаар бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангана |
| Бондын батлан даалт | "Монголын финтек групп" ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргана |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

СЭХ
2023 01 10
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ 02

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоолын Хавсралт 2**

## Бонд эргүүлэн худалдан авах нөхцөл

| | |
|---|---|
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Компани нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бонд эзэмшигчийн хүсэлтийн дагуу Бондыг эргүүлэн худалдан авна |
| Бондыг эргүүлэн худалдан авах үнэ | Бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн төлбөрийн нийлбэр дүн байна |
| Бондыг эргүүлэн худалдан авах хугацаа | Компани нь бонд эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд Бондын үнийн дүнгээс хамааран дараах хугацаанд бондыг эргүүлэн худалдан авна.<br>- 50,000,001 (тавин сая нэг) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бол Бонд эзэмшигч мэдэгдэл илгээснээс хойш ажлын 10 хоногийн дараа;<br>- 50,000,000 (тавин сая) хүртэл төгрөгийн үнийн дүнтэй бол мэдэгдэл ирүүлсэн тухайн өдөр; |
| Бондын татвар | Бонд гаргагч нь Бонд эзэмшигчийн бондтой холбоотойгоор олсон хүүгийн орлогын үнийн дүнгээс татварт ногдох 5 хувийг суутган шилжүүлж, Бонд эзэмшигчийн нэрийн өмнөөс төсөвт шилжүүлэн тайлагнана |
| Арилжааны шимтгэл | Бондыг худалдах, худалдан авах арилжааны шимтгэлийг талууд тус бүрдээ хариуцна |

Sendly

НЭЭЛТТЭЙ›
БОНД

# Нэг.

# Үнэт цаас гаргагчийн тухай

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

### 1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Сэндли ББСБ" ХК нь 2015 оны 5 дугаар сард "Гялс кредит" нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллага юм.

Зураг 1: Сэндли ББСБ ХК-ийн хамт олон



Үнэт цаас гаргагч нь финтек технологид суурилсан, "Sendly" гар утасны аппликейшнээр дамжуулан олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 оны 5 дугаар сард зах зээлд амжилттай нэвтрүүлж, Америкийн нэгдсэн улс, Австрали, Япон зэрэг улсад, 2022 оны 6 дугаар сараас Европын холбооны улсад оршин суугаа Монгол улсын иргэдэд түргэн шуурхай, олон улсын стандартын дагуу, хямд өртөгтэй мөнгөн гуйвуулгын үйлчилгээг үзүүлж байна.

"Sendly" мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад болон дотоодын зах зээлд өөрийн гэсэн өнгө төрх, брэндийг бий болгож, хэрэглэгч үйлчлүүлэгчдэдээ таниулах зорилгоор 2021 оны 12 дугаар сард компанийн оноосон нэрийг "Сэндли ББСБ" ХХК хэмээн өөрчилсөн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 сарын 10-ны өдрийн 413 тоот тогтоолоор үнэт цаас гаргагчийн нийт хувьцааны 29.97 хувьтай тэнцэх хэмжээний 67,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргах, нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн билээ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10




Сэндли ББСБ ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу 2022 оны 09 сарын 26-ны өдрөөс 09 сарын 30-ны өдрийг дуустал Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн нийт хувьцааны 29.97 хувьтай тэнцэх 67 сая ширхэг энгийн хувьцааг нэг бүрийг нь 150 төгрөгөөр нийтэд санал болгон нийт 10,050,000,000 төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, 3,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй, нээлттэй хувьцаат компани болсон билээ.

**Алсын хараа**

Харилцагчид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн хурдан, хамгийн бага зардлаар хүргэх дэлхийн стандартад нийцсэн санхүүгийн эко дэд бүтцийг бий болгох.

**Эрхэм зорилго**

Ажилтан бүрийн чин сэтгэлээр санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээг хэрэглэгч бүрт найдвартай хүргэнэ.

**Үнэт зүйлс**

Мэргэжлийн өндөр ур чадвартай баг хамт олон, харилцагч, технологи, мэдээллийн аюулгүй байдал, харилцагчийн үйлчилгээ

**Давуу тал**

- Мэргэжлийн боловсон хүчин
- МУ даяар хамгийн өргөн сүлжээг бий болгосон, ОУ-д нэвтэрсэн үйлчилгээ
- Өөрсдийн хөгжүүлсэн IT систем

СЭНДЛИ ББСБ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

Сэндли ББСБ ХК нь 2022 оны 11 сард БНСУ-д ажиллаж амьдарч буй Монгол улсын иргэдэд Монголын хөрөнгийн зах зээлд гадаад улсаас оролцох боломж, хэрхэн хамгийн оновчтой хөрөнгө оруулалтыг хийх талаар мэдлэг, мэдээллийг хуваалцах зорилго бүхий "Open invest 2022 Korea" арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцож, компанийн өнөөгийн үйл ажиллагаа, давуу тал, цаашид зорьж хэрэгжүүлэх төлөвлөгөө амжилттай танилцуулсан билээ.




Сэндли ББСБ ХК нь "Open invest 2022 Korea" арга хэмжээнд оролцох үедээ тус улсын хөрөнгийн зах зээлд олон жил үйл ажиллагаа явуулж буй "Шинхан Секьюритис" компанитай 2025 онд тус улсын KOSDAQ хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаа буюу DR/deposit receipt/ гаргах үйл ажиллагаанд үндсэн зөвлөхөөр ажиллах гэрээ байгуулсан билээ. Шинхан Секьюритис компани нь БНСУ-даа хоёрдугаарт жагсдаг Шинхан группийн охин компани бөгөөд 2009 оноос хойш хамгийн олон гадаад компанийг Солонгосын хөрөнгийн биржид гаргасан туршлагатай тэргүүлэх үнэт цаасны компаниудын нэг юм.




DR (Depositary Receipt) буюу Хадгаламжийн сертификат гэдэг нь аль нэг компани хувьцаагаа гадаадын хөрөнгийн бирж дээр санал болгохын тулд нийтэд үнэт цаасаа санал болгон бүртгүүлэх процессыг эхнээс нь туулахгүйгээр, дотоодын зах зээлд гаргасан хувьцаагаа гадаадын зах зээлд давхар борлуулах боломжтойгоор үнэт цаасжуулан арилжаалах боломж олгодог санхүүгийн хэрэгсэл юм.

СЗХ БҮРТГЭВ №-31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Сэндли ББСБ ХК нь олон нийтэд хувьцаагаа санал болгон амжилттай арилжаалж, нээлттэй компани болж буйтай холбогдуулан анхны хувьцаа эзэмшигчдийн хурлаа 2022 оны 11 сарын 17-ны өдөр "Blue Sky Tower"-н Emerald танхимд зохион байгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус нийт 9 гишүүдийг сонгож, нээлттэй хувьцаат компанийн дүрмээ баталсан билээ.




### 1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХАЯГ

| | |
|---|---|
| Хуулийн этгээдийн нэр | "Сэндли ББСБ" ХК |
| Үйл ажиллагааны төрөл | • Зээлийн үйл ажиллагаа<br>• Гадаад валютын арилжаа<br>• Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ<br>• Факторинг үйлчилгээ<br>• Итгэлцлийн үйлчилгээ<br>• Төлбөрийн баталгаа гаргах |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2015/05/04 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9007001010 |
| Регистрийн дугаар | 5961548 |
| Хаяг | Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,50 мянгат Бакула ренбүчи гудамж 8/4 |
| Утас | +976 7017-7700 |
| Цахим шуудан | info@sendly.mn |
| Цахим хаяг | www.sendly.mn |

СЭНДЛИ ББСБ ХК Sendly

СЗХ
2023 оны 1 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 332

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

### 1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

#### "SENDLY" үйлчилгээний үүсэл

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчид нь 2016 онд Монгол Улсын гадаад төлбөр тооцооны системд шинэ гарцыг эрэлхийлэх, и-коммерс буюу онлайн худалдааг хөгжүүлэх, дэлхий даяарх төлбөр тооцооны цахим шилжилтэд хөл нийлүүлэн алхах зорилгоор АНУ-ын "ACI WORLDWIDE" компанитай хамтран ажиллах болжээ.

Төслийн эхэн үед зөвхөн төлбөрийн системийн шийдэлд анхаарч байсан бол хэрэгжүүлэх явцад зах зээлд бат бөх байр сууриа эзлэхийн тулд өөрийн компанийн бусдаас ялгарах онцлог, давуу талыг бий болгох бизнесийн шийдлүүд байгааг олж харсан. Ингээд гадаадад амьдарч байгаа Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын зардлыг бууруулах, гадаадад амьдарч байх хугацаандаа өөрийн эх орондоо ипотекийн зээл, сайн дурын нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах, Монгол улс руу гаднаас орох валютын урсгалыг нэмэгдүүлэх боломжийг бий болгожээ.

#### "SENDLY" үйлчилгээний тухай

Сэндли төсөл эхэлснээр Лондон, Сингапур, Люксембург зэрэг олон улсын санхүүгийн төвүүдэд оффис нээх, тухайн улсуудын хуулийн дагуу тусгай зөвшөөрлийг авах зэрэг цаг хугацаа, хичээл зүтгэл их шаардагдсан ажлын ард чадварлаг хамт олныхоо хүчин чармайлтаар амжилттайгаар гарсан билээ.

Үнэт цаас гаргагчийн Англи улс дахь охин компани болох MonRemit Limited нь 2021 онд тус улсын Санхүүгийн зохицуулах хороо (FCA буюу Financial Conduct Authority)-оос Англи болон Европын холбооны орнуудад үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг авч чадсан байна.

Сэндли ББСБ ХК нь 2020 оны 5 дугаар сард буюу Монгол Улс FATF (Financial Action Task Force буюу Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага)-ийн "саарал жагсаалт"-д ороод байх үед АНУ-ын 31 мужид албан ёсоор үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий XXX компани (харилцагчийн хүсэлтээр нэрийг нууцалсан болно) -тай хамтарч эхэлсэн. Эхэн үедээ тус улсаас Монгол Улс руу мөнгөн гуйвуулга хийхэд шаардагддаг 14 хоногийг 30 минут болгон товчилж чадсан бол өнөөдөр энэ хугацаа 10 минутад хүрээд байна.

2021 онд WechatPay үйлчилгээний Монгол Улс дахь албан ёсны түнш болсноор БНХАУ-ын иргэд Монгол Улсад аялан ирэхдээ Улаанбаатар хот доторх худалдаа, үйлчилгээний газруудад тусгайлан байршуулсан QR-ийг wechat аппликейшнээр уншуулснаар төлбөр нэн даруй хийгдэх боломжтой болсон юм.

СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Зураг 2: "SENDLY" мөнгөн гуйвуулгын үйлчилгээний түүх




## 1.1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 318 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан. Одоогоор зээл, гадаад валютын арилжаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, факторинг, итгэлцэл, төлбөрийн баталгаа гаргах зэрэг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрөл

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|
| 1 | Зээл | 2015.07.03 | №318 тогтоол |
| 2 | Гадаад валютын арилжаа | 2018.02.07 | №62 тогтоол |
| 3 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 2018.02.07 | №62 тогтоол |
| 4 | Факторинг | 2021.10.13 | №441 тогтоол |
| 5 | Итгэлцэл | 2021.10.13 | №441 тогтоол |
| 6 | Төлбөрийн баталгаа гаргах | 2021.10.13 | №441 тогтоол |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

## 1.2.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Зураг 3: Хувьцаа эзэмшигчдийн бүтэц




* (давхардсан захиалгын тоогоор)

“Сэндли ББСБ” ХК-ийн хамгийн том хувьцаа эзэмшигч нь Монголын финтек групп хаалттай ХК нийт 56.42 хувийг эзэмшдэг бөгөөд олон нийт 29.97 хувь, 8.95 хувийг “Сэндли Эмплойе” ХХК, 3.58 хувийг Б.Наранбат, 0.77 хувийг “Sendly” аппликейшнийг хөгжүүлэгч Радикс технологийн компани, үлдсэн 0.32 хувийг компанийн 7 ажилчид тус тус эзэмшиж байна.

Хүснэгт 2: Хувьцаа эзэмшигчид

| № | Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг | Эзэмшиж буй хувьцааны хувь |
|---|---|---|---|
| 1 | Монголын финтек групп ХК | 126,141,700 | 56.42% |
| **2** | **Олон нийт** | **67,000,000** | **29.97%** |
| 3 | Сэндли Эмплойе ХХК | 20,000,000 | 8.95% |
| 4 | Б.Наранбат | 8,000,000 | 3.58% |
| 5 | Радикс технологи ХХК | 1,714,200 | 0.77% |
| 6 | Батдорж Нямжаргал | 285,700 | 0.13% |
| 7 | Зургаа Цолмон | 107,100 | 0.05% |
| 8 | Чойжоо Дашсүрэн | 71,400 | 0.03% |
| 9 | Лхагважав Нарантуяа | 71,400 | 0.03% |
| 10 | Охиндоо Нямдэлэг | 71,400 | 0.03% |
| 11 | Ганхуяг Саруул-Од | 71,400 | 0.03% |
| 12 | Гантөмөр Гантуяа | 35,700 | 0.02% |
| | НИЙТ | 223,570,000 | 100.00% |

СЭНДЛИ ББСБ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

### 1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОЛГОЙ КОМПАНИ

#### МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП ХК

"Монголын финтек групп" хаалттай ХК нь финтек технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох, олон улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэн тэлэх гүүр нь буюу "Санхүүгийн Холдинг" компани болох зорилгоор байгуулагдсан билээ.

Тус компани нь санхүү, үл хөдлөх хөрөнгө зуучлал, хөрөнгийн зах зээл зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн охин компаниуддаа дэвшилтэт технологийг нэвтрүүлж, үйл ажиллагааг нь удирдлагаар ханган ажиллаж байна. Тус компанийн нийт хувьцааны 76.6 хувийг "Монголиан мючуал финанс групп" ХХК, үлдсэн 23.4 хувийг 252 (давхардсан захиалгын тоогоор) хувь хүн болон байгууллагууд эзэмшиж байна.

#### "МОНГОЛИАН МЮЧУАЛ ФИНАНС ГРУПП" ХХК

"Монголиан мючуал финанс групп" ХХК нь 2017 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын санхүүгийн болон технологийн салбарт шинэлэг, шуурхай үйлчилгээг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготойгоор үүсгэн байгуулагджээ.

Тус компани нь худалдаа үйлчилгээ, санхүү, үл хөдлөх хөрөнгийн зуучлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй өөрийн охин компаниуддаа дэвшилтэт технологийг нэвтрүүлж, харилцагч үйлчлүүлэгчдийнхээ найдвартай хамтрагч нь болох замаар зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нь нэмэгдүүлэхэд удирдлагаар ханган ажиллаж байна.

#### "МОНГОЛ МЮЧУАЛ" ПТЕ.ЛТД

"Монголиан мючуал финанс групп" ХХК-ийг Сингапур улсад бүртгэлтэй "Монгол Мючуал" Пте.Лтд компани 100 хувь эзэмшдэг. Монгол Мючуал Пте.Лтд-ийн 70 хувийг Монгол Улсын иргэн Б.Наранбат, 30 хувийг М.Цолмон нар эзэмшиж байна.

Тус компани нь 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсан ба АНУ, Англи, Япон, Солонгос, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай төлбөр тооцоог саадгүй гүйцэтгэх боломжтой төлбөрийн системийн платформыг хөгжүүлэх, хамтран ажиллах, дэлхийн зах зээлд өөрийн охин компаниудыг сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## ТОЛГОЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Зураг 4: Толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц




### 1.2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭРГЭЛДЭЭ КОМПАНИУД

### ХАЙ ПЭЙМЭНТ СОЛЮШНС ХХК



"Хай пэймэнт солюшнс" ХХК нь 2018 оноос эхлэн Монгол Улсад цахим төлбөр тооцооны иж бүрэн, найдвартай экосистемийг нэвтрүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд финтек технологид суурилсан "Hi-Pay" гар утасны аппликейшнийг хөгжүүлж, төлбөр тооцооны цогц шийдлийг бий болгохоор ажиллаж байна.

"Хай пэймэнт солюшнс" ХХК нь Монгол Улсад анх удаа "E-commerce payment gateway" төлбөрийн системийг нэвтрүүлж, дэлхийн жишигт нийцсэн төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг "Hipay" аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн, дэлхийн топ 19

банкны хэрэглэгчдийн картын мэдээллийг хүлээн авах, хадгалах, аюулгүй байдлын стандартын технологийг нийлүүлэгч “ACI WorldWide” компанитай хамтран ажиллаж байна.

“Хай пэймэнт солюшнс” ХХК 2022 оны жилийн эцсийн байдлаар 360 мянга гаруй хэрэглэгчтэйгээр 110 тэрбум төгрөгийн картын гүйлгээ, 10 тэрбум цахим мөнгөний гүйлгээ хийн үйл ажиллагаагаа явуулж байна.

## ГЯЛС ТӨГРӨГ ХЗХ

“Гялс төгрөг” ХЗХ нь 2016 онд үүсгэн байгуулагдсан ба 2021 оны эцсийн байдлаар нийт 15,395 гишүүнтэй болоод байна. Гялс төгрөг нь Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт нийт 45 салбар нэгжээр дамжуулан 12 төрлийн хадгаламж, зээлийн үйлчилгээг уламжлалт болон онлайн хэлбэрээр хослуулан хүргэж, салбартаа өөрийн байр суурийг эзлэн, дэвшилтэт технологийг амжилттай нэвтрүүлж чадсан хоршоо юм.

2018 онд олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч “Micro Finanza Rating” байгууллага Гялс төгрөг ХЗХ-ны санхүүгийн чадавхад үнэлгээ хийн “BB” зэрэглэл тогтоосон нь тус хоршооны үйл ажиллагааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чухал ач холбогдол үзүүлжээ. Тус хоршоо нь 2022 оны 3-р улирлын байдлаар 28.2 тэрбум төгрөгийн актив хөрөнгөтэй, 18.9 тэрбум төгрөгийн зээлийн багц, 19.7 тэрбум төгрөгийн хадгаламжийн багцтай үйл ажиллагаагаа явуулж байна.

## ХӨҮМ МОРГЕЙЖ КОРПОРЭЙШН ХХК

“Хөүм моргейж корпорэйшн” ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий компани юм. Тус компани нь гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдэд санхүүгийн хүртээмжийг бий болгож, эх орондоо орон сууц худалдан авах боломжийг www.1home.mn вэб сайтаар дамжуулан олгох зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.



“Хөүм моргейж корпорэйшн” нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, өөрийн зэргэлдээ компани болох Сэндли ББСБ-ын аппликейшнээр дамжуулан гадаад улсад амьдарч буй Монгол Улсын иргэд орон сууцны зээл авах, зээлийн төлөлтийг саадгүй төлөх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## hi-daatgal МАСТЕР ШИЙДЭЛ ХХК



Мастер шийдэл ХХК нь 2014 онд байгуулагдаж, 2015 оны 01 дүгээр сард “Даатгалын зуучлагч”-ын тусгай зөвшөөрлийг авснаар үйл ажиллагаагаа эхлүүлжээ. Тус компани нь “Hipay” аппликейшнээр дамжуулан даатгалын гэрээг онлайнаар зуучлан борлуулах “Hi-daatgal” платформыг хөгжүүлж буй даатгалын зуучлагч компани юм.

2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, Мастер шийдэл ХХК нь “Hi-daatgal” платформоор дамжуулан 234.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 5,660 ширхэг даатгалын гэрээг амжилттай зуучлан борлуулсан байна.

## Investlab ИНВЕСТЛАБ ВИ СИ ХХК

“Инвестлаб ви си” ХХК нь 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр байгуулагдсан, гарааны бизнест шаардлагатай санхүүжилтийг олгож, хууль эрх зүй, технологийн чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготой, олон улсын “Venture capital fund”-н үйл ажиллагааны зарчмаар ажиллаж буй компани юм. Одоогийн байдлаар “Инвестлаб ви си” ХХК - ийн хөрөнгө оруулалтын багцад 10 гаруй гарааны бизнес нэгдээд байна.

Тэдгээр компаниудаас онцлох төслүүд нь “Дижитал вэндинг” ХХК ийн “Hi-charge” зөөврийн цэнэглэгч түрээс, “Эко кэш” хог хаягдал төлбөртэй хүлээн авах автомат машин, “Зочил” онлайн худалдааны платформ зэрэг төслүүд багтаж байна.

**Digital Vending**
Зөөврийн powerbank түрээсийн үйлчилгээ

**Zochil**
Онлайн худалдааны цахим платформ

**Wings Pos**
Эмнэлэгийн програмын цогц шийдэл

Зочлох үйлчилгээний салбарын цогц шийдэл

Тийз болон аялалын платформ

Хог хаягдал төлбөртэй хүлээн авах машин

СЗХ БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

## СТОКЛАБ СЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК

"Стоклаб секьюритиз ҮЦК" ХХК нь 2021 онд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрлөө авч, Монгол Улсынхаа хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшилд өөрийн хувь нэмрээ оруулж, мэргэжлийн өндөр ёс суртахуун, ур чадварыг баримтлан түргэн шуурхай Гадаад улсад ажиллаж амьдарч буй болон Улаанбаатар хот, орон нутгийн харилцагчдадаа дэвшилтэт технологид суурилсан, төлбөрийн уян хатан нөхцөлтэй, хамгийн бага шимтгэлтэйгээр хөрөнгийн зах зээлийн зуучлалын үйлчилгээ"-г үзүүлж байна.

Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдэд хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг бий болгох, хөрөнгө оруулалтын бааз суурийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарт цахим мөнгөний хэрэглээг нэмэгдүүлэх боломжийг хамтран бүрдүүлэх зорилгоор 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр "Монголбанк", "Санхүүгийн зохицуулах хороо"-ны дэмжлэгтэйгээр "Стоклаб секьюритиз ҮЦК" ХХК, "Хай пэймэнт солюшнс ХХК", "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК нар хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд анх удаа гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэд үнэт цаасны данс нээх, түүгээрээ дамжуулан Эрдэнэс тавантолгой компанийн 1072 хувьцааныхаа ногдол ашгаа авах, Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох, бусад брокерын компанид байгаа үнэт цаасаа шилжүүлэн, удирдах боломжийг нээж өгсөн юм.

Тус компани харилцагч нь гар утасны апп ашиглан авах боломжтой дараах төрлийн үйлчилгээнүүдийг хөгжүүлээд байна. Үүнд:

- Үнэт цаасны данс онлайнаар нээх.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж төв дэх бэлэн мөнгөний дансаа цэнэглэх.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх бэлэн мөнгө, ногдол ашиг, бондын данснаасаа мөнгө хүсэх.
- Монголын хөрөнгийн бирж дээр зарлагдсан анхдагч зах зээлийн арилжаанд оролцох.
- Хоёрдогчийн арилжаанд оролцох
- Бусад брокерын компанид байгаа үнэт цаасаа шилжүүлэн авах, удирдах.
- Өөрийн дансанд хүүхдийн дэд дансаа нээн хөрөнгийн зах зээлд оролцох
- Үнэт цаасны үлдэгдэл болон өгөөжийн тооцооллоо харах.
- Биржийн бус зах зээлийн арилжаанд зуучлах

2022 оны 3 улирлын байдлаар, "Стоклаб секьюритиз ҮЦК" нь Үнэт цаасны апп-аар дамжуулан нийт 7,838 харилцагчид шинээр данс нээж, анхдагч зах зээлийн арилжаанд давхардсан тоогоор 2,232 харилцагч 3.9 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаанд давхардсан тоогоор 9,293 харилцагч 844.5 сая төгрөгийн арилжаанд оролцсон байна.

## АРТ КРЕДИТ ХХК

Арт кредит ХХК нь 2017 оны 10 сарын 02-ны өдөр байгуулагдсан бөгөөд 2020 оны 11 сарын 25-ны өдөр Сангийн яамнаас “Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах” тусгай зөвшөөрлийг авсан билээ. Тус компани нь тусгай зөвшөөрөл авсанаас хойш 2 жилийн хугацаанд лотерейн зах зээлийн судалгаа, тохирлын машин үйлдвэрлэгчтэй холбогдож техник хэрэгслийг судлах зэрэг бэлтгэл ажлыг хангасан байна.




Дэлхийн стандарт, жишигт нийцсэн лотерейг Монгол улсад нэвтрүүлж, сугалааны талаарх олон нийтийн ойлголтыг үндсээр нь өөрчилж, Монгол улсын АНХНЫ шударга, ил тод, тогтвортой, хариуцлагатай үйл ажиллагаа бүхий лотерей болох зорилготой тус компанийн анхны тохирол нь 2022 оны 12 сарын 18-нд явагдсан бөгөөд одоог хүртэл нийт 3 удаагийн тохиролоор 3,366 азтан тодорсон байна. Лотерейн тохирол нь тогтмол 7 хоногт 2 удаа олон нийтийн телевизийн сувгуудаар шууд дамжуулагддаг болно.

## МОНИ МАРКЕТ ФАНД ХХК

Мони маркет фанд нь 2021 оны 6 дугаар сард дөрвөн хувьцаа эзэмшигчтэйгээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь сул чөлөөтэй, богино хугацаат эх үүсвэрийг нэгдсэн платформын тусламжтай, харилцан ашигтайгаар банк бус санхүүгийн байгууллагуудын хооронд зуучлах, тэдгээрийг холбох, цаашлаад мөнгөний зах зээлийн хамтын санг олон улсын жишигт нийцүүлэн байгуулах эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.






Мөнгөний захын оролцогчдын тоог нэмэгдүүлэх, санхүүгийн байгууллагын ажилтнуудын ур чадварыг сайжруулах зорилгоор санхүүгийн зах зээлийн олон улсын практик, актив пассивын удирдлага, репо зээлийн талаар танхимын болон онлайн сургалтуудыг зохион байгуулж, Улаанбаатар хотын болон орон нутгийн нийт 40 томоохон ББСБ-уудтай Репо зээлийн Мастер гэрээг байгуулсан.

СЭХ
2023 01 10
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

Мони Маркет Фанд ХХК нь биржийн бус зах зээлд анхны богино хугацаат бондыг гарган арилжаалж, санхүүгийн байгууллагуудын улирлын нөлөөллийн онцлогоос хамаарсан богино хугацаат мөнгөний эрэлтийг хангаж ажилласан бөгөөд 2021 оны 12 сарын 21-ний өдөр Мөнгөний захад Репо зээлийн анхны арилжаа явагдаж эхэлснээс хойш 2022 оны эцэс хүртэл нийт 455 удаагийн хэлцлээр 69.7 тэрбум төгрөгийн Репо зээлийн арилжааг хийж гүйцэтгэсэн байна.

## КОРЕА РЕМИТАНС ХХК

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа нийт Монгол иргэдийн 30 орчим хувь нь буюу 50 мянга орчим иргэд БНСУ-д ажиллаж, амьдарч байна. Монгол Улсаас тус улсад хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд тухайн иргэдэд зориулсан албан ёсны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг бий болгох зорилготойгоор “Кореа ремитанс” ХХК нь байгуулагдсан билээ. Тус компани нь Монгол болон Солонгос улсын хооронд “Sendly” аппликейшнээр дамжуулан мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор “Gmoney Transfer” компанитай хамтран ажиллаж байна.

Одоогийн байдлаар “Кореа ремитанс” ХХК нь БНСУ-д “Сэндли Монголиа” хэмээх охин компаниа байгуулж, тус улсын Санхүүгийн зохицуулах хорооноос мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар ажиллаж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэд хэрэглэхэд хялбар, цаг хугацаа хэмнэсэн, албан ёсны эрхтэй, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авах боломжтой болох юм.

## БУСАД ҮҮСГЭН БАЙГУУЛСАН КОМПАНИУД:

Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Сэндли эмплойе” ХХК, “Гялс пропертиз” ХХК, “Датапүүл Монголиа” ХХК, “Хай лоялти” ХХК нарыг үүсгэн байгуулсан байгаа боловч идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ

**Зураг 5: Бүтэц зохион байгуулалт**




## 1.3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

### ЕРДИЙН ГИШҮҮД



**Б.Наранбат**
ТУЗ-ийн дарга
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Монголын финтек групп ХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2018 - одоо Хай пэймэнт солюшнс ХХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2016 - одоо Гялс тэгрэг ХЗХ, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
2015 - 2016 Төрийн банк, Гүйцэтгэх захирлын орлогч
2014 - 2015 Төрийн банк, Хөрөнгө зохицуулалтын газрын захирал
2007 - 2013 Сангийн яам: Санхүү эдийн засгийн бодлогын газар мэргэжилтэн

СЭНДЛИ ББСБ ХК

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



Б.Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

Туршлага

2018 - одоо Техбокс ХХК, Гүйцэтгэх захирал
2017 - 2018 Төрийн банк, Актив, пассивын удирдлагын газрын захирал
2007 - 2015 Сангийн яам, Эрсдэлийн удирдлага дотоод аудитын газар Ахлах мэргэжилтэн

---



М. Цолмон
ТУЗ-ийн гишүүн
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 10 жил Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт 5 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Монголын финтек групп ХК, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
2017 - одоо Монгол алт ХК, Гүйцэтгэх захирал
2014 - 2016 Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Гүйцэтгэх захирал
2008 - 2012 Сангийн яам, Санхүү эдийн засгийн бодлогын газар мэргэжилтэн

---



Н.Билгүүн
ТУЗ-ийн гишүүн,
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 9 жил ажилласан

Туршлага

2022 - одоо Инвестлаб Ви Си ХХК, Гүйцэтгэх захирал
2020 - 2022 Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зөвлөх
2018 - 2020 Селус Номадс ХХК-ийн ерөнхий менежер
2013 - 2018 Сангийн яам, Санхүүгийн бодлогын газар мэргэжилтэн

---



Н.Цэвэгмид
ТУЗ-ийн гишүүн,
Эдийн засагч

Хөрөнгийн зах зээлд 13 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Райнос инвестмент ҮЦК ХХК, Дэд захирал
2016 - 2021 Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК, Гүйцэтгэх захирал
2014 - 2016 Дэу Секьюритис Монгол ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалтын менежер
2009 - 2014 Гаули ҮЦК ХХК, Дэд захирал

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10



Л.Нарантуяа
ТУЗ-ийн гишүүн
Хуульч

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

Туршлага

2022 - одоо Монголын Финтек Групп ХК-ийн Хууль, эрх зүй хариуцсан захирал
2018 - 2022 Монголиан Мючуал Финанс Групп ХХК, Хууль, эрх зүй хариуцсан захирал
2009 - 2018 Төрийн банк, хууль эрх зүйн газар хуульч, Ахлах хуульч
2008 - 2009 Зоос банк, мэргэжилтэн

## ХАРААТ БУС ГИШҮҮД



Б.Анужин
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга

Банк санхүүгийн салбарт 10 жил ажилласан

Туршлага

2021- одоо Central TV, Бизнес хөгжил хариуцсан захирал
2018 - 2021 Австралын худалдааны танхим, Гүйцэтгэх захирал
2015 - 2018 Эрнст энд янг монголиа аудит ХХК, Ахлах аудитор
2013 - 2015 Азийн сан, мэргэжилтэн, төслийн зохицуулагч, төслийн зөвлөх
2012 - 2013 Азийн сан, мэргэжилтэн



Б.Цэлмэг
ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Эрсдлийн удирдлагын хорооны дарга

Санхүүгийн зах зээлд 14 жил ажилласан

Туршлага

2022 - одоо Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
2018 - 2022 Хас Банк, Санхүү газрын захирал
2015 - 2018 "Эс Эм Би Си" авиаши капитал, Санхүү төслийн менежер
2008 - 2015 "Жэй Пи Морган" Хөрөнгө оруулалтын сан, Татварын ахлах зөвлөх



Ц.Саруултуяа
ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны дарга

Боловсролын салбарт 7 жил ажилласан

Туршлага

2021 - одоо МУИС- БС, Ахлах багш
2017 -2019 Голомт Банк, Бизнес хөгжлийн менежер
2012 - 2017 Тайвань, АИС ШУТИХ, Судалгааны төсөл
2007 - 2009 Голомт Банк, Судалгааны менежер



Б.Мөнхцэцэг
ТУЗ-ийн нарийн бичиг
Эрх зүйч

Туршлага

2022.11 – одоог Сэндли ББСБ ХК, ТУЗ-ийн нарийн бичиг
2022.06 – одоог Монголын Финтек групп ХК, ТУЗ-ийн нарийн бичиг
2021.03 – 2022.06 Хай Пэймэнт Солюшнс ХХК, Хуулийн мэргэжилтэн

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## 1.3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГЫН БАГ



Б.Одгэрэл
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 16 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Сэндли ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
2013 - 2016 Төрийн банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал
2011 - 2013 Хадгаламж банк, Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал



Х.Ичинхорлоо
Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
Нягтлан бодогч

Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Сэндли ББСБ ХК, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Ерөнхий нягтлан бодогч
2015 - 2016 Төрийн банк, Харилцааны менежер, мэргэжилтэн
2009 - 2014 Төрийн банк, Салбарын Ерөнхий нягтлан бодогч



П.Болорчулуун
Салбарын удирдлага хариуцсан захирал
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 18 жил ажилласан

Туршлага

2021 - одоо Сэндли ББСБ ХК, Салбарын удирдлага хариуцсан захирал
2013 - 2021 Төрийн банк, Тооцооны төвийн захирал
2010 - 2013 Хадгаламж банк, Дотоод аудитын газар, Ахлах аудитор
2004 - 2010 Монголшуудан банк, Эдийн засагч



Д. Баярбат
Эрсдэл хяналт хариуцсан захирал
Санхүүч

Банк санхүүгийн салбарт 15 жил ажилласан

Туршлага

2022 - одоо Сэндли ББСБ ХК, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал
2017 - 2022 Гялс төгрөг ХЗХ, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал
2010 - 2017 Төрийн банк, Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



М.Мөнхгэрэл
Санхүү хариуцсан захирал
Эдийн засагч

Санхүүгийн салбарт 10 жил ажилласан

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХК, Санхүү хариуцсан захирал
2020 - 2021 НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Санхүүгийн ажилтан
2012 - 2017 Эрнст энд Янг Монголиа Аудит, Ахлах аудитор



И.Түвшинзул
Мэдээлэл технологи хариуцсан захирал
Эдийн засагч

Банк санхүүгийн салбарт 20 жил ажилласан

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХК, Мэдээллийн технологи хариуцсан захирал
2017 - 2021 Тээвэр хөгжлийн банк, Иргэдийн банкны газрын захирал
2011 - 2015 Төрийн банк, Программ ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн



Э.Мөнхдэлгэр
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
Эдийн засгийн кибернетик

Банк санхүүгийн салбарт 12 жил ажилласан

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирал
2016 - 2021 Гялс төгрөг ХЗХ, Ахлах менежер
2013 - 2016 Төрийн банк, Хүний нөөцийн газар, Сургалт хөгжлийн ахлах мэргэжилтэн



Б.Нямжаргал
Мөнгөн гуйвуулга хариуцсан дэд захирал
Эдийн засагч

Банк санхүүгийн салбарт 12 жил ажилласан

Туршлага
2022 - одоо Сэндли ББСБ ХК, Мөнгөн гуйвуулга хариуцсан захирал
2022 - одоо Монголын ББСБ-уудын холбоо, Мэргэжлийн комплаенсийн хорооны дарга
2017 - 2018 Дэлхийн банк: Экспортыг дэмжих төсөл : Бизнес хөгжүүлэлтийн ажилтан

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

# 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 1.4.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

**Үнэт цаас гаргагч нь олон улсын мөнгөн гуйвуулга болон зээл, санхүүгийн бусад үйлчилгээ гэсэн хоёр үндсэн чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.**

### Зээлийн үйл ажиллагаа

| Харилцагчийн тоо | Дундаж зээл олголт |
|---|---|
| 7084 | 2.8 сая төгрөг |

**Үнэт цаас гаргагч нь финтек шийдэлд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж зорилтод зах зээлд нийлүүлдэг билээ. 2021 онд жижиг дунд үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид зориулсан бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлсэн бол 2022 онд тогтмол орлоготой иргэдэд зориулсан хэрэглээний зээлийг шинээр зах зээлд гарган hipay аппликейшнээр дамжуулан харилцагчдад хүргэсний үр дүнд тус компанийн нийт зээлийн 90.5 хувийг цахим зээл эзлэж байна.**

График 1: Зээлийн үзүүлэлтүүд




2021.12.31

График 2: Зээлдэгчийн хүйс




2022.10.31

### Зээлийн багц

**2022 оны 10 дугаар сарын 31 өдрийн байдлаар 8,078-н харилцагчид 21.9 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийн эрх олгосны үр дүнд үнэт цаас гаргагчийн зээлийн багц 16.3 тэрбум төгрөгт хүрсэн ба зээлтэй харилцагчийн тоо 7,002 болсон байна. Өнгөрсөн жилийн эцэстэй харьцуулахад зээлийн багц 103% буюу 8.3 тэрбум төгрөгөөр өсч, харилцагчийн тоо 76% нэмэгдэж 8,966 болсон байна.**

Хүснэгт 3: Зээлийн багц

| № | Бүтээгдэхүүн нэр (сая төгрөг) | 12/31/2021 | | | 10/31/2022 | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зээлийн тоо | Үлдэгдэл сая.төг | Эзлэх хувь | Зээлийн тоо | Үлдэгдэл сая.төг | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| 1 | **Цахим** | **3019** | **7,316** | **90.9%** | **6832** | **14,779** | **90.5%** | **7,463** | **102.0%** |
| 1.1 | Мерчант зээл | 2766 | 7,301 | 90.7% | 3923 | 11,198 | 68.6% | 3,896 | 53.4% |
| 1.2 | Хэрэглээний зээл | 2 | 1 | 0.0% | 2750 | 3,573 | 21.9% | 3,572 | 261340.4% |
| 1.3 | Бусад | 251 | 13 | 0.2% | 159 | 8 | 0.1% | (5) | -36.6% |
| 2 | **Уламжлалт** | **133** | **734** | **9.1%** | **252** | **1,555** | **9.5%** | **821** | **111.8%** |
| | **Дүн** | **3152** | **8,050** | **190.9%** | **7084** | **16,334** | **100.0%** | **8,284** | **102.9%** |

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

График 3: Зээлийн бүтээгдэхүүн (сая төгрөг)




## Мерчант зээлийн төрөл

**Жижиг дунд үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид зориулсан зээлийн 85% нь хүнс үйлдвэрлэл, худалдаа, бөөний болон жижиглэн худалдаа эрхэлдэг зээлдэгчид байгаа нь энэ салбарт богино хугацааны хөрөнгө оруулалт, бараа татан авалтын эргэлт шаардлагатай байдгийг харуулж байна.**

Хүснэгт 4: Мерчант зээл

| № | Бизнесийн салбар | 12/31/2021 | | 10/31/2022 | | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Үлдэгдэл | Тоо | Үлдэгдэл | |
| 1 | Хүнс болон жижиглэн худалдаа | 2,029.00 | 5,746,793.97 | 2,689.00 | 8,331,587.45 | 78.7% |
| 2 | Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа | 133.00 | 462,130.78 | 195.00 | 651,477.58 | 6.3% |
| 3 | Машин мотоциклийн засвар үйлчилгээ | 58.00 | 151,290.40 | 62.00 | 164,636.48 | 2.1% |
| 4 | Боловсруулах үйлдвэрлэл | 53.00 | 147,900.81 | 47.00 | 154,463.25 | 2.0% |
| 5 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 45.00 | 69,030.81 | 108.00 | 181,242.27 | 0.9% |
| 6 | Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа | 21.00 | 43,664.66 | 38.00 | 82,567.50 | 0.6% |
| 7 | Барилга | 19.00 | 39,766.18 | 36.00 | 143,765.42 | 0.5% |
| 8 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 4.00 | 26,509.67 | 8.00 | 49,592.61 | 0.4% |
| 9 | Боловсрол | 7.00 | 11,990.00 | 10.00 | 41,128.82 | 0.2% |
| 10 | Бусад | 397.00 | 602,215.33 | 730.00 | 1,397,168.94 | 8.2% |
| | **Нийт мерчантын зээл** | **2,766.00** | **7,301,292.60** | **3,923.00** | **11,197,630.32** | 100.0% |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Хүртээмжтэй байдал

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид хүрч үйлчлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотод 6, орон нутагт 48 салбар нэгжээр дамжуулан зээлийн хүсэлтийг судалж, олголт хийж ажилласан байна.

Хүснэгт 5: Зээлийн бүтээгдэхүүний хүртээмж

| № | Бүс | 12/31/2021 | | | 10/31/2022 | | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зээлийн тоо | Үлдэгдэл | Эзлэх хувь | Зээлийн тоо | Үлдэгдэл | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| 1 | ТӨВ | 261 | 484,291 | 6.0% | 179 | 1,170,901 | 7.2% | 686,611 | 142% |
| 2 | УБ | 2163 | 5,534,598 | 68.8% | 2529 | 6,323,242 | 38.7% | 788,645 | 14% |
| 3 | ОН | 728 | 2,031,215 | 25.2% | 4376 | 8,840,025 | 54.1% | 6,808,809 | 335% |
| **Дүн** | | **3152** | **8,050,104** | **100.0%** | **7084** | **16,334,168** | **202.9%** | **8,284,065** | **102.9%** |

Мөн зээлийн эрхийн хэмжээгээр нийт зээлийн зээлийн багцад эзлэж буй хувь хэмжээг харахад 1-5 сая төгрөгийн зээлийн эрхтэй харилцагч 47%, 5–9 сая төгрөгийн зээлийн эрхтэй харилцагч 15%, 9–10 сая төгрөгийн зээлийн эрхтэй харилцагч 38% тус тус эзэлж байна.

Хүснэгт 6: Зээлийн эрх ба багцад эзлэх хувь

| Интервал, төгрөг | Тоо | Зээлийн эрх | Багц | | Ашиглалтын хувь |
|---|---|---|---|---|---|
| | | | Үлдэгдэл | эзлэх хувь | |
| **1-2 сая** | 1,913.0 | 2,321.1 | 1,746.4 | 15.6% | 75% |
| **2-3 сая** | 523.0 | 1,493.0 | 1,178.7 | 10.5% | 79% |
| **3-4 сая** | 185.0 | 708.8 | 571.9 | 5.1% | 81% |
| **4-5 сая** | 460.0 | 2,273.9 | 1,775.4 | 15.9% | 78% |
| **5-7 сая** | 178.0 | 1,104.7 | 901.9 | 8.1% | 82% |
| **7-9 сая** | 116.0 | 943.0 | 769.3 | 6.9% | 82% |
| **9-10 сая** | 548.0 | 5,476.7 | 4,254.1 | 38.0% | 78% |
| **Дүн** | **3,923.0** | **14,321.2** | **11,197.6** | **100.0%** | **78%** |

## Жендерийн тэгш байдал

Нийт зээлдэгчийн 26 хувь эрэгтэй, 74 хувь нь эмэгтэйчүүдэд зээл олголт хийж дэмжлэг үзүүлсэн байна.

| Хүйс | 12/31/2021 | | 10/31/2022 | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Үлдэгдэл | Тоо | Үлдэгдэл |
| Эмэгтэй | 2,463 | 6,138,315 | 5,260 | 11,817,577 |
| Эрэгтэй | 685 | 1,896,631 | 1,820 | 4,259,434 |
| Хуулийн этгээд | 4 | 15,158 | 5 | 257,231 |
| **Нийт зээл** | **3,152** | **8,050,104** | **7,085** | **16,334,243** |

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

## "Sendly" Олон улсын мөнгөн гуйвуулга

Үнэт цаас гаргагч нь олон улсын мөнгөн гуйвуулга хийх "Sendly" гар утасны аппликейшнийг 2020 оны 5 дугаар сард зах зээлд амжилттай нэвтрүүлсэн бөгөөд энэхүү аппликейшнээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэд мэдээллийн аюулгүй байдал, олон улсын стандартыг хангасан түргэн шуурхай мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авах боломжтой болсон юм. Тус компанийн зүгээс дараах орнуудаас Монгол Улсын хооронд шилжүүлэг гүйцэтгээд байна.

АНУ АВСТРАЛИ ЯПОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ 27 УЛС



## "Sendly" үйл ажиллагааны үзүүлэлт

Үнэт цаас гаргагч нь Sendly аппликейшнээр дамжуулан 2022 оны 10-р сарын байдлаар нийт 8.08 сая ам.доллар буюу 25.4 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын гүйлгээг хүлээн авсан байна. Үнэт цаас гаргагч нь 2021 онд 19.6 мянган ширхэг гүйлгээ хүлээн авсан нь арилжааны банкуудын нийт хүлээн авсан 42.4 мянган ширхэг SWIFT гүйлгээний 46.2 хувьтай тэнцэж байна.

2022 оны 10 дугаар сарын байдлаар мөнгөн гуйвуулгын тоо болон үнийн дүнг валют тус бүрээр (өссөн дүнгээр) тооцвол:

График 4: Төгрөгийн гуйвуулга




Sendly аппликейшн нь Монгол Улсаас АНУ руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 03 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 10-р сарын байдлаар нийт 1.78 тэрбум төгрөгийн гүйлгээг дамжуулаад байна.

График 5: Ам.долларын гуйвуулга




Sendly аппликейшн нь АНУ-аас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2020 оны 05 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 10-р сарын байдлаар нийт 11.8 сая ам.доллар, 36.6 тэрбум төгрөгийн гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 6: Автрали долларын гуйвуулга




Sendly аппликейшн нь Австрали улсаас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 05 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 10-р сарын байдлаар нийт 1.05 сая австрали долларын гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 7: Япон иенийн гуйвуулга




Sendly аппликейшн нь Япон улсаас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 10-р сарын байдлаар нийт 83.7 сая иений гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 8: Еврогийн гуйвуулга




Sendly аппликейшн нь Европын холбооны 27 улсаас Монгол Улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2022 оны 6 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 10-р сарын байдлаар нийт 152 мянган еврогийн гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

График 9: Гуйвуулгын тоо




Sendly аппликейшнийг нэвтрүүлсэнээс хойш 2022 оны 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 46.2 мянган гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зорилгоор үнэт цаас гаргагч нь дараах нэмэлт үйлчилгээнүүдийг мобайл аппликейшн дотор санал болгон ажиллаж байна.

1. Орон сууцны зээл – 2022 онд АНУ-д ажиллаж байгаа хэрэглэгч өөрийн нэр дээрх орон сууцыг Монгол улсдаа худалдан авч, сар бүрийн зээлийн төлбөрийг Сэндлигээр дамжуулан төлж байна.
2. Онлайн дэлгүүр - 2022 оны 3 дугаар сард Хайпэй аппликейшнтэй хамтран Сэндли ашиглаж буй харилцагч хаанаас ч хамаагүй өөрийн дуртай онлайн дэлгүүрт нэвтрэн худалдан авалт хийх бүрэн боломжтой байдлаар 8 онлайн дэлгүүрийг нэвтрүүлээд байна.
3. Сайн дурын нийгмийн даатгал – Гадаад улсад амьдарч буй Монгол иргэн нийгмийн даатгалын ерөнхий газартай Сайн дурын нийгмийн даатгалын гэрээ

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

байгуулагдсан тохиолдолд сар бүрийн төлөлтийг Сэндлигээр дамжуулан хийх боломжтой.

4. Дэлхийн Монголчуудын Төгөл – 2022 оны 7 дугаар сард Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Зөвийг шүгэлдэгчид ТББ нартай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дотор гадаадад ажиллаж амьдарч буй Монгол иргэд өөртөө, эсхүл хэн нэгэнд зориулан мод захиалан тарих боломжтой төгөлийг байгуулахаар шав тавьсан төдийгүй 10 дугаар сард анхны тариалалтыг эхлүүлээд байна.

## "Sendly" Америкийн нэгдсэн улсад

Анх 2020 оны 5 дугаар сард АНУ-ын 33 мужаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийх боломжтой болсноор Sendly мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд Сэндли ББСБ ХК нь одоогийн байдлаар АНУ-д мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Golden Transfer, Prabhu Money Transfer, Moneytun зэрэг компаниудтай хамтран ажиллаж байна.




"Sendly" үйлчилгээ нэвтэрсэн АНУ-ын 33 муж



Sendly аппликейшнийг Америкийн нэгдсэн улсаас дансаа бүртгүүлэхэд аливаа хүндрэл гаргахгүй байхаар загварчилсан бөгөөд Plaid систем дэмжин ажиллаж байна. Энэхүү систем нь Sendly аппликейшнийг АНУ-д үйл ажиллагаа явуулж буй 5,000 орчим банктай холбогдож ажиллах боломжоор хангадаг байна.

Plaid: Энэхүү систем нь АНУ-ын арилжааны банкуудын нэгдсэн систем ба системд нэгдсэн дурын банкны аппликейшн руу нэвтрэн гүйлгээ хийх боломжтой, аюулгүй байдлыг бүрэн хангасан найдвартай банкны цогц систем юм. Энэ нь Sendly аппликейшнээр гүйлгээ үүсгэсэн харилцагч өөрийн ашигладаг интернэт банкны аппликейшн руу давхар нэвтрэх шаардлагагүйгээр шууд өөрийн ашигладаг банкны аппликейшнээр дамжуулан мөнгөн гуйвуулга хийх боломжийг бүрдүүлсэн, хялбар, цаг хугацаа хэмнэх боломжтой дэвшилтэт шийдэл болсон юм.

Сэндли ББСБ ... Улаанбаатар хот

**PLAID системээр дамжуулан найдвартай шилжүүлэх боломж**



**PCI DSS стандарт хангасан төлбөр дамжуулагч**



Картын шилжүүлэг хийхэд олон улсын PCI DSS стандартыг хангасан Америкийн Tabapay Inc компанитай хамтран ажилладаг бөгөөд Visa, Mastercard, American Express, Discover, Star, NYCE, Accel cards зэрэг өргөн хэрэглээнд ашиглагддаг бүх картыг дэмждэг байна.

## Монгол улсаас АНУ-руу шилжүүлэх мөнгөн гуйвуулга

Sendly мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь 2021 оны 3 дугаар сараас эхлэн Монгол Улсаас АНУ руу мөнгөн гуйвуулга хийх шугамыг нээсэн бөгөөд шилжүүлэг хийгдэх хугацаа нь ACH буюу АНУ-ын цахим гүйлгээ, төлбөр тооцооны системээс хамааран 1-3 өдөрт хийгддэг билээ. Шимтгэлийн хувьд хамгийн хямд буюу 1.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгийн 1.25 хувь, 1.0 сая төгрөгөөс доош тогтмол 12,500 төгрөг байдаг буюу нэг удаагийн шилжүүлгээр дээд тал нь 8.0 сая төгрөгийг гуйвуулах боломжтой байдаг юм.

**Монгол улсаас 1-3 өдөрт хамгийн хямд**







## Sendly Австрали улсад

Австрали улсаас шилжүүлэг хийхэд мөнгөн гуйвуулгын програм хангамж нийлүүлэгч Flexewallet болон Австрали, Шинэ Зеланд улсын мөнгөн гуйвуулгын нэгдсэн систем болох POLi Payments зэрэг компаниудаар дамжуулан харилцагчийн шилжүүлгийг найдвартай дамжуулан ажиллаж байна.

СЭХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02




POLI төлбөр тооцооны аюулгүй систем



## Sendly Япон улсад

Сэндли ББСБ ХК нь мөнгөн гуйвуулгын City Express компанийн Япон дахь салбартай хамтран ажилладаг бөгөөд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн Япон улсаас Монгол улс руу мөнгөн гуйвуулга хийж эхэлсэн билээ. Япон улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг гурван төвшинд олгодог бөгөөд хамтран ажиллагч City Express компани нь 2 дугаар төвшний зөвшөөрөлтэй компани болно.

Japan Post банкны 30,000 гаруй КИОСК машиныг ашиглан шилжүүлэг хийх боломжтой



## Sendly Европт

MONREMIT money transfer

Сэндли ББСБ ХК-ийн Англи улс дахь охин компани болох MonRemit Limited нь 2021 онд Англи улсын Санхүүгийн зохицуулах хороо болох FCA /Financial Conduct Authority/-с Англи болон Европын холбооны орнуудад үйл ажиллагаа явуулах API /Authorized Payment Institution/ тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд 2022 оны 5 дугаар сард багтаан Европын холбооны орнуудад үйлчилгээгээ нэвтрүүлэхээр ажиллаж байна.

## WeChat Pay хамтын ажиллагаа

Сэндли ББСБ ХК нь өнгөрсөн 2021 онд БНХАУ-ын “WechatPay” үйлчилгээний Монгол Улс дахь албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд “WechatPay” төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлснээр Монгол Улсад суугаа Хятад улсын иргэд төлбөрийн хялбар систем ашиглах, Монгол Улсын бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ БНХАУ-д худалдаалан төлбөр тооцоогоо хийх боломжийг бүрдүүлсэн байна.

WeChat Pay



| QR Code Payment | Web Payment | In-App Payment | Mini Program | Official Account |
|---|---|---|---|---|

## Sendly Зээлийн үйлчилгээ

Сэндли ББСБ ХК нь зээлийн үйл ажиллагааны уламжлалт арга барилыг орчин үеийн технологитой хослуулсан цахим зээлийн үйлчилгээг үзүүлж байгаа билээ. 2021 онд жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд энэхүү үйлчилгээ нь зэргэлдээ компани болох “Хай пэймэнт солюшнс” ХХК-ийн зах зээлд нэвтрүүлсэн "Hipay" болон "Hipay-Merchant" аппликейшнээр дамжин хэрэглэгчдэд хүрч байна.

## Sendly цахим зээлийн үйлчилгээ



Хэрэглэгч, харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг хангах зорилгоор сар бүр тэнцүү төлбөр хийх нөхцөлтэй 12 сарын хугацаатай зээлийн шугамын эрх, “Hipay” аппликейшн дахь бүтээгдэхүүн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжтой “E-zeel” үйлчилгээ, даатгалын зээл зэрэг Sendly цахим зээлийн үйлчилгээг "Hipay" болон "Hipay-Merchant" аппликейшнээр дамжуулан гар утаснаасаа авах боломжийг нэвтрүүлээд байна. Үүнээс гадна уламжлалт аргаар авсан орон сууцны зээл, лизинг, хөрөнгө барьцаалсан зээл гэх мэт бусад төрлийн зээлүүдийнхээ үлдэгдлийг хянах, эргэн төлөлтөө хийх зэрэг зээл олголтоос бусад үйлчилгээг "Hipay" болон "Hipay-Merchant" аппликейшний “Sendly зээл” дэд цэсээр дамжуулан авах боломжтой юм.

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

## Sendly Мерчант зээлийн үйлчилгээ

Жижиг дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой мерчант зээлийн үйлчилгээний хэрэглэгч болсноор тухайн бизнес эрхлэгчдэд 1.0 сая төгрөг хүртэлх зээлийн шугам нээгдэхээс гадна тухайн бизнес эрхлэгчдэд нэмэлт үнэлгээ, судалгаа хийгдсэнээр 10.0 сая хүртэлх төгрөгийн зээлийг 12 сарын хугацаанд шугамаар авч ашиглах боломжтой эрх олгох, хялбар, шуурхай давуу талыг бий болгосон үйлчилгээ юм. Мөн энэхүү аппликейшнээр дамжуулан дараах нэмэлт үйлчилгээг авах боломжийг хэрэглэгч, харилцагчиддаа үзүүлж байна.

**Санхүүгээ хянах боломж**
Өдөр тутмын орлогоо хянах, бизнесээ удирдах

**Цахим зээлийн үйлчилгээ**
Эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх шуурхай

**И-баримт**
Мерчант нь үйлчлүүлэгчдээ НӨАТ-ын баримт олгох





**Автомат төлөлт**
Hipay Аппликейшнд картаа холбосон бол зээл төлөхдөө үйлдэл хийх шаардлагагүй

**QR төлбөр**
Шуурхай төлбөр тооцоо

### Мерчантын зээлийн онцлог

- Боломжит эрхийн хэмжээнд хүссэн үедээ зээл авах
- Зээл авах бүрт төлбөрийн хуваарь 30 хоногийн хугацаанд өдөр бүр төлөх нөхцөлтэйгээр шинэчлэгдэх
- Өдөр бүр бага дүнгээр төлбөр хийх нь харилцагчийг санхүүгийн ачааллалд өртөхгүй байхаас хамгаалах
- Зээл төлөлтийн гүйлгээг Hipay аппликейшнд холбосон картнаас автоматаар төлүүлэх
- Харилцагч аппликейшн ашиглан цахим хэтэвч, эсвэл арилжааны банк дах картын данснаасаа зээлээ шууд төлөх
- Зээлээ хугацаандаа төлбөл хүү тооцохгүй зэрэг онцлог давуу талтай

Зээлийн үйлчилгээний уламжлалт аргачлалыг технологитой хослуулснаар хэрэглэгчид илүү хялбар, хямд өртөгтэй, цаг хугацаа, зардал хэмнэсэн үйлчилгээг авах боломжтой болж байна.

Сэндли ББСБ ХК Sendly Улаанбаатар

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

Сэндли ББСБ ХК нь Монгол орны өнцөг булан бүрт суугаа харилцагчиддаа илүү ойр хүрч ажиллах зорилгоор Улаанбаатар хотод 6, орон нутагт 48, нийт 54 салбар нэгжээр үйл ажиллагаагаа явуулж байна. Зээлийн эрх олгох судалгааг салбар нэгжээрээ дамжуулан хэрэгжүүлж байгаа нь зээлийн эрсдэлийг бууруулах гол хүчин зүйлийн нэг болж байна.

Зураг 6: Сэндли ББСБ ХХК салбар нэгжийн байршил



## Зээлийн үлдэгдлийн мэдээлэл

Хүснэгт 7: 2022.10.31-ний өдрийн байдлаарх зээлийн багц, бүтээгдэхүүний төрлөөр, сая төгрөг

| № | Төрөл | Бүтээгдэхүүний нэр | 10/31/2022 | | Эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зээлийн тоо | Үлдэгдэл | | |
| 1 | Уламжлалт | Зээлийн шугам | 87 | 1,180.87 | 7.23% | 9.52% |
| | | Лизингийн зээл | 159 | 137.02 | 0.84% | |
| | | Орон сууцны зээл | 2 | 203.55 | 1.25% | |
| | | ҮХХ барьцаалсан зээл | 3 | 26.58 | 0.16% | |
| | | Автомашин барьцаалсан зээл | 1 | 7.23 | 0.04% | |
| 2 | Цахим | Мерчант зээл | 3923 | 11,197.63 | 68.55% | 90.48% |
| | | Хэрэглээний зээл | 2750 | 3,573.02 | 21.87% | |
| | | Даатгал | 153 | 7.99 | 0.05% | |
| | | E-Zeel | 6 | 0.28 | 0.00% | |
| | | **Дүн** | **7084** | **16,334.17** | **100.0%** | **100.00%** |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 10: 2022.10.31-ний өдрийн байдлаарх зээлийн багцын бүтээгдэхүүний төрөл




2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт зээлийн багцын 90.5 хувь цахим, 9.5 хувийг уламжлалт хэлбэрээр олгосон зээл эзэлж байна. Цахимаар олгосон зээлийн багцын 68.5 хувийг мерчантын зээлийн багц эзлэж байна.

## Нийт зээлийн үйл ажиллагаа

Сэндли ББСБ ХК нь 2021 оны 4 дүгээр сараас эхлэн зээлийн үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд харилцагчдын тоо улирал тутамд тасралтгүй нэмэгдсээр 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 8,514 харилцагчтай болсон ба эдгээр харилцагчдийн 7,084 нь зээлийн үйлчилгээг ашиглаж байна.

График 11: Нийт харилцагч ба зээлдэгчдийн тоо



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

Сэндли ББСБ ХК-ийн нийт зээлийн багцын хэмжээ 2021 оны жилийн эцсээс 6.7 дахин нэмэгдэж жилийн эцсийн байдлаар 8.28 тэрбум төгрөгт хүрч 100% өссөн үзүүлэлттэй байна. Зээлийн үлдэгдлийг олгосон хэлбэрээр нь хуваан авч үзвэл цахимаар олгосон зээл 90.5 орчим хувийг эзэлж байгаа бол уламжлалт буюу салбар нэгжээр дамжин олгогдсон зээлийн хэмжээ 9.5 орчим хувийг эзэлж байна.

График 12: Нийт зээлийн үлдэгдэл, сая төгрөг




Үнэт цаас гаргагчийн нийт олгосон зээлийн 84.2 хувь хэвийн ангилалтай бол хугацаа хэтэрсэн зээлийн түвшин 5.1 хувьтай, чанаргүй зээлийн хэмжээ 10.6 хувь байна. 2022 оны 3-р улирлын байдлаар ББСБ-ын салбарын дундаж хэвийн зээл 90.5 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 4.2 хувь, чанаргүй зээлийн хэмжээ 7.3 хувь байна.

График 13: Зээлийн багцын чанар



БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## 1.4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Үнэт цаас гаргагч компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэх, эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд, иргэдийн боловсролд тогтмол анхаарч, дэмжихэд чиглэсэн байдаг.

### Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа



Сэндли ББСБ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх, ой мод, ойн санг нэмэгдүүлэх, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилтыг дэмжин "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд хамт олны санаачлагаар нэгдэж 2030 он хүртэл 1,500,000 ширхэг мод тарихаар батламжилсан.




Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, "Sendly Money Transfer", "Зөвийг Шүгэлдэгчид" ТББ-аас гадаадад ажиллаж, амьдарч буй монголчууддаа зориулан хэрэгжүүлж буй "Дэлхийн Монголчуудын төгөл" төсөлд Сэндли ББСБ ХК нь хамтран ажиллаж байна.

### Хорт хавдрын эсрэг аян



Нийгмийн хариуцлагын хүрээнд Үнэт цаас гаргагч нь зээлийн хүүгийн орлогын 1.0 хувийг хавдрын эсрэг сайн үйлсийн аян болон хавдрын эсрэг эмч мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэхэд зориулдаг. Энэ хүрээнд Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, Эрүүл хүнс, хавдаргүй иргэн ТББ, "Элэг нэгт монголчууд" ТББ-н тэргүүн Ж.Чинбүрэнтэй хамтран ажиллаж байна. Эрүүл хүнс, Хавдаргүй иргэн төрийн бус байгууллагаар дамжуулан "Монгол улсад амьд донороос элэг шилжүүлэн суулгах төсөл"-д нийт 124.8 сая төгрөг хандивлаж, 9 хүний алтан

амийг аврах үйлсэд хувь нэмэр оруулжээ. Мөн түүнчлэн Хавдар судлалын үндэсний төвийн 49 эмч, ажиллагсдыг гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахад зардлыг бүрэн хариуцсан байна.

## Монголын Аутизмын холбооны хамтын ажиллагаа



Үнэт цаас гаргагч нь 2021 оны 6 дугаар сард Монголын аутизмын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд 2021 онд мөнгөн гуйвуулгын шимтгэл бүрт 1000 төгрөг, 2022 онд мөнгөн гуйвуулгын гүйлгээний шимтгэлийн орлогын 2 хувийг уг холбоонд хандивлаж олон нийтэд аутизмыг таниулах, ойлгуулах, боловсролын хүртээмж, сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлд дэмжин ажилласан байна.

## Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа




Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 10 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж буй Лантуун дохио ТББ-ийн жил бүр зохион байгуулдаг "Ид шидийн уут" 2022 арга хэмжээнд оролцож, алслагдсан дүүргүүдийн 100 хүүхдэд дулаан хувцас, гарын бэлгийг хүргэж ажиллаа.

## Олон нийтийн эрүүл мэнд, биеийн тамирын үйл ажиллагаа




"Улаанбаатар Марафон 2022" олон улсын гүйлтийн тэмцээнд Сэндли ББСБ ХК нь ивээн тэтгэгчээр хамтран ажилласан бөгөөд энэхүү арга хэмжээнд 20 мянга гаруй хүн бүртгүүлж, тэдний дотор Монгол Улсын нэр хүндтэй тамирчид болон гадаадын 26 орны 150 гаруй гүйгч, тамирчид оролцсон юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
СЗХ БҮРТГЭВ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## Шагнал урамшуулал




Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны 2020 оны "Шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээтэй ББСБ" болж "Алтан од" цомыг хүртсэн юм.



2021 оны 12 дугаар сард "Global Banking & Finance Review" сэтгүүлээс жил бүр тодруулдаг "Fastest Growing FinTech Company In Central Asia 2021" буюу "Төв Азийн хамгийн хурдацтай хөгжиж буй Финтек компани 2021" шагналыг "Sendly" аппликейшн хүртсэн юм.




2021 оны 12 дугаар сард Монгол Улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулж, бизнесийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн шилдгүүдийг тодруулдаг "Bloomberg TV Mongolia Awards"-с High Payment Solutions маань амжилттай оролцож "Best Solution Of The Year" шагналын эзэн болсон.



2021 оны 12 дугаар сард "Forbes Mongolia Finance Awards 2021"-ийн "Шилдэг мөнгөн гуйвуулгын аппликейшн" шагналыг хүртсэн.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
ТГЭВ-02

# 1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 1.5.1 2022.10 САРЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГСӨН АУДИТЫН ДҮГНЭЛТ

**“Шонхор үнэлгээ аудит” ХХК нь “Сэндли ББСБ” ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн тайланд аудит хийж дараах дүгнэлтийг гаргасан байна.**

**Бид “Сэндли ББСБ” ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, сонгон авсан тайлбар тодруулгад аудит хийлээ. Бидний дүгнэлтээр “Сэндли ББСБ” ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.” хэмээн дүгнэсэн байна.**

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын компаниас гаргасан “Аудитын дүгнэлт”-ээс уншиж танилцана уу.

**Мөн “Шонхор үнэлгээ аудит” ХХК нь “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, тодруулгад аудит хийлээ. Бидний дүгнэлтээр “Сэндли ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.” гэж дүгнэжээ.**

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Аудитын компаниас гаргасан “Аудитын дүгнэлт”-ээс уншиж танилцана уу.

## 1.5.2 СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Хүснэгт 8: Санхүү байдлын тайлан

| Мянган төгрөг | 2019 | 2020 | *2021* | 2022.10* |
|---|---|---|---|---|
| | | Хөрөнгө | | |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 1,403,679 | 1,812,909 | 10,395,001 | 27,753,501 |
| Мөнгөн хөрөнгө | 33,467 | 925,009 | 1,169,363 | 6,175,961 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэвэр) | - | - | - | 1,252,427 |
| Нийт зээл | 1,061,134 | 707,053 | 8,608,223 | 16,334,168 |
| *Зээлийн эрсдэлийн сан* | (44,000) | (44,000) | (7,793) | (731,588) |
| Бусад авлага | 353,078 | 221,145 | 505,485 | 4,020,796 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | - | 3,701 | 119,722 | 701,736 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 447,050 | 76,528 | 209,635 | 352,793 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 25,213 | 16,678 | 168,745 | 201,675 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | 344,287 | 59,850 | 40,890 | 151,118 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 77,549 | - | - | - |

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

| | | | | |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,850,729 | 1,889,437 | 10,604,636 | 28,106,294 |
| Өр төлбөр ба эздийн өмч | | | | |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 467,415 | 333,839 | 3,457,431 | 7,678,598 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 467,415 | 333,839 | 3,457,431 | 7,678,598 |
| Богино хугацаат өр төлбөр | - | - | 100,000 | 1,812,575 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | - | - | 2,580,000 | 5,238,448 |
| Мөнгөн гуйвуулгын өглөг | - | - | 726,844 | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 467,415 | 333,839 | 50,587 | 627,574 |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | - | - | - | - |
| ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | 1,383,314 | 1,555,599 | 7,147,205 | 20,427,697 |
| Энгийн хувьцаа | 1,428,500 | 1,428,500 | 6,428,500 | 7,828,500 |
| Бусад хөрөнгө | - | - | - | 9,634,800 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (45,186) | 127,099 | 718,705 | 2,944,660 |
| Нийгмийн хөгжлийн сан | - | - | - | 19,737 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | 1,850,729 | 1,889,437 | 10,604,636 | 28,106,294 |

Хүснэгт 9: Орлого үр, дүнгийн тайлан

| Мянган төгрөг | 2019 | 2020 | 2021 | 2022.10* |
|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 119,562 | 444,601 | 558,316 | 3,041,995 |
| Хүүгийн зардал | - | - | 1,437 | 362,579 |
| Цэвэр хүүгийн орлого | 119,562 | 444,601 | 556,879 | 2,679,416 |
| Хүүгийн бус орлого | 601 | 328,768 | 1,808,592 | 6,083,893 |
| Арилжааны цэвэр орлого | - | 286 | 69,771 | 166,486 |
| Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого | 339 | 248,333 | 241,172 | 1,385,022 |
| Санхүүгийн үйлчилгээний шимтгэл | 262 | 80,149 | 1,497,649 | 4,532,384 |
| Хүүгийн бус зардал | 346,457 | 537,273 | 1,706,888 | 5,661,529 |
| Болзошгүй эрсдэлийн зардал | - | - | 7,793 | 723,795 |
| Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал) | (226,294) | 236,097 | 650,790 | 2,377,985 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | - | 222 | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 4,043 | 30,806 | 30,346 | 66,992 |
| Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал) | (230,337) | 205,513 | 620,444 | 2,310,993 |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | (230,337) | 205,513 | 620,444 | 2,310,993 |
| Орлогын татварын зардал | - | 12,906 | 45,236 | 249,831 |
| **Цэвэр ашиг (алдагдал)** | (230,337) | 192,607 | 575,208 | 2,061,162 |

СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР

ХК
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

Хүснэгт 10: Мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөг | 2019 | 2020 | 2021 | 2022.10* |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (226,524) | 254,384 | 274,701 | 2,054,718 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 119,824 | 773,370 | 2,199,392 | 9,125,888 |
| Зээлийн хүүгийн орлого | 119,480 | 444,575 | 558,316 | 3,040,665 |
| Гадаад валютын арилжааны орлого | - | 286 | 59,386 | 166,486 |
| Гадаад валютын ханшийн зөрүү | - | - | 84,041 | 1,385,022 |
| Мөнгөн гуйвуулгын орлого | | 80,149 | 260,028 | 237,566 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 262 | - | 1,237,622 | 4,284,596 |
| Бусад үндсэн үйл ажиллагааны орлого | 82 | 248,359 | - | 11,551 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 346,348 | 518,986 | 1,924,691 | 7,071,170 |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | - | - | - | 362,579 |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 118,372 | 112,184 | 380,426 | 1,074,334 |
| Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж | - | 375 | - | 2,387 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 11,637 | 5,723 | 43,510 | 133,419 |
| Албан томилолт, сургалтын зардал | | 978 | 8,545 | 31,659 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | | - | 131,949 | 176,270 |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 8,880 | 4,250 | 47,544 | 62,273 |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал | 2,654 | 1,198 | 14,416 | 34,612 |
| Татвар, даатгалын төлсөн мөнгө | 20,322 | 1,000 | - | 957 |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 790 | 10,949 | 176,223 | 429,746 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | - | 9,851 | 275 | 100 |
| Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө | - | - | 27,826 | 839,253 |
| Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарах мөнгө | - | 9,000 | - | - |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | 150,097 | 256,341 | 275,647 | 280,656 |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 1,980 | 2,320 | - | 4,100 |
| Ногдол ашгаар олгосон мөнгө | - | - | - | - |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 31,616 | 104,817 | 818,329 | 3,638,824 |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 253,986 | 637,158 | (30,346) | (66,992) |

СЭНДЛИ ББСБ ХК
Sandly
УЛААНБААТАР ХОТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого | 258,029 | 667,964 | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага | 4,043 | 30,806 | 30,346 | 66,992 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 27,463 | 891,542 | 244,354 | 1,987,726 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,005 | 33,467 | 925,009 | 4,188,236 |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **33,467** | **925,009** | **1,169,363** | **6,175,961** |

**Тайлбар: Санхүүгийн тайлан нь оронгийн нарийвчлалаас шалтгаалан 1,000.0 төгрөгөөс доош дүнгээр зөрж болно.*

## 1.5.3 АШИГТ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ

Компанийн үндсэн үйл ажиллагаа буюу мөнгөн гүйвуулга, арилжаа болон зээлийн үйл ажиллагааны нийт цэвэр орлогын хэмжээг өмнөх оны эцэстэй харьцуулахад 2022 оны 10 дугаар сарын байдлаар 3.7 дахин буюу 6.4 тэрбумаар нэмэгджээ. Үндсэн үйл ажиллагааны орлого ийнхүү өсөхөд үнэт цаас гаргагчийн итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэр 122.1 хувиар буюу 3.1 тэрбум төгрөөр өссөн болон банк, санхүүгийн байгууллагаас татсан санхүүжилт 1.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

График 14: Үндсэн үйл ажиллагааны нийт цэвэр орлогын бүтэц




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Цэвэр ашгийн үзүүлэлт 2022 оны 10 дугаар сарын байдлаар 2,061.2 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны жилийн эцсээс 258.3 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт эх үүсвэрийн хэмжээ өнгөрсөн оноос 165.0 хувиар өсөж санхүүжилтийн хэмжээ өргөжсөнтэй холбоотой юм. (Тайлбар: 2022 оны компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг тус оны 10 дугаар сарын байдлаарх аудитлагдсан санхүүгийн гүйцэтгэлээр тооцов.)

СЭХ
Он сар өдөр
2023
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 15: Цэвэр ашиг ба нийт цэвэр орлогын харьцуулалт




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Нийт хөрөнгийн өгөөжийг 2021 оны жилийн эцсийн тайланд үндэслэн тооцоход 7.3 хувь буюу компанийн нийт хөрөнгийн ашиглалт 2020 оноос 2022 оны 10 дугаар сар хүртэл дунджаар 7.7 хувь байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшин энэ оны эхний 10 сарын байдлаар 10.1 хувь болж өссөн нь цэвэр ашгийн дүн 2021 оны жилийн эцсээс даруй 258.3 хувиар өссөнтэй холбоотой юм.

График 16: Нийт хөрөнгийн өгөөж ба өөрийн хөрөнгийн өгөөж, хувиар




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 10 дугаар сарын байдлаар Сэндли ББСБ-ын цэвэр хүүгийн орлогын ахиуц 13.8 хувьд хүрч, 2021 оны жилийн эцсээс 4.9 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Цэвэр хүүгийн орлогын ахиуц өсөхөд Монголбанкнаас бодлогын хүүг 6.0 хувиас нэг дахин өсгөж 13.0 хувьд хүргэсэн нь хүүгийн орлогыг нэмэгдүүлжээ.

СЭХ
БҮРТГЭВ
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 17: Цэвэр хүүгийн орлогын маржин




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

## 1.5.4 ЗЭЭЛИЙН АКТИВЫН ЧАНАР БА ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

Компанийн цэвэр зээлийн багц нь 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт хөрөнгийн 55.5 хувийг бүрдүүлж байна. Тус хугацаанд нийт зээлийн багцыг 13.8 тэрбум төгрөгийн хэвийн зээл, 0.8 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 1.7 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн багц тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн эзлэх хэмжээ өссөн нь авлага цуглуулалт удаашралтай байгааг харуулах хэдий ч, жилийн эцэс ойртоход зээлдэгчдийн баярын улирал дахь борлуулалтын орлого нэмэгдэж зээлийн эргэн төлөлт эргэн сайжирдаг байна.

График 18: Зээлийн активын чанар




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

СЭХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

Эрсдэлийн санг чанаргүй зээлийн хэмжээнд харьцуулсан харьцаа нь тухайн зээл олгогчийн чанаргүй зээлийн болзошгүй эрсдэлээс хэр сайн урьдчилсан сэргийлж байгаа түвшинг илтгэдэг. Компанийн хувьд эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа 2022 оны 10 дугаар сарын эцэст 41.9 хувь байна. Зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 731.6 сая төгрөгт хүрч 2021 оны жилийн эцсээс 93.8 дахин өсчээ.

График 19: Зээлийн эрсдэлийн сан




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

## 1.5.5 ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ БА САНХҮҮГИЙН ХӨШҮҮРЭГ

График 20: Өрийн эх үүсвэрийн бүтцийн өөрчлөлт




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

СЭХ БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

2022 оны 10 дугаар сарын байдлаарх өрийн эх үүсвэрийн бүтцэд итгэлцлийн үйлчилгээний өглөг 68.2 хувь буюу 5.2 тэрбум төгрөг, банк, санхүүгийн байгууллага дахь богино хугацаатай өр төлбөрийн дүн 23.6 хувь буюу 1.8 тэрбум төгрөг, бусад өглөг 8.2 хувь буюу 0.6 тэрбум төгрөгийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 11: Өр төлбөрийн харьцаа үзүүлэлт

| Харьцаа үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 | 2022.10* |
|---|---|---|---|---|
| Санхүүгийн хөшүүрэг, (Өр төлбөр**/Эздийн өмч) | 0.0% | 0.0% | 37.5% | 34.5% |
| Нийт хөшүүрэг, (Нийт хөрөнгө/Эздийн өмч) | 133.8% | 121.5% | 148.4% | 137.6% |
| Өр төлбөрийн хувь, (Нийт өр төлбөр/Эх үүсвэр) | 25.3% | 17.7% | 32.6% | 27.3% |

*Тайлбар: **-Өр төлбөр гэдэгт итгэлцэл ба богино хугацаат банк, санхүүгийн байгууллагын зээлийг оруулж тооцов.*

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Санхүүгийн хөшүүрэг 2022 оны 10 дугаар сард буурсан нь эздийн өмчийн дүн 7.1 тэрбум төгрөгөөс 185.8 хувиар өсөж 20.4 тэрбум төгрөгт хүрсэнтэй холбоотой юм. Эздийн өмчийн энэхүү өсөлт нь хувьцаат капиталын 21.8 хувиар буюу 1.4 тэрбум төгрөгөөр, бусад өөрийн хөрөнгө 9.6 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

График 21: Нийт хөрөнгийн бүтэц, эх үүсвэр талаас




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

Сэндли ББСБ-ын нийт хөрөнгө 2019 оноос хойш тасралтгүй өсөөр 1.8 тэрбум төгрөгөөс 2022 оны 10 дугаар сарын байдлаар 28.1 тэрбум төгрөгт хүрч 15.1 дахин нэмэгджээ. Энэхүү өсөлтөд эздийн өмч өмнөх оны эцсээс 2.8 дахин өссөн нь нөлөөлж, тус компанийн эх үүсвэрийн бүтцэд өөрийн хөрөнгийн хэмжээ давамгайлж байна. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 9 дүгээр сард олон нийтэд хувьцаагаа санал болгож 10.05 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь эздийн өмч, зээлийн багц, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өсгөжээ.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

## 1.5.6 МӨНГӨН УРСГАЛ БА ХӨРВӨХ ЧАДВАР

График 22: Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ




Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

2021 онд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын 25.4 хувийг зээлийн орлого эзэлж байсан бол 2022 оны 10 дугаар сард 2.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3.0 тэрбум төгрөгт хүрчээ. Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого өнгөрсөн оны эцсээс 3.5 дахин өсөж нийт үндсэн мөнгөн орлогын 4.2 тэрбум төгрөгийг бүрдүүлж байна. Мөн гадаад валютын ханшийн зөрүүний мөнгөн орлого 1.4 тэрбум төгрөг бөгөөд үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын 15.2 хувь юм.

График 23: Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний задаргаа, (сая төгрөг)




СЭНДИ ББСБ ХК 9022121175 УЛААНБААТАР

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## 1.5. САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 12: Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, 2022 оны 10 дугаар сар | Байвал зохих | Утга | Биелсэн эсэх |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 79.2% | Тийм |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 79.3% | Тийм |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 72.6% | Тийм |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 87.6% | Тийм |
| Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт | | | |
| Хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү, -дутуу) | 733,097.1 | 731,587.6 | (1,509.6) |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 1.3% | Тийм |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 4.7% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх захирал, ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 4.7% | Тийм |
| Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 6.1% | Тийм |
| Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Гадаад валютын ханшийн эрсдэл | | | |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | 17.1% | Тийм |
| Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 25.6% | Тийм |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Үндсэн хөрөнгийн үзүүлэлт | | | |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 0.7% | Тийм |
| Өгөөж | | | |
| Хөрөнгө (актив)-ийн өгөөж | | | 13.5% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | | 18.7% |

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

## ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Өөрийн хөрөнгийн үзүүлэлт нь банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй байгаа эсэхийг тодорхойлсон үнэлгээ илэрхийлэх ба компанийн хувьд 2022 оны 10 дугаар сарын байдлаар хангалттай үнэлгээтэй байна.

## ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлдэг. Тус үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулж тооцдог. Үнэт цаас гаргач нь 2022 оны 10 дугаар сард энэхүү харьцааг зохих түвшинд хангаж байна.

## АКТИВЫН ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Актив хөрөнгийн эрсдэл гэдэг нь тухайн активыг нэг этгээдэд их хэмжээгээр төвлөрүүлснээр хүү, төлбөрийг эргүүлэн төлөх чадахгүйд хүрэхэд учрах эрсдэлийг томьёолдог. Тус эрсдэлийн улмаас банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн хүндрэлд орох эрсдэлтэй байдаг ба тус үзүүлэлтийг үнэт цаас гаргагч бүрэн хангаж ажиллаж байна.

## ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ

Гадаад валютын ханшийн эрсдэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэл юм. Үнэт цаас гаргагчийн хувьд гадаад валютын актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа нь бүрэн хангагдаж байна.

## БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн байгууллага нь бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэхдээ санхүүгийн хөшүүргийг зүй зохистой түвшинд, эрсдэлийн тодорхой хязгаарлалтан дунд ашиглах ёстой байдаг. Өрийн бичиг буюу компанийн бонд болон итгэлцлийн

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

үйлчилгээ нь ББСБ-ын эх үүсвэр бүрдүүлэх банкнаас ялгарах гол суваг болдог. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн зохистой харьцаануудаас дүгнэхэд компани нь өрийн бичиг гаргаж санхүүжилт татах орон зай өндөр байна.

### ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Банк, санхүүгийн байгууллага нь өөрийн хөрөнгийн бүтэц, төрөлжүүлэлтээ зохион байгуулахдаа хөрвөх чадвараа хадгалж байхыг эрмэлздэг. ББСБ-ын хувьд үндсэн хөрөнгөд хэт их хөрөнгөө байршуулах нь богино хугацаанд түргэн борлогдох хөрөнгийн хувь хэмжээг багасгаж эрсдэл үүсгэдэг. Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгөө зохистой харьцаанд бүрдүүлж чадсан байна.

Үнэт цаас гаргагч Сэндли ББСБ нь 2022 оны 9 дүгээр сард хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар 10.05 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн. Энэхүү үйл явдал нь компанийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, СЗХ-ноос тавьж буй өр төлбөрийн эрсдэлийг даах чадамжийг өсгөсөн ба энэ хэрээр өрийн бичиг, итгэлцлийн үйлчилгээний цар хүрээгээ тэлж эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна.

## 1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Хуулийн дүгнэлтийн хэсгээс:

### Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:

Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 31 хэлцэл хийсэн бөгөөд тус гэрээнүүдээс 11 хэлцэл хэрэгжиж дууссан, 20 хэлцэл дүгнэлт гаргах өдрийн байдлаар бүгд хэвийн хэрэгжиж байгаа ба ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна.

### Их хэмжээний хэлцлийн талаар:

Компанийн их хэмжээний хэлцлийн хувьд нийт 2 хэлцэл одоогоор хэрэгжиж байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй болно. Үнэт цаас гарагч нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах талаар Компанийн тухай хуульд заасан журмыг мөрдөж ажилласан гэж дүгнэв.

### Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний талаар:

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 8 гэрээ байгуулсан. Тэдгээрээс 1 хэлцэл хэрэгжиж дууссан бөгөөд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг оруулан нийт 7 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## 1.7 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 дугаартай тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг баталсан байна. Тус эрх зүйн баримт бичигт эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, зорилт, үндсэн зарчим, төрөл, ангилал, хэрэгжүүлэх үе шат, шинжилгээ, тайлагнал, хяналт хариуцлагын талаар тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд "Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх журам" болон "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр"-ийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 06 тоот тогтоолоор, "Дотоод хяналтын үйл ажиллагааны журам"-ыг Гүйцэтгэх захирлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталсан байна.

Дотоод хяналт шалгалтыг газар дээрх болон зайны гэсэн хэлбэрээр зээл, нягтлан бодох бүртгэл, салбарын үйл ажиллагаа, мэдээлэл технологи, комплаенс, бусад гэсэн хүрээнд гүйцэтгэж байна.

Сэндли ББСБ нь Covid-19 цар тахлын тархалт, дэгдэлтийн хугацаанд зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд болон ББСБ-д учирч болох эрсдэлийг тооцон түүний сөрөг нөлөөг бууруулах, зайлсхийх эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Байгууллагын дотоод сүлжээ, серверт зайнаас хандаж онлайн горимоор ажиллах боломжийг fortclient программ ашиглан орон нутгийн бүх салбар, нэгжийн хүрээнд бүрдүүлсэн.
- Гамшгаас хамгаалах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан бүх нэгжид мөрдүүлсэн.
- 2021 онд нийт 295 мерчант зээлийн нэмэгдүүлсэн хүүг тэглэсэн.
- Цар тахлын нөлөө, барааны хомсдол, тээврийн үнийн өсөлт зэргээс шалтгаалан зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа доголдсон, зээлийн гэрээний хугацаа сунгах хүсэлт гаргасан 74 зээлдэгчийн 210 сая төгрөгийн зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсан.

Сэндли ББСБ-ын зээлийн эрсдэлийн бодлогын хүрээнд нэг зээлдэгчид олгох зээлийн дээд дүнг бага байлгах, төвлөрлийн эрсдэлийг боломжит доод түвшинд барих бөгөөд 2022 оны 10 дугаар сарын байдлаар нэг зээлдэгчид ногдох зээлийн дүн 2.8 сая төгрөг байна. Чанаргүй зээлийн эзлэх хувь 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт зээлийн багцын 10.7 хувийг эзэлж байна.

он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 2019 оноос хойш бүрэн хангаж ажиллажээ.

Хүснэгт 13: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

| Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт | Байвал зохих | 2019 | 2020 | 2021 | 2022.10* |
|---|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, Эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 69.40% | 72.80% | 70.60% | 79.2% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 69.40% | 72.80% | 70.60% | 79.30% |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 74.50% | 82.30% | 67.40% | 72.60% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 8% | 277% | 34.00% | 87.60% |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 19.80% | 17.40% | 4.20% | 1.30% |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ Гүйцэтгэх Захирал ажилтан, Холбогдох нэг Этгээдэд олгосон зээл, адилтан тооцох актив, бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 2.50% | 0.00% | 0.00% | 4.70% |
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | 2.20% | 54.20% | 4.70% | 17.10% |

Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан

## Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг:

“Сэндли ББСБ” ХК нь эрсдэлийг тодорхойлохдоо өөрийн стратегийн хэрэгжилт, үйл ажиллагаанд тодорхойгүй сөрөг байдал үүсэх магадлал болон түүний нөлөөллөөр хэмжихээр тогтоожээ.

Эрсдэлийг удирдахдаа хараат бусаар үнэлгээ хийх, тогтмол сайн тайлагналтай байх, байнга сайжруулалт хийж байх, эрдсэл нь хэмжигдэхүйц байх, баримтжуулсан байх зэрэг зарчмыг мөрдөнө.

## Эрсдэлийн төрөл, тэдгээрийг удирдах зарчим

“Сэндли ББСБ” ХК-ийн үйл ажиллагаанд учирч болох үндсэн эрсдэлүүдийг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

### Зээлийн эрсдэл:

Зээлийн үйл ажиллагаанаас учрах эрсдэл болон хүлээгдэх өгөөжийг хамгийн оновчтой түвшинд байлгахад зээл төлөгдөхийг баталгаажуулсан хангалттай нотолгоо, итгэл үнэмшлийг олж авсны эцэст зээлийг олгох, аливаа зээлийн

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

чанар муудах нөхцөл байдлыг эрт илрүүлэх, эрсдлийн шинжилгээг хараат бусаар хийх, зээлийн багцыг тархаан байршуулах зэрэг зарчмыг баримтлана.

### Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэх хохирлыг хамгийн бага түвшинд барин ажиллана. Ингэхдээ зах зээлийн өөрчлөлтийг ажиглаж, мэдрэх, мэдээллийн тасралтгүй солицох урсгалыг компани дотроо бий болгох, тогтоосон хязгаарт эрсдэлийг хамгийн бага түвшинд барьж ажиллахыг эрмэлзэнэ. Эрсдэлийн түвшин зөвшөөрсөн хязгаараас давсан тохиолдолд залруулах арга хэмжээг шуурхай авна. Зөвшөөрсөн эрсдэлийн хязгаарт хяналтыг байнга тавьж, тайлан боловсруулж эрх бүхий албан тушаалтанд тогтмол танилцуулна.

### Үйл ажиллагааны эрсдэл:

Ажилтны санаатай, санамсаргүй үйлдэл, дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам, заавар, мөн автоматжуулсан системийн доголдол, гадаад хүчин зүйлийн сөрөг нөлөөллийн улмаас хохирол хүлээх эрсдэлийг тодорхойлжээ. Уг эрсдэлтэй холбогдох удирдлагын хэрэгжүүлэхдээ ажилтан бүр, нэгж, алба тус бүр эрдэлийг цаг алдалгүй илрүүлэх, бүртгэх, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авч ажиллана.

### Хөрвөх чадварын эрсдэл:

Энэ төрлийн эрсдэлийн гол удирдлагын хувьд зах зээлийн хэвийн, хэвийн бус нөхцөлд аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн бүрэн гүйцэтгэж чадахуйц бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийн зохистой нөөцтэй байх, түүнчлэн компанийн ашигт ажиллагааг зохистой түвшинд барихад анхаарна.Хөрвөх чадварыг богино, дунд, урт хугацаанд ангилж шинжлэх, макро эдийн засгийн судалгаа, хүндрэл учирсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, шаардлагатай үед шинэчилж ажиллана.

### Нэр хүндийн, стратегийн болон комплаенсийн эрсдэл:

Компанийн нэр хүндэд хохирол учруулж, улмаар санхүүгийн тайланд сөрөг нөлөө үүсэх эрсдэлийг хүндийн эрсдэл хэмээн хэлэх бөгөөд ажилтан бүр ёсзүйн дүрмийг чандлан дагаж, харилцагчтай харилцах харилцаа, үйлдэл, үйл ажиллагааг хянаж компанийнхаа нэр хүндийг ямагт хамгаалах үүрэгтэй.

Байгууллагын нөөцийг үр ашиггүй зарцуулснаас үүдэх бизнесийн болон үйл ажиллагааны зорилгодоо хүрч чадахгүйд хүрэх, бизнес төлөвлөгөөний хэрэгжилт тааруу, зах зээлийн өөрчлөлттэй дасан зохицох чадвар бага

он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

зэргээс үүдэн бизнесийн өсөлт буурах, алдагдал хүлээх эрсдэлийг стратегийн эрсдэлд хамааруулна.

Компанийн үйл ажиллагаанд хамаарах, мөрдөгддөх хууль тогтоомж, журам, зааварт нийцүүлж үйл ажиллагаа явуулах чадамж алдагдах эрсдэлийг комплаенсийн эрдэл гэж ойлгох бөгөөд эрсдэл, хяналтын тогтолцоонд хамгаалалтын гурван шугамын загварыг үйл ажиллагаанд мөрдлөг болгоно.

## Эрсдэлийн удирдлагын процесс:

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| Эрсдэлийг тодорхойлох | Эрсдэлийг үнэлэх | Эрсдэлийг удирдах | Хяналт |

## Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт

Эрсдэлийн удирдлагыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), Дотоод хяналт шалгалтын чиг үүрэг хариуцсан албан тушаалтан, Гүйцэтгэх удирдлага болон компанийн бусад ажилтнууд дараах байдлаар хэрэгжүүлнэ.

## Хяналт, хариуцлага

1. Компанийн үйл ажиллагаанд гарч болох эрсдэлийг бууруулах зорилгоор шат дараалсан болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хяналтыг компанийн холбогдох албан тушаалтнууд батлагдсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэнэ.

2. Компанийн ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, бодлого, журам, заавар, гарын авлага, аргачлалын дагуу ажил үүргээ гүйцэтгэж үнэнч шударгаар ажиллана. Мөн компани хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтална.

3. Компанийн ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, банкны хэмжээнд хэрэглэж буй журам, заавар, компанийн газар, нэгжийн дотоод үйл ажиллагааны журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон ажилтны ажлын байрны тодорхойлолтоор зохицуулна.

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# 1.8 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын №22/03 дугаартай тогтоолын хавсралтаар баталсан “Ногдол ашгийн бодлого”-ын баримт бичигт дараах агуулгыг тусгасан байна.

## Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна;
- Компани дор дурдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
    - ✓ компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
    - ✓ шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар байдал;
    - ✓ ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
    - ✓ ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
    - ✓ компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;
    - ✓ Компанийн дүрэм, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан тусгай зориулалтын сангуудад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа;
- Компани нээлттэй хувьцаат компани болсон үеэс хойш нэг жилийн дараагаас эхлэн ТУЗ-ийн тогтоолоор татварын дараах цэвэр ашгийн 20 болон түүнээс дээш хувийг ногдол ашиг болгон хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

## Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр төлж болно.
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.

СЭНДЛИ ББСБ ХК

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10

- Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгана.
- Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбарлана.

## Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө.
- Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК дахь хувьцаа эзэмшигчийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

СЭНДЛИ ББСБ ХК Sendly

Sendly

НЭЭЛТТЭЙ БОНД

# Хоёр.

# Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

# 2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2.1.1 МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Улсын зээлжих зэрэглэл гэдэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон зээллэгийн хүүгийн болон үндсэн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм. Олон улсад Эс энд Пи (S&P), Фитч (Fitch), Мүүдис (Moodys) гэсэн зэрэглэл тогтоогч 3 агентлаг нийт зах зээлийн 95 орчим хувийг хамран үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 1999 оноос эхлэн Сангийн яам болон Монгол банкны зүгээс олон улсад нэр хүндтэй, бие даасан зээлжих зэрэглэл тогтоогч S&P Global Ratings, Fitch Ratings болон Moody's Investors Service агентлагуудтай гэрээ байгуулсны үндсэн дээр тогтоолгож эхэлсэн.

Сүүлийн байдлаар манай улсын зээлжих зэрэглэлийг S&P болон Fitch агентлаг нар B тогтвортой, Moody's агентлаг B3 тогтвортой хэмээн үнэлж байгаа нь хөрөнгө оруулалтын эрсдэлтэй зэрэглэлд ангилагдаж буйг харуулж байна.

Хүснэгт 14: Монгол Улсын зээлжих зэрэглэл

| Ангилал | | S&P | Moody's | Fitch |
|---|---|---|---|---|
| Хамгийн өндөр зэрэглэл | Хөрөнгө оруулахад тохиромжтой ангилал | AAA | Aaa | AAA |
| Өндөр зэрэглэл | | AA+ | Aa1 | AA+ |
| | | AA | Aa2 | AA |
| | | AA- | Aa3 | AA- |
| Төлбөрийн өндөр чадамжтай | | A+ | A1 | A+ |
| | | A | A2 | A |
| | | A- | A3 | A- |
| Төлбөрийн чадамжтай | | BBB+ | Baa1 | BBB+ |
| | | BBB | Baa2 | BBB |
| | | BBB- | Baa3 | BBB- |
| Эрсдэлтэй | Эрсдэлтэй ангилал | BB+ | Ba1 | BB+ |
| | | BB | Ba2 | BB |
| | | BB- | Ba3 | BB- |
| Өндөр эрсдэлтэй | | B+ | B1 | B+ |
| | | **B** | B2 | **B** |
| | | B- | **B3** | B- |
| Маш өндөр эрсдэлтэй | | CCC+ | Caa1 | CCC+ |
| | | CCC | Caa2 | CCC |
| | | CCC- | Caa3 | CCC- |
| Дампуурхад ойр | | CC | Ca | CC |
| | | | | C |
| Дампуурсан | | SD | C | SD |
| | | D | | DD |
| | | | | D |

Эх сурвалж: S&P, Moody's, Fitch агентлагуудын вэб сайт

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Түүхэн өгөгдлийг авч үзвэл S&P агентлаг 2007-2013 онуудад Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хамгийн өндөр буюу "BB-" түвшинд үнэлж байсан. Харин 2016-2017 онд Moody's агентлаг түүхэндээ хамгийн муу буюу "Caa1" түвшинд үнэлж байжээ. 2018 оноос хойш манай улсын зээлжих зэрэглэл одоогийн байгаа түвшинд тогтвортой хадгалагдсаар байна.




Эх сурвалж: Монгол банк

## 2.1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хүснэгт 15: Монгол Улсын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | нэгж | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022.III |
|---|---|---|---|---|---|---|
| Үндэсний тооцоо | | | | | | |
| ДНБ, оны үнээр | их наяд төг | 32.4 | 36.8 | 36.9 | 43.5 | 35.2 |
| ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр | их наяд төг | 26.4 | 27.9 | 26.6 | 27 | 20.2 |
| ДНБ-ний бодит өсөлт | хувь | 7.70% | 5.60% | -4.60% | 1.50% | 3.7% |
| Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр | сая төг | 10.3 | 11.6 | 11.4 | 12.6 | 14.3 |
| | | | | | | |
| Мөнгө санхүү | | | | | | |
| Мөнгө M1 | их наяд төг | 4 | 3.9 | 4.1 | 6.5 | 6.2 |
| Мөнгө M2 | их наяд төг | 19.4 | 20.8 | 24.2 | 27.8 | 27.5 |
| Нэгдсэн төсвийн орлого | их наяд төг | 10 | 11.9 | 10.4 | 14.2 | 12.5 |
| Нэгдсэн төсвийн тэнцэл | их наяд төг | 0.0 | -0.6 | -4.5 | -2.9 | -0.9 |
| Гадаад валютын албан нөөц | тэрбум ам.дол | 3.5 | 4.3 | 4.5 | 4.3 | 2.9 |
| Засгийн газрын гадаад өр | тэрбум ам.дол | 7.1 | 7.8 | 8.6 | 8.4 | 7.6 |
| Экспорт | тэрбум ам.дол | 7.0 | 7.6 | 7.5 | 9.2 | 8.9 |
| Импорт | тэрбум ам.дол | 5.8 | 6.1 | 5.2 | 6.8 | 6.3 |
| Гадаадын шууд хөрөнгө оруулалт | тэрбум ам.дол | 2.7 | 3.1 | 2.6 | 2.7 | 1.3* |
| | | | | | | |
| Хүүгийн түвшин | | | | | | |
| Бодлогын хүү | % | 11.00% | 11.00% | 6.00% | 6.00% | 13.00% |
| Инфляцийн түвшин | % | 8.10% | 5.20% | 2.30% | 13.40% | 14.50% |
| Хадгаламжийн хүү, жилээр | % | 11.20% | 10.60% | 8.30% | 8.70% | 8.80% |
| Зээлийн хүү, жилээр | % | 16.90% | 16.90% | 15.80% | 14.30% | 15.60% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Төгрөг ам.долларын албан ханш | төг | 2,644 | 2,734 | 2,849 | 2,849 | 3,344 |
| | | | | | | |
| Банкны салбар | | | | | | |
| Зээлийн өрийн үлдэгдэл | их наяд төг | 17.2 | 18 | 17.6 | 20.7 | 22.9 |
| Хугацаа хэтэрсэн зээл | % | 4.90% | 4.60% | 7.10% | 4.50% | 5.06% |
| Чанаргүй зээл | % | 10.40% | 10.10% | 11.20% | 9.90% | 11.15% |
| Зээлийн хүү, сараар | % | 1.30% | 1.30% | 1.30% | 1.20% | 1.30% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо

Тайлбар: (*) - 2022 оны 2-дугаар улирлаар тайлагнасан статистик мэдээлэл

## Бодит сектор

Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2020 оны цар тахлын дараа аажмаар сэргэж, 2021 онд 1.6 хувиар өссөн бол 2022 оны эхний есөн сард 3.7 хувь өсчээ. 2022 онд манай улсын эдийн засаг сэргэхэд цар тахлын үед хумигдсан байсан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил эерэгээр нөлөөлсөн.

График 24:Бодит ДНБ-ий өсөлт, (2015 оны зэрэгцүүлэх үнээр)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны эхний есөн сард ДНБ 3.7 хувиар өсөхөд дотоодын хөл хорионы дэглэмийг сулруулж, үйлдвэрлэл үйлчилгээний салбар ковидын өмнөх энгийн цагийн горимоор ажиллах болсон зэрэг Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зохицуулалтын арга хэмжээ суурь нөхцөл болжээ. Тайлант жилийн хоёрдугаар хагаст улсын хэмжээнд барилга угсралтын ажил идэвхждэг, мөн газар тариалан, ургац хураалт, хөдөө аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэл нэмэгддэг учраас эдийн засгийн өсөлт цаашид хадгалагдах төлөвтэй байна.

Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд нам түвшинд хадгалагдах урьдчилсан тооцоог 9 дүгээр сарын тайландаа шинэчлэн танилцуулсан. Тус тайланд дурдсанаар 2022 оны эдийн засгийн

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

өсөлтийг 2.3 хувиас бууруулж 1.7 хувьд хүргэж доошлуулсан. Эдийн засгийн ирээдүйн төлөв байдалд Олон улс дахь эрчим хүчний хямрал, хэрэглээний үнийн өсөлт, тээвэр логистикийн саатал хамгийн их нөлөөлөхөөр байна.

Хүснэгт 16: Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

| Институт | 2022Т |
|---|---|
| Дэлхийн Банк | 2.4% |
| Олон Улсын Валютын Сан | 2.5% |
| Азийн Хөгжлийн Банк | 1.7% |
| Монголбанк | 3.0% |
| Дундаж | 2.4% |

Эх сурвалж: Олон улс болон дотоодын эдийн засгийн институцийн 3-дугаар улирлын тайлан, мэдэгдэл

## Гадаад сектор:

2022 оны эхний 11 сарын байдлаар Монгол Улсын нийт экспорт 11.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны жилийн эцсээс 20.6 хувиар, харин импортын бараа, үйлчилгээ 7.9 тэрбум ам.долларт хүрч 16.1 хувиар өссөн байна. 2022 онд гадаад худалдааны тэнцэл 3.3 тэрбум ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнд олон улсын таваарын зах зээл дээр түүхий эдийн үнэ өндөр байсан нь хил, гаалийн саадаас үүссэн биет хэмжээний бууралтыг нөхсөн байна.

График 25: Гадаад худалдааны нөхцөл, (тэрбум ам.доллар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны эхний арван нэгэн сарын уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал 2.7 хувиар, нүүрс 74.2

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

хувиар, алт 9.3 хувиар тус тус өссөн бол төмрийн хүдэр болон боловсруулаагүй газрын тосны экспорт тус бүр харгалзан 38.1 ба 50.1 хувиар буурчээ. Нүүрсний экспортын борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 119.7 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.2 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 17: Уул уурхайн гаралтай гол нэрийн бүтээгдэхүүний экспорт

| Барааны нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | | Өсөлт | Борлуулалтын орлого, сая ам.доллар | | Өсөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021.I-XI | 2022.I-XI | | 2021.I-XI | 2022.I-XI | |
| Зэсийн баяжмал | мян.т | 1,256.7 | 1,291.0 | +2.7% | 2,835.3 | 2,476.2 | -12.7% |
| Нүүрс | сая.тн | 15.6 | 27.2 | +74.2% | 2,613.6 | 5,743.1 | +119.7% |
| Алт | т | 15.9 | 17.4 | +9.3% | 924.8 | 993.9 | +7.5% |
| Төмрийн хүдэр, баяжмал | мян.т | 7,091.9 | 4,388.4 | -38.1% | 950.6 | 369.9 | -61.1% |
| Боловсруулаагүй газрын тос | мян.барр | 4,348.9 | 2,171.9 | -50.1% | 273.4 | 208.9 | -23.6% |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## Инфляц ба Мөнгөний бодлого:

Монгол Улсын жилийн инфляц 2022 оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 14.5 хувьд хүрээд байна. Монголбанкнаас улирал тутам гаргадаг 9 дүгээр сарын "Инфляцын тайлан"-д дурдсанаар импортын бараа, бүтээгдэхүүний инфляцид үзүүлэх шууд нөлөө нийт үнийн өсөлтийн тал орчим хувийг тайлбарлаж байна. Инфляцын өсөлтөд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд:

- Хил, гаалын хорио цээрийн дэглэм нь импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сааруулж үнэ өсөх нөхцөл болсон
- Ковидын хөл хорио, Украины хямралаас үүдэлтэй эрчим хүчний хомсдол, тээврийн зардал өсөлт нь үнэ өсөхөд шууд нөлөөлсөн
- Ажиллах хүчний зардал, түүхий эдийн хомсдол, үнийн шокууд нь эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-03

График 26: Инфляцын түвшин




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны 2022 оны 9 дүгээр сарын "Инфляцын тайлан"-д инфляцын хүлээлт энэ онд буурч, 2023 онд эргэн өсөх төлөв ажиглагдаж байгааг онцолжээ. 2022 оны инфляцын төсөөлөл буурахад шатахууны үнэ буурсан нь голлон нөлөөлсөн. Ирэх онд хүнсний үнийн өсөлт нэмэгдэх, геополитикийн хурцадмал байдал, импортын барааны үнийн өсөлт нэмэгдэнэ гэх мэт суурь хүчин зүйлс хэвээр хадгалагдахаар төсөөлөгдөж байна. Инфляцын өсөлт нь өрхийн хэрэглээнд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх зорилгоор мөнгөний хатуу бодлогыг Төв банкнаас хэрэгжүүлж байна.

Хүснэгт 18: Инфляцыг өдөөж болзошгүй эрсдэлүүд

| Эрсдэл, тодорхой бус байдал | Магадлал | Нөлөө |
|---|---|---|
| Эрчим хүч, шатахууны үнийн өсөлт нь импортын бараа бүтээгдэхүүний тээврийн зардлыг өсгөж, өртөг нэмэгдсэнээр инфляц өсөх | Өндөр | Өндөр (Өсгөх) |
| Бараа, бүтээгдэхүүний үнэ түүхий эдийн нийлүүлэлтийн тасалдлын улмаас өсөх | Дунд | Өндөр (Өсгөх) |
| Хил, гаалийн хязгаарлалт үргэлжилж, худалдааны эргэлт удааширснаар импортын бүтээгдэхүүний үнэ өсөх | Дунд | Дунд (Өсгөх) |
| Геополитикийн асуудлууд нь түүхий эдийн үнийг өсгөж, улмаар бараа бүтээгдэхүүний үнээр дамжин инфляцыг нэмэгдүүлэх | Өндөр | Өндөр (Өсгөх) |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Энэ онд бодлогын хүүг Монголбанкнаас 5 удаа өсгөсөн бөгөөд оны эхнээс нэг дахин нэмэгдүүлж 13.0 хувьд хүргээд байна. Энэхүү үнийн өсөлттэй тэмцэх мөнгөний хатуу бодлого нь инфляцыг нам дор түвшинд барих бодлогын хэрэгсэл болж байгаа хэдий ч эдийн засгийн өсөлтийг удаашруулах, мөнгөний нийлүүлэлт багасах макро хүчин зүйл болсон. Олон улсын валютын сангийн мэдээллээр 2022 оны Монгол улсын инфляцын төсөөллийг 14.7 хувьд хүрнэ гэж таамаглаж байна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Мөнгөний нийлүүлэлт

2022 оны 3-дугаар улиралд мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өсөж, 27.5 их наяд төгрөгт хүрсэн байна. М2 мөнгөний өсөлтөд валютын хадгаламжийн 10.9 хувиар, валютын харилцах 89.4 хувиар, төгрөгийн харилцах 12.8 хувиар өссөн нь тус тус зэрэг нөлөө үзүүлсэн. Төгрөгийн хадгаламж өнгөрсөн оны 3-дугаар улиралтай харьцуулахад 17.9 хувиар буурсан бол төгрөгийн харилцах данс 12.8 нэгж хувиар өссөн байна.

2022 оны 9 дүгээр сарын эцсийн байдлаар төгрөгийн харилцах оны эхнээс 3.7 хувиар, төгрөгийн хадгаламж 16.4 хувиар буурчээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд валютын хадгаламж 16.3 хувиар, валютын харилцах 74.9 хувиар өссөн нь нөлөөлжээ.

График 27: Мөнгөний нийлүүлэлт, (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 онд макро эдийн засгийн эрсдэлтэй орчноос үүдэж арилжааны банкуудын зээл гаргалт удааширсан нь мөнгөний нийлүүлэлт буурах гол нөхцөл болсон. Мөн ам.долларын эсрэг төгрөгийн ханш оны эхнээс 20.7 орчим хувиар суларсан нь иргэдийн дунд харилцах, хадгаламжаа ам.доллараар байршуулах эрэлтийг нэмэгдүүлж, улмаар төгрөгт итгэх итгэлийг сулруулж байна.

## Төлбөрийн тэнцэл

2022 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 104.4 сая ам.долларын алдагдалтай гарсан ба урсгал дансны тэнцэл 879.8 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 499.6 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

БНХАУ-ын Ковид-19 хөл хорио, хил гаалийн хязгаарлалтын дэглэмүүд нь уул уурхай экспортын хэмжээг бууруулж, төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлж байна. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2022 оны 2-дугаар улиралд өмнөх улирлын 953.6 сая ам.доллараас буурч 104.4 сая ам.долларт хүрсэн. Монгол Улсын экспортын орлого буюу валютын орох урсгалын гол суваг БНХАУ-ын дотооддоо баримталж

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

буй цар тахлын эсрэг бодлого нь манай улсын экспортын орлого, төлбөрийн тэнцлийн алдагдалд шууд нөлөөлж байна.

Дотоодын эрэлт үнийн өсөлтөөс шалтгаалан буурах хандлагатай байгаа хэдий ч импортын үнийн дүн экспортын үнийн дүнгээс хэтээрч, цэвэр дүнгээр валютын гадагш чиглэсэн гарах урсгал өсч байна. Монгол Улсын Засгийн газраас хилийн боомтуудыг үе шаттайгаар нээх, хөрш орнуудын тавьж буй эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах замаар экспортын хэвийн урсгалаа тогтвортой байлгахыг зорьж байна.

График 28: Төлбөрийн тэнцэл, (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

## Валютын ханш:

2022 оны 9 дүгээр сарын байдлаар Гадаад валютын албан нөөц 2,794.6 сая ам.долларт хүрч 2021 оны жилийн эцсээс 35.9 хувиар буурсан байна. 2021 оны 1-дүгээр улиралд Гадаад валютын албан нөөц сүүлийн гурван жилд хамгийн өндөр түвшинд буюу 4,774.6 сая ам.долларт хүрч байсан. Энэ онд Гадаад валютын албан нөөц эрс буурснаар Монголбанкны зүгээс оны эхнээс алт худалдан авалтаа нэмэгдүүлэн, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 19,868.8 кг алт худалдан аваад байна. Тус үзүүлэлт нь өнгөрсөн жилийн мөн үеэс 158.7 кг алтаар буурсан үзүүлэлт болж байна. Экспортын саатал, хил гаалийн хязгаарлалт нь манай улсын экспортоос олох валютын орлого буурахад нөлөөлж байгаа бөгөөд Төв банкнаас ам.долларын эсрэг төгрөгийн ханшийг тогтворжуулах боломжийг улам бүр хумьж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-03

График 29: Гадаад валютын албан нөөц, (сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

Ам.долларын ханш:

2022 онд төгрөгийн ам.доллартой харьцах ханш эрс суларч, 2022 оны 11 дүгээр сарын дундаж ханш оны эхнээс 19.6 хувиар сулраад байна. 2022 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар өмнөх сараас төгрөгийн ам.долларын эсрэг ханш 1.1 хувь суларчээ.

Хятадын юанийн ханш:

Төгрөгийн юаньтай харьцах ханш 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монголбанкнаас зарласан дундаж албан ханш 474.52 төгрөг байсан нь өнгөрсөн сарын мөн үеэс 1.3 хувиар суларсан үзүүлэлт болж байна.

График 30: Валютын сарын дундаж ханш, (төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

### 2.1.3 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 5.4 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 8.4 хувиар буурсан үзүүлэлт юм. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2021 оноос эхлэн 5.0 их наяд төгрөгөөс дээш түвшинд хүрэхэд 2.0 их наяд төгрөг хүртэлх дүн бүхий "Эрдэнэс Тавантолгой" бондын арилжаа, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, компанийн нээлттэй бондууд гэх мэт үнэт цаасны төрлүүд, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт босгох сонирхол нэмэгдсэн нь нөлөөлжээ.

График 31: Зах зээлийн үнэлгээ ба ЗЗҮ/ДНБ харьцаа




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2022 оны 2-дугаар хагас жилд Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны IPO эхэлсэн бөгөөд Төрийн банк нь хөрөнгийн зах зээлээс 25.4 тэрбум төгрөг, Голомт банк 118.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж Монголын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа нээлттэй арилжаалж эхэлсэн. Энэхүү түүхэн үйл явдал нь Монголын хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлсэн. Ирэх онд үлдсэн 3 банк хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалах үйл явц үргэлжлэх учраас хөрөнгийн зах зээлийн арилжааны үнийн дүн өндөр хэвээр байх хүлээлттэй байна.

Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс энэ оны 11 дүгээр сард 34,323 хүрч өмнөх сараас 1.1 хувиар өсчээ. Монголбанкны зүгээс инфляцыг онилсон мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд бодлогын хүүг энэ онд нэг дахин нэмэгдүүлж 13.0 хувьд хүргэсэн нь хувьцааны үнэлгээг бууруулах хүчин зүйл болсон юм. Иймд хөрөнгө оруулагчдын хувьд тодорхой нөхцөлтэй, банкны хадгаламжаас өндөр хүүтэй, татвар бага хөрөнгө оруулалтын хэрэгслийг идэвхтэй сонирхож байна. Компаниудын хувьд Монголын хөрөнгийн бирж дээр хөрөнгө оруулагчдын энэхүү хэрэгцээ шаардлагад тохирсон тогтмол өгөөжтэй үнэт цаасыг амжилттай гаргаж, хөрөнгө оруулалт татсаар байна.

СЭХ
он сар өдөр
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 32: Үнэт цаасны гүйлгээ ба ТОП-20 индекс




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Хөрөнгийн зах зээлийн идэвхжил

2022 оны эхний гурван улирлын Монголын хөрөнгийн биржийн нийт арилжааны дүн 328.5 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны арилжааны дүнгээс буурсан хэдий болович системийн нөлөө бүхий банкууд хувьцаагаа нээлттэй арилжаалах чухал үйл явц эхэлсэн болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, компанийн нээлттэй бондуудын гаргалт нэмэгдэж байна.

График 33: Арилжааны үнийн дүн, (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

СЭНДЛИ ББСБ ХК

СЗХ
он сар өдөр
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

## 2.2 ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

### 2.2.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛ

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 940.6 тэрбум төгрөгөөр буюу 38.2 хувиар өсөж 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын 8.2 хувьтай тэнцэж байна. Активын өсөлтийн 93.0 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 53.0 хувийг өр төлбөрийн өсөлт бүрдүүлж байна.

График 34: ББСБ-ын салбарын ийт хөрөнгө ба нийт зээл




Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

2022 оны 3-дугаар улирлын байдлаар 522 банк бус санхүүгийн байгууллага 10 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээлдэгчдийн давхардсан тоо 5.2 хувиар өсөж 1.6 сая хүрчээ. Аппликейшн ашиглан бага дүнтэй, богино хугацаатай хэрэглээний зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотойгоор зээлдэгчдийн тоо ийнхүү огцом өссөн байна. Мөн иргэд, жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн яаралтай хэрэгцээг ББСБ-ын түргэн шуурхай үйлчилгээ нөхөж чадаж байгаа юм.

График 35: ББСБ-ын тоо, харилцагчдын тоо




*Эх сурвалж: Санхүүгийн салбарын тойм 2021, СЗХ*

- Финтек зээлийн үйлчилгээг 2022 оны 3-дугаар улирлын байдлаар 36 банк бус санхүүгийн байгууллага үзүүлж байгаа бөгөөд үүний 5 нь зөвхөн онлайн зээлийн үйлчилгээг санал болгож байгаа бол 31 ББСБ нь уламжлалт болон дэвшилтэт технологийг хослуулсан зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн валютын арилжаа явуулдаг 4 аппликейшн байна.

2022 оны 3-дугаар улирлын байдлаар аппликейшнээр зээл олгодог эдгээр банк бус санхүүгийн байгууллагууд нь нийт 1.4 сая зээлдэгчийн 346.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд нэг зээлдэгчид дунджаар 237.5 мянган төгрөгийн зээл олгосон байна. Энэхүү нэг зээлийн хэмжээ нь нийт зээлийн дунджаас 6 дахин, уламжлалт хэлбэрээр олгож байгаа зээлийн дунджаас 53 дахин бага байна.

Хүснэгт 19: Уламжлалт ба финтек ББСБ

| | Цэвэр зээл /тэр.төг/ | Эзлэх хувь | Зээлдэгчийн тоо | Эзлэх хувь | Харилцагчдын тоо | Эзлэх хувь | Дундаж зээл /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Уламжлалт | 2,319.3 | 87.0% | 184,047 | 11.2% | 374,364 | 7.6% | 12,601.8 |
| Финтек | 346.8 | 13.0% | 1,460,376 | 88.8% | 4,523,211 | 92.4% | 237.5 |
| Нийт | 2,666.1 | | 1,644,423 | | 4,897,575 | | 1,621.3 |

Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

2022 оны 3-дугаар улирлын байдлаар нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.0 хувь буюу 900.2 тэрбум төгрөгөөр өсөж 2.6 их наяд төгрөгт хүрсэн. Мөн түүнчлэн нийт 142.1 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2.5 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

График 36: Зээлийн жигнэсэн дундаж хүүгийн харьцуулалт




Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №-01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

Хүснэгт 20: ББСБ-ын тоо, хөрөнгийн хэмжээ

| Үзүүлэлт | Нийт хөрөнгийн дүн (тэрбум.төг) | ББСБ тоо | Нийт хөрөнгөөр салбарт эзлэх хувь |
|---|---|---|---|
| 5.0 тэрбумаас дээш | 2,552.0 | 107 | 75.0% |
| 2.5-5.0 тэрбум | 487.9 | 149 | 14.3% |
| 1.9-2.5 тэрбум | 253.2 | 117 | 7.4% |
| 1.4-1.9 тэрбум | 55.7 | 34 | 1.6% |
| 0.6-1.4 тэрбум | 24.9 | 25 | 0.7% |
| 0.6 тэрбум хүртэлх | 27.2 | 90 | 0.8% |

Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл

Салбарын нийт хөрөнгийн 89.3 хувь нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 256 ББСБ байгаа бол 7.4 хувь нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөтэй 117 ББСБ байна. Нийт салбарын хөрөнгийн 3.1 хувийг нь 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 149 ББСБ бүрдүүлж байна.

График 37: ББСБ-ын салбарын зээлийн багцын чанар




*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

2022 оны 3-дугаар улиралд ББСБ-ууд 3.4 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.7 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдсөн. Тус тайлант хугацаанд ББСБ-ын салбар нь 1.6 сая зээлдэгчийн 2.6 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн 92.1 хувийг иргэдийн зээл эзэлж байгаа бол үлдсэн 7.9 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл эзэлж байна. Нийт олгосон зээлийн 71.4 хувийг иргэдийн хэрэглээний зээл бүрдүүлж байгаа ба бизнесийн зээл 6.5 хувийг бүрдүүлж буй үзүүлэлттэй байна.

СЭНДЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ

График 38: Хуулийн этгээдэд олгосон зээл, бүтээгдэхүүний төрлөөр, (хувиар)




График 39: Иргэдэд олгосон зээл, бүтээгдэхүүний төрлөөр, (хувиар)




*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

Тайлант улиралд олгосон 3.4 их наяд төгрөгийн зээлийг хугацааны хувьд ангилбал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл 24.5 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл 18.6 хувийг тус тус эзэлж байна.

График 40: ББСБ-ын салбарын эх үүсвэрийн бүтэц, (тэрбум төгрөг)




*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

Сүүлийн 3 жилийн үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2019 оны эцэст 1.2 их наяд төгрөг байсан бол 2022 оны 3-дугаар улиралд 68.5 хувиар өсөж 2.1 их наяд төгрөгт хүрч, нийт өр төлбөрийн дүн 1.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Өр төлбөрийн дүн 2019 оны эцсээс 2.7 дахин өссөн нь ББСБ-уудад Биржийн бус зах зээл, богино хугацаат мөнгөний захын репо санхүүжилт, Монголын хөрөнгийн бирж дээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах гэх мэт эх үүсвэрийн шинэ боломжууд гарч ирсэнтэй холбоотой.

он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

График 41: ББСБ-ын салбарын ашигт ажиллагаа ба нийт орлого, зардал (тэрбум төгрөг)




*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

2022 оны 3-дугаар улирлын байдлаар нийт ББСБ-ууд 624.8 тэрбум төгрөгийн орлого олж, 389.7 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 235.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 76.5 хувь буюу 270.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 88.8 хувиар буюу 183.3 тэрбум төгрөгөөр, ашиг 58.7 хувь буюу 87.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ББСБ-ын нийт харилцагчийн тоо сүүлийн өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөж 4.9 сая хүрсэн нь финтект суурилсан үйлчилгээний цар хүрээ, ББСБ-уудын тоо нэмэгдсэнтэй шууд холбоотой юм.

Хүснэгт 21: ББСБ-ын салбарын харилцагчдын хүн ам зүйн шинж байдал

| Үзүүлэлт | Дүн | Уламжлалт | Финтек |
|---|---|---|---|
| Нийт харилцагчдын тоо | 4,897,575 | 374,364 | 4,523,211 |
| Эрэгтэй | 2,857,346 | 198,036 | 2,659,310 |
| Эмэгтэй | 2,036,219 | 172,892 | 1,863,327 |
| Зээлдэгчдийн насжилт | 1,642,794 | 324,502 | 1,318,292 |
| 18-35 насны | 529,848 | 178,372 | 351,476 |
| 36-45 насны | 961,640 | 87,559 | 874,081 |
| 46-55 насны | 118,100 | 44,997 | 73,103 |
| 55-аас дээш | 33,206 | 13,574 | 19,632 |
| Зээлдэгчдийн боловсрол | 1,642,794 | 324,502 | 1,318,292 |
| Дээд | 1,157,313 | 189,076 | 968,237 |
| Тусгай дунд | 188,655 | 39,848 | 148,807 |
| Бүрэн дунд | 214,976 | 73,499 | 141,477 |
| Дунд | 55,508 | 10,908 | 44,600 |
| Бага | 26,342 | 11,171 | 15,171 |

*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 10 БҮРТГЭВ-02

Хүснэгт 22: ББСБ ба банкны салбарын үндсэн үзүүлэлтийн харьцуулалт

| Үзүүлэлтүүд | 2021.III | 2022.III | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **2,460.1** | **3,400.8** | **38.2%** |
| Банкны салбартай харьцуулахад, хувиар | 6.2% | 8.2% | 2.0% |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **1,682.1** | **2,124.7** | **26.3%** |
| Банкны салбартай харьцуулахад, хувиар | 52.1% | 53.4% | 1.3% |
| **Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө** | **1,078.4** | **1,275.5** | **18.3%** |
| Банкны салбартай харьцуулахад, хувиар | 100.5% | 80.5% | -20.0% |
| **Нийт зээл** | **1,765.9** | **2,666.1** | **51.0%** |
| Банкны салбартай харьцууулахад, хувиар | 8.6% | 11.4% | 2.8% |

*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

Тайлант улиралд нийт ББСБ-уудын 92.7% буюу 484 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-ын салбарын нийт зээлийн багц нь банкны салбарын зээлийн багцын 11.4%-тай дүйцэж байна.

График 42: ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа, төрлөөр




*Эх сурвалж: СЗХ, 2022 оны 3-дугаар улирлын ББСБ салбарын тайлан*

СЭНДЛИ ББСБ ХК sendly УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## Бичил санхүүгийн зах зээлд гарч буй технологийн дэвшил

Санхүүгийн үйлчилгээг иргэдийн амьдралд илүү хүртээмжтэй, хялбар, зардал багатай хүргэх санхүүгийн үйлчилгээний технологийн шийдэл болсон "финтек" зах зээл манай улсад хүчтэй нэвтэрч байна. Дэлхий дахинд Ковид-19 цар тахлын нөлөө нь хүмүүсийн амьдралын хэв маягийг өөрчилж, технологитой илүү ойр байх шаардлагыг үүсгэсэн юм. Манай улсын хувьд мөн адил 3G интернэтийн сүлжээ хэрэглэгчдийн тоо 2021 онд 3.5 сая, 4G хэрэглэгчид 2.8 саяд хүрсэн нь ухаалаг гар утасны хэрэглээг нэмэгдүүлж байна[1]. Хэрэглэгчдийн зан төлвийн хувьд хялбар, гар утсанд ойр шийдлийг илүүтэй дэмжин ашиглаж байна. СЗХ-ноос мэдээлснээр финтек харилцагчдын тоо 2022 оны 3-дугаар улиралд давхардсан тоогоор 4.5 саяд хүрчээ. Өнөөдрийн байдлаар Аппликейшн ашиглан цахим зээл олгож байгаа компани Монгол Улсын хэмжээнд 36 компани байна.

Хүснэгт 23: Аппликейшнээр зээл олгож буй компаниуд

| № | Финтек | Апп нэр | № | Финтек | Апп нэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мобифинанс | Monpay | 19 | Ньюстар финанс | Nsf.mn, Lite+ |
| 2 | Тус финтек | TUS Fintech | 20 | Шинэхэн инвест | www.bayan.mn |
| 3 | Эм Пи Эс Си | Toki | 21 | Очир ундраа ОМЗ | Opay |
| 4 | Инвескор хэтэвч | Pocket | 22 | Грийн финтек | t finance green fintech |
| 5 | Кэйш флов финанс | Tugrug app | 23 | Зээл Эм Эн платформ | Zeel.mn |
| 6 | Ашид капитал | Simple, Simple Agent | 24 | Жи Эс Би Капитал | GSB Prime |
| 7 | Лэндмн | LendMN | 25 | Грийн-Инвестмент | Gate.mn |
| 8 | Таван богд финанс | PayOn.mn | 26 | Цогзолфинанс | Pocket |
| 9 | Нөмөр кредит | numur | 27 | Начин заан финанс | Naizly |
| 10 | Соно финтек | Sono Mongolia | 28 | Нанокапитал | Nano Capital |
| 11 | Ард кредит | Ard | 29 | Мөнгөнзоос кредит | Pocket |
| 12 | Сэндли | Hi-PayMerchant, Hipay, Sendly | 30 | Хас хаан | ХАСХААН |
| 13 | Омни капитал | Moni Digital | 31 | Монголиа импакт финанс | Qmoni |
| 14 | Бизнес-Инвест девелопмент | БИД app | 32 | Фин экспресс | Finex |
| 15 | Говьфинанс | CashOne Lite, CashOne | 33 | Смарткапитал фанд | My Credit |
| 16 | Хатан суудал инвест | Zeely | 34 | Нэмэх төгрөг | Most Money |
| 17 | Нэт капитал финанс корпораци | Net app | 35 | Өсөх ундарга финанс | ufinance |
| 18 | Энт кредит инвестмент | EntcreditMN | 36 | Солонго капитал | 100k.mn |

*Эх сурвалж: СЗХ, ББСБ-уудын 2022 оны 3-дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэл*

[1] Харилцаа холбооны зохицуулах хороо, 2021 оны "Үүрэн холбооны дата" мэдээллийн сан

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## 2.2.2 МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй уламжлалт болон цахим зээл, гадаад мөнгөн гуйвуулга, мерчант зээлийн зах зээлийн олон улсын болон дотоодын нөхцөл байдал, цаашдын чиг хандлага болон боломжит зах зээлийн багтаамжийг энэ бүлэгт оруулсан болно.

### Дэлхийн мөнгөн гуйвуулгын өнөөгийн байдал

Олон улсын валютын сангийн тодорхойлсноор мөнгөн гуйвуулга гэдэг нь гадаад улсад түр хугацаагаар ажиллаж амьдарч буй хүмүүсийн хийж буй бизнесийн бус шинж чанартай мөнгөн шилжүүлэг юм.

Дэлхийн банк болон KNOMAD байгууллагын 2022 оны 11 дүгээр сард нийтлэгдсэн хамтарсан судалгаагаар 2021 онд 781.0 тэрбум ам.долларын мөнгөн гүйлгээ хийгдсэн ба энэхүү мөнгөн гуйвуулгын хэмжээ 2022 онд 794.0 тэрбум ам.долларт хүрч 1.6 хувиар өсөх төлөвтэй байна. 2016-2021 онуудад дэлхийн даяарх мөнгөн гуйвуулгын дүн жилд дунджаар 5.6 хувиар тэлж байна.

График 43: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ, (тэрбум ам.доллар)




Эх сурвалж: Дэлхийн банк ба KNOMAD хамтарсан судалгаа, 2022/11

Дэлхийн банкны судалгаанд тайлагнасан олон улсын мөнгөн гуйвуулгын дүнг бүс нутгаар харвал өмнөд хөрш БНХАУ-ын мөнгөн гуйвуулгын дүн тасралтгүй буурч 2022 онд өнгөрсөн оноос 3.8 хувиар буурах тооцоо гарчээ. Зүүн Ази ба Номхон далайн бүс нутгийн мөнгөн гуйвуулгын хэмжээ 2022 онд 0.8 хувиар өсөх төлөвтэй байна. Харин 2023 онд Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас бусад бүс нутгуудад мөнгөн гуйвуулгын дүн дунджаар 3.3 хувиар өсөх тооцоололтой байна.

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

График 44: Дэлхийн мөнгөн гуйвуулгын хэмжээ, тэрбум ам.доллар




Эх сурвалж: Дэлхийн банк ба KNOMAD хамтарсан судалгаа, 2022/11

**Мөнгөн гуйвуулга нь хүлээн авагч болон илгээгч гэсэн хоёр талд хуваагддаг ба мөнгөн гуйвуулгын урсгал нь орлогын түвшин өндөртэй улс орнуудаас орлогын түвшин дунд болон бага улс орнууд руу чиглэлтэй байдаг.**

График 45: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч бага, дунд орлоготой улс




График 46: Хүлээн авсан мөнгөн гуйвуулгаар тэргүүлэгч бага, дунд орлоготой улс, ДНБ-д эзлэх хувиар




Эх сурвалж: Дэлхийн банк ба KNOMAD хамтарсан судалгаа, 2022/11

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 47: Мөнгөн гуйвуулгын өсөлт, хувиар




Эх сурвалж: Дэлхийн банк ба KNOMAD хамтарсан судалгаа, 2022/11

Мөнгөн гуйвуулгын өсөлтийг бүс нутгаар харуулбал Монгол Улсын нутаг дэвсгэр оршдог Зүүн Азийн бүс нутагт олон улсын мөнгөн гуйвуулгын хэмжээ 2022 онд 3.7 хувь, 2023 онд 0.8 хувиар өсөх хүлээлттэй байна. Бага, дунд орлоготой улс орнуудын мөнгөн гуйвуулгын өсөлт 2022 онд 4.9 хувь байх бол ирэх онд 2.0 хувь орчимд өсөх хандлагатай байна. Дэлхийн банкнаас гаргасан судалгаанд 2022 оны 2-дугаар улирлын байдлаар 200 ам.доллар шилжүүлэх зардал Өмнөд Азид харьцангүй бага буюу 4.1 хувь байгаа бол Африкийн бүс нутаг, Европ ба төв Азид олон улсын дунджаас өндөр шилжүүлгийн зардал гарч байна.

График 48: 200 ам.доллар шилжүүлэхэд гарах зардал, (2021-2022)




Эх сурвалж: Дэлхийн банк ба KNOMAD хамтарсан судалгаа, 2022/11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## Дэлхийн мөнгөн гуйвуулгын цаашдын төсөөлөл

Уламжлалт мөнгөн гуйвуулга нь банкууд болон хувь хүмүүс, Western Union, Money Gram зэрэг мөнгөн гуйвуулгын компаниуд дээр тогтож ирсэн бол орчин цагт технологи хурдтай хөгжиж, санхүүгийн салбарт ахиц өөрчлөлтүүд гарснаар мөнгөн гуйвуулгын салбар дижитал хэлбэр рүү эрчимтэй шилжиж байна. Дижитал мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь олон сая хүмүүст зардал багатай, аюулгүй шилжүүлгийг түргэн шуурхай хийх боломжийг олгодгоороо онцлогтой. Allied Market Research судалгааны байгууллагын тайланд дурдсанаар 2020 оны байдлаар дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээл 705.5 тэрбум ам.доллароор үнэлэгдэж байсан ба 2015-2024 оны хооронд дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээлийн хэмжээг жилд дунджаар 2.9 хувь өсөхөөр төсөөлсөн байна. Энэ нь 2024 он гэхэд 881.0 тэрбум ам.доллар хүрэх төлөвтэй байгааг харуулж байна.

График 49: Дэлхийн мөнгөн гуйвуулгын төсөөлөл




Эх сурвалж: Allied Market Research, The World Migration Report 2022

Дэлхийн хэмжээнд гадаадад ажиллаж амьдарч буй хүмүүс нь “The World Migration Report 2022” тайланд дурдсанаар 2020 оны байдлаар 280.5 сая хүн байгаа бөгөөд түүхэн өсөлтийн дунджийг тооцоход жилд 2.8 хувиар өсөж байна. Энэхүү төсөөллөөр тооцоход 2024 онд дэлхий дахинаа гадаадад ажиллаж амьдарч буй хүмүүсийн тоо 313.9 саяд хүрэх төлөвтэй байгаа ба технологийн шилжилтийн нөлөөгөөр дижитал мөнгөн гуйвуулгын үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## Дотоодын мөнгөн гуйвуулгын өнөөгийн байдал

Монгол Улсын хэмжээнд 2022 оны хоёрдугаар улиралд гадаадад ажиллаж амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга 2021 оноос 7 хувиар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 25 хувиар тус тус буурч, цэвэр дүнгээр 34 сая ам.долларын эерэг валютын урсгал орж ирсэн.

График 50: Хүлээн авсан мөнгөн гуйвуулга, (мянган ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк, Гадаад секторын статистик

Өмнөд Солонгос улсаас хүлээн авсан валютын нийт урсгал энэ оны 2 дугаар улиралд 12.3 сая ам.доллар, АНУ-аас 14.1 сая ам.доллар, Сингапур улсаас 10.3 сая ам.доллар буюу хамгийн өндөр валютын орлого хүлээж авсан. Шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын хэмжээг харвал Өмнөд Солонгос улс руу 18 хувь, АНУ руу 24 хувь тус тус эзэлж байна.

График 51: Шилжүүлсэн мөнгөн гуйвуулга, (мянган ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк, Гадаад секторын статистик

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Манай улсаас гарч буй мөнгөн гуйвуулгын шилжүүлэг нь Өмнөд Солонгос, АНУ гэх мэт Монгол Улсын иргэдийн хамгийн ихээр зорчдог, оршин суудаг улс орнууд байна. Эдгээр улс орнууд нь манай улсын хувьд онлайн худалдан авалт, сургалтын төлбөрийн зардал, хэрэглээний зардлын шилжүүлэг гэх мэт эдийн засгийн харилцаа идэвхтэй байдаг орнууд юм.

График 52: Гадаад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тархалт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол улсын "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого"-ын нэгдсэн тайланд Өмнөд Солонгос улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын 39,982 иргэд, АНУ-д 19,170 иргэд хамгийн олноор суурьшиж байна.

График 53: Гадаадад оршин суугаа хүн амын тоо




Эх сурвалж: Үндэсний статискийн хороо, "Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллого"

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

График 54: Гадаад улсад оршин суугаа иргэдийн хувь, насны бүлгээр, (2020 он)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үндэсний Статистикийн хорооноос мэдээлснээр гадаад оршин суугаа 15-34 насны иргэдийн 52.4 хувь нь суралцах зорилгоор гадаад улсад амьдарч байна. Харин 35-54 насны иргэд суурьших, хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, хувиараа хөдөлмөрлөх зорилгоор суурьшиж буй шалтгаан давамгайлж байна.

График 55: Дотоод мөнгөн гуйвуулгын хэмжээ




Эх сурвалж: Монголбанк, Гадаад секторын статистик

Монгол Улсын хүлээн авсан мөнгөн гуйвуулга 2021 оны жилийн эцсээр 198.2 сая ам.доллар, гадаад улс руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 78.1 сая ам.доллар байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 15.4 хувь болон 13.2 хувиар тус тус буурсан үзүүлэлт юм.

Дотоодын мөнгөн гуйвуулгын хэмжээ сүүлийн жилүүдэд буураад байгаа нь Монгол улсад FATF - аас (Дэлхийн мөнгө угаах терроризмтой тэмцэх байгууллага) 2017 оноос эхлэн хатуу хяналт тавьж сануулга өгч эхэлсэн, 2019 онд Монгол улс саарал жагсаалтад орсон, мөн дэлхий дахинаа Ковид-19 цар

тахал тархсан зэрэг нөхцөл байдлуудтай холбоотой байсан юм. 2020 оны 10 дугаар сараас Монгол улс саарал жагсаалтаас гарч, дотоод дахь Ковид-19 цар тахлын нөлөөлөл буурч эхэлсэн нь иргэдийн хэрэглээг идэвхжүүлж, мөнгөн шилжүүлгийн тоог өсгөж байна.

Цар тахлын нөлөөлөл ороогүй буюу 2019 оныг хүртэлх хүлээн авсан мөнгөн гуйвуулгын жилийн дундаж өсөлт 3.6 хувь, шилжүүлсэн мөнгөн гуйвуулгын жилийн дундаж өсөлт 5.7 хувь байна. Энэхүү төсөөллөөр цаашдын өсөлтийг тооцож үзэхэд, Монгол улс 2024 онд 220.7 сая ам.долларын гуйвуулга хүлээн авах, 92.1 сая ам.долларын шилжүүлэг хийх төлөвтэй байна.

## Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж

Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамжийг тооцоолохдоо гадаадад суугаа Монгол иргэдийн тоо, мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нэвтэрсэн буюу АНУ, Австрали, Япон улсуудын нэг сарын дундаж шилжүүлгийн дүн дээр үндэслэн зах зээлийн багтаамжийг тооцоолов. Үндэсний Статистикийн хорооны 2020 оны хүн ам, орон сууцны сүүлийн тайлангаар гадаадад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдийн тоог нас хүйс, зорилгоор нь авч үзвэл

Хүснэгт 24: Гадаадад оршин суугаа Монгол иргэд, хүйсээр

| Зорилго | Эр | | Эм | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Албан томилолт | 737 | 1.30% | 460 | 0.70% | 1,196 |
| Бусад | 5,003 | 8.83% | 6,565 | 10.00% | 11,567 |
| Гэр бүлийн шалтгаанаар | 7,042 | 12.43% | 8,363 | 12.74% | 15,406 |
| Суралцах | 19,359 | 34.17% | 22,464 | 34.22% | 41,823 |
| Суурьших | 5,694 | 10.05% | 8,650 | 13.18% | 14,346 |
| Хөдөлмөрийн гэрээгээр | 7,314 | 12.91% | 5,462 | 8.32% | 12,776 |
| Хувиараа ажиллах | 11,507 | 20.31% | 13,681 | 20.84% | 25,187 |
| Нийт | 56,656 | 100.00% | 65,645 | 100.00% | 122,301 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт гадаад улсад суугаа Монгол иргэдийн дийлэнх хувийг суралцах зорилгоор оршин суугаа иргэд бүрдүүлж байгаа бол албан томилолтоор оршин суугаа иргэд хамгийн бага хувийг бүрдүүлж байна. Албан томилолт, бусад зорилгоорх хүмүүсийг мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хэрэглэх хандлага багатай гэж үзэн нийт тооноос хасаж тооцвол мөнгөн гуйвуулгын үйлчилгээг идэвхтэй хэрэглэх хандлагатай 109,538 иргэн байна. Үнэт цаас гаргагчаар дамжуулан хийсэн нэг харилцагчийн сарын дундаж мөнгөн гуйвуулгын хэмжээ 370.4 ам.доллар байгаа бөгөөд энэхүү тоонд суурилан зорилгоор нь ангилж авч үзвэл сарын 40.5 сая ам.долларын багтаамжтай ба жилийн 486.0 сая ам.доллар болж байна.

## Гадаад улсад оршин суугаа Монгол иргэд – Насны бүлгээр авч үзвэл

2020 оны байдлаар нийт 122,301 Монгол иргэд гадаад улсад оршин суугаа бөгөөд үүнээс Sendly аппликейшн идэвхтэй хэрэглэх хандлагатай 15-54 насны

102,293 хүн байгаа нь нийт гадаад улсад суугаа Монгол иргэдийн 83.0 хувийг бүрдүүлж байна.

График 56: Гадаадад суугаа Монгол иргэдийн тоо, насны бүлгээр




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үүнээс Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ашиглах боломжтой Монгол иргэдийн тоо 102,293, Үнэт цаас гаргагчийн нэг харилцагчийн сарын дундаж шилжүүлгийн дүн 374.0 ам.доллароор тооцож үзвэл сард 38.3 сая ам.доллар, жилд 459.0 сая ам.долларын зах зээлийн багтаамжтай байна.

Хүснэгт 25: Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж

| Мөнгөн гуйвуулгын зах зээлийн багтаамж тооцсон арга | Дүн / сая ам.доллар/ |
|---|---|
| Гадаадад оршин сууж буй зорилгоор | 486.0 |
| Гадаадад оршин сууж буй улс орнуудаар | 148.8 |
| Гадаадад оршин сууж буй хүмүүсийн насанд суурилсан | 459.0 |
| Дундаж шилжүүлгийн хэмжээ | 364.6 |
| Дундаж /төгрөгөөр/ | 1.1 их наяд ₮ |

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах боломжтой гадаад улсад оршин суугаа иргэдийн зорилго, улс орон, насанд суурилсан тооцооллоос харахад дунджаар 364.6 сая ам.доллар буюу 1.1 их наяд төгрөгийн гадаад гуйвуулгын зах зээлийн багтаамж байна гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.

### 2.2.3 ЗЭЭЛИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үнэт цаас гаргагч нь цахим хэлбэрээр мерчантын болон хэрэглээний зээл олгодог ба зах зээлийн багтаамжийг тодорхойлохын тулд тус компанийн гол хоёр бүтээгдэхүүний зах зээлд төвлөрч шинжилгээ хийсэн болно.

#### Мерчантын зээл, багтаамж

Мерчант зээлийн үйлчилгээ нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан богино хугацаатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой бүтээгдэхүүн бөгөөд бараа татан авалт, яаралтай бэлэн мөнгөний шаардлага үүсдэг худалдаа наймаа эрхлэгчид болон үйлчилгээ эрхлэгчид, цахим худалдаа хийдэг хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн юм.

Мерчантын зээлийн салбарыг судлахын тулд эхлээд худалдааны салбарын нөхцөл байдлын талаар судалж үзсэн ба тус салбарт зээл олгодог банк болон ББСБ-ын тоо баримтаас харахад дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 26: Банк болон ББСБ-ын худалдааны салбарт олгосон зээл, (2021 он)

| Худалдааны зээл | | Олгосон зээл | Зээлдэгч | Дундаж хугацаа | Дундаж хүү /жил/ |
|---|---|---|---|---|---|
| Банк | А.а.нэгж | 788 тэрбум төг | 6,021 | 17 сар | 12% |
| | Иргэд | 167 тэрбум төг | 31,966 | 45 сар | 16% |
| Бусад | ББСБ | 332 тэрбум төг | - | 1 сараас 5 жил | 33% |
| | ХЗХ | 11 тэрбум төг | - | - | 27% |
| Нийт | | 1.3 их наяд төг | - | - | 22% |

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо

Худалдааны салбарт Банк болон ББСБ, ХЗХ олгосон зээлийн дүн 2021 онд нийт 1.3 их наяд төгрөг байсан ба дундаж хүү нь 22 хувь байжээ. Банкны хувьд иргэдэд олгосон худалдааны зориулалттай зээлийн хэмжээ 167 тэрбум төгрөг, зээлдэгчийн тоо 31 мянга байгаа бол аж ахуйн нэгжид олгосон худалдааны зээл 788 тэрбум төгрөг, зээлдэгчийн тоо 6 мянга байв. ББСБ болон ХЗХ зөвхөн худалдааны зориулалттай олгосон зээлийн дундаж хугацаа 1 сараас 5 жилийн хугацаатай байдаг байна.

Худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж буй маш олон аж ахуйн нэгж, хувь хүн, хувиараа бизнес эрхлэгчид байдаг маш том салбарын нэг юм.

Монгол Улсад хүнсний худалдааны чиглэлээр 14,769[2] худалдааны газар үйл ажиллагаа явуулж байгаагаас 6,519 нь Улаанбаатар хотод байрладаг энэ тоонд лангуу түрээслэгчид, түргэн үйлчилгээний цэг, худалдааны төвүүдэд ил задгай худалдаа эрхлэгчид ороогүй болно.

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүний 15.7 хувь, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 38 хувийг бүрдүүлж байна. Мөн тус

[2] Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамны дотоод худалдааны салбарын 2020 оны тоо баримт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

салбарт Монгол Улсын нийт ажиллах хүчний 13 хувь буюу 143.5 мянган хүн ажиллаж байна.

2021 оны байдлаар худалдааны салбарын нийт борлуулалт 32.4 их наяд төгрөгтэй тэнцсэн ба үүнээс 20.5 их наяд төгрөгийн борлуулалт буюу 63.3 хувийг жижиглэнгийн худалдааны салбар эзэлж байна.

График 57: Худалдаан салбарын борлуулалт, (их наяд төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Харин тус салбарт олгосон арилжааны банкны зээлийн нөхцөл байдлын талаар судалж үзэхэд 2022 оны 11-дүгээр сарын байдлаар арилжааны банкны нийт зээлийн үлдэгдлийн 21 хувь буюу 4.7 их наяд төгрөгийн зээлийг худалдааны салбар эзэлж байна.

График 58: Банкны салбарын зээлийн бүтэц, хувиар




Эх сурвалж: Монголбанк

Арилжааны банкны системийн нийт зээлийн багцад худалдааны салбарын зээлийн дүн 2022 оны 11 дүгээр сард 2018 оноос 7 орчим пунктээр нэмэгдсэн байгаа нь энэ салбарын өсөлт, багтаамж нь хэр өндөр түвшинд байгааг илтгэж

СЗХ
он сар өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

байна. Ххудалдааны салбарын зээлийн чанаргүйдэл бусад салбаруудтай харьцуулахад бага байгаа нь Монгол Улс дотооддоо коронавирусийн тархалтыг хумьж, худалдаа үйлчилгээний салбарыг бүрэн нээсэнтэй холбоотой юм. Мөн Монгол Улс нь хөгжиж буй орон бөгөөд өрхийн хэрэглээ өндөр учраас худалдааны эргэц түргэн, хөдөлмөрийн насны идэвхтэй залуу хүн ам зонхилсон хүн ам зүйн бүтэцтэй зэрэг хүчин зүйлс өөрөгөөр нөлөөлж байна.

График 59: Банкны системийн зээлийн чанаргүйдэл, харьцуулалт




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбарын зээлийн багцын үлдэгдлийг худалдааны салбар ба системийн хэмжээнд харьцуулбал худалдааны салбарын зээлийн эргэн төлөлт харьцангуй сайн, зээлээ хугацаанд нь найдвартай төлөх мөнгөн урсгал бий болгох чадамжтай салбар гэдэг нь харагдаж байна.

График 60: Банкны салбарын зээлийн чанаргүйдэл, салбараар




График 61: ББСБ-ын салбарын шинээр зээл олголт, салбараар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, СЗХ

Худалдааны салбар нь мөнгөн урсгал, ашигт ажиллагаа, зээлийн чанар, үйл ажиллагааны эргэцийн хурд бусад салбараас илүү өндөр байдаг нь тус салбарт богино хугацаатай зээл олгох тохиромжтой салбар болохыг илтгэж байна. Иймд Сэндли ББСБ нь худалдааны салбар, тэр дундаа мерчантын зээлийн бүтээгдэхүүнийг харилцагчдад хүргэж эхэлсэн байна.

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Мерчантын зээлийн салбарт тулгамдаж буй асуудал

**Мерчантын зээлийн салбарт тулгамдаж буй асуудал болон түүнийг шийдвэрлэх бүтээгдэхүүн үйлчилгээг Үнэт цаас гаргагч нэвтрүүлэх болсон үндэслэлийг судалж үзэхэд дараах үр дүн гарсан болно.**

График 62: Мерчантуудын санхүүжилтийн эх сурвалж ба санхүүжилтийн зарцуулалт[3]




Эх сурвалж: Монголбанк

**Мерчантуудын хувьд ихэвчлэн банкнаас зээл авдаг гэж 81 хувь нь хариулсан бол бусад эх үүсвэрээс буюу 7 хувь нь ББСБ, 12 хувь нь найз нөхөд, хөнгөлөлттэй зээл болон бусад эх үүсвэрээс авдаг гэсэн байна. Зарцуулалтын хувьд 64 хувь нь эргэлтийн хөрөнгийн санхүүжилт хэлбэрээр ашигладаг гэж хариулжээ.**

График 63: Мерчантуудад шаардлагатай зээлийн хэмжээ




Эх сурвалж: Монголбанк

**Монгол банкнаас жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаанаас харахад 1-50 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж 62.5 хувь нь хариулжээ.**

[3] Монголбанкны жижиг дунд үйлдвэрлэл хөгжил, санхүүжилтийн байдал 2017 тайлан

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

График 64: Мерчантууд банкнаас зээл авахад тулгардаг асуудал







Эх сурвалж: Монголбанк

Дээрх түүвэр судалгааны үр дүнгээс харахад зээлд хамрагдаж чадахгүй байгаа жижиг дунд бизнес эрхлэгчдийн хамгийн том хүндрэл нь барьцаа хөрөнгийн бэрхшээл байдаг аж. Худалдаа эрхлэгчид ихэвчлэн лангуу түрээслэн бараа материал борлуулдаг учир лангуу түрээсийн гэрээ болон борлуулж буй бараа материалыг банкууд зээлийн барьцаа болгодоггүй байна.

## Төгрөг-АТМ

Энэ салбарт банк болон банк бус санхүүгийн байгууллагаас гадна өдрийн зээл олгодог “Төгрөг-АТМ” буюу “Т-АТМ” нэртэй иргэний үнэмлэх, хурууны хээ уншуулан зээл олгодог үйлчилгээ зах худалдааны төвүүдэд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна. Нарантуул, Хархорин захуудад долоо хоногийн 10 хувь, 14 хоногийн 20 хувь, 21 хоногийн 30 хувийн хүүтэй зээл олгодог ба тухайн худалдаа эрхлэгчийн борлуулж буй бараа бүтээгдэхүүн зэргийг барьцаалбар болгон авдаг энэ төрлийн мөнгө зээлдүүлэгчид тус салбарын хамгийн том асуудал болоод байна.

Монголын Худалдаачдын Холбооноос авсан мэдээллээр албан бус 300 гаруй мянган худалдаа эрхлэгчдийн 70 гаруй хувь нь яаралтай бэлэн мөнгөний хэрэгцээ үүсэхэд өдрийн зээл авдаг тухай дурдсан ба ямар нэг татвар, бүртгэл мэдээллийн системээс гадуур хийгддэг энэ төрлийн үйлчилгээ нь маш том өрийн сүлжээ үүсгэж, улмаар өндөр хүүний дарамтад худалдаа эрхлэгчдийг оруулдаг тухай дурдсан болно.

Өдрийн зээл олгодог хувь хүмүүс нь худалдаа эрхлэгчдэд байдаг яаралтай, бага хэмжээний, богино хугацаатай бэлэн мөнгөний эрэлт хэрэгцээнд үндэслэн өндөр

хүүтэй, торгуультай, ил тод бус зээл олгодог гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Мерчантын салбарт тулгамдаж буй эдгээр асуудлуудыг шийдвэрлэж, ил тод, бүртгэлтэй, сахилга баттай, таатай нөхцөлтэй бүтээгдэхүүн үйлчилгээ энэ салбарт нэн шаардлагатай байна.

## Сэндли ББСБ компанийн шийдэл

Сэндли ББСБ компани нь худалдаа эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн технологийн шийдэлд суурилсан, таатай нөхцөлтэй мерчантын зээл олгож эхэлснээр энэ салбарт тулгамдаад байгаа ил тод бус байдал болон өндөр хүүний дарамтыг бууруулахад хувь нэмэр оруулж эхлээд байна.

Гар утас ашиглан цахимаар зээл авах боломж нь харилцагч өөрийн боломжит зээлийн нөхцөл, үлдэгдэл, эргэн төлөлтөө хянах боломж олгохоос гадна харилцагч санхүүгийн сахилга баттай байх, нөгөө талаас хүмүүс хооронд хийгддэг байсан бүртгэлгүй зээлийг ил тод болгон бүртгэлжүүлж буй нь банк санхүүгийн салбарт хийж буй томоохон шийдэл болж байгаа юм.

Мөн Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани болох Хай Пэймэнт Солюшнс ХХК-ийн Hi Pay төлбөр тооцооны шийдлээр дамжуулан худалдаа эрхлэгчид төлбөр тооцоогоо хийх, гадаад мөнгөн гуйвуулга хийх зэрэг нэмэлт үйлчилгээнүүдэд холбогдох боломжийг олгож байна.




Сэндли ББСБ нь мерчантын зээл олгохдоо худалдаа үйлчилгээ эрхлэгчийн лангууны түрээслэгч гэдгийг нотлох гэрээ, бизнесийн орлого нотлох, зээлийн сангийн мэдээлэл зэрэгт үндэслэн зээлийн эрхийг тооцдог байна. Мөн Улаанбаатар хотод 6 салбар, хөдөө орон нутагт байрлах 48 салбараар дамжуулан худалдаа үйлчилгээ эрхэлж буй төлбөрийн чадвартай, байнгын бизнесийн орлоготой мерчантуудад хүрч байна. Сэндли ББСБ компани үйлчилгээ үзүүлдэг салбар нэгжийн тоогоороо банк бус санхүүгийн байгууллагын салбартаа эхэнд ордог бол санхүүгийн байгууллага дундаа Хаан банк болон Төрийн банкны дараа ордог байна.

## Мерчантын зээлийн үйлчилгээ үзүүлэх боломжит зах зээл

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас хийсэн "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага" MNS 5021-1:2019[4] стандартын 4 дүгээрт заасан нэр томьёоны төрлөөр үйл ажиллагаа

[4] ХХААХҮЯ: https://mofa.gov.mn/exp/blog/10/181

явуулж буй жижиглэн худалдааны газруудын тоог судалж үзэхэд 15,763 гарсан байна.

Хүснэгт 27: Жижиглэн худалдааны газруудын тоо, (2020)

| № | Ангилал | Дэлгүүрийн төрөл | Хүчин чадлын хэмжээ м.кв | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | | | Улаанбаатар | Аймагт | |
| 1. | Том | Хайпермаркет | 33 | 10 | 43 |
| 2. | Дунд | Супермаркет | 142 | 175 | 317 |
| 3. | Багавтар | Минимаркет | 670 | 574 | 1244 |
| 4. | | Ая тухтай дэлгүүр | 84 | 70 | 154 |
| 5. | Бага | Хүнсний дэлгүүр | 3,638 | 6,332 | 9,970 |
| 6. | | ШТС-ын дэргэдэх дэлгүүр | 30 | 69 | 99 |
| 7. | | Мухлаг | 1,669 | 82 | 2,251 |
| 8. | Хүнсний бус худалдаа | Төрөлжсөн барааны дэлгүүр | 520 | 1,048 | 1568 |
| 9. | | Аутлет | 30 | 3 | 63 |
| 10. | | Бутик | 53 | 1 | 54 |
| | | Нийт | 6,899 | 8,864 | 15,763 |

Эх сурвалж: ХХААХҮЯ

Хүснэгт 28: Худалдааны газрын ангилал, (2020 он)

| № | Ангилал | Дэлгүүрийн төрөл | Хүчин чадлын хэмжээ м.кв | | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | | | Улаанбаатар | Аймагт | |
| 1. | Бөөний худалдаа | Бөөний худалдааны төв | 18 | 129 | 147 |
| 2. | | Агуулах дэлгүүр | 12 | 22 | 34 |
| | | Нийт | 30 | 151 | 181 |
| 3. | Ерөнхий нэршил | Зах (хүнсний лангуу) | 22/6650 | 39/3410 | 61/9960 |
| 4. | | Худалдааны төв | 81 | 69 | 150 |
| | | Нийт | 103/6550 | 108/3410 | 211/9960 |
| 5. | Дэлгүүрийн төрөл | Их дэлгүүр | 3 | 6 | 9 |
| 6. | | Үйлдвэрийн нэрийн дэлгүүр | 15 | 54 | 69 |
| 7. | | Хуучин барааны дэлгүүр | 74 | 178 | 252 |
| | | Нийт | 92 | 238 | 330 |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8. | Дэлгүүрийн бус худалдаа | Авто чингэлэг | 397 | 149 | 546 |
| 9. | | Автомат | 2 | 1 | 3 |
| 10. | | Цахим | - | 11 | 11 |
| 11. | | Шууд | - | 8 | 8 |
| 12. | | Үүргийн | - | 9 | 9 |
| 13. | | ТҮЦ | 1091 | 22 | 1113 |
| | | Нийт | 1490 | 200 | 1690 |
| 14. | Худалдааны агуулах | Худалдааны агуулах | 59 | 48 | 107 |
| 15. | | Төрөлжсөн агуулах | 41 | 51 | 92 |
| | | Нийт | 100 | 99 | 199 |
| 16. | Ил задгай хүнсний худалдаа | | 129 | 35 | 164 |
| | Бүгд дүн (16 чиглэлээр) | | 1944/6550 | 831/3410 | 2775/9960 |

Эх сурвалж: ХХААХҮЯ

Дээрх тоон үзүүлэлтээс харахад Сэндли ББСБ компанийн мерчантын зээлийн үйлчилгээ үзүүлэх боломжит зах зээлд зах худалдааны төв, хуучин барааны дэлгүүр, түргэн үйлчилгээний цэг, ил задгай хүнсний худалдаа, минимаркет,мухлаг, хүнсний жижиг дэлгүүрүүдийг оруулан тооцож болохоор байна. Мөн зах худалдааны төвийн лангуу түрээслэгчдийн тоог гаргаж ирэх зорилгоор “Монголын Худалдаа Эрхлэгчдийн Холбоо”-ноос тодруулахад дараах үр дүн гарав.

Хүснэгт 29: Худалдаа үйлчилгээний төвийн түрээслэгчдийн тоо[5]

| № | Худалдаа, үйлчилгээний томоохон төвүүд | Худалдаа эрхлэгч, түрээслэгчдийн тоо (албан бус) |
|---|---|---|
| | Чингэлтэй дүүрэг | |
| 1. | “Бөмбөгөр-1” худалдааны төв | 2,400 |
| 2. | “Бөмбөгөр-2”, “Содон” худалдааны төв | 4,000 |
| 3. | “Алтжин бөмбөгөр” худалдааны төв | 3,800 |
| 4. | “Шонхор зах” | 2,100 |
| 5. | “Нарантуул-2” худалдааны төв | 1,800 |
| | Баянзүрх дүүрэг | |
| 6. | “Нарантуул” худалдааны төв | 10,000 |
| 7. | “Өгөөмөр” техникийн зах | |
| 8. | Шөнийн зах | |
| 9. | “Дүнжингарав” худалдааны төв | 3,400 |
| 10. | “Сандэй плаза” худалдааны төв | 4,200 |
| 11. | “Баянзүрх” худалдааны төв/хойд/ | 500 |
| | Сүхбаатар дүүрэг | |

[5] www.facebook.com/Монголын-Худалдаачдын-Холбоо

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭЛ №1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭЛ-02

| | | |
|---|---|---|
| 12. | 100 айл орчмын барилгын материалын бүх дэлгүүр | 4,000 |
| 13. | "Меркури" худалдааны төв | |
| Баянгол дүүрэг | | |
| 14. | "Барс" худалдааны төв | 1,800 |
| 15. | "Хар хорин" худалдааны төв | 6,200 |
| Хан-Уул дүүрэг | | |
| 16. | "Мишээл экспо" худалдааны төв | 1,100 |
| | Нийт | 45,300 |
| Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй мерчантуудын тоо[6] | | |
| 17. | 18 аймагт хийсэн судалгаа | 52,000 |
| | Улсын хэмжээнд нийт | 97,300 |

Эх сурвалж: Монголын худалдаачдын холбоо

Мерчантын зээл олгох боломжтой томоохон худалдааны төвүүдийн лангуу түрээслэгч, худалдаа эрхлэгчийн тоо 45,300 гарч байна. Мөн Сэндли ББСБ компаниас хийсэн зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад 18 аймагт 52,000 орчим мерчантууд байгаа гэсэн үр дүн гарчээ.

Сэндли ББСБ компанийн зүгээс мерчантын зээл олгох боломжит зах зээл нь эдгээр жижиг дунд бизнес эрхлэгчид болон лангуу түрээсэлдэг худалдаа эрхлэгчид байх боломжтой.

## Мерчантын зээлийн зах зээлийн багтаамж

Мерчантын зах зээлийг судалж үзэхэд жижиг дунд бизнес эрхлэгчид, зах худалдааны төвийн лангуу түрээслэгчид, худалдаа эрхлэгчдийн тоо албан бусаар Улаанбаатар хотын лангуу түрээсэлдэг томоохон худалдааны төвүүдэд 45,300 орчим, хөдөө орон нутагт 52,000 орчим гарч байна. Эдгээр худалдаа эрхлэгчдэд сард дунджаар 1 сая төгрөгийн мерчантын зээл олгоно гэж үзэхэд, Улаанбаатар хотын томоохон худалдааны төвүүдэд 543 тэрбум төгрөг, орон нутагт 624 тэрбум төгрөг буюу нийт 1.2 их наяд төгрөгийн зах зээл байхаар харагдаж байна.

[6] Сэндли ББСБ компанийн зах зээлийн судалгааны үр дүн

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022121175
УЛААНБААТАР ХОТ

Зураг 7: Мерчантын зээлийн хэрэгцээ, зах зээл




Эх сурвалж: Андеррайтерийн зураглал

Одоогоор Сэндли ББСБ компанийн хувьд Улаанбаатар хотын нийт боломжит зах зээл болох 45,300 хэрэглэгчийн 10 орчим хувьд буюу 4,348 харилцагчид мерчантын зээл олгоод байгаа ба 2023 онд Улаанбаатар хотын боломжит зах зээлийн 20 хувьд хүрнэ гэж үзвэл 8,900 орчим мерчантын харилцагчтай болохоор байна.

Хүснэгт 30: Сэндли ББСБ компанийн мерчантын зээл авах боломжит зах зээл




Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

## Хэрэглээний зээл, багтаамж

Хэрэглээний зээлийн тооцооллыг хийхдээ 2021 оны цалин хөлс, ажил эрхлэлт болон финтек зээлийн дундаж үзүүлэлт зэргийг ашиглан зах зээлийн багтаамжийг тооцоолов.

СЭХ
онБ Сар
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Хүн амын насны бүлгээрх ангилал

Сэндли ББСБ -ийн зээлийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийг насны бүлгээр авч үзвэл 20-39 насныхан дийлэнх хувийг эзэлдэг. Цаашид тус компани нь энэ сегментэд хамаарах насны иргэдэд үйлчилгээ хүргэхээр зорьж байна. Эдгээр зорилтот насны бүлгийн хүн амын тоо улсын хэмжээнд 1,066,742 буюу нийт хүн амын 31.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 31: Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| Ажиллах хүч (мян.хүн) | 1,357.4 | 1,358.6 | 1,273.9 | 1,250.6 | 1,226.5 |
| Ажиллагчид (мян.хүн) | 1,238.3 | 1,253.0 | 1,146.2 | 1,162.9 | 1,127.1 |
| Ажилгүй иргэд (мян.хүн) | 119.1 | 105.6 | 127.7 | 87.7 | 99.3 |
| Ажиллах хүчнээс гадуурх хүн ам (мян.хүн) | 863.0 | 868.0 | 832.2 | 877.5 | 878.1 |
| Ажиллах хүчний оролцооны түвшин (%) | 61.1 | 61.0 | 60.5 | 57.0 | 58.3 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (%) | 55.8 | 56.3 | 54.4 | 54.6 | 53.6 |
| Ажилгүйдлийн түвшин (%) | 8.8 | 7.8 | 10.0 | 7.0 | 8.1 |

Эх сурвалж: 1212.mn

2021 оны байдлаар Монгол улсын нийт ажиллах хүчний хэмжээ 1.2 сая, нийт ажиллагсдын тоо 1.1 сая байна. Сэндли ББСБ-н зүгээс нийт хөдөлмөр эрхлэгч 1.1 сая иргэдэд Sendly аппликейшнээр дамжуулан хэрэглээний зээлийн үйлчилгээг хүргэхээр төлөвлөж байна.

График 65: Улсын дундаж цалин




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод дундаж цалин хамгийн өндөр буюу 1.5 сая төгрөг, баруун бүсэд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг, улсын дундаж цалин 1.4 сая төгрөг байна.

Финтекийн зээлийн үлдэгдэл

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2021 оны тоон мэдээллээр Монгол улсад финтекээр зээлийн үйлчилгээ авсан 1.35 сая иргэн байгаа ба дунджаар нэг иргэн 228.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Үүнээс хэрэглээний зээлийг тооцоход:

Үндэсний статистикийн хорооноос гаргасан цалин хөлсний улсын дундаж дүнтэй харьцуулбал иргэд орлогынхоо 16 хувийг сар бүр цахим зээлийн төлбөрт зориулж, жилд 2.1 сая төгрөгийн зээл авч ашиглаж байна. Дээрх дүнг Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо, Үндэсний статистикийн хорооноос гаргасан цалин хөлсний улсын дундаж статистик мэдээлэлтэй харьцуулах замаар цахим зээлийн зах зээлийн багтаамжийг тооцвол 2.3 их наяд төгрөг байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт хөдөлмөр эрхлэгчдийн тоо 1.1 сая хүн байна. Нэг иргэний сарын дундаж финтек зээлийн хэмжээ 228.0 мянган төгрөг гэж тооцоход сард 256.9 тэрбум төгрөг буюу жилийн 3.0 их наяд төгрөгийн зах зээлийн багтаамжтай байна.

## 2.2.4 НИЙТ ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

Сэндли ББСБ-ын үйлчилгээ явуулж буй дараах үндсэн 3 сегментээр ангилан зах зээлийн багтаамжийг тооцооллоо.

- Мөнгөн гуйвуулга
- Хэрэглээний зээл
- Мерчантын зээл

Хүснэгт 32: Сэндли ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нийт багтаамж

| Боломжит нийт зах зээлийн багтаамж | Дүн /төгрөг/ |
|---|---|
| Мөнгөн гуйвуулгын зах зээл | 1.1 их наяд |
| Мерчантын зээлийн зах зээл | 1.2 их наяд |
| Хэрэглээний зээлийн зах зээл | 3.0 их наяд |
| Нийт боломжит зах зээл | 5.3 их наяд |

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Хэрэв Сэндли ББСБ нь дотоодын мөнгөн гуйвуулгын зах зээлийн 50 хувь, мерчантын зах зээлийн 20 хувь, хэрэглээний зээлийн зах зээлийн 5 хувийг эзлэх юм бол дараах үр дүн гарч байна.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9027... УЛААНБААТАР ХОТ ... 5601 5...548

СЭЖ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ 02

Хүснэгт 33: Сэндли ББСБ-ын зорилтот зах зээлийн нийт багтаамж

| Зорилтот зах зээлийн багтаамж | Дүн /төгрөг/ |
|---|---|
| Мөнгөн гуйвуулгын зах зээл | 550 тэрбум |
| Мерчантын зээлийн зах зээл | 240 тэрбум |
| Хэрэглээний зээлийн зах зээл | 150 тэрбум |
| Нийт боломжит зах зээл | 940 тэрбум |

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад Сэндли ББСБ үйл ажиллагаа явуулж буй мөнгөн гүйлгээ, мерчант болон хэрэглээний зээлийн зах зээлийн нийт багтаамж 5.3 их наяд төгрөг байна. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн нөөц, бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогоос хамаарч боломжит нийт зах зээлд эзлэх орон зай тодорхойлогдох болно.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭ

# 2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

## 2.3.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨРСӨЛДӨГЧИД

2022 оны 3-дугаар улирлын байдлаар цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ, онлайн зээлийн үйлчилгээ эрхэлдэг 36 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудыг дотор нь ангилж үзвэл зөвхөн онлайн зээлийн үйлчилгээ үзүүлдэг 11 ББСБ, онлайн болон уламжлалт зээлийн үйлчилгээг хослуулан хүргэдэг 15 ББСБ байна.

Зураг 8: Финтекийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэгдсэн матриц




Эх сурвалж: App store, Play store, 2022 оны 5 дугаар сарын байдлаар

Дээрх матрицаас харвал Үнэт цаас гаргагч Сэндли ББСБ нь цахим зээл олгодог, онлайнаар мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хийдэг цорын ганц өрсөлдөөний давуу тал бүхий компани юм.

### Финтек ББСБ салбарын өрсөлдөгч компаниуд

Үнэт цаас гаргагч нь харилцагчдад цахимаар зээлийн эрх олгохоос гадна салбар нэгжээс уламжлалт байдлаар зээл авсан харилцагчийн зээлийн үлдэгдлийг аппликейшнд харуулах, аппликейшн ашиглаж зээлээ төлөх, хянах боломжийг хангасан. Мөн зээлийн эргэн төлөлтийг харилцагчийн арилжааны банкны картаас автомат таталт хийж болдгоороо бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-аас өрсөлдөөний хувьд маш том давуу талтай юм.

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
Sendly

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02

Хүснэгт 34: ББСБ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өрсөлдөгчдөөр

| Тусгай зөвшөөрөл | ББСБ тоо | Sendly | lendmn | ARD | InvesCore | sendmn |
|---|---|---|---|---|---|---|
| Зээл | 493 | + | + | + | + | + |
| Факторинг үйлчилгээ | 38 | + | + | | + | |
| Төлбөрийн баталгаа гаргах | 22 | + | | | + | |
| Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах | 5 | | + | | | |
| Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 35 | + | + | + | | + |
| Гадаад валютын арилжаа | 147 | + | + | + | | + |
| Итгэлцлийн үйлчилгээ | 46 | + | + | + | + | |
| Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 18 | | | + | + | |
| Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх | 39 | | + | + | + | |

Эх сурвалж: СЗХ

Финтекийн салбарт дээрх 36 ББСБ-аас гадна арилжааны 12 банк, 2 оператор компани үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс МХБ-д бүртгэлтэй ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ, Инвескор ББСБ-уудаас гадна СэндМН ББСБ нар финтек салбартаа тэргүүлж байна. Эдгээр ББСБ-уудтай харьцуулбал Сэндли ББСБ нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээг технологийн шийдэлтэй хослуулан зах зээлд нэвтрүүлснээрээ онцлогтой.

Хүснэгт 35: Цахим үйлчилгээ үзүүлэгч ББСБ-уудын үйлчилгээний харьцуулсан үзүүлэлт

| | Sendly | lendmn | pocket | ARD CREDIT NBFI | simple | storepay | sendmn |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зээл олгох | √ | √ | √ | √ | √ | | √ |
| Шилжүүлэг хийх | √ | √ | √ | √ | √ | | √ |
| Цахим мөнгөний үйлчилгээ | | √ | √ | √ | | | |

СЭНДЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Оноо цуглуулах | √ | √ | √ | | | √ | |
| Төлбөр тооцоо хийх | √ | √ | √ | √ | | √ | |
| Онлайн худалдаа | √ | √ | √ | √ | | √ | |
| Гадаад мөнгөн гүйвуулга | √ | | | | | | √ |
| Картын төлбөрийн систем | | | | | | | √ |
| Харилцагчийн тоо / Апп таталт | 13,000+ | 1,000,000+ | 500,000+ | 500,000+ | 100,000+ | 100,000+ | 10,000+ |

Эх сурвалж: app store, play store

## 2.3.2 МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ӨРСӨЛДӨГЧИД

**Үнэт цаас гаргагчийн үзүүлж буй мөнгөн гүйвуулгын үйлчилгээтэй өрсөлдөхүйц нэгэн төрлийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын шилжүүлгийн дүн, шилжүүлгийн шимтгэлийн дүнг доор харууллаа.**

Хүснэгт 36: Мөнгөн гүйвуулгын үйлчилгээ үзүүлэгч компаниудын мэдээлэл

| Компани | Улсууд | Валют | Шимтгэл | Байгуулагдсан он | Байршил |
|---|---|---|---|---|---|
| MoneyGram | Дэлхийн 200 гаруй оронд байрлах 347,000 салбар нэгжүүдээс мөнгө гүйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 50+ | - Тухайн улсаас хамааран 2 хүртэл хувийн шимтгэлтэй | 1980 он | АНУ, Техас муж |
| Western Union | Дэлхийн 200 гаруй орон руу мөнгө гүйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 170+ | - Тухайн улсаас хамааран 1- 2 хувийн шимтгэлтэй | 1851 он | АНУ, Колорадо муж |
| Swift | Дэлхийн 200 гаруй оронд байрлах 11,000 салбар нэгжүүдээс мөнгө гүйвуулах, мөнгө хүлээн авах боломжтой | 200+ | - Тухайн улсаас хамааран 0.1-1.5 хувийн шимтгэлтэй | 1973 он | Белги улс, Ла Холпи муж |
| sendmn | Бэлнээр дэлхийн 170 гаруй орон, Онлайнаар Австрали, Япон, Солонгос зэрэг ази номхон далайн бүсийн 11 орон дээр нь Пакистан, Орос, Турк зэрэг улсууд | 10+ | - Тухайн улсаас хамааран 0.1-1.5 хувийн шимтгэлтэй | 2016 он | Монгол улс, Улаанбаатар хот |
| Public Credit | Дэлхийн 160 гаруй улсын 400.000 гаруй салбар нэгжээр дамжуулан бэлнээр мөнгө шилжүүлэх боломжтой. | 4 | 1.5-2.5% | 2016 он | Монгол улс, Улаанбаатар хот |

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хувь хүн | Бэлэн, Онлайн аль аль нь болно. | - | Нэгдсэн нэг шимтгэлийн дүн гэж байхгүй, шимтгэл багатай ч ханш өндрөөр бодогддог. | - | - |

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Монгол улсын 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт 181 ББСБ байгаа бөгөөд, үүнээс Орхон аймагт хамгийн олон, харин Говь-Алтай аймагт хамгийн цөөн ББСБ-ын салбар нэгж байдаг байна. Одоогийн байдлаар Сэндли ББСБ нь нийт 18 аймагт өөрийн салбар нэгжийг байгуулаад байна.

- Хамгийн их улс руу шилжүүлдэг байгууллага: MoneyGram, Western Union, Swift
- Хамгийн олон валютын төрлөөр гүйлгээ хийдэг байгууллага: Western Union
- Хамгийн их хэрэглэгчтэй байгууллага: MoneyGram, Western Union
- Шууд гүйлгээ буцаадаг байгууллага: MoneyGram, Western Union, Finablr

Хүснэгт 37: ББСБ-уудын орон нутаг дахь тархац

| Аймаг | ББСБ-ын тоо | Сэндли ББСБ | Лэнд.мн | Ард | Инвескор |
|---|---|---|---|---|---|
| Архангай аймаг | 3 | 3 | - | - | - |
| Баян-Өлгий аймаг | 7 | 1 | - | - | - |
| Баянхонгор аймаг | 8 | 1 | - | - | - |
| Булган аймаг | 2 | 1 | - | - | - |
| Говь-Алтай аймаг | 1 | - | - | - | - |
| Говьсүмбэр аймаг | 4 | 2 | - | - | - |
| Дархан-Уул аймаг | 18 | 3 | - | - | - |
| Дорноговь аймаг | 8 | 4 | - | - | - |
| Дорнод аймаг | 13 | 3 | - | - | - |
| Дундговь аймаг | 4 | 2 | - | - | - |
| Завхан аймаг | 3 | 2 | - | - | - |
| Орхон аймаг | 20 | 1 | - | - | 1 |
| Өвөрхангай аймаг | 15 | 6 | - | - | - |
| Өмнөговь аймаг | 12 | 3 | - | - | - |
| Сүхбаатар аймаг | 8 | 4 | - | - | - |
| Сэлэнгэ аймаг | 11 | 4 | - | - | - |
| Төв аймаг | 18 | 1 | - | - | - |
| Увс аймаг | 7 | 3 | - | - | - |
| Ховд аймаг | 4 | - | - | - | - |
| Хөвсгөл аймаг | 8 | - | - | - | - |
| Хэнтий аймаг | 7 | 4 | - | - | - |
| Дүн | 181 | 48 | - | - | 1 |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний процессын зураглал

Хувь хүнээр дамжуулах мөнгөн гуйвуулга:

Хувь хүнээр дамжин хийгдэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хамгийн анхны олон улсын мөнгөн гуйвуулга хийх арга гэж хэлж болох ба зөвхөн итгэлцэл дээр явагддаг хуулийн зохицуулалтгүй гуйвуулгын үйлчилгээ юм. Энэ төрлийн гуйвуулгад дамжуулж байгаа хувь хүн нь гуйвуулгын шимтгэл, валютын ханш, хугацаа зэргийг өөрийн ашиг сонирхолд тохируулан тогтоодог сул талтай.




## Банкаар дамжуулах мөнгөн гуйвуулгын зураглал:

SWIFT олон улсын мөнгөн гуйвуулгын системийг ашиглан гүйлгээг дамжуулдаг хамгийн найдвартай хууль ёсны арга юм. Зөвхөн харилцагч банкуудаар дамжуулан гүйлгээ хийгддэг тул харилцагч биш банк руу гүйлгээ шилжүүлсэн тохиолдолд дамжуулагч банкийг оролцуулдаг байна. Шилжүүлэгт оролцож буй бүх банк үйлчилгээнийхээ шимтгэлийг авдаг тул шимтгэлийн зардал хамгийн өндөр байдаг.




СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10




## Sendly аппликейшний мөнгөн гуйвуулгын зураглал:

**Олон улсын мөнгөн гуйвуулга хийх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авсан байгууллагуудаар дамжуулан хийгддэг албан ёсны үйлчилгээ юм. Шимтгэл бага, хурдан шуурхай найдвартай үйлчилгээг харилцагчдад санал болгодог.**




СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

### 2.3.3 SWOT ШИНЖИЛГЭЭ

Сэндли ББСБ-ын одоогийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор дараах SWOT шинжилгээ хийлээ.

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| - **Хамгийн олон салбар нэгж:** Сэндли ББСБ нь Улаанбаатар хотод 6, орон нутагт 48 салбартай. Монголын хамгийн олон салбартай ББСБ юм.<br>- **Анхдагч ББСБ:** Мөнгөн гуйвуулга хийх улс орнуудын зохицуулагч байгууллагаас "Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл" авч финтек технологи ашиглан Монгол Улсад үйлчилгээ үзүүлж буй анхдагч ББСБ юм.<br>- **Анхдагч үйлчилгээ:** Хилийн чандад байгаа Монгол иргэдэд орон сууцны зээлийн үйлчилгээ, үнэт цаасны арилжаанд орох, сайн дурын нийгмийн даатгал, онлайн худалдаа гэх мэт нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйлчилгээг аппликейшнээр дамжуулан хүргэдэг анхны ББСБ юм.<br>- **Экосистем:** Хай Пэймент Солюшн ХХК, Радикс технологи ХХК-тай хамтран өөрсдийн бизнес модель, зээлийн коре системдээ тулгуурлан Сэндли экосистемийг бүрдүүлж байна.<br>- **Токен сервис:** Гадаадын банкны данс болон картын мэдээллийг Sendly аппликейшн дээр тодорхой хугацаанд сануулж болох тул гүйлгээ хийх тоолонд картын мэдээлэл оруулах шаардлагагүй.<br>- **Аюулгүй байдал:** Картын төлбөрийг аюулгүй дамжуулах (PCI DSS) олон улсын стандартыг хангасан.<br>- **Синержи:** Sendly аппликейшнээр HiPay дансаа цэнэглэн аппликейшн доторх үйлчилгээг авах боломжтой.<br>- **Найдвартай:** Олон улсын стандартыг хангасан найдвартай, албан ёсны мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хэрэглэгчдэд санал болгодог.<br>- **WeChat-тай хамтардаг:** WeChat-тай интеграц хийгдэж Монголын финтек компаниудад төлбөрийн шийдлийг нэвтрүүлсэн.<br>- **ACH:** Зээл олголтыг тухайн хэрэглэгчийн хүссэн банкны дансруу Hipay системээр дамжуулан Монголбанкны ACH-р шууд хийж гүйцэтгэдэг.<br>- **Автомат таталттай:** Hipay-ийн карт хүлээн авах зөвшөөрөл, карт хадгалах токен сервис үйлчилгээг ашиглан зээлдэгчийн | - **Танигдаж эхэлж байгаа:** Зах зээлд шинээр нэвтэрч буй тул хэрэглэгчдэд бүрэн танигдаагүй.<br>- **Шинэ үйлчилгээ нэвтрүүлэх хугацаа:** Шинэ үйлчилгээгээ хэрэглэгчдэд таниулахад хугацаа их зарцуулдаг.<br>- **Шаардлага өндөр:** Харилцагчийг таньж мэдэх стандарт нь шат дараалсан хяналттай тул шинэ харилцагчид тавигдах шаардлага өндөр.<br>- **Цаг хугацаа:** Үйлчилгээгээ шинээр нэвтрүүлж буй улсуудын зохицуулагч байгууллагын дүрэм стандартаас шалтгаалж тусгай зөвшөөрлийг авахад цаг хугацаа, зардал их зарцуулдаг.<br>- **Иргэдийн технологийн чадавх:** нийт зээлийн багцын дийлэнх хувийг зээлдэг орон нутгийн зээлдэгч нар нь ухаалаг утас, шинэ технологийг хэрэглэх чадвар сул байдгаас зээл олгох, зээлийн эргэн төлөх үйл ажиллагаанд ажилтнууд цаг их зарцуулдаг. |

Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| эргэн төлөлтийг автоматаар буюу recurring payment-ээр төлдөг.<br>**Чанаргүй зээлийн багц:** Эргэн төлөлтийг автоматжуулснаар чанаргүй зээлийн багц 2021 оны жилийн эцсээр 0.1 хувь буюу салбарын дунджаас 7 дахин бага. | |
| Аюул | Боломж |
| - **Өрсөлдөөн их:** Финтекийн салбар хурдацтай хөгжиж байгаа учир дотоод өрсөлдөөн их.<br>- **Хууль эрх зүй:** Шинээр мөрдөгдөх СЗХ-ны "ББСБ-ын зээлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу Финтек ББСБ-уудад тавигдах шаардлага өндөр болсон<br>- **Тогтворгүй байдал:** Хэрэв Монгол Улс дахин саарал жагсаалтад орох тохиолдолд өөр улсад мөнгөн гуйвуулгын үйлчилгээг шинээр нэвтрүүлэхэд хязгаарлалтад орох эрсдэлтэй.<br>- **Давагдашгүй хүчин зүйлс:** Цар тахал, байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойгүй нөхцөл байдал болсон тохиолдолд зээлийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй.<br>- **Эдийн засаг удаашрах:** Инфляцын дарамт 2022 оны 11 дүгээр сарын байдлаар үргэлжилж байгаа бөгөөд инфляцын өндөр түвшин цаашид хадгалагдах хүлээлт эдийн засагт үүссэнээр, хэрэглээ буурч, эдийн засгийн өсөлт удаашрах эрсдэлтэй.<br>- **Орлуулах бүтээгдэхүүн:** Зах зээл дээр хямд өртгөөр гадаад гуйвуулга хийх ижил төстэй аппликейшнүүд, бизнес модель түгээмэл болж байна. Иймд гадаад мөнгөн гуйвуулгын зах зээл дээр өрсөлдөөн ширүүсэх эрсдэлтэй. | - **Тэргүүлэх:** Сэндли ББСБ нь Хөгжингүй орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, компаниудтай хамтран ажилласнаар компанид шинэ инновац нэвтрүүлж салбартаа тэргүүлэх боломжтой.<br>- **UnionPay:** UnionPay картын системийг ашиглан тухайн сүлжээ нэвтэрсэн бүх улс, оронд мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх боломжтой.<br>- **Шинэ бүтээгдэхүүн:** Мөнгөн гуйвуулга нэвтэрсэн улс орнуудад ажиллаж амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх боломжтой.<br>- **Зардлыг бууруулах:** Орон нутгийн 48 салбараар дамжуулан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлыг бууруулах боломжтой.<br>- **Олон улсын санхүүжилт:** Сэндли ББСБ нь гадаадын биржүүдэд бүртгүүлэх, улмаар нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах бүрэн боломжтой. |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# 2.4 САНХҮҮГИЙН ТААМАГЛАЛ

Хүснэгт 38: Санхүү байдлын тайлангийн төсөөлөл

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| | Хөрөнгө | | | |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 33,563 | 62,756 | 81,698 | 94,944 |
| Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгө | 3,612 | 5,027 | 9,941 | 14,070 |
| Нийт зээл | 31,102 | 58,596 | 74,335 | 85,588 |
| *Эрсдэлийн сан* | (1,313) | (3,383) | (5,810) | (8,414) |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 131 | 2,030 | 2,606 | 2,983 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 32 | 487 | 626 | 716 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 280 | 325 | 294 | 205 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 239 | 284 | 253 | 164 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | 41 | 41 | 41 | 41 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - | - | - |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 33,843 | 63,081 | 81,992 | 95,149 |
| | Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | | | |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 10,786 | 28,753 | 32,865 | 27,901 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 1,058 | 8,058 | 13,058 | 8,058 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 4,700 | 3,700 | 700 | - |
| Өрийн бичиг* | - | 10,000 | 10,000 | 10,000 |
| Бусад өр төлбөр | 5,028 | 6,995 | 9,106 | 9,843 |
| ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | 23,057 | 34,328 | 49,127 | 67,248 |
| Энгийн хувьцаа | 17,429 | 17,429 | 17,429 | 17,429 |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал), эхний үлдэгдэл | 732 | 5,629 | 16,900 | 31,699 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал), эцсийн үлдэгдэл | 5,629 | 16,900 | 31,699 | 49,820 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН | 33,843 | 63,081 | 81,992 | 95,149 |

*Тайлбар: (*)-Компани 2024 онд нэмэлтээр дахин 10.0 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэр татах төлөвлөгөөтэй байна.*

Эх сурвалж: Компанийн дотоод үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөллөөс дүгнэхэд нийт активын өсөлтийн хувьд 2023 онд 63.1 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байгаа бол 2025 он гэхэд 95.1 тэрбум төгрөг хүрэх тооцоололтой байна. Сэндли ББСБ нь 2023 онд 10.0 тэрбум төгрөгийн компанийн өрийн бичгийн үлдэгдэлтэй байх бол, 2024 оноос өрийн бичгийн эргэн төлөлт хийгдсэний дараа итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нэмэгдэх төлөвтэй байна. Санхүү байдлын тайлангийн төсөөллөөс харвал 2024 онд дахин өрийн хэрэгслээр 10.0 тэрбум төгрөгтэй дүйцэх санхүүжилт татах ажээ. Харин 2023 онд нийт 10.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татах зорилготой юм.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-18

Нийт хөрөнгийг эх үүсвэрийн бүтцээр задалж авч үзвэл өөрийн хөрөнгийн хэмжээ энгийн хувьцаа гаргалтаар нэмэгдэхгүй гэдэг нь харагдаж байна. Харин хуримтлагдсан ашгийн нөлөөгөөр эздийн өмчийн дүн 67.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 70.7 хувийг эзлэх төлөвтэй байна.

График 66: Нийт өр төлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, хувиар




Эх сурвалж: Компанийн дотоод үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө

Дээрх графикаас харахад Сэндли ББСБ нь итгэлцлийн үйлчилгээ, банк, санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр нийт хөрөнгөө нэмэгдүүлэх хандлагатай байна. Санхүүгийн байгууллагын хувьд бэлэн мөнгө, зээл олгох санхүүжилтийн хэрэгцээ бусад бизнесийн салбаруудтай харьцуулахад өндөр байдаг. Хэрэв компанийн хувьд хөшүүргийг оновчтой ашиглаж чадвал эрсдэлийг дагаж борлуулалтын орлого, ашигт ажиллагаа нэмэгдэх үндсэн том хүчин зүйл болох юм.

График 67: Цэвэр зээлийн багц, (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Компанийн дотоод үйл ажиллагааны тайлан төлөвлөгөө

СЭНДЛИ ББСБ ХК
Sandly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10

Сэндли ББСБ-ийн цэвэр зээлийн багц 2022 оны 10 дугаар сарын байдлаар 15.6 тэрбум төгрөг байсан ба нийт хөрөнгийн 55.5 хувийг эзэлж байна. Хэрэв зээл олголтын санхүүжилтээ төлөвлөсний дагуу нэмэгдүүлж, амжилттай эх үүсвэр татаж чадвал 2023-2025 оны хооронд цэвэр зээлийн багцын нийт хөрөнгөд эзлэх хувь дунджаар 84.1 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

Хүснэгт 39: Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| Зээлийн бүтээгдэхүүний орлого | 11,407 | 25,467 | 32,874 | 37,392 |
| Зээлийн бүтээгдэхүүний зардал | (3,294) | (5,999) | (7,258) | (7,236) |
| Зээлийн бүтээгдэхүүний цэвэр орлого | 8,113 | 19,468 | 25,616 | 30,156 |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний орлого | 1,136 | 2,450 | 3,417 | 4,383 |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний зардал | (780) | (1,390) | (1,839) | (2,287) |
| Мөнгөн гүйвуулгын шимтгэлийн зардал | (607) | (1,217) | (1,666) | (2,114) |
| Апп-ын зардал | (96) | (96) | (96) | (96) |
| Платформ ашигласны төлбөр | (77) | (77) | (77) | (77) |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний цэвэр орлого | 356 | 1,060 | 1,578 | 2,096 |
| Нийт цэвэр орлого | 8,469 | 20,528 | 27,194 | 32,252 |
| Үйл ажиллагааны зардал | (3,013) | (4,857) | (6,134) | (6,616) |
| Хүү татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (EBITDA) | 5,456 | 15,671 | 21,060 | 25,636 |
| Элэгдлийн зардал | (59) | (81) | (89) | (89) |
| Хүү, татварын өмнөх ашиг (EBIT) | 5,397 | 15,590 | 20,971 | 25,547 |
| Хүүгийн зардал | - | 1,600 | 1,600 | 1,600 |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | 5,397 | 13,990 | 19,371 | 23,947 |
| Татварын зардал | (500) | (2,719) | (4,572) | (5,826) |
| Цэвэр ашиг (алдагдал) | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |

Эх сурвалж: Компанийн дотоод үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2022 онд 4.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах хүлээлттэй байгаа бол 2025 он гэхэд тус үзүүлэлт 3.7 дахин өсөж 18.1 тэрбум төгрөгт хүрэхээр бизнес төлөвлөгөөнд тусгажээ.

График 68: Нийт цэвэр орлого, цэвэр ашгийн төсөөлөл




Эх сурвалж: Сэндли ББСБ

СЭЗХ
... он ... сар ... өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөллийн хувьд 2022 оны 10 дугаар сарын эцсийн тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн олон нийтэд хувьцаагаа нээлттэй санал болгох замаар өмчийн эх үүсвэр татсан нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 6.1 тэрбум төгрөгт хүрэхэд нөлөөлжээ. 2023 онд үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн өсөж, мөн итгэлцэл, өрийн үнэт цаасанд төлсөн төлбөрийн бууралтаар 5.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байх төсөөлөлтэй байна. 2024 онooс мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл 9.9 тэрбум төгрөгөөс 14.0 тэрбум төгрөг болж нэмэгдэх төлөвтэй байна.

Хүснэгт 40: Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | |
| Цэвэр ашиг | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |
| Элэгдлийн зардал | 59 | 81 | 89 | 89 |
| Ажлын капиталын өөрчлөлт: | (16,462) | (25,810) | (11,916) | (8,380) |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (11,507) | (14,459) | 2,972 | 9,829 |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | | | |
| Үндсэн хөрөнгө худалдаж авсан | (8) | (126) | (58) | - |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | (8) | (126) | (58) | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан | 4,700 | 5,000 | 2,000 | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (100) | (6,000) | (5,000) | (700) |
| Итгэлцлийн үйлчилгээ гаргасан | 1,058 | 10,000 | 15,000 | 10,000 |
| Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн | (2,580) | (3,000) | (10,000) | (15,000) |
| Хувьцаа гаргасан | 11,000 | - | - | - |
| Бонд гаргасан | - | 10,000 | 10,000 | 10,000 |
| Бонд төлсөн | - | - | (10,000) | (10,000) |
| Бусад | (121) | - | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 13,957 | 16,000 | 2,000 | (5,700) |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 2,442 | 1,415 | 4,914 | 4,129 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,169 | 3,612 | 5,027 | 9,941 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,612 | 5,027 | 9,941 | 14,070 |

Эх сурвалж: Компанийн дотоод үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2024 онд нэмж 10.0 тэрбум төгрөгийн бонд гаргах төлөвлөгөөтэй байгаа ба тус онд өмнөх оны бондын эргэн төлөлтдөө зориулж 10.0 тэрбум төгрөгийг үндсэн төлбөрт гаргах юм. Мөн финтек бизнесийн тэлэлтэд зориулж 2023, 2024 онд зээл болон харилцагчдадаас татах итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэрийг нэмэгдүүлэх байдлаар үйл ажиллагаагаа санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

## Зээлдэгчдийн тоо

Сэндли ББСБ нь 2021 оны эцсийн байдлаар нийт 3.9 мянган зээлдэгчтэй байсан ба үүний 70 орчим хувь буюу 2.7 мянган харилцагч нь цахим зээлийн

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

харилцагчид байсан байна. 2022 оны жилийн эцэс гэхэд нийт цахим зээлдэгчдийн тоо 11.3 мянгад хүрэхээр төсөөлсөн ба 2022 оноос цааш цахим цээлийн харилцагчдын тоо жилд дунджаар 30 орчим хувиар нэмэгдэхээр төсөөлжээ.

## Зээлийн багцын хэмжээ

HiPay аппликэйшнээр дамжуулан Сэндли ББСБ-ын цахим зээлийн үйлчилгээг 2021 оны 4-дүгээр сараас зах зээлд нэвтрүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн эрхтэй харилцагчдын 61.5 хувь нь зээл авсан бөгөөд тэдгээрийн дундаж зээлийн хэмжээ 4.3 сая төгрөг байсан байна.

Компани 2025 он гэхэд 95.1 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй болж өсөхөөр төсөөлж байгаа ба үүнээс 90.0 хувийг буюу 85.8 тэрбум төгрөг нь нийт зээлийн багцыг бүрдүүлэхээр тооцоолж байна. Зээлийн багцын 90.0-ээс дээш хувийг цахим зээл үлдсэн 10.0-аас ихгүй хувийг уламжлалт маягаар олгосон зээл эзлэхээр төлөвлөж байна. Компанийн зүгээс нийт хөрөнгийн 91.2 хувийг нийт зээлийн багц дээр барьж ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 41: Зохистой харьцааны үзүүлэлт

| Зохистой харьцаа | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт | | | |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн нийт актив | 55% | 60% | 71% |
| Өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн нийт актив | 55% | 60% | 71% |
| 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө/Нийт актив | 54% | 60% | 71% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 17% | 30% | 50% |
| Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт | | | |
| Эрсдэлийн сангийн хүрэлцээ | 132% | 128% | 126% |
| Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 23% | 27% | 12% |
| Үндсэн хөрөнгийн үзүүлэлт | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 0.5% | 0.4% | 0.2% |
| Өгөөж | | | |
| Хөрөнгө /актив/-ийн өгөөж | 18% | 18% | 19% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 33% | 30% | 27% |

Эх сурвалж: Сэндли ББСБ

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөлд үндэслэсэн ББСБ-ын зохистой харьцааг 2023-2025 оны хооронд тооцоолоход өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, хөрөнгийн төвлөрлийн харьцаанууд хангалттай түвшинд байхаар харагдаж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Өгөөж

График 69: Нийт хөрөнгийн өгөөж ба Өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Сэндли ББСБ

Өөрийн хөрөнгийн өгөөж (Return on equity) болон нийт хөрөнгийн өгөөж (Return on asset) тус бүр харгалзан 2022 оны эцэст 21.2 хувь, 14.5 хувь байх бол 2025 оны байдлаар 26.9 хувь, 19.0 хувь болохоор төлөвлөсөн байна. Үүнд зардал багатайгаар олон харилцагчдыг хамрах финтек бизнесийн тэлэлт болон зардлын тогтворжилт хүчтэй нөлөөлөх юм.

## Санхүүгийн хөшүүрэг

2023 оноос өр төлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлснээр өр төлбөр нь эздийн өмчийн дүнтэй харьцуулахад 46.2 хувьд хүрэх төсөөлөлтэй байна. 2025 он гэхэд энэхүү хөшүүргийн харьцаа буурч өөрийн хөрөнгийн дүн өр төлбөрийн дүнг давснаар өр төлбөр нь өөрийн хөрөнгийн 26.9 хувьтай тэнцэх төлөвтэй.

График 70: Санхүүгийн хөшүүргийн харьцаа




Эх сурвалж: Сэндли ББСБ

# 2.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

## Үйл ажиллагааны дунд хугацааны стратеги

Сэндли ББСБ хувьд олон нийтэд танигдаж эхэлж байгаа энэ үед салбарын амьдралын мөчлөгийг тодорхойлох замаар үйл ажиллагаа, маркетингийн стратегийг боловсруулан ажиллаж байна.

Салбарын амьдралын мөчлөг

Сэндли ББСБ-ын үйл ажиллагаа явуулж буй салбарын амьдралын мөчлөгийг Хилл энд Жонесийн аргачлалыг ашиглан тодорхойлов. Тухайн аргачлалаар тодорхойлоход салбарын амьдралын мөчлөг өсөлттэй үе дээр байна. Мөнгөн гуйвуулга, зээлийн үйлчилгээ нь финтек рүү шилжиж байгаатай холбоотой олон улс, Монгол Улсад маш хурдан салбартаа өсөлтийг үзүүлж байна. Салбарын өсөлттэй үед эрэлт хурдацтай нэмэгдэж, ашигт ажиллагаа нэмэгдэж, үнэ буурч, салбар компаниудын харьцангуй бага өрсөлдөөнөөр тодорхойлогдоно. Салбарт шинэ өрсөлдөгч орж ирэхэд харьцангуй амархан байдаг.




Эх сурвалж: Зураг 2.4, Хилл энд Жонес (2008)

Сэндли ББСБ хувьд салбарын өсөлттэй байгаа үед дараах стратегийг баримталж ажиллаж байна.

- Монгол Улсын иргэд хамгийн их оршин суудаг бүс нутгуудад мөнгөн гүйлгээний үйлчилгээгээ нэвтрүүлэх.

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний зах зээлийн хувь хэмжээгээ нэмэгдүүлэхийн тулд хэрэглэгчийн санхүүгийн боловсролыг сайжруулах, хэрэглэгчдэд танигдах үйл ажиллагааг тогтмол хийх.
- Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж зах зээлийн шинэ сегментэд нэвтрэх.
- Эрэлт, ашгийн тогтвортой байлгахын тулд шимтгэл, хүүгийн зохистой хэмжээг барьж ажиллах.

Олон улсын мөнгөн гуйвуулга

Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ нь гадаад улсад  сурч, ажиллаж, амьдарч буй Монгол иргэдэд үйл ажиллагаагаа нэвтрүүлээд буй бөгөөд цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэн, үйл ажиллагаагаа шинэ улсуудад нэвтрүүлэх, таниулах ажлуудыг шат дараалалтайгаар төлөвлөн гүйцэтгэж байна.

Дээрх зах зээлүүдэд нэвтрэхийн тулд Үнэт цаас гаргагч нь зорилтот зах зээл болох хувиараа ажиллаж буй, хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй, суурьшиж буй, суралцаж буй болон гэр бүлийн шаардлагаар гадаад улсуудад оршин сууж буй 15 – 54 насны 100,000 орчим иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг таниулах, хэрэглээг идэвхжүүлэх төлөвлөгөөт маркетингийн ажлуудыг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэхээр бэлтгээд байна.

Цаашид Sendly аппликейшнийг зөвхөн Монгол Улс ба бусад улсын хооронд мөнгөн гуйвуулга хийх бус олон улс хооронд мөнгөн гуйвуулга хийх платформ болгохоор зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд нийт хийгдэж буй гадаад мөнгөн гуйвуулгын дүнгээр дэлхийд хоёрт ордог Арабын Нэгдсэн Эмират улс руу үйл ажиллагаагаа тэлэхээр зохих зах зээлийн судалгаа болон тусгай зөвшөөрөл авах ажлуудыг эхлүүлээд байна.

Үнэт цаас гаргагч нь зорилтот зах зээлд, хамгийн хямд үнээр бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгох буюу cost focus стратегийг баримтлан ажиллахын хажуугаар нэмэлт үйлчилгээнүүдийг нэвтрүүлснээр өрсөлдөгч байгууллагуудаас ялгарах буюу differentiation focus стратегийг давхар баримталж, одоогийн байдлаар албан ёсны тусгай зөвшөөрөлтэйгөөр олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хамгийн хямд буюу дунджаар 1.33 хувийн шимтгэлтэйгээр хэрэглэгчдэд санал болгож байна. Цаашид үнэт цаас гаргагч нь cost focus стратегийг differentiation focus стратегитай хослуулан баримталж, зах зээл дээрх өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэн ажиллахаар зорьж байна.

Зээлийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь уламжлалт болон дижитал сувгуудаар дамжуулан зээл олгодог ба эдгээр сувгууд нь тус бүр өөр өөрийн гэсэн зорилтот зах зээлд хүрэх зорилготойгоор ажиллаж байна. Дижитал зээл буюу мерчантын зээлийн зорилтот зах зээл нь жижиг дунд бизнес эрхлэгчид байдаг бол уламжлалт зээлийн үйлчилгээг хөдөө орон нутагт байршилтай салбаруудаар түлхүү олгож байна.

Үнэт цаас гаргагч нь зээлийн үйлчилгээндээ differentiation focus стратегийг түлхүү баримталж, хэрэглэгчдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, технологид суурилсан шийдлүүдийг ашиглах стратегийг баримтлан ажиллаж байна. Компани нь

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

хамгийн олон орон нутгийн салбартай давуу талаа ашиглан орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулсан мерчантын зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох замаар зах зээлийн эзлэх хувиа нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

## Зах зээлд нэвтрэх стратеги

Sendly аппликейшн нь 2021 оны жилийн эцсээр нийт 13,300 гаруй таталт, 5,300 гаруй идэвхтэй хэрэглэгчтэй байна.

2022 онд маркетингийг идэвхжүүлж аппликейшнийн таталтын тоог 50,000-с дээш хүргэх, идэвхтэй хэрэглэгчдийн тоог 15,000-с дээш хүргэх зорилттой ажиллаж байгаа ба хэрэглэгчдээс бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой судалгааг байнга авч, санал хүсэлтийг маркетингийн үйл ажиллагаанд тусган ажиллаж байна.

Зорилтот улсууд



Үнэт цаас гаргагч нь Үндэсний статистикийн хорооноос хийсэн хамгийн сүүлийн буюу 2020 оны Монгол Улсын хүн ам, орон сууцын тооллогыг харгалзан үзэж Монгол иргэд хамгийн ихээр суурьшсан улсуудад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон бусад санхүүгийн үйлчилгээг /Орон сууцны зээл, Онлайн дэлгүүр, Сайн дурын нийгмийн даатгал/ таниулах, үүний зэрэгцээ Монгол болон олон улсын зах зээлд брендийн нэр хүндийг өсгөхөд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. 2022 онд багтаан эхний ээлжид дараах улсуудад үйлчилгээгээ нэвтрүүлэхээр зорьсон билээ. Үүнд:

| Улс | Оршин суугаа иргэдийн тоо | Нэвтрэх хугацаа | Үйл явц |
|---|---|---|---|
| Европын холбооны 27 улс | 22,000 | 2022.05.31 | Нэвтэрсэн |
| Өмнөд Солонгос улс | 40,000 | 2022-2023 | Бэлтгэл ажил хангасан |
| БНХАУ | 5,000 | 2022-2023 | Бодит орчинд тестлэхэд бэлдэж байгаа |
| Их Британи | 1,400 | 2022.08.31 | Нэвтэрсэн |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
21175 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
Сэндли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## Sendly Euro Tour 2022

Зах зээлд танигдах ажлын хүрээнд европын холбооны улсуудад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэддээ зориулсан санхүүгийн үйлчилгээг мөнгөн гуйвуулгын аппликейшнээр дамжуулан үзүүлэх үйлчилгээг танилцуулах арга хэмжээг 2022 онд төлөвлөсөн хэдий ч уулзалт, өдөрлөгийг Европын орнуудад хийгээгүй юм. Гэсэн хэдий ч 2022 онд нэвтрүүлэхээр төлөвлөж байсны дагуу Европын 27 оронд мөнгөн гуйвуулгыг хэвийн гүйцэтгэж байна.

Sendly Europe TOUR 2022

Цаашид Sendly аппликейшнийг зөвхөн Монгол Улс ба бусад улсын хооронд мөнгөн гуйвуулга хийх бус олон улс хооронд мөнгөн гуйвуулга хийх платформ болгохоор зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд нийт хийгдэж буй гадаад мөнгөн гуйвуулгын дүнгээр дэлхийд хоёрт ордог Арабын Нэгдсэн Эмират улс руу үйл ажиллагаагаа тэлэхээр зохих зах зээлийн судалгаа болон тусгай зөвшөөрөл авах ажлуудыг эхлүүлээд байна.

### Байршуулалтын стратеги

Sendly олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний сегмент нь 200 мянга гаруй иргэд Sendly үйлчилгээгээр дамжуулан нийт 35 тэрбум төгрөгийн гүйлгээг амжилттай шилжүүлжээ. Үүний 46.7 хувь нь суралцахаар, 29.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 11.9 хувь нь гэр бүлийн шалтгаанаар гадаадад амьдарч байна.

Бид нийт гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монголчууд болон Монгол улсад суугаа тэдний дотны хэн нэгэнд өөрсдийн үйлчилгээг таниулах зорилгоор өөрсдийн маркетинг, сурталчилгаагаа дотоодын зах зээл болон гадаад улсад суугаа Монголчууд хэмээн хуваагаад байна.

Гадаад улсад ажиллаж буй сегментэд хүрэхэд тухайн орны Монголчуудын төлөөлөл бүхий холбоо, тухайн улсад ажиллаж амьдардаг хүмүүсийн төлөөлөл, олны танил мөн нийгмийн хариуцлагын ажлууд зэрэг аргуудаар дамжуулан өөрсдийн үйлчилгээг албан ёсны, хурдан шуурхай, аюулгүй гэх мессежийн дор хүргэдэг. Бидний нэг томоохон амжилттай өрнөсөн кампанит ажлуудаас дурдвааc АНУ-д оршин суугаа хэрэглэгчид рүүгээ ил захидлууд илгээх, Монгол Улсад суугаа гэр бүлд нь хэрэглэгчдийг төлөөлөн бэлэг хүргэх, гүйлгээний шимтгэлийн тодорхой хувийг “Монголын Аутизмын Холбоо”-нд хандивлах зэрэг нийгмийн хариуцлагын хүрээнд олон маркетингийн ажлууд хийгээд байна.

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-18 БҮРТГЭВ-02

Харин Монгол улсад суугаа гэр бүл болон нийтэд өөрсдийн үйлчилгээг мөн адил 3 мессеж болох албан ёсны, хурдан шуурхай, аюулгүй мөнгөн гуйвуулгын үйлчилгээ гэх санааг хүргэснээр Гадаад улсад суугаа Монголчуудад бидний үйлчилгээг санал болгодог. Бид өөрсдийн үндсэн сувгууд болон сошиал медиа руу маркетингийн мессеж хүргэх замаар энэхүү ойлголтоо таниулан хоногшуулдаг.

## Сурталчилгааны стратеги

Цогц маркетингийн харилцаа холбоо (IMC) Маркетингийн стратегийг өөрсдийн сурталчилгааны стратегид бид ашигладаг. Энэхүү стратегийг бид зурааснаас дээш, зурааснаас доош болон зураас дундуур гэсэн 3 хэсэгт задлан хувааж авч үздэг. Тухайн ангиллын тусламжтайгаар сурталчилгааны стратегийг нарийвчлан тодорхойлдог билээ.

### Зурааснаас дээш буюу Above The Line - ATL

Өргөн хүрээг хамарсан, зорилтот сегмент, хэрэглэгчийн персонаг үл хамааран нийтийг хамарсан маркетингийн арга хэрэгслийг ашиглан хийж буй маркетингийг Зурааснаас дээш буюу ATL маркетинг гэж нэрлэдэг. ATL маркетинг нь зар сурталчилгаа, маркетингийн сувгуудаар дамжуулан урт хугацаанд брэнд хоногшуулах, таниулах зорилготой байдаг ба ихэвчлэн телевиз, радио, сонин/сэтгүүлийн сурталчилгаа нь энэхүү арга хэрэгсэлд хамаарна.

### Зурааснаас доош буюу Below The Line - BTL

Зорилтот сегмент болон хэрэглэгчийн персонаг тодорхойлсны дараагаар тодорхойлсон сегмент рүү хамгийн боломжит, шууд үр дүн, хариу үйлдэлд суурилсан маркетингийн арга хэрэгслээр дамжуулан хүрэх маркетингийн аргыг BTL маркетинг гэж нэрлэдэг. BTL маркетинг нь и-мейл маркетинг, хайлтын системийн оновчлол, үзэсгэлэн худалдаа зэрэг аргаар зорилтот хэрэглэгч руу шууд хүрэх арга хэрэгслүүд хамаарна.

### Зураас дундуур буюу Through The Line - TTL

Энэхүү маркетингийн арга зам нь ATL, BTL 2 арга замыг нийлүүлсэн буюу брэнд танигдалт болон хариу үйлдэл дээр суурилсан цогц маркетингийн арга хэрэгслээр дамжуулан хүрэхийг TTL маркетинг гэж нэрлэдэг. Ихэвчлэн хосолсон аргаар зорилтот болон макро түвшинд хүрэхүйц ажлууд байдаг ба ТВ реклам дундуур QR уншуулах сурталчилгаа, сошиал медиа маркетинг зэрэг арга хэрэгслүүд хамаарч болно.

СЭНДЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023 01 10
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

Хүснэгт 42. ATL, BTL, TTL арга замуудын харьцуулалт

| Зурааснаас дээш буюу ATL | Зурааснаас доош буюу BTL | Зураас дундуур буюу TTL |
|---|---|---|
| ·Макро хэмжээг хамарсан | · Микро хэмжээг хамарсан | · Микро, макро аль аль хэмжээг хамарсан |
| ·Масс медиа цацалт | · Зорилтот сегмент рүү чиглэсэн | · Нийтийг болон зорилтот сегментэд зэрэг хүрч болдог |
| ·Өргөн цар хүрээтэй | · Үр дүнг хэмжихэд хялбар | · Ихэвчлэн нийтийн онлайн сүлжээний платформ Фейсбүүк, Сошиал медиа зэрэг нь энэхүү ангилалд багтдаг |
| · Брэнд хоногшуулалт болон танигдалтад тохиромжтой | · Борлуулалт болон ашиг нэмэхэд тохиромжтой | |
| · Нийт хүрсэн хүмүүсийн тоо болон бусад мэдээлэл авах боломжгүй | · Нийт хүрсэн хүмүүсийн тоо болон бусад мэдээлэл авч хэмжихэд хялбар | |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

Sendly

НЭЭЛТТЭЙ БОНД

# Гурав.

# Үнэт цаасны тухай

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

# 3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 3.1.1 БОНДЫН НЭРЛЭСЭН ҮНЭ, ХУГАЦАА НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | "Сэндли ББСБ" ХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хүүтэй бонд |
| Бондын арилжаа | Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Биржид бүртгүүлэх бондын тоо ширхэг | 85,000 (наян таван мянга) ширхэг |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000 (зуун мянга) төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ | 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөг |
| Бондын хугацаа | 18 сар |
| Бондын хүү | 19.2 хувь (арван ес аравны хоёр), жилийн |
| Хүүгийн төлөлт | Улирал тутам |
| Үндсэн төлбөр төлөлт | Хугацааны эцэст |
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй. |
| Бондыг эргүүлэн худалдан авах үнэ | Бонд гаргагч нь бондын үндсэн төлбөрийг нэрлэсэн үнээр худалдан авч, хуримтлагдсан хүүг төлнө. (Бондыг эргүүлэн худалдан авах дэлгэрэнгүй нөхцөлийг энэхүү үнэт цаасны танилцуулгын "Үнэт цаас гаргах тухай тогтоол" хэсгээс харна уу.) |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. |
| Үнэт цаасны хүүгийн орлогын татвар | 5.0 хувь |
| Бондын барьцаа, батлан даалт | Толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалж, батлан даалт гаргасан болно. |
| Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

## 3.2 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо дотоодын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлт, банкны хадгаламжийн хүү, ижил төрлийн өрийн хэрэгслийн хүү зэргийг харгалзан бонд эзэмшигчдэд жилийн 19.2 хувийн хүүг санал болгож байна.

### Төв банкны үнэт цаасны хүү

Монголын хөрөнгийн биржээр арилжаалагддаг Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ны хүү нь компанийн бондын эрсдэлгүй нэрлэсэн хүүгийн суурь түвшин болдог хэдий ч Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын хүрээнд ЗГҮЦ-ыг 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс хойш арилжаалахыг зогсоосон. Хамгийн сүүлд арилжаалагдсан 6 сарын хугацаатай ЗГҮЦ-ны хүү 11.805% байсан.

### Бодлогын хүү ба инфляц

Монголбанкнаас бодлогын хүүг 2018 оноос 2020 оны 3 дугаар сар хүртэл 11.0 хувь орчимд хадгалсаар ирсэн. Харин 2020 оны 3 дугаар сард 10.0 хувь, 4 дүгээр сард 9.0 хувь, 9 дүгээр сард дахин бууруулж 8.0 хувь болгож бууруулсан. Ийнхүү Төв банкнаас мөнгөний зөөлөн бодлогыг сүүлийн 2 гаруй жилийн хугацаанд тууштай баримталсан нь цар тахлын хүндрэлийг даван туулах, зээл олголтыг дэмжих, хамгийн гол нь эдийн засгаа сэргээх зорилготой байв.

Гэсэн хэдий ч инфляцын түвшин 2022 оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 14.5 хувьд хүрсэн нь бодлогыг хүүг эрсэн нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэв. 2022 он гарснаас хойш оны эхэнд 6.0 хувь байсан бодлогын хүү 12 дугаар сарын байдлаар 13.0 хувьд хүрч нэг дахин нэмэгдсэн. Энэхүү бодлогын хүүгийн нэг дахин өсөлт нь хөрөнгө оруулагчдын хүлээлтийг өөрчилж, бондын хүүгийн өгөөжийг өсгөх хүлээлтийг хөрөнгийн зах зээл дээр бий болгоод байна.

### Эрсдэлийн урамшуулал

Монгол улсын төгрөгийн ханшийн савалгаа, Засгийн газрын өрийн дарамт, хэрэглээний үнийн өсөлт, худалдааны түнш орнуудын улс төрийн хурцадмал байдал, үйлдвэрлэлийн зардлын өсөлт зэрэг нь дотоодын эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулж, тодорхой бус байдлыг нэмэгдүүлсээр байна. Эдгээр сөрөг хүчин зүйлс нь компаниудын гаргаж буй төгрөгөөр нэрлэсэн бондын эргэн төлөлтийн эрсдэлийг нэмэгдүүлж байгаа ба бондын хүүг тодорхой түвшинд өсгөх нь хөрөнгө оруулагчдад эрсдэлийн урамшуулал болж байгаа юм.

### Банкны хадгаламжийн хүү

2022 оны 11 дүгээр сард банкуудын шинээр татсан 10-12 сарын хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 12.7 хувь байна. Монголбанкнаас 9 болон 12 дугаар сард бодлогын хүүгээ 3 нэгжээр нэмэгдүүлж 13.0 хувьд хүргэсэн нь шинээр татаж байгаа хадгаламжийн хүүг өсөх нөхцөл болжээ. Монгол Улсын системийн 5 банкны 12 сарын хугацаатай хадгаламжийн зарласан хүүг харьцуулж харвал дунджаар 12.1 хувь байна.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

График 71: Төгрөгийн, 12 сарын хугацаатай хадгаламжийн хүү




Эх сурвалж: Банкуудын вэб хуудас

## Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүүгийн харьцуулалт

Зах зээл дээр нээлттэй арилжаалагдаж байгаа бондуудын хүүгийн түвшинг харвал бодлогын хүүгийн өсөлт, инфляцын өсөлттэй уялдуулж банкны хадгаламжийн хүүтэй өрсөлдөхүйц түвшинд тогтоож байна. Хамгийн сүүлд Монголын хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалагдсан “Инвескор бонд 2.0”-ын хүүгийн түвшин жилийн 18.0 хувь байна.

| № | Бонд, ХБҮЦ-ны нэр | Бүртгэсэн огноо | Хүү (жилийн) |
|---|---|---|---|
| 1 | Бичил Глобус ХБҮЦ | 2022.11.15 | 17.50% |
| 2 | Инвескор бонд | 2022.10.21 | 18.00% |
| 3 | ЛэндМН актив ХБҮЦ | 2022.10.07 | 17.00% |
| 4 | Нөмөр кредит ассет ХБҮЦ | 2022.09.29 | 17.50% |
| 5 | Бэрс ХБҮЦ | 2022.08.15. | 16.80% |
| 6 | Симпл ассет ХБҮЦ | 2022.06.16 | 15.00% |
| 7 | Омни актив ХБҮЦ | 2022.01.28 | 14.50% |

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

# 3.3 БОНДЫН БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТ

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох “Монголын финтек групп” хаалттай ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын 31 дугаартай тогтоол, 2023 оны 01 дүгээр сарны 06-ны өдрийн хурлын 01 дугаартай тогтоолын дагуу өөрийн эзэмшиж буй “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргах нийт 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая)

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл (хүү болон үндсэн төлбөр)-ийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор дор дурдсан хувьцааг Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл холбогдох журмын дагуу барьцаалуулсан болно. Барьцааны зүйлийн үнэлгээг талууд "Гэрэгэ эстимэйт" ХХК-ийн гаргасан хөндлөнгийн хараат бус үнэлгээний тайлан (энэхүү үнэт цаасны танилцуулгын "Үнэлгээний дүгнэлт, нэмэлт тодруулга" хэсгээс үзнэ үү.) болон 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн нэмэлт тодруулга албан бичиг (энэхүү үнэт цаасны танилцуулгын "Үнэлгээний дүгнэлт, нэмэлт тодруулга" хэсгээс үзнэ үү.)-т үндэслэсэн болно.

| № | Барьцаа хөрөнгө | Барьцаалуулагч | Тоо ширхэг | Нэгжийн үнэ, ₮ | Барьцаа хөрөнгийн үнийн дүн | Үүргийн гүйцэтгэл хангуулах хувь | Барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийн дүн*, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцаа | "Монголын финтек групп" хаалттай ХК | 111,785,000 | 150.0 | 16,767,750,000 | 70.0% | 11,288,000,000 |

**Тайлбар: Үнэт цаас гаргахтай холбоотой зардал багтсан дүн*

Үнэт цаас гаргагчийн Биржээр арилжаалагдаж буй энгийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр эхэлсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар "Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцааны нийт 56 арилжааны өдрийн хаалтын ханшаар тооцсон жигнэсэн дундаж ханш 169.84 төгрөг байгаа бол тухайн өдрийн турш арилжигдсан ханшаар тооцсон жигнэсэн дундаж ханш 168.71 төгрөг байна. СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.7-д заасны дагуу барьцаалах нэгж хувьцааны үнийг тогтоохдоо сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан тогтоохоор заасан байдаг. Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаа нь холбогдох журамд заасан хугацаанд арилжаалагдаагүй байгаа учраас 56 арилжааны өдрийн жигнэсэн дундаж ханшийг барьцааны үнэлгээнд ашиглах нь тохиромжгүй гэж андеррайтеруудын зүгээс дүгнэсэн. Иймд 56 арилжааны өдрийн жигнэсэн дундаж ханш болон хөндлөнгийн үнэлгээний компанийн дүгнэлтээр гарсан хувьцааны ханшийн аль багаар нь барьцаа хөрөнгийн дүнг тооцов. Мөн СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.6-д "Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан даах болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна." гэсний дагуу толгой компани "Монголын финтек групп" хаалттай ХК нь бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргасан болно.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## 3.4 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь 85,000 (наян таван мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, эргэн худалдах нөхцөлтэй бондыг олон нийтэд санал болгож нийт 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаас гаргагч нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулах юм.

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн (төгрөг) |
|---|---|---|
| 1 | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх | 8,500.0 сая |

## 3.5 ӨРИЙН БИЧГЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:

- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн бичгийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй;
- Өрийн бичгийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах эрхтэй;
- Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь хугацааны эцэст өрийн бичгийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах эрхтэй;
- Үнэт цаас гаргах тухай шийдвэрт зааснаар үнэт цаасны өгөөж буюу хүүг улирал тутамд төлөхийг шаардах эрхтэй;
- Хэрэв үнэт цаас гаргагч нь дээрх 4, 5-д дурдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол андеррайтераар дамжуулан барьцаалуулагч-толгой компаниас үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авахыг шаардах эрхтэй;
- Өрийн бичиг гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол өрийн бичиг эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах (Иргэний хуулийн 208.6) эрхтэй;
- Барьцаалуулагчийн талаарх мэдээлэлтэй танилцах (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам) эрхтэй;
- Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа бондыг Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүг төлөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах эрхтэй;

Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:

- Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн бичгийн төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан өрийн бичгийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд “Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль”-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагчийн үүрэг

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
- Өрийн бичгийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Хувьцааны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу улирал тутамд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
- Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
- Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнг ҮЦТХТ нь хөрөнгө оруулагчийн үнэт цаасны данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна;
- Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- Баталгаа гаргагчийн талаар хөрөнгө оруулагчдад тодорхой үнэн зөв мэдээллийг өгөх;
- Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргэх;

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

- Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;

- Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа бондыг эргүүлэн худалдан хүсэлт гаргасан тохиолдолд “Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай” тогтоол болон холбогдох журмын дагуу худалдан авах үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч буюу нээлттэй бонд гаргагч нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор мэдээлнэ.
  - ✓ Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон;
  - ✓ Бонд гаргах шийдвэрт заасны дагуу өрийн гаргасан бондыг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн;
  - ✓ Бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн;
  - ✓ Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
  - ✓ Хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;
  - ✓ Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
  - ✓ Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
  - ✓ Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан;

## 3.6 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

### Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө, хуваарь



СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1-т заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэлийн аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана. Тус хуулийн 12.2-т зааснаар Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгох бөгөөд Хороо нь уг зөвшөөрлийг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгох бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулна.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 22/07 дугаартай тогтоолын дагуу нийт 85,000 (наян таван мянга) ширхэг нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах бөгөөд биржийн Анхдагч зах зээлийн арилжааны тогтоосон үнийн аргыг ашиглан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн болно.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй бондын худалдан авах захиалгын хугацааг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл олгосны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

## Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаартай тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр цаг хугацааны ахлах дарааллаар санал болгон арилжих арга юм.

## Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан анхдагч зах зээлийн арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч аливаа зөрчил гараагүй, амжилттай болсон гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх, арилжаа эрхлэх байгууллагад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Энэ өдрөөс эхлэж бондын хүү тооцогдож эхэлнэ.

## Бонд худалдан авах заавар

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандаа байршуулах боломжтой. Хэрэв үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдгийг та тооцно уу.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

1. Дурын банкнаас бонд авах мөнгөн дүнг дараах зааврын дагуу байршуулаад өөрийн үйлчлүүлдэг брокерийн компанийн аппликейшнийг ашиглан захиалгаа оруулах эсхүл брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.

   Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
   Дансны нэр: Таны өөрийн нэр
   Дансны дугаар: **** **** **** (өөрийн брокероос лавлах)
   Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

2. Дурын данснаас өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн номинал дансанд байршуулаад цахимаар болон утсаар захиалгаа баталгаажуулах боломжтой.

   Банкны нэр: ҮЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр
   Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр
   Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар
   Гүйлгээний утга: регистрийн дугаар

## Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг үнэт цаас авах мөнгөн дүн дээр нэмж байршуулна. Уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэл багтсан байна.

## Албан татвар

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн татвар төлнө.

Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн 18.6.3-т заасан ногдол ашгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 20.2.5-д заасан 5 хувийн татвар төлнө.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

Sendly

НЭЭЛТТЭЙ >
БОНД

# Дөрөв.

# Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогчид

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# 4.1 ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Брокер, Дилер, Андеррайтер

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот

Утас: +976 7777 6377

Цахим шуудан: info@ucc.mn

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, НьюЙоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

2008 он, Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан.
2009 он, Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан.
2010 он, Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн.
2010 он, Bank of China International-тай түншлэв.
2011 он, Шилдэг брокерийн компани
2011он, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн
2013 он, Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага"
2015-2018 он, Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх
2016 он, Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч.
2018 он, МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

2018 он, Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шилдэг Мэргэжилтэн”

2019-2020 он, Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан.

2019 он, “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов.

2020 он “ЛэндМН” ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер

2020 он, Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн

2020 он, МҮОНТ-н “Цагийн хүрдийн баатар”

2020 он, Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер

2021 он, Биржийн бус зах зээл /OTC/-ийн анхны гишүүн байгууллага

2021 он, Монгол банк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан “Sandbox” төслийн анхны бүтээгдэхүүн болох “Монпэй” бондын андеррайтер

2021 он, Биржийн бус зах зээлийн /OTC/-ийн анхны “БИД” бондын андеррайтер

2022 он, Биржийн бус зах зээл /OTC/-д гаргасан “Ашид капитал ББСБ” ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер

2022 он, Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер

2022 он, МҮОНТ-ийн орон даяарх “Ногоон сум” аянд хамтрагч компани

2022 он, “Төрийн банк “ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат болох эхлэлийг тавьсан

2022 он, “Сэндли ББСБ” ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер

2022 он, “ЛэндМН” ХБҮЦ-д хамтрагч андеррайтер

Өнөөгийн байдлаар “ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК” нь:

“Мобифинанс ББСБ”, “М-Си-Эс Инвестмент” ХХК, “Капитрон банк”, “Ай Си Ти групп”, “Сүү ХК”, “Төрийн банк”, “БИД ББСБ” , “Ашид капитал ББСБ”, “Монголчех Метал”, “ОНДО”, “Монголын финтек групп”, “Эрхэт Монгол групп” гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 200.0 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
121175 УЛААНБААТАР

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-18
БҮРТГЭВ

# 4.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын нэр: "РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Централ Тауэр, 13 давхар, 1308Б тоот

Утас: +976 7510 0575

Цахим шуудан: Info@rhinosinvest.com

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. "Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч манай компани гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлаад байна.

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийн толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон "ЛэндМН" ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа "АНД Системс" ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.
- 2022 онд "Сэндли ББСБ" ХК-ийн IPO-д туслах андеррайтер, "ЛэндМН" ХБҮЦ-д Үндсэн андерратераар тус тус ажилсан.

Сэнгли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга

Байгууллагын нэр: "ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер, Андеррайтер

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парк Плэйс оффис, 4 давхар, 403, 404 тоот

Утас: +976 7012 1530

Цахим шуудан: info@golomtcapital.com

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд Голомт Банк ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдсан. Тус компани нь СЗХ-оос 2011 онд брокерын үйлчилгээ, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, 2015 онд андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2018 онд Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК-ийн давхар бүртгэлд (FPO) хамтран андеррайтераар, даатгалын зах зээлд тэргүүлэгч "Мандал Даатгал" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2019 онд шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч "Түмэн Шувуут" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч "Монос Хүнс" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2021 онд конвиниес дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн IPO Үндсэн андеррайтераар, 2022 онд "Инвескор ББСБ" ХК-ийн FPO үндсэн андеррайтер, "Голомт Банк" ХК-ийн IPO туслах андеррайтер, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн туслах андеррайтераар ажилласан IPO андеррайтерийн зах зээлд нийт 204.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд буй тэргүүлэгч компани юм.

Түүнчлэн Голомт Капитал ҮЦК ХХК нь 2015 онд Монголын анхны даатгагдсан бонд болох "Эрчим" бонд, 2017 онд анхны нээлттэй бонд болох "Сүү" бонд, 2020 онд анхны хайбрид бонд болох "Мастер" бонд, анхны банкны баталгаат бонд болох "Нөмөр" бонд, 2021 онд анхны биржийн бус зах зээлийн бонд болох "Монкон" бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай хамт олон юм. Голомт Капитал ҮЦК нь Бонд, ХБҮЦ-ны зах зээлд нийт 200 гаруй тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, зах зээлд тэргүүлж байна.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02
СЭНГЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## АНДЕРРАЙТЕРИЙН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ЭРХ, ҮҮРЭГ:

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн Монголын хөрөнгийн биржээр нээлттэй бонд гаргах ажлыг зохион байгуулах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэт цаасны танилцуулга, холбогдох материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, арилжааг зохион байгуулах, эрх бүхий байгууллагуудтай харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулна.
- Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаарт заасны дагуу Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр ажиллана.
- Андеррайтер тус бүр нь энэхүү гэрээ болон ажил гүйцэтгэх төлөвлөгөөнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй бөгөөд андеррайтер тус бүр төлөвлөгөөнд заасан ажлыг заасан хугацаанд гүйцэтгэх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтерийг шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр үнэн зөв, түргэн шуурхай хангаж ажиллах үүрэгтэй.
- Андеррайтер тус бүр төлөвлөгөөнд заасан ажлыг шударга ёсоор, төлөвлөгөөнд заасан хугацаанд гүйцэтгэнэ.
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь бонд гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэх аливаа үйлдэл хийсэн гэж Андеррайтерууд үзсэн тохиолдолд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.
- Андеррайтерууд зөвшилцсөний дагуу бондыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх зарчмыг тогтоох, хуваарилалтыг хийх эрхтэй.

СЭНЛЛИ ББСБ ХК

СЗХ
он сар өдөр
БҮ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# 4.3 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: "ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК

Үйл ажиллагааны чиглэл: Аудитын үйлчилгээ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Метро бизнес төв, 6 давхар, 603 тоот

Утас: +976 8011 0088

Цахим шуудан: shonkhor.mn@gmail.com

“Шонхор үнэлгээ аудит” ХХК нь 2014 онд байгуулагдсан. 2017 оноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллагын бүртгэлд хамрагдаж эхэлсэн. Мөн 2018 оноос Даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй болсон. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын гишүүн байгууллага юм. Бид өнгөрсөн хугацаанд Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниуд, санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг олон аж ахуйн нэгжүүдэд аудит, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлийн үйлчилгээг зохих хууль, дүрэм, журмын дагуу үзүүлсээр ирсэнийг дурдахад таатай байна. Тухайлбал 2022 онд буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар авч үзэхэд “MCS групп” компаниуд, “Монре даатгал”, “Simple ассет” ТЗК, “Гүүдсек” ХХК зэрэг томоохон болон олон нийтийн ашиг сонирхол бүхий 200 орчим аж ахуйн нэгжид аудитын үйлчилгээ үзүүлсэн байна.

Манай компани мэргэшсэн нягтлан бодогч, аудитор, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, хөрөнгийн үнэлгээчин гэх мэт мэргэжлийн зэрэг цол, туршлагатай ажилтнуудаа түшиглэхээс гадна шинэ тутам хөгжиж буй салбаруудын талаарх мэдлэгээ үргэлж дээшлүүлэхийг хичээн ажилладаг.

Бидний энэ удаагийн үйлчилгээний гэрээний зорилго бол “Компанийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Аудитын тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль”-иудыг удирдлага болгон СЗХ, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудаас батлан гаргасан холбогдох дүрэм, журам, зааврыг анхаарч үзсэний үндсэн дээр үнэт цаас гаргагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд АОУС-ын дагуу санхүүгийн тайлангийн аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршиж байгаа юм.

Бид “Сэндли ББСБ” ХК-ийн бэлтгэн гаргасан санхүүгийн тайлан холбогдох хууль, журам, СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн эсэхэд холбогдох дүгнэлтийг өгөхөөс гадна цаашид анхаарч ажиллах асуудлуудынх нь талаарх зөвлөмжийг хүргүүлсэн болно.

### Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх үүрэг:

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын “Иргэний хууль” “Нягтлан бодох бүртгэл” “Аудитын тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм,

СЭХ он сар өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10

журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудит стандартын дагуу үнэт цаас гаргагчийн 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болсон завсар үеийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

- Үйл ажиллагааны баримтжуулалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт,санхүүгийн тайлан гаргалтын талаар мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана.
- Үйлчлүүлэгч байгууллагаас ирүүлсэн тайланг үндэслэн баримт, холбогдох мэдээ, мэдээлэлд тулгуурлан шалгаж баталгаажуулах ба шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт материалыг шаардаж авах, биечлэн үзэх, тайлбар нотолгоог бичгээр гаргуулан авах эрхтэй.
- Тайланг шалгаж баталгаажуулахдаа нягтлан бодох бүртгэл, санхүүгийн талаарх хуульчилсан акт, дүрэм, журам, заавар, стандарт, аргачлалыг удирдлага болгон ажиллана.

## 4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: "ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН

Үйл ажиллагааны чиглэл: Хуулийн зөвлөгөө

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

Утас: +976 11 330048

Факс: +976 11 330049

Вэб хуудас: www.mdskhanlex.mn

Цахим шуудан: info@mdsa.mn

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг. "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-т заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Тухайлбал, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн бирж дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох "Wolf" төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах; "Монгол Улсын Хөрөнгийн Бирж" дээр гаргасан анхны 100% даатгагдсан "Эрчим бонд" гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах; "ЛэндМН" ББСБ ХК-ийн IPO, 2 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох төсөл; "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган

олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, "Түмэн шувуут" ХК-ийн IPO гаргах төсөл; "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл; "Монголын Ипотекийн Корпораци" ХХК-ийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төслүүд; "Сэндли ББСБ" ХХК, "Төрийн банк" ХХК, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн IPO төсөл, "ЛэндМН актив ТЗК" ХХК болон "Бэрс актив ТЗК" ХХК-ийн автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төслүүд дээр хууль зүйн дүгнэлт гаргаж ажилласан. Түүнчлэн биржийн бус зах зээлд "Ай си рэйт" ХХК-ийн өрийн хэрэгсэл гаргахад хууль зүйн дүгнэлт гаргасан туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог AsiaLaw сэтгүүл Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс ХХН-ийг "2021 оны Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байна.

### Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Энэхүү гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагч үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталсан журмын дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв, хуульд нийцсэн эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбогдсон асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд, бүрэн гүйцэд гүйцэтгэх;
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх;
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах.
- Үнэт цаас гаргагчтай харилцах, мэдээлэл өгөх ажилтныг томилон ажиллуулах;
- Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн түвшинд, чанартай үзүүлж, хуулийн дүгнэлтийг аливаа доголдолгүй, бүрэн гүйцэд гаргах.
- Хуулийн дүгнэлт болон зөвлөх үйлчилгээний үнэн зөв, хууль ёсны байдлыг хариуцах.
- Хуулийн зөвлөх нь энэ Гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаас гаргагч болон Андеррайтертай үйл ажиллагаагаа уялдуулж, тэдгээрт ажлын явц, үр дүнгийн талаар тогтмол танилцуулж байх;

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# ХАРААТ БУС ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ДҮГНЭЛТ

## АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

"Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК (Үндсэн андеррайтер гэх), "Райнос инвестмент ҮЦК" ХХК (Туслах андеррайтер гэх), "Голомт Капитал ҮЦК" ХХК (Туслах андеррайтер гэх) нар нь Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК (РД: 5961548) -тай 2022 оны 12 сарын 22-ны өдөр, АГ-22/23 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 100,000 төгрөгийн үнэтэй, 85,000 ширхэг бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгож нийт 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөг татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж байгаа билээ.

Андеррайтерууд нь энэхүү үйл ажиллагаанд Монгол Улсын макро эдийн засгийн орчин, ирээдүйн төлөв, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл, салбарын чиг хандлага, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, стратеги, бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл зэргийг судалсны үндсэн дээр үнэт цаасны танилцуулгыг боловсруулан бэлтгэж, Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд танилцуулж байна.

1. Үнэт цаас гаргагчийн тухай
2. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв
3. Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл
4. Хүүгийн түвшин тогтоосон үндэслэл
5. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын тухай
6. Эрсдэлийн бодлого
7. Хөрөнгө оруулалтын боломж
8. Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

### 1. Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2015 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд "Гео финанс" ХХК, "Гялс кредит ББСБ" ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ. Компанийн оноосон нэрийг өөрийн брэнд бүтээгдэхүүний нэрээр буюу "Сэндли ББСБ" ХХК хэмээн өөрчилснийг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 328 тоот тушаалаар зөвшөөрч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна. Тус компани нь хувьцаагаа олон нийтэд МХБ-ээр дамжуулан санал болгож 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр нийт 10.05 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн юм. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр нээлттэй хувьцаат компанийн гэрчилгээгээ авч, Улсын бүртгэлд бүртгэсэн билээ.

СЗХ
он сар өдөр
БҮРТГ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

"Сэндли ББСБ" ХК нь зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл, факторинг, төлбөрийн баталгаа гаргах тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн компанийн бусдаас ялгарах онцлог, давуу тал нь Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон жижиглэн худалдаа эрхлэгч буюу мерчантын зээлийн үйлчилгээ юм.

Салбартаа анх удаа олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлснээр гадаадад суугаа Монгол иргэд зардал багатайгаар мөнгөн гуйвуулга хийх, түүнчлэн эх орондоо орон сууц худалдаж авах, сайн дурын нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон байна. Цаашлаад Монгол Улсад орох валютын урсгал ч нэмэгдэх таатай нөхцлийг бүрдүүлснийг  2021 онд "Сэндли ББСБ" ХК-ийн хүлээн авсан мөнгөн гуйвуулгын тоо нь арилжааны банкуудын нийт хүлээн авсан SWIFT гүйлгээний тооны 46.2 хувьтай тэнцэж байгаагаас харж болохоор байна.

Үнэт цаас гаргагч нь 2021 онд жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилготой мерчантын зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь банкны барьцаа хөрөнгийн шаардлагыг хангаж чадахгүй байгаа жижиглэн худалдаа эрхлэгчдийг өндөр хүүтэй өдрийн зээл, далд эдийн засгийн харилцаанаас сэргийлсэн чухал ач холбогдолтой үйл явдал байв.

"Сэндли ББСБ" ХК нь үйлчилгээ үзүүлдэг салбар нэгжийн тоогоороо банк бус санхүүгийн салбартаа тэргүүлдэг бөгөөд орон нутагт 48, Улаанбаатар хотод 6 нийт 54 салбараар уламжлалт болон цахим зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Монгол Улсад бизнес эрхэлж буй жижиглэн худалдаа эрхлэгчдийн богино хугацааны эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүрэн цогц экосистемийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ амжилттай хүргэж байна.

"Сэндли ББСБ" ХК нь 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр БНСУ-ын "Шинхан секьюритис" компанитай хамтын ажиллагааны гэрээг Сөүл хотноо байгуулсан нь "Дэлхийг хэрэх" уриатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн олон улсын зах зээлд бизнесээ тэлэх чухал дэвшил боллоо. "Сэндли ББСБ" ХК нь 2025 онд Солонгосын KOSDAQ хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаа буюу DR (Deposit receipt) гаргахад "Шинхан секьюритис" нь үндсэн зөвлөхөөр ажиллахаар болсон. DR гаргаснаар валютын ханш болон хувьцааны үнийн хэлбэлзлээс хамааран KOSDAQ болон Монголын хөрөнгийн бирж хооронд шилжин арилжаалах бололцоо хоёр орны хөрөнгө оруулагчдад бүрдэх юм.

Үнэт цаас гаргагчийн толгой компани нь өөрийн охин компаниудын зах зээлд эзлэх байр суурь, өрсөлдөх чадвар, үнэ цэнийг ямагт нэмэгдүүлэхэд удирдлагаар хангаж ажилладаг бөгөөд зэргэлдээ компани хоорондын синержи үүсгэн, харилцан бие биенээ дэмжин ажилладаг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн салбарт олон жил ажилласан туршлагатай, мэргэшсэн, ирээдүйн тогтвортой өсөлтийг бүрэн хангах чадвартай хэмээн үзэж байна.

СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

## 2. Үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв

- Макро эдийн засгийн ерөнхий төлөв:

Монгол Улсын ДНБ-ий өсөлт 2022 оны 3-дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.7 хувийн бодит өсөлттэй гарсан. 2020-оос 2021 оны хооронд дотоодод үргэлжилсэн Ковид-19 цар тахлын хөл хорио, хязгаарлалтын дэглэм нь эдийн засгийн үйл ажиллагааг бүхэлд нь агшихад хүргэсэн билээ. Энэхүү цар тахлын хөл хорионд хамгийн хүчтэй нэрвэгдсэн салбарууд нь худалдаа, үйлчилгээний салбарууд байсан юм. Гэвч Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний хүрээнд хөл хориог цуцалж иргэд аажмаар хэвийн амьдрал руу шилжиж байна. Энэхүү цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтэд жижиглэн болон бөөний худалдаа, хоол, зочлох үйлчилгээний салбарын өсөлт хамгийн их эерэг нөлөө үзүүлж байгааг ҮСХ-ноос мэдээлсэн.

Улсын инфляцын түвшин 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 14.5 хувь байсан нь 6-дугаар сараас эхлэн 9-дүгээр сар хүртэл дөрвөн сар дараалан буураад байсан үнийн өсөлт дахин идэвхжсэнийг харуулав. Инфляцын өсөлтийн 50 орчим хувийг импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт эзэлж байгааг Монголбанкнаас гаргасан 9 дүгээр сарын “Инфляцын тайлан”-д онцолсон байна. Инфляцын хүлээлтийн хувьд Украины дайнтай холбоотой геополитикийн хурцадмал байдал, тээвэр логистикийн саатал, урд хөрш БНХАУ-ын цар тахлын дэгдэлт нэмэгдсэн зэрэг нь инфляц дунд хугацаанд өндөр түвшинд хадгалагдах хүлээлт бий болгож байна.

Инфляцын өндөр түвшин нь эрэлтийг бууруулах, үйлдвэрлэлийн өртгийг өсгөх, зээлийн хүүгийн түвшинг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн тогтвортой өсөлтийг алдагдуулах хүчин зүйл болдог. Иймд инфляцыг барихын тулд Монголбанкны зүгээс мөнгөний бодлогын хүүг 2022 онд 5 удаа, оны эхнээс 7 нэгжээр өсгөж өнөөдрийн байдлаар 13.0 хувьд хүрсэн байна.

| Институт | 2023 E | |
|---|---|---|
| | Инфляц | Эдийн засгийн өсөлт |
| Олон Улсын Валютын Сан | 12.30% | 4.00% |
| Азийн хөгжлийн банк | 9.30% | 4.90% |
| Монгол Банк | 7.80% | 4.00% |
| Дундаж | 9.80% | 4.30% |

- Салбарын төлөв:

Үнэт цаас гаргагчийн голлох үйл ажиллагааны чиглэл нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон зээлийн үйлчилгээ билээ. 2022 оны 3-дугаар улирлын байдлаар Мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ, финтек шийдлийг ашиглан иргэдэд санхүүгийн үйлчилгээ хүргэж буй тогтворжсон 36 ББСБ, валютын арилжаа явуулдаг 4 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Финтек

Sendly ... УЛААНБААТАР ХОТ

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

шийдлээр аппликейшн ашиглан зээл олгодог 36 банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдэл нь 346.8 тэрбум төгрөг буюу нийт ББСБ-ийн салбарын зээлийн үлдэгдлийн 13.0 хувийг эзэлж байна. Зээлдэгчдийн тоогоор авч үзвэл финтек ББСБ-уудын нийт зээлдэгчдийн тоо 1.46 сая хүрчээ. Энэ нь ББСБ салбарын нийт зээлдэгчдийн 88.8 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд нэг зээлдэгчид дунджаар 237.5 мянган төгрөгийн зээл олгосон байна. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг финтек шийдэл ашиглан хүргэж буй 2 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас Үнэт цаас гаргагч нь зээлийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг хослуулан хүргэж буй анхны финтек компани юм.

- Мөнгөн гуйвуулгын зах зээлийн төлөв:

Дэлхийн мөнгөн гуйвуулгын зах зээл 2022 онд 794 тэрбум ам. доллараар хэмжигдэнэ гэсэн урьдчилсан төсөөллийг Дэлхийн банкнаас энэ оны 11 дүгээр сард гаргасан. Мөн түүнчлэн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өсөлт 2023 онд манай улсын оршиж буй Зүүн Азийн бүс нутагт 0.8 хувь байх бол бага, дунд орлоготой улс орнуудын хувьд 2.0 хувь байна гэж Дэлхийн банкны мөнгөн гуйвуулгын судалгааны тоймоос гарчээ. Дэлхий дахинд 200 ам.долларын мөнгөн гуйвуулга хийх зардал 6.0 хувь байгаа бол Үнэт цаас гаргагч нь мөнгөн гуйвуулгын үйлчилгээндээ 0.6-1.3 хувийн шимтгэл авч үйлчилгээ үзүүлж байна.

- Зах зээлийн багтаамж:

"Сэндли ББСБ" ХК-ийн үйлчилгээг мөнгөн гуйвуулга, хэрэглээний зээл, мерчантын зээл гэсэн үндсэн 3 сегментээр ангилан зах зээлийн багтаамжийг тооцоолов. Хэрэв "Сэндли ББСБ" ХК нь дотоодын мөнгөн гуйвуулгын зах зээлийн 50 хувь, мерчантын зах зээлийн 20 хувь, хэрэглээний зээлийн зах зээлийн 5 хувийг эзлэх юм бол дараах үр дүн гарч байна.

Сэндли ББСБ-ийн зах зээлийн нийт багтаамж

| Зах зээл | | Сэндли | |
|---|---|---|---|
| Боломжит нийт зах зээлийн багтаамж | Дүн /төгрөг/ | Зорилтот зах зээлийн багтаамж | Дүн /төгрөг/ |
| Мөнгөн гуйвуулгын зах зээл | 1.1 их наяд | Мөнгөн гуйвуулгын зах зээл | 550 тэрбум |
| Мерчантын зээлийн зах зээл | 1.2 их наяд | Мерчантын зээлийн зах зээл | 240 тэрбум |
| Хэрэглээний зээлийн зах зээл | 3.0 их наяд | Хэрэглээний зээлийн зах зээл | 150 тэрбум |
| Нийт боломжит зах зээл | 5.3 их наяд | Нийт зорилтот зах зээл | 940 тэрбум |

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад Сэндли ББСБ үйл ажиллагаа явуулж буй мөнгөн гүйлгээ, мерчант болон хэрэглээний зээлийн зах зээлийн нийт багтаамж 5.3 их наяд төгрөг байна. Үнэт цаас гаргагч нь боломжит нийт зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх стратеги хамтын ажиллагаа, санхүүгийн хүчин чадлаа өсгөх, олон улсын байгууллагуудтай хамтрах гэх мэт бүхий л талаар ажиллаж байна.

3. Бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

"Сэндли ББСБ" ХК байдлын тайлангийн төсөөллөөс дүгнэхэд нийт активын өсөлт 2023 онд 63.1 тэрбум төгрөг хүрэх төлөвлөгөөтэй байгаа бол 2025 он гэхэд 95.1 тэрбум төгрөг хүрэх тооцоололтой байна. Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу зээлийн үйлчилгээг идэвхжүүлж, санхүүгийн хөшүүргийг оновчтой ашигласнаар санхүүгийн үзүүлэлтээ хангаж ажиллах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө | | | | |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 33,563 | 62,756 | 81,698 | 94,944 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3,612 | 5,027 | 9,941 | 14,070 |
| Нийт зээл | 31,102 | 58,596 | 74,335 | 85,588 |
| *Эрсдэлийн сан* | *(1,313)* | *(3,383)* | *(5,810)* | *(8,414)* |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 131 | 2,030 | 2,606 | 2,983 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 32 | 487 | 626 | 716 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | 280 | 325 | 294 | 205 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 239 | 284 | 253 | 164 |
| Биет бус хөрөнгө (цэвэр) | 41 | 41 | 41 | 41 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | - | - | - | - |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 33,843 | 63,081 | 81,992 | 95,149 |
| Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | | | | |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 10,786 | 28,753 | 32,865 | 27,901 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 1,058 | 8,058 | 13,058 | 8,058 |
| Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр | 4,700 | 3,700 | 700 | - |
| Өрийн бичиг | - | 10,000 | 10,000 | 10,000 |
| Бусад өр төлбөр | 5,028 | 6,995 | 9,106 | 9,843 |
| ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ | 23,057 | 34,328 | 49,127 | 67,248 |
| Энгийн хувьцаа | 17,429 | 17,429 | 17,429 | 17,429 |
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал), эхний үлдэгдэл | 732 | 5,629 | 16,900 | 31,699 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал), эцсийн үлдэгдэл | 5,629 | 16,900 | 31,699 | 49,820 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН | 33,843 | 63,081 | 81,992 | 95,149 |

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлангийн төсөөлөл

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| Зээлийн бүтээгдэхүүний орлого | 11,407 | 25,467 | 32,874 | 37,392 |
| Зээлийн бүтээгдэхүүний зардал | (3,294) | (5,999) | (7,258) | (7,236) |
| Зээлийн бүтээгдэхүүний цэвэр орлого | 8,113 | 19,468 | 25,616 | 30,156 |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний орлого | 1,136 | 2,450 | 3,417 | 4,383 |
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний зарлага | (780) | (1,390) | (1,839) | (2,287) |
| Мөнгөн гүйвуулгын шимтгэлийн зардал | (607) | (1,217) | (1,666) | (2,114) |
| Апп-ын зардал | (96) | (96) | (96) | (96) |
| Платформ ашигласны төлбөр | (77) | (77) | (77) | (77) |

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

| | | | | |
|---|---|---|---|---|
| Мөнгөн гүйвуулгын үйлчилгээний цэвэр орлого | 356 | 1,060 | 1,578 | 2,096 |
| Нийт цэвэр орлого | 8,469 | 20,528 | 27,194 | 32,252 |
| Үйл ажиллагааны зардал | (3,013) | (4,857) | (6,134) | (6,616) |
| Хүү татвар, элэгдэл, хорогдлын өмнөх ашиг (EBITDA) | 5,456 | 15,671 | 21,060 | 25,636 |
| Элэгдлийн зардал | (59) | (81) | (89) | (89) |
| Хүү, татварын өмнөх ашиг (EBIT) | 5,397 | 15,590 | 20,971 | 25,547 |
| Хүүгийн зардал | - | 1,600 | 1,600 | 1,600 |
| Татварын өмнөх ашиг (алдагдал) | 5,397 | 13,990 | 19,371 | 23,947 |
| Татварын зардал | (500) | (2,719) | (4,572) | (5,826) |
| Цэвэр ашиг (алдагдал) | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн орлого үр дүнгийн тайлангийн төсөөлөл

| Сая төгрөг | 2022Т | 2023Т | 2024Т | 2025Т |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | |
| Цэвэр ашиг | 4,897 | 11,271 | 14,799 | 18,121 |
| Элэгдлийн зардал | 59 | 81 | 89 | 89 |
| Ажлын капиталын өөрчлөлт: | (16,462) | (25,810) | (11,916) | (8,380) |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (11,507) | (14,459) | 2,972 | 9,829 |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | | | |
| Үндсэн хөрөнгө худалдаж авсан | (8) | (126) | (58) | - |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | (8) | (126) | (58) | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан | 4,700 | 5,000 | 2,000 | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | (100) | (6,000) | (5,000) | (700) |
| Итгэлцлийн үйлчилгээ гаргасан | 1,058 | 10,000 | 15,000 | 10,000 |
| Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн | (2,580) | (3,000) | (10,000) | (15,000) |
| Хувьцаа гаргасан | 11,000 | - | - | - |
| Бонд гаргасан | - | 10,000 | 10,000 | 10,000 |
| Бонд төлсөн | - | - | (10,000) | (10,000) |
| Бусад | (121) | - | - | - |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 13,957 | 16,000 | 2,000 | (5,700) |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 2,442 | 1,415 | 4,914 | 4,129 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 1,169 | 3,612 | 5,027 | 9,941 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,612 | 5,027 | 9,941 | 14,070 |

Хүснэгт 3. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл

"Сэндли ББСБ" ХК-ийн зээлийн багц 2022 оны эцсийн байдлаар 31.1 тэрбум төгрөг байх ба нийт хөрөнгийн 91.9 хувийг эзлэхээр байна. Хэрэв зээл олголтын санхүүжилтээ төлөвлөсний дагуу нэмэгдүүлж, амжилттай эх үүсвэр татаж чадвал 2023-2025 оны хооронд нийт зээлийн багцын нийт хөрөнгөд эзлэх хувь дунджаар 91.2 хувьд хүрэх төсөөлөлтэй байна.

## 4. Хүүгийн түвшин тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо дотоодын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлт, банкны хадгаламжийн хүү, ижил төрлийн өрийн хэрэгслийн хүү зэргийг харгалзан бонд эзэмшигчдэд жилийн 19.2 хувийн хүүг санал болгож байна.

**ЗАХ ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ХАРЬЦУУЛАЛТ**




## 5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 85,000 (наян таван мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, эргэн худалдах нөхцөлтэй бондыг олон нийтэд санал болгож нийт 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Үнэт цаас гаргач нь энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулах юм.

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн (төгрөг) |
|---|---|---|
| 1 | Зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэх | 8,500.0 сая |

## 6. Эрсдэлийн бодлого

Үнэт цаас гаргагч нь “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг баталж эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, зорилт, үндсэн зарчим, төрөл, ангилал, хэрэгжүүлэх үе шат, шинжилгээ, тайлагнал, хяналт хариуцлагын талаар тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Мөн мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх журам” болон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”, “Дотоод хяналтын үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 16

Дотоод хяналт шалгалтыг газар дээрх болон зайны гэсэн хэлбэрээр зээл, нягтлан бодох бүртгэл, салбарын үйл ажиллагаа, мэдээлэл технологи, комплаенс, бусад гэсэн хүрээнд гүйцэтгэж байна. Сэндли ББСБ нь Covid-19 цар тахлын тархалт, дэгдэлтийн хугацаанд зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаанд болон ББСБ-д учирч болох эрсдэлийг тооцон түүний сөрөг нөлөөг бууруулах, зайлсхийх эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- ✓ Байгууллагын дотоод сүлжээ, серверт зайнаас хандаж онлайн горимоор ажиллах боломжийг fortclient программ ашиглан орон нутгийн бүх салбар, нэгжийн хүрээнд бүрдүүлсэн.
- ✓ Гамшгаас хамгаалах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан бүх нэгжид мөрдүүлсэн.
- ✓ 2021 онд нийт 295 мерчант зээлийн нэмэгдүүлсэн хүүг тэглэсэн.
- ✓ Цар тахлын нөлөө, барааны хомсдол, тээврийн үнийн өсөлт зэргээс шалтгаалан зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа доголдсон, зээлийн гэрээний хугацаа сунгах хүсэлт гаргасан 74 зээлдэгчийн 210 сая төгрөгийн зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулсан.

Эрсдэлийн удирдлагыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), Дотоод хяналт шалгалтын чиг үүрэг хариуцсан албан тушаалтан, Гүйцэтгэх удирдлага болон компанийн бусад ажилтнуудын түвшинд хэрэгжүүлж компанийн эрсдэлийн удирдлагын хяналт, хариуцлагын тогтолцоог дараах зохих дотоод журмын дагуу ханган ажиллаж байна. Үүнд:

- ✓ Компанийн үйл ажиллагаанд гарч болох эрсдэлийг бууруулах зорилгоор шат дараалсан болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, хяналтыг компанийн холбогдох албан тушаалтнууд батлагдсан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэнэ.
- ✓ Компанийн ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, бодлого, журам, заавар, гарын авлага, аргачлалын дагуу ажил үүргээ гүйцэтгэж үнэнч шударгаар ажиллана. Мөн компани хамт олны үнэт зүйл, эрхэм зорилт, ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээг хатуу баримтална.
- ✓ Компанийн ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, банкны хэмжээнд хэрэглэж буй журам, заавар, компанийн газар, нэгжийн дотоод үйл ажиллагааны журам, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон ажилтны ажлын байрны тодорхойлолтоор зохицуулна.

## 7. Хөрөнгө оруулалтын боломж

- Өндөр өгөөж

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 19.2 хувийн хүүг санал болгож байгаа нь 2022 онд Монгол хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдсан бонд,

хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-аас харьцангуй өндөр хүүтэй байна. 2022 оны 12 дугаар сарын Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн хурлаар бодлогын хүүг нэг нэгжээр өсгөж 13.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан нь зах зээл дээр шинээр гарч буй тогтмол хүүтэй үнэт цаасны суурь хүүг өсгөж байна. Мөн хөрөнгийн зах зээл дээр хамгийн сүүлд нээлттэй арилжаалагдсан "Инвескор Бонд 2.0" нь жилийн 18.0 хувийн хүүтэй гарсан ба тус бондын өгөөжөөс 1.2 пунктээр өндөр байгаа нь хөрөнгө оруулагч нарт хөрөнгөө илүү өндөр өгөөжтэй удирдах боломжийг олгож байгаа юм.

- Арилжааны боломж

Үнэт цаас гаргагчийн компанийн бонд нь Монгол хөрөнгийн биржийн систем дээр нээлттэй байршиж, олон нийтэд арилжаалагдах учраас бонд эзэмшигч нь хэрэгцээтэй үедээ худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр борлуулах, худалдан авах бүрэн боломжтой байна. Бондыг эзэмшиж буй хөрөнгө оруулагч нь зах зээл дээр хадгаламжийн хүү буурах эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа дөхөх тусам бондын үнэ өссөнөөр (the pull to par effect) ханшийн зөрүүнээс ашиг хүртэх боломжтой. Мөн Үнэт цаас гаргагчийн зүгээс хөрөнгө оруулагч нартаа бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сараас хойш бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй байхаар таатай нөхцөлийг санал болгож байна.

- Эргэн төлөгдөх барьцаа, батлан даалттай бонд

"Сэндли ББСБ ХК"-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс санхүүжилт татах зорилгоор гаргаж буй 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондын үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор Үнэт цаас гаргагч ба Андеррайтерууд нь харилцан тохиролцсоны үндсэн дээр толгой компани нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулна. Мөн СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.6-д заасны дагуу толгой компани "Монголын финтек групп" хаалттай ХК нь өөрийн эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцаагаар батлан даалт гаргасан болно.

## 8. Хөрөнгө оруулагчдад зөвлөх нь

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн танилцуулгын бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллүүд нь ирээдүйн макро эдийн засгийн орчин, хөрөнгийн зах зээлийн төлөв байдлын судалгаанд үндэслэсэн таамаглалууд дээр суурилж байгаа учраас нийгэм, эдийн засгийн урьдчилан таамаглах боломжгүй гэнэтийн шокуудын улмаас өөрчлөгдөж болно гэдгийг анхаарах нь зүйтэй.

Иймд хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан "Эрсдэлийн удирдлага", "Бизнес төлөвлөгөө",

“Зах зээлийн судалгаа” хэсгүүдтэй сайтар уншиж, танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

Бирж болон Хороонд хүргүүлж байгаа танилцуулга нь адил бөгөөд, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хоорондоо болон Үнэт цаас гаргагчтай аливаа сонирхлын зөрчилгүй болно.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав.

Овог, нэр: **Б.НАРАНБАТ**
Албан тушаал: **Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн дарга**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **Б.ОДГЭРЭЛ**
Албан тушаал: **Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн гүйцэтгэх захирал**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **М.МӨНХГЭРЭЛ**
Албан тушаал: **Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн Санхүү хариуцсан захирал**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **Х. ИЧИНХОРЛОО**
Албан тушаал: **Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **Б.ӨЛЗИЙБАЯР**
Албан тушаал: **Андеррайтерийн"Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК -ийн Гүйцэтгэх захирал**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **Н.ЦЭВЭГМИД**
Албан тушаал: **Андеррайтерийн"Райнос инвестмент ҮЦК"ХХК -ийн Дэд захирал**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

Овог, нэр: **С. ГАН-ЭРДЭНЭ**
Албан тушаал: **Андеррайтерийн"Голомт капитал ҮЦК" ХХК -ийн Гүйцэтгэх захирал**

**Гарын үсэг: ........................................................................ (Тамга/тэмдэг)**

СЗХ
БҮРТГЭВ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

/2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх аудитын тайлан/

"ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот
Утас: 70150001, 80110050
Цахим хаяг: www.shonkhor.mn
И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2022.12.30-ны 22/157

танай ______ -ны № ______ -т

"Сэндли ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

## АУДИТОРЫН ТАЙЛАН

**Дүгнэлт**

Бид "Сэндли ББСБ" ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний холбогдох тайлан, сонгон авсан тайлбар тодруулгад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр "Сэндли ББСБ" ХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү дүгнэлтийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



**Онцлох асуудал**

2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр буюу НББОУС 34-ийн дагуу бэлтгэгдсэн санхүүгийн тайлан тул өмнөх үеийн харьцуулах мэдээллийг 2021 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр авч үзсэн.

**Аудитын гол асуудлууд**

Аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба асуудал тус бүрээр тусад нь дүгнэлт гаргаагүй болно. Бидний хувьд үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд голлох нөлөөллийг үзүүлж байгаа зээл, түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын дүнгийн тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан. Бид зээл болон түүнтэй адилтгах хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг давтан тооцоолж үзэхэд тооцоолсон зээлийн болзошгүй эрсдэлийн сан санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээс хэтрэхээргүй байна. Мөн 2022 онд "Сэндли ББСБ" ХК-д нэгдсэн "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх шийдвэр болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийг шалгасан. Түүнчлэн 2022 онд хийгдсэн олон нийтэд санал болгон хувьцаа гаргасантай холбоотой үйл явдлыг авч үзсэн.

**Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тайлант нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай залилан үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг баримтлан санхүүгийн тайланг бэлтгэх үүрэгтэй.

**Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага**

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэх талаар боломжит үндэслэлтэй баталгааг олж авах, түүнчлэн аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.
Компанид хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, холбогдох тооцооллууд болон тодруулгууд үндэслэлтэй эсэхийг үнэлдэг.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



Түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэсээр хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж үзвэл бид аудиторын тайландаа холбогдох тодруулгыг хийх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Мөн компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй бүхий залилан ба алдааг бүрэн илэрхийлдэг гэсэн баталгаа биш юм. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залилт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудит хийх үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг.

**Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар**

Бид аудит хийж гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, Банк бус санхүүгийн байгууллагад мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас тогтоосон дүрэм, журмын биелэлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд дээр дурьдагдсан асуудлуудаар хууль, журмыг ноцтой зөрчсөн гэсэн үл үндэслэлтэй нотолгоо олдоогүй болно.

(Энэхүү дүгнэлт нь хавсралтын хамт хүчин төгөлдөр болно.)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ШИЙРЭВ

# ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Банк бус санхүүгийн байгууллагын (цаашид Компани гэх) Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл болон Санхүү хариуцсан захирал О.Нямдэлгэр бид энэхүү тайлангийн 1-25 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу материаллаг алдаагүй илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

**Балжиннямын Одгэрэл**
Гүйцэтгэх захирал

**Очирдоогийн Нямдэлгэр**
Санхүү хариуцсан захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2022 оны 12 дугаар сарын 28

СЗХ
БҮРТГЭВ
Сэндли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭ

## АУДИТЛАГДСАН САНХҮҮ БАЙДЛЫН ЗЭРЭГЦҮҮЛСЭН ТАЙЛАН

2022 оны 10 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"СЭНДЛИ ББСБ" ХК** (мян.төг)

| Балансын зүйл | Тодруулга | 2022.10.31 | 2021.10.31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгөн хөрөнгө | 6 | 6,175,961 | 4,188,236 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэвэрээр/ | 7 | 1,252,427 | - |
| Зээл /цэвэрээр/ | 8 | 15,602,981 | 3,782,503 |
| Бусад авлага | 9 | 4,020,796 | 1,376,462 |
| Бусад хөрөнгө | 9 | 701,736 | 171,895 |
| Эргэлтийн хөрөнгийн нийт дүн | | 27,753,901 | 9,519,096 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө | 10 | 201,675 | 75,302 |
| Биет бус хөрөнгө | 11 | 151,118 | 40,890 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 352,793 | 116,192 |
| **Нийт хөрөнгийн дүн** | | 28,106,294 | 9,635,288 |
| **Өр төлбөр** | | | |
| Богино хугацаат өр төлбөр | 12 | 1,812,575 | - |
| Бусад эх үүсвэр | 13 | 5,238,448 | 4,903,436 |
| Бусад өр төлбөр | 14 | 627,575 | 36,858 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | | 7,678,598 | 4,940,294 |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | 7,678,598 | 4,940,294 |
| **Эздийн өмч** | | | |
| Энгийн хувьцаа | 15 | 7,828,500 | 4,428,500 |
| Бусад өмч | 16 | 9,634,800 | |
| Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | 17 | 2,944,660 | 266,494 |
| Нийгмийн хөгжлийн сан | 18 | 19,737 | |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | | 20,427,696 | 4,694,994 |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | | 28,106,294 | 9,635,288 |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 оны 10 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"СЭНДЛИ ББСБ" ХК** (мян.төг)

| ҮЗҮҮЛЭЛТ | Тодруулга | 2022.10.31 | 2021.10.31 |
|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 3 | 3,041,995 | 197,183 |
| Хүүгийн зардал | 4 | 362,579 | - |
| Цэвэр хүүгийн орлого | | 2,679,416 | 197,183 |
| Хүүгийн бус орлого | 3 | 6,083,893 | 916,472 |
| Хүүгийн бус зардал | 4 | 5,661,529 | 963,805 |
| Цэвэр хүүгийн бус орлого зардлын дүн | | 422,364 | (47,332) |
| Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал | | 3,101,779 | 149,851 |
| Болзошгүй эрсдлийн зардал | | 723,795 | 909 |
| Үйл ажиллагааны ашиг | | 2,377,985 | 148,942 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | | 66,992 | 13,945 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал | 5 | 2,310,993 | 134,997 |
| Орлогын татварын зардал | 5 | 249,831 | 12,000 |
| **Цэвэр ашиг** | | **2,061,162** | **122,997** |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

## АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭРЭГЦҮҮЛСЭН ТАЙЛАН

2022 оны 10 сарын 31 -ний өдрөөр дуусгавар болсон хугацаанд

"СЭНДЛИ ББСБ" ХК

(мян.төг)

| ҮЗҮҮЛЭЛТ | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Нөөцийн хөрөнгийн сан | Бусад өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **1,428,500** | | | | 127,099 | 1,555,599 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 16,398 | 16,398 |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,428,500** | | | | 143,497 | 1,571,997 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт) | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт (бууралт) | | | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз (гарз) | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 122,997 | 122,997 |
| Ногдол ашиг | | | | | | |
| Хувьцаат капиталын өсөлт | 3,000,000 | | | | | 3,000,000 |
| **2021 оны 10 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **4,428,500** | | | | **266,494** | **4,694,994** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | |
| **Залруулсан үлдэгдэл** | **4,428,500** | | | | 266,494 | 4,694,994 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт (бууралт) | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт (бууралт) | | | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз (гарз) | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | | 2,061,162 | 2,061,162 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) залруулга үр | | | | | 617,004 | 617,004 |
| Сангуудын өөрчлөлт | | | | | | |
| Ногдол ашиг | | | | | | |
| Хувьцаат капиталын өсөлт | 3,400,000 | - | 19,737 | 9,634,800 | | 13,054,537 |
| **2022 оны 10 дугаар сарын 31-ний үлдэгдэл** | **7,828,500** | **-** | **19,737** | **9,634,800** | 2,944,660 | 20,427,696 |

Сэндли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

# АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ЗЭРЭГЦҮҮЛСЭН ТАЙЛАН

2022 оны 10 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант үе

**"СЭНДЛИ ББСБ" ХК** (мян.төг)

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022.10.31 | 2021.10.31 |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 2,054,718 | 3,277,171 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 9,125,887 | 4,107,213 |
| Зээлийн хүүгийн орлого | 3,040,665 | 197,183 |
| Үнэт цаасны хүүгийн орлого | 1,330 | - |
| Гадаад валютын арилжааны орлого | 166,486 | 51,102 |
| Гадаад валютын ханшийн зөрүү | 1,365,022 | - |
| Үнэт цаасны үнэлгээний зөрүү | - | 212,157 |
| Мөнгөн гуйвуулгын орлого | 237,566 | 219,155 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 4,284,596 | 434,059 |
| Бусад үйлчилгээний орлого | 10,222 | 2,993,558 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 7,071,170 | 830,042 |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | 362,579 | - |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | 1,074,334 | 234,363 |
| Ажилтнуудад олгосон нэмэлт шагнал, тэтгэмж | 2,367 | - |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | 133,419 | 26,287 |
| Албан томилолт, сургалтын зардал | 31,659 | 100 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 176,270 | 99,825 |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 62,275 | 14,240 |
| Бичиг хэргийн зардал, хэвлэлийн зардал | 34,612 | 7,964 |
| Татвар, даатгалд төлсөн мөнгө | 957 | - |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | 429,746 | 62,751 |
| Зээл болон түүнтэй холбоотой ашиглалт баригдуулахтай холбогдон гарсан мөнгө | 100 | 275 |
| Нягтлангийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө | 839,253 | - |
| Аудитын төлбөр, зөвлөх үйлчилгээний мөнгө | 280,656 | 194,941 |
| Зохицуулагчийн үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | 4,100 | - |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | 3,638,624 | 189,296 |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | (66,992) | (13,945) |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого | - | - |
| Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага | 66,992 | 13,945 |
| Байр болон, зочин төлөөлөгчийн зардал | 40,660 | 11,231 |
| Торгуулийн зардал | 1,410 | - |
| Бусад | 24,922 | 2,714 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 1,987,726 | 3,263,227 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,188,236 | 925,009 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 6,175,961 | 4,188,236 |

УЛААНБААТАР ХОТ

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

## 1. ББСБ-ын талаарх мэдээлэл

Сэндли ББСБ ХК нь 2015 оны 05 сард банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор анх Гэлс кредит ББСБ нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. Монгол улсын бүртгэлийн албанд бүртгэгдсэн ба хуулийн этгээдийн регистерийн дугаар 5961548, улсын бүртгэлийн дугаар 9015003084. Тус компанийн хувьд 2021 оны сүүлийн хагас жилээс хойш үйл ажиллагаагаа идэвхжүүлэн өргөжүүлсэн байгаа бөгөөд 2021 оны 12 дугаар сард оноосон нэрээ өөрчлөн Сэндли ББСБ ХК болгон өөрчилсөн байна. 2022 оны 5 дугаар сард Гэгээн алтан од ББСБ-ыг нэгтгэсэн байна. Мөн 2022 оны 9 сард 67,000,000 ширхэг хувьцааг нэрлэсэн үнэ 150 төгрөгөөр анхдагч зах зээлд гаргасан. Одоогийн байдлаар Улаанбаатар хотод 6 салбар, Орон нутагт 48 салбартайгаар Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөл авсан үйл ажиллагааны төрлүүд:

- Зээлийн үйл ажиллагаа
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа
- Гадаад валютын арилжаа
- Итгэлцлийн үйл ажиллагаа
- Факторингийн үйлчилгээ
- Төлбөрийн баталгаа гаргах

Албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, 40/50 мянгат Бакула Ринбүчийн гудамж 8/4 тоот.

## 2. Нэгтгэн бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

*Тайлан бэлтгэх үндэслэл*

Эдгээр санхүүгийн тайлангуудыг "Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого"-ын дагуу толилуулсанаар бэлтгэсэн.

Сэндли ББСБ –ын санхүүгийн тайлангууд нь түүхэн өртгийн зарчим дээр үндэслэн бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасанаас бусад тохиолдолд мянгачлан, Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнасан.

Өөрөөр заагаагүй бол тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай мөрдсөн болно.

*Санхүүгийн хэрэглүүрүүд – Хэмжилтийн үндсэн зарчмууд*

Санхүүгийн хэрэглүүрүүдийг ангиллаас нь хамааруулан бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр доор тайлбарласны дагуу бүртгэл хөтөлдөг.

*Бодит* үнэ цэнэ нь хэмжилт хийгдэх өдрөөр тухайн зах зээлд оролцогчдын хоорондын арилжаагаар байгууллага хийгдэх хөрөнгийн худалдах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг хамгийн сайн илэрхийлэх дүн нь тухайн идэвхтэй зах зээлийн арилжааны үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангалттай түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаг буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгө болон өр төлбөрийн үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн тоо ширхэгээр үржүүлэн гаргана.

Гадаад зах зээлийн үнийн мэдээлэл авах боломжгүй санхүүгийн зарим хэрэгслийн бодит үнэ цэнийг хэмжихэд бэлэн мөнгөний урсгалын хөнгөлөлттэй загвар эсвэл сүүлийн үеийн гүйлгээний дүн эсвэл хөрөнгө оруулагчдын санхүүгийн мэдээллийг харгалзан үзэх зэрэг үнэлгээний аргачлалыг ашигладаг.

Бодит үнэ цэнийг дотор нь түвшингээр нь ангилан тодорхойлох ба эдгээр түвшинг дараах байдлаар тодорхойлно. Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийг идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 1-р түвшин, тухайн хөрөнгө болон өр төлбөртэй холбоотой шууд (үнэ) болон шууд бус (үнэ) боломжит өгөгдлүүдийг ашиглан, үнэлгээний аргуудаар бодит үнэ цэнийг тооцоолон гаргасан бол 2-р түвшин, зах зээл дээрх бэлэн

өгөгдлүүд дээр бус зах зээл дээр мэдэгдэхгүй байгаа өгөгдлүүдийг илүү тулгаарлан бодит үнэ цэнийг хэмжсэн бол 3-р түвшний бодит үнэ цэнэ гэж үзэх тус тус ангилна.

*Өртөг* гэдэг нь хөрөнгийг худалдан авах үед мөнгөөр болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн бодит үнэ цэнэ бөгөөд үүнд хөрөнгө худалдан авахтай холбоотой гарсан аливаа гүйлгээний зардлууд ч мөн багтана. Бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй эсвэл хөрөнгийн зах зээлээс үнийг нь тодорхойлох боломжгүй, өмчөөрх хөрөнгө оруулалт болон дээрхтэй адил өмчийн хэрэглүүрээр нэгтгэгдэх үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг өртгөөр нь хэмжинэ.

*Гүйлгээний зардлууд* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал гэдэг нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх байсан зардал юм. Гүйлгээний зардалд зээл олгох, нягтлан бодох бүртгэл хөтлөх үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд, зөвлөх, хуулийн болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулалтын үйлчилгээний төлбөр болон банкны шимтгэл, хураамж төлбөрүүд, мөн гадаад гүйлгээ, дотоодын банк, банк санхүүгийн байгууллагад шилжүүлэх эр төлбөрийн шилжүүлэг, ХАОАТатвар, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх татвар хураамжууд хамаарна. Мөн гүйлгээний зардалд репо зээлийн өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүжилтийн зардлууд, дотоод удирдлагын буюу итгэмжлийн үйлчилгээний өглөгийн зардлууд орно.

*Хорогдуулсан өртөг* нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс үндсэн дүнгийн аливаа эргэн төлөлтийг хасан, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлуулсан гүйлгээний зардал, мөн үнийн аливаа нэмэгдэл эсвэл хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлуулсан шимтгэлийн хамт) тусад нь толилуулахгүй бөгөөд тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох зүйлийн дансны үнэд оруулан тусгасан болно.

**2 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (Үргэлжлэл)**

*Үр ашигт хүүгийн арга* нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргах авах хүүгийн хувь болно.

Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл дискаунтлах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг мөн зах зээлийн түвшинд тохируулагдаагүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

***Санхүүгийн хөрөнгийн ангилал***

Санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. (а) зээл болон авлага; (б) худалдан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө; (в) хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө; болон (г) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, үр дүнгийн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийг дотор нь 2 ангилдаг: (i) анх хүлээн зөвшөөрөх үед ийнхүү ангилагдсан, (ii) худалдан борлуулах зорилгоор эзэмшихээр болсон. ББСБ-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгө нь бүгд "зээл болон авлага" гэж ангилагдсан. Зээл болон авлагад ББСБ нь ойрын хугацаанд худалдан борлуулах зорилготой байгаа санхүүгийн хөрөнгүүдээс бусад тодорхойлж болохуйц эсвэл тогтмол төлбөртэй, деривативгүй, харьцуулагдахуйц бус санхүүгийн хөрөнгүүд орно.

он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

***Санхүүгийн өр төлбөрийн ангилал***

ББСБ-ын бүх санхүүгийн өр төлбөрүүдийг бусад санхүүгийн өр төлбөр ангилалд ангилж, хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

***Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрөх***

Бүх санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн найдвартай нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ байдаг. Бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн хоорондох зөрүү үүсэх нөхцөлд л тухайн зөрүү дүнгээр анхдагч хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг бүртгэх бөгөөд энэхүү бодит үнэ цэнэ нь ижил төрлийн хэрэглүүрийн саяхан арилжаалагдсан үнэ болох нь эсвэл зөвхөн зах зээл дээрээс бэлэн олж болохуйц мэдээлэл дээр үндэслэх үнэлгээний аргачлалаар тооцсон болох нь нотлогдсон байх ёстой. Тухайн санхүүгийн хэрэглүүрийг зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон ("энгийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан хүлээлгэн өгөх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа, худалдан авалтын арилжаа хийсэн өдөр буюу ББСБ нь санхүүгийн хөрөнгийг хүлээлгэн өгөх үүрэг хүлээсэн өдрөөр хүлээн зөвшөөрнө. Бусад бүх худалдан авалтыг ББСБ нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

***Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх***

ББСБ-ын санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг хүлээн авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) ББСБ нь хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл шаардлага хангасан, дамжуулан өгөх хэлцэл оролцооны үр дүнд (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэндээ шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь шилжүүлээгүй мөн авч үлдээгүй боловч хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Нөгөө тал нь хөрөнгийг бүхэлд нь гуравдагч этгээдэд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр борлуулах бодит боломжтой байгаа нөхцөлд хяналтыг авч үлдсэнд тооцно.

***Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх***

Санхүүгийн өр төлбөрийн төлөх үүргийн хугацаа дууссан, санхүүгийн өр төлбөр төлөх үүргээс чөлөөлөгдсөн болон уг өр төлбөрийг төлөх үүрэг дуусгавар болсон үед санхүүгийн өр төлбөрийг данснаас хасна.

Санхүүгийн өр төлбөрийн хугацаа дуусаагүй үед тухайн өр төлбөрийн нөхцөл их хэмжээгээр өөрчлөгдсөн үед эсвэл зээлдүүлэгчээс хуучин өр төлбөрийнхөө оронд өөр нөхцөлтэй, шинэ өр төлбөр сольж хүлээж авсан тохиолдолд өмнөх өр төлбөрийг данснаас хасч, шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд шинэ болон хуучин өр төлбөрийн дансны үнийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

***Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт***

"Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах" журмыг СЗХ-ны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 145/124 тоот хамтарсан тушаалаар баталсан. Уг журмын дагуу олгосон зээлийг хугацаа хэтэрсэн хоногоос хамааран 5 ангилах ба ангилал тус бүрт урьдчилан тогтоосон, тогтмол хувиар үнэ цэнийн бууралтын санг тооцоолдог.

Зээлийн үнэ цэнийн бууралтын сан тооцох хувийг доорх хүснэгтээр харуулав:

| | Хэвийн | Хугацаа хэтэрсэн | Хэвийн бус | Эргэлзээтэй | Муу |
|---|---|---|---|---|---|
| Хугацаа хэтэрсэн хоног | Хугацаандаа төлөгдөж байгаа | 1-90 хоног | 91-180 хоног | 181-360 хоног | 360 хоногоос дээш |
| Зээлийн эрсдлийн сангийн хувь /%/ | 0% | 5% | 25% | 50% | 100% |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

***Дотоод хяналт шалгалт***

Гүйцэтгэх захирлын шууд удирдлаган дор дотоод хяналтын газар 2 орон тоотойгоор жил удирдлын төлөвлөгөө батлуулан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийдэг. 2022 оны 10 дугаар сарын 31-нийг дуустлах хугацаанд төв, орон нутгийн 8 нэгжид шалгалт хийж гүйцэтгэсэн байна. Мөн зайны хяналт шалгалтыг өөрийн байгууллагын дотоод ERP программ ашиглан зээлийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоодын дансны үйл ажиллагаа гэсэн чиглэлүүдээр сар бүр хийсэн байна.

***Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө***

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө, банкинд байршуулсан харилцах, хугацаагүй хадгаламжууд, банкинд 3 сар болон түүнээс бага хугацаатай байршуулсан богино хугацаат хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтууд орно. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хязгаарлалттай дансуудыг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

***Үйл ажиллагааны түрээс***

ББСБ нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнх эрсдэл болон өгөөж нь түрээслүүлэгчээс ББСБ-д шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж, тухайн тайлант хугацааны орлого, үр дүнгийн тайланд (түрээсийн зардлаар) бүртгэнэ. Түрээслэгч тал нь нэмэгдэл төлбөртэй болон төлбөргүйгээр хөрөнгөө үргэлжлүүлэн түрээслүүлэх эрхтэй ба түрээсийн хугацааны эхэнд тухайн эрхээ ирээдүйд хэрэгжүүлнэ гэсэн тодорхой үндэслэлтэй үед түрээсийн гэрээний нөхцлийг тухайн хугацаанд цуцлах боломжгүй байна. Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

***Үндсэн хөрөнгө***

ББСБ-ын эзэмшиж буй үндсэн хөрөнгүүдийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр тусгана. Урсгал засвар, үйлчилгээний өртгийг гарсан үед нь зардлаар бүртгэнэ.

Үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг шинэчилсэн бол, холбогдох өртгийг капиталжуулж, хүчин сольсон хэсгийн дансны үнийг зарлагадана.

Тайлант хугацааны эцэст удирдлага үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх аливаа үзүүлэлт байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв ийм үзүүлэлт байгаа нөхцөлд хөрөнгийн нөхөгдөх үнийг тооцоолох ба энэ хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлогддог. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулан үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэдэг. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан тооцоолол өөрчлөгдсөн нөхцөлд өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцааж болно.

Хөрөнгө борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг дансны дүнтэй харьцуулан тооцож, тухайн жилийн орлого, үр дүнгийн тайланд бүртгэнэ (үйл ажиллагааны бус орлого, зардал хэсэгт).

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

| | Ашиглалтын хугацаа /жилээр/ |
|---|---|
| Барилга | 25 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Тавилга эд хогшил | 10 жил |
| Компьютер, дагалдах хэрэгсэл | 2 жил |

Хэрэв хөрөнгө хуучирсан, ашиглалтын хугацаа нь дууссан бол хөрөнгийн үлдэх өртгийг ББСБ-ын хөрөнгийг борлуулах боломжит үнээс худалдан борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээр

он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Тооцоолно. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчилнө.

*Биет бус хөрөнгө*

Гүүдвиллээс бусад биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд ББСБ-ын үндсэн биет бус хөрөнгө нь компьютерийн програм хангамж юм.

Худалдан авсан программ хангамжийг өртөг дээр нь тэдгээрийг ашиглахад бэлэн болгохтой холбогдон гарсан зардлыг нэмсэн дүнгээр хүлээн зөвшөөрнө.

| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 33,467,231.33 | 925,009,112.45 |

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.*

АУДИТЛАГДСАН
2021.01.24

СЭНДЛИ ББСБ ХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

"Тэлс кредит ББСБ" ХХК-ний Санхүүгийн тайлангийн тодруулгууд 2020 оны 12 сарын 31-нээрх болон үг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 1 - Товч танилцуулга**

**1.1. Компанийн тухай:**

"Тэлс кредит ББСБ" ХХК

(Аж ахуйн нэгжийн нэр)

Регистр: 5961548

Улсын бүртгэлийн дугаар: 9015003084

Захирал: Ч.Дашсүрэн — Утас: 70127700 — е-мэйл:

Ня-бо: О.Нямдалаг — Утас: 99998149 — е-мэйл: nimgee22@gmail.com

**Өмчийн хэлбэр:**

ББСБ, 100 хувь хувийн.

**Компанийн байршил хаяг:**

УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Центр 34 төв А корпус 1 тоот

**Харилцдаг санхүү, татварын байгууллага:**

Баянгол дүүргийн санхүү төрийн сангийн хэлтэс, татварын байгууллагатай харилцдаг.

**1.2. Үйл ажиллагааны чиглэл:**

"Зээлийн үйл ажиллагаа"-ны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

**ТОДОТГОЛ 2 - Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого**

**2.1. Санхүүгийн тайлагналын суурь**

Компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар акруэл сууриар бэлтгэгдсэн байна.

Компани нь нягтлан бодох бүртгэлээ тэргэвээр бүртгэдэг ба нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу явагдаж байна.

**2.2. Санхүүгийн тайлант бэлтгэсэн байдал**

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ санхүү бүртгэлийн MS Excel программ ашиглан гаргадаг.

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгануудаас бүрдсэн байна.

**2.3. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим**

Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид ч гэсэн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Дээрх тасралтгүй үйл ажиллагааны талаарх төсөөлөл нь үр дүн нь тодорхойгүй байгаа ирээдүйд болж болох үйл явцад суурилсан болно.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

"Тэлс кредит ББСБ" ХХК-ний Санхүүгийн тайлангийн тодруулгууд 2020 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дууссан болсон жилийн хувьд

**2.4. Санхүүгийн хэрэгслүүд**

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, зээлийн болон зээлийн хүүгийн авлагаас бүрдэнэ.

**2.5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь мөнгө, түүнтэй адилтгах зүйлсээс бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.

**2.6. Авлага/зээл**

Компанийн авлага нь зээл, зээлийн хүүгийн авлагаас бүрдэнэ. Зээлийн цэвэр үлдэгдэл нь үндсэн зээлийн дүнгээс зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлийг хассан дүнгээр илэрхийлэгдэнэ.

**2.7. Үндсэн хөрөнгө**

***Өртөг:*** Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, гаалийн татвар, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлуудаас бүрдсэн.

***Элэгдэл:*** Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг.

| | | |
|---|---|---|
| Тоног төхөөрөмж | 10 жил | 10% |
| Компьютер түүний дагалдах хэрэгсэл | 5 жил | 20% |
| Тавилга эд хогшил | 10 жил | 10% |

**2.8. Биет бус хөрөнгө**

***Өртөг:*** Биет бус хөрөнгө нь ашиглагдах биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөөр илэрхийлэгдэхгүй хөрөнгө бөгөөд дараах 2 шалгуурын аль нэгийг хангаж байвал тодорхойлогдох хөрөнгө гэж үзнэ.

Аж ахуйн нэгж хөрөнгийг холбогдох гэрээ, хөрөнгө, өр төлбөрийн түрээслэж, борлуулж, шилжүүлж, солилцож байвал энэ хөрөнгийг тусад нь авч үзэх боломжтой гэж үзвэл

Биет бус хөрөнгө нь гэрээний буюу бусад хууль эрхийн акын дагуу тодгээр эрхийн шилжүүлэгдэх эсвэл тусад нь авч үзэх шинж чанараас нь үл хамааран үүсч байвал

Биет бус хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцно.

**2.9. Өглөг**

Өр төлбөр, өглөгийг бусад компанид төлөх гэрээний эрх үүссэн хариуцлагаар хүлээн зөвшөөрнө. Компани нь өр төлбөрийг төлж барагдуулснаар эдийн засгийн үр ашгийг агуулж байгаа хөрөнгө, нөөц бууруулах магадлалтай.

**2.10. Орлого**

Орлогыг нягтлан бодох бүртгэлийн өсөлт суурьтаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.Орлого хүлээн зөвшөөрөх цаг үеийг тодорхойлон эдийн засгийн үр өгөөжийг хүртэх магадлалтай, үнэн бодитойгоор хэмжих боломжтой байгаа нөхцөлд бүртгэнэ.

СЭНДЛИ ББСБ ХК
9022121175
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ



**2.11. Өртөг, зардал**

Үйл ажиллагааны зардал, өртөг нь цалин хөлсний зардал, бусад үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлаас бүрдэнэ.

**2.12. Татвар**

***ААНОАТ:*** Тус компанийн үйл ажиллагаа нь тайлант хугацаанд СТОУС-ын дагуу санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон татварын өмнөх ашгийг Монгол улсын ААНОАТ-ын хууль, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу татвараас чөлөөлөгдөх орлого болон татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулан орлогын албан татварыг тодорхойлдог ба санхүүгийн тайлагналыг тасалбар болгох өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээг мөрдөн татварын тооцооллыг хийдэг.

***НД, ХХОАТ:*** НД болон ХХОАТ-ын хуулийн дагуу суутган авч төсөөт төлдөг.

**ТОДОТГОЛ 3 - Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| **Бэлэн мөнгө** | | |
| **Төгрөг** | 119,338.37 | 119,338.37 |
| **Бэлэн мөнгөний үлдэгдэл** | 119,338.37 | 119,338.37 |
| **Банкин дахь харилцах дансны мөнгө** | | |
| **Төгрөг** | 33,347,892.96 | 81,263,870.89 |
| **Гадаад валютын** | | 843,625,903.19 |
| **Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | 33,347,892.96 | 924,889,774.08 |
| **Нийт дүн** | 33,467,231.33 | 925,009,112.45 |

**ТОДОТГОЛ 4 - Зээл**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Хэвийн зээл | 1,017,134,002.18 | 663,053,488.77 |
| Муу зээл | 44,000,000.00 | 44,000,000.00 |
| Зээлийн эрсдлийн сан | (44,000,000.00) | (44,000,000.00) |
| Нийт дүн | 1,017,134,002.18 | 663,053,488.77 |

**ТОДОТГОЛ 5 - Бусад авлага**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага | 332,756,064.27 | 221,145,333.10 |
| Орлогын албан татварын авлага | 20,322,113.20 | - |
| Бусад авлага | - | - |
| Нийт дүн | 353,078,177.47 | 221,145,333.10 |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ

"Гялс кредит ББСБ" ХХК-ний Санхүүгийн тайлангийн тодруулгууд 2020 оны 12 сарын 31-нээрх болон үг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 6 - Бусад хөрөнгө**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Материал,үнэ бүхий зүйл | 4,785,500.00 | 210,000.00 |
| бусад | 72,763,738.50 | 3,491,244.97 |
| Нийт дүн | 77,549,238.50 | 3,701,244.97 |

**ТОДОТГОЛ 7 - Үндсэн хөрөнгө**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Тээврийн хэрэгсэл | 21,591,300.00 | - |
| Хуримтлагдсан элэгдэл | (4,107,155.40) | - |
| Тавилга, эд хогшил | 6,094,030.00 | 9,833,602.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (609,403.00) | (2,069,352.64) |
| Компьютер техник хэрэгсэл | 2,244,600.00 | 30,296,750.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | - | (21,382,562.99) |
| Нийт дүн | 25,213,371.60 | 16,678,436.37 |

**ТОДОТГОЛ 8 - Биет бус хөрөнгө**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Бусад биет бус хөрөнгө | - | - |
| програм хангамж | 344,287,009.00 | 59,849,781.33 |
| Хуримтлагдсан элэгдэл / биет бус хөрөнө / | | - |
| Нийт дүн | 344,287,009.00 | 59,849,781.33 |

**ТОДОТГОЛ 9 - Богино хугацаат өр төлбөр**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Бусад өглөг | 457,415,493.46 | 321,785,810.03 |
| Цалингийн өглөг | | 52,785.87 |
| Орлого татварын өглөг | | - |
| Нийт дүн | 457,415,493.46 | 321,838,595.90 |

СЭНДИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

"Гялс кредит ББСБ" ХХК-ний Санхүүгийн тайлангийн тодруулгууд 2020 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дууссан болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 10 - Эздийн өмч**

( төгрөгөөр)

| Төрөл | | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|---|
| Өмч | а) төрийн | - | - |
| | б) хувийн | 1,428,500,000.00 | 1,428,500,000.00 |
| | в) хувьцаат | - | - |
| **Дүн** | | **1,428,500,000.00** | **1,428,500,000.00** |
| **Тайлант үеийн ашиг (алдагдал)** | | **(230,336,800.00)** | **205,513,198.67** |
| **Өмнөх үеийн ашиг (алдагдал)** | | **165,150,334.62** | **(66,414,397.58)** |
| **Хуримтлагдсан ашиг алдагдал дүн** | | **(45,186,465.38)** | **139,098,801.09** |
| **Нийт дүн** | | **1,383,313,534.62** | **1,567,598,801.09** |

**ТОДОТГОЛ 11 - Хүүгийн орлого**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Зээлийн хүүгийн орлого /хугацаандаа байгаа/ | 119,480,417.52 | 379,781,113.93 |
| Зээлийн хүүгийн орлого /хугацаа хэтэрсэн/ | | 64,813,806.22 |
| Банкин дахь харилцах дансны хүүгийн орлого | 81,524.78 | 26,569.74 |
| Цэвэр хүүгийн орлогын дүн | 119,561,942.30 | 444,601,491.89 |

**ТОДОТГОЛ 12 - Хүүгийн бус орлого**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого | 261,900.00 | 80,149,226.58 |
| валютын арилжааны орлого | | 285,875.42 |
| валютын ханшийн тэгшитгэлийн орлого | 339,400.00 | 248,332,909.56 |
| Бусад | | 222,182.37 |
| **Нийт дүн** | 601,300.00 | 328,990,193.93 |

**ТОДОТГОЛ 13 - Үндсэн бус үйл ажиллагааны зардал**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Зочин төлөөлөгчийн зардал | 272,100.00 | 305,600.00 |
| Торгуулийн зардал | 2,460,930.50 | 30,500,000.00 |
| Баяр ёслолын зардал | 1,310,000.00 | - |
| Бусад | - | - |
| **Нийт дүн** | 4,043,030.50 | 30,805,600.00 |

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

"Тэлс кредит ББСБ" ХХК-ний Санхүүгийн тайлангийн тодруулгууд 2020 оны 12 сарын 31-нээрх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн хувьд

**ТОДОТГОЛ 14 - Хүүгийн бус зардал**

( төгрөгөөр)

| Төрөл | 2019.12.31 | 2020.12.31 |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | 65,683,412.00 | 91,551,998.00 |
| Гэрээгээр ажиллагчдын ажлын хөлс | 52,689,000.00 | 20,184,042.00 |
| Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал | 11,636,546.00 | 5,722,669.00 |
| Заал болон түүнтэй холбоотой ашиглалт баргагдуулах зардал | 2,041,400.00 | 9,851,000.00 |
| Албан томилолтын зардал | 2,479,655.00 | 977,978.00 |
| Бичиг хэргийн зардал | 1,161,600.00 | 781,260.00 |
| Шуудан холбоо, интернэтийн зардал | 9,418,724.73 | 4,192,511.90 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 150,096,600.00 | 256,341,039.00 |
| Сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардал | 8,200,700.00 | - |
| Элэгдэл, хорогдлын зардал | - | 18,735,357.23 |
| Түрээсийн зардал | 7,125,000.00 | 9,000,000.00 |
| Автоматжуулалттай холбоотой урсгал зардал | 2,286,836.55 | 96,752,137.31 |
| Хөдөлмөр хамгааллын зардал галын аюулаас хамгаалах зардал | 230,000.00 | - |
| Сургалтын зардал | 250,000.00 | 1,948,413.00 |
| Ариун цэврийн зардал | 451,800.00 | 416,510.00 |
| Зар сурталчилгааны зардал | 790,000.00 | 10,949,362.66 |
| Зохицуулалтын хураамжийн төлбөр | 1,980,000.00 | 2,320,000.00 |
| Шатахууны зардал | 679,500.00 | 57,000.00 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | | 1,000,000.00 |
| Бусад зардал | 29,256,235.52 | 6,491,608.96 |
| Нийт дүн | 346,457,011.80 | 537,272,887.15 |

**ТОДОТГОЛ 15 - Холбоотой талуудтай хийсэн гүйлгээ**

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан, зохих тодруулга хийгдсэн.

**ТОДОТГОЛ 16 - Болзошгүй өр төлбөр**

Тус компанид 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

**ТОДОТГОЛ 17 - Балансын дараах үйл явц**

"Тэлс кредит ББСБ" ХХК-ийн 2020 оны 12 -р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

Хүндэтгэсэн,
Аудитор............................ Ц.Чанцалдулам
(Аудитор, мэргэшсэн нягтлан бодогч)

АУДИТОР
СЭНЛЛИ ББСБ ХК
Senlly

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

" ГЯЛС КРЕДИТ ББСБ" ХХК-ИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Жуулчны гудамж Центр 34 тоот, 5 давхар, 500 тоот
Утас/ Факс: (976) 96000004
E-mail: ChadvarlagAUDIT@gmail.com

2021.01.29 № 21/05

УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ

"Гялс кредит ББСБ" ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийх явцад бидний анхаарлыг татсан санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг энэхүү тайланд багтаасан болно.

Дотоод хяналтын системийн талаар гүйцэтгэсэн горим нь тус компанийн 2020 оны 12 сарын 31-наарх болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд аудит хийхтэй холбоотойгоор хяналтын орчны талаар ойлголт авах явдлаар хязгаарлагддаг билээ. Иймд энэхүү горимыг гүйцэтгэх явцад бидний анхааралд өртсөн тодорхой зүйлүүдийг удирдлагад хүргэх зорилгоор энэхүү тайланг толилуулав.

Бидний хийсэн энэ шалгалтын горим нь хяналтын бүх процедур ба өргөчлөлыг тодорхойлж, дэлгэрэнгүй буюу нарийвчилсан зөвлөмж, заавар өгөх зорилгогүй юм.

Энэхүү тайланг зөвхөн компанийн удирдлагад зориулан бэлтгэснээс бус өөр бусад зорилго агуулаагүй болно.

Тайланд бичигдсэн эдгээр зөвлөмжүүдийн талаар ярилцах эсвэл тэдгээрийг хэрэгжүүлэх өөлд туслахад бид бэлэн байх болно.

Санхүүгийн тайланд аудит хийх явцад танай компанийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлд ажиглагдсан зөрчил дутагдал, түүнийг цаашид засч залруулах, сайжруулах талаар бидний өгсөн дараах зөвлөмжүүдийг ажил хэрэг болгоход анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

Энэхүү аудитын ажилд хамтран ажилласан болон аудитын ажлын явцад туслалцаа үзүүлж байсан явдалд компанийн удирдлага, ажилтнуудад талархалаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ Д.РЭНЦЭНХАНД

ЧАДВАРЛАГ АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

"Гэлс кредит ББСБ" ХХК Санхүүгийн тайланд өгөх зөвлөмжүүд 2020 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Бид санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системийг сайжруулахтай холбогдуулан дараах зөвлөмжүүдийг өгч байна.

**Нягтлан бодох бүртгэлийн талаар**
Бодит байдал:

Тус компани нь одоогийн байдлаар боловсруулан эцэслэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Зөвлөмж:

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг; мөн хуулийн 18.2.-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн, өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах.

**Санхүүгийн тайлан бэлтгэсэн талаар**
Бодит байдал:

- ААНОТатвар, санхүү болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайланд 42,819,709.69 төгрөгийн алдагдалтай гарсан ба санхүүгийн тайландаа 12,905,820.00 төгрөгийг татварын зардал бичиж хуримтлагдсан ашгийн хэмжээг бууруулан тайлагнасан.
- ААНБОАТатварын тайланд алдагдалтай татвар ногдуулаагүй байхад 12,000,000.00 төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан байна.

Зөвлөмж:

Санхүүгийн тайлан болон орлого үр дүнгийн тайланд 12,905,820.00 төгрөгийн татварын зардлыг хасч залруулан, хуримтлагдсан ашгийн хэмжээг нэмэгдүүлэх.

Өмнөх оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өрийг тайланд 1,201,896.69 төгрөгөөр залруулан тайлагнах

Цаашид санхүү, татварын тайланд татварын өглөг, авлагын үлдэгдлийг үнэн зөв тусгах, татварын нэхэмжлэхийн дагуу татвараа төлж, татварын өрийн үлдэгдлийг бууруулан, торгууль алданги зэрэг эрсдлээс сэргийлэх

АУДИТОР Ц.ЧАНЦАЛДИЙМАА
(Мэргэшсэн нягтлан бодогч)

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав

МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000128499

2014.03.27
/ Бүртгэсэн он сар өдөр /

9018016003
/ Хувийн хэргийн дугаар /

5821975
/ Регистрийн дугаар /

Шонхор үнэлгээ аудит ХХК
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2014.03.24 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

6920 Аудитын үйл ажиллагаа /2016.01.07-2019.01.07/
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

6621 Хөрөнгийн үнэлгээ хийх /хугацаа 2014.12.17-2017.12.17/

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 2 | 1 000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / эзэмшигчийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 27, 3 тоот, Утас1: 99018172, Утас2: 99096173, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

*Гэрчилгээ дахин олгосон* *2016 он 10 сар 28 өдөр*

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Хянасан ажилтан |
| 1 | [illegible] | 2016.09.26 | С.[illegible] |
| 2 | [illegible] | 2019.10.28 | С.Мөнхсайхан |
| 1 | Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж, 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв | 2017.01.31 | С.Мөнхсайхан |
| 2 | 6619 Санхүү, [illegible] бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ болон сургалт хийх үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2017.01.31 | С.Мөнхсайхан |
| 3 | Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, , сүхбаатар, 13, 302 байгууллага 803 тоот Утас1 95155515, Утас2 99096173, Факс 70150001 хаягийг шинээр бүртгэв | 2017.01.31 | С.Мөнхсайхан |
| 4 | Хувь нийлүүлэгчээс 1 хасагдаж, 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв | 2018.03.21 | Б.[illegible] |
| 5 | [illegible] бүртгэв | 2019.03.21 | [illegible] |
| 6 | Хувь нийлүүлэгчээс 0 хасагдаж, 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв | 2019.06.06 | [illegible] |
| 7 | 6920 Аудитын үйл ажиллагаа (2019.01.23-2022.01.23) зэрэг үйл ажиллагаа шинээр бүртгэв. 6621 Эрсдэлийн үнэлгээ хийх [illegible] (2019.03.01-2021.03.01) зэрэг үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2019.06.17 | Э.[illegible] |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

**САНГИЙН ЯАМ**

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээ
тушаалын 4 дүгээр хавсралт

## АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 2-2016

Аж ахуйн нэгжийн нэр: "Шонхор үнэлгээ Аудит" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 5821975

Аж ахуйн нэгжийн хаяг: УБ хот, ЧД, 2-р хороо, 27-р байр, 3 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2016 оны 01 сарын 07-ны өдөр, тушаал № 2

**Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бүсдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно

САНГИЙН САЙД ........................ / Б.БОЛОР /

УЛААНБААТАР ХОТ

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9021171 ... УЛААНБААТАР ХОТ ... 5961548

СЭХ он сар 10 өдөр БҮРТГЭВ № 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 21 өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

**Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тухай**

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.4.2, Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аудитын үйл ажиллагаа эрхлэх дараах хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар тус тус сунгасугай.

| д/д | Хуулийн этгээдийн нэр | Сунгах хугацаа |
|---|---|---|
| 1 | "Энур Аудит" ХХК | 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс |
| 2 | "Авера-Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 3 | "Алаг уул финанс Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 4 | "Гэрэлт Хөхийн Тэнцвэрт Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 5 | "Мэжик Консалтинг Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 6 | "Номгон Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 7 | "Пантер Мидланд Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 8 | "ПрайсуотерХаусКуперс Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 9 | "Уваа-уул аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |
| 10 | "Шонхор Үнэлгээ Аудит" ХХК | 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс |

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь сунгагдсан хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

Б.ЖАВХЛАН

9763000099

СЭНДЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ

СӨХ
20.. он .. сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, НЭМЭЛТ ТОДРУУЛГА

# СЭНДЛИ ББСБ ХХК

# INITIAL PUBLIC OFFERING (IPO)

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК
Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан

Үнэлгээний өдөр
2021.12.31

Тайлангийн өдөр
2022.05.16

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
8-р хороо, Сүхбаатарын талбай 20-6
Эрдэм цамхаг, 1004 тоот
Утас: +976 7000-5000
gantulga@geregepartners.mn

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
Гэрэгэ

Сэндли ББСБ ХХК -ийн Удирдлагад

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1-р хороо, Жуулчин Бизнес 34 центр,
А корпус, 1 тоот
Утас: 70177700
Цахим хуудас: www.sendly.mn

2022 оны 5-р сарын 16-ны өдөр

**Үнэлгээний үр дүнг хүргүүлэх тухай**

Танай компанитай байгуулсан "Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу бид Сэндли ББСБ ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 34,096,591,256 (Гучин дөрвөн тэрбум ерэн зургаан сая таван зуун ерэн нэг мянга хоёр зуун тавин зургаа) төгрөг байхаар тооцоолж үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Энэхүү үнэлгээний ажил нь Сэндли ББСБ ХХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр анхлан гаргах зориулалтаар хийгдэж байгаа бөгөөд үнэлгээний үр дүнг өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Үнэлгээний тооцоолол Сэндли ББСБ ХХК-иас ирүүлсэн мэдээлэл болон Үнэлгээчдийн өөрсдийн хийсэн шинжилгээ, төсөөллийг ашиглав.

Үнэлгээний ажилтай холбоотой асуулт, тодруулга байвал бидэнтэй холбоо барихыг хүсье.

Хүндэтгэсэн,

Гэрэгэ Эстимэйт ХХК-г төлөөлж:

Д. Ганбаатар, MMY
Мэргэшсэн үнэлгээчин
Гүйцэтгэх захирал

Д.Гантулга, MRICS
Мэргэшсэн үнэлгээчин
Үнэлгээ хариуцсан захирал

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

## АГУУЛГА

1. ЕРӨНХИЙ ТОЙМ..........4
2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД..........7
3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ..........9
Макро эдийн засгийн төлөв байдал..........9
Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын өнөөгийн байдал..........11
4. КОМПАНИЙН ТУХАЙ..........12
Санхүүгийн үзүүлэлт..........14
5. ҮНЭЛГЭЭ..........16
Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ..........16
Харьцуулалтад авч үзсэн компаниуд..........16
Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт..........21
Гадаадын компаниудтай харьцуулах нь..........23
Зах зээлийн харьцуулалтын аргын үр дүн..........23
Хөрөнгөд суурилсан үнэлгээ..........24
Цэвэр хөрөнгө..........25
Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ..........25
Үнэлгээний үндсэн орц, төсөөллүүд..........25
Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл..........30
Үнэлгээний үр дүнгийн тодруулга..........33
6. ХАВСРАЛТ..........34

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭЛ-02

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт ........ 9
Зураг 2: ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагааны эзлэх хувь ........ 10
Зураг 3: Финтек болон уламжлалт ББСБ-ын ялгаа ........ 12
Зураг 4: Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа ........ 18
Зураг 5: Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа ........ 19
Зураг 6: ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа ........ 21

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд ........ 9
Хүснэгт 2: Монгол Улсын ДНБ-ний төсөөлөл, 2022 - 2026 ........ 10
Хүснэгт 3: Финтек, уламжлалт ББСБ-ын зарим үзүүлэлтийн харьцаа ........ 11
Хүснэгт 4: Сэндли ББСБ-ын балансын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он ........ 14
Хүснэгт 5: Сэндли ББСБ-ын орлогын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он ........ 15
Хүснэгт 6: Сэндли ББСБ ХХК-ийн санхүүгийн гол харьцаанууд ........ 15
Хүснэгт 7: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он ........ 17
Хүснэгт 8: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он ........ 17
Хүснэгт 9: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он ........ 18
Хүснэгт 10: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он ........ 19
Хүснэгт 11: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он ........ 20
Хүснэгт 12: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он ........ 20
Хүснэгт 13: Үндсэн үзүүлэлтээр салбарт эзлэх хувь ........ 21
Хүснэгт 14: СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, 2021 он ........ 22
Хүснэгт 15: Гадаадын компаниудын үндсэн үржүүлэгчид ........ 23
Хүснэгт 16: Зах зээлийн харьцуулалтын шинжилгээний үр дүн ........ 23
Хүснэгт 17: Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ ........ 24
Хүснэгт 18: Сэндли ББСБ ХХК-ийн цэвэр хөрөнгийн дүн ........ 25
Хүснэгт 19: Сэндли ББСБ ХХК-ийн зээлийн үйл ажиллагааны төсөөлөл, сая төг ........ 27
Хүснэгт 20: Сэндли ББСБ ХХК-ийн орлогын төсөөлөл, 2022 – 2026 он ........ 30
Хүснэгт 21: Сэндли ББСБ ХХК-ийн хөрөнгийн үзүүлэлтийн төсөөлөл, 2022 – 2026 он ........ 31

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

| | |
|---|---|
| ББСБ – | Банк бус санхүүгийн байгууллага |
| СЗХ – | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| ҮОУС – | Үнэлгээний Олон Улсын Стандарт |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

## 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

| | |
|---|---|
| **Тайлангийн өдөр** | **2022 оны 5-р сарын 16-ны өдөр** |
| **Үйлчлүүлэгч** | Сэндли ББСБ ХХК. Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв. |
| **Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө** | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бизнес 34 центр, 01 тоотод хаяг бүртгэлтэй Сэндли ББСБ ХХК-ийн 100%-ийн бизнес өмчлөл |
| **Үнэлгээний өдөр** | **2021 оны 12-р сарын 31-ний өдөр** |
| **Үнэлгээний стандартын нийцэл** | Үнэлгээний Олон Улсын Стандарт 2022 (ҮОУС 2022) |
| **Тайлангийн зорилго / Үнэлгээний ажлын заавар** | Сэндли ББСБ ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох (IPO) үйл ажиллагаанд зориулж тус компанийн 100 хувийн өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар тооцоолох |
| **Ашигласан үнэ цэнийн суурь** | Зах зээлийн үнэ цэн |
| **Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэн** | Үнэлгээний өдрийн байдлаарх бизнес өмчлөлийн нийт үнэ цэн 34,096,591,256 (Гучин дөрвөн тэрбум ерэн зургаан сая таван зуун ерэн нэг мянга хоёр зуун тавин зургаа) төгрөг.<br><br>Бидний үнэлгээ дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд:<br>• Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх зэрэг Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;<br>• Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;<br>• Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.<br><br>Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно. |
| **Таамаглал** | Тооцооны нэгж: Сэндли ББСБ ХХК нь "Монголын Финтек Групп" хаалттай ХК-ийн охин компани бөгөөд "Монголын Финтек Групп" ХК нь "Гялс төгрөг" ХЗХ, "Хөум моргейж корпорэйшн" ХХК, "Гялс зууч" ХХК, "Хай пэймэнт солюшнс" ХХК, "Хай лоялти" ХХК, "Инвестлаб Ви Си" ХХК, "Стоклаб Секьюритиз" ХХК, "Кореа Ремитанс" ХХК, "Датапүүл Монголиа" ХХК зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компаниудад хувьцаа эзэмшдэг. |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10



| | |
|---|---|
| | бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагаа хэсэгчилсэн байдлаар "Монголын Финтек Групп" ХК-ийн хувьцаа эзэмшдэг бусад компанийн үйл ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс үүсэх үр дагаврыг тооцоолоогүй бөгөөд Сэндли ББСБ ХХК-ийн бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно. |
| | Нэмэлт санхүүжилт: Сэндли ББСБ ХХК-д нэмэлтээр татах санхүүжилт нь тус компанийн бизнесийн онцлогоос хамаарч үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаанд шууд болон санхүүгийн хөшүүргэ байдлаар нөлөөлнө. Иймд энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсэний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно. |
| | Тасралтгүй байдал: Сэндли ББСБ ХХК нь цаашид бизнесийн үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв. |
| Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт | Бид Үйлчлүүлэгчийн бизнестэй танилцах, мэдээлэл авах уулзалтуудыг 2022 оны 3 болон 4-р саруудад хийсэн бөгөөд холбогдох бусад мэдээллийг үнэлгээний ажлын явцад цахим шуудангаар авч үнэлгээнд ашиглав. |
| Стандартаас гажсан эсэх | Гажаагүй |
| Үнэлгээчид | Бид Үйлчлүүлэгчээс өгсөн даалгаврын дагуу энэ төрлийн бизнесийн үнэлгээг хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна. Д.Гантулга нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Үнэлгээ хариуцсан захирал бөгөөд тус компанийн бизнесийн болон тусгай зориулалтын хөрөнгийн үнэлгээний ажлуудыг удирдан ажилладаг. Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Гүйцэтгэх захирал болно. Л.Халиун нь ACCA буюу олон улсын мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн зөвлөх үнэлгээчнээр ажилладаг. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институт (RICS)-ийн гишүүн бөгөөд Д.Гантулга, Д.Ганбаатар, Л.Халиун нар нь Монгол улсын мэргэшсэн үнэлгээчид болно. Үнэлгээчний сертификатын хуулбарыг Хавсралт 4-д үзүүлэв. |
| | Энэхүү үнэлгээний ажлын багийг Д.Гантулга удирдан ажилласан бөгөөд үнэлгээний тайланг бэлтгэсэн болно. |
| Ашиг сонирхлын зөрчил | Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно. |
| **Тайлангийн хэрэглэгчид / Нууцлал** | Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№



бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно.

| | |
|---|---|
| **Тайлангийн хэрэглээ** | **Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй** тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн **тараахыг хориглоно.**<br><br>**Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй** тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай **холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа** баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг **хориглоно.**<br><br>Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.<br><br>Үнэлгээний өдрөөс хойш үнэлгээний тайлан гарах өдрийн хооронд Орос Украйны дайнаас үүдэлтэйгээр дэлхийн улс төрийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдал цаг тутам өөрчлөгдөж байна. Иймд үнэлгээний үр дүнг хэрэглэхдээ тухайн цаг үеийн нөхцөл байдлыг хамт авч үзэхийг Үнэлгээчид зөвлөж байна. |
| Мэргэжлийн хариуцлагын даатгал | Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу Үнэлгээчний хариуцлагын даатгалд хамрагдсан болно. |
| Бусад | Тайланг Монгол хэл дээр бэлтгэсэн бөгөөд нэмэлт материалыг үндсэн эхийн хуулбар байдлаар хавсралтад үзүүлэв. |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

## 2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

**Үнэлгээний үр дүнг ашиглахаас өмнө үнэлгээнд ашигласан дараах үндсэн таамаглал болон өгөгдлүүдтэй танилцахыг зөвлөж байна.**

**Тооцооны нэгж:** Сэндли ББСБ ХХК нь "Монголын Финтек Групп" хаалттай ХК-ийн охин компани бөгөөд "Монголын Финтек Групп" ХК нь "Тэлс төгрөг" ХХК - хадгаламж зээлийн хоршоо, "Хөум моргейж корпорэйшн" ХХК - хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах замаар орон сууцны зээл олгох бизнесийн үйл ажиллагаа, "Тэлс зууч" ХХК - үл хөдлөх хөрөнгө зуучлал, "Хай пэймант солюшнс" ХХК - төлбөр тооцооны үйл ажиллагаа, "Хай лоялти" ХХК - урамшууллын онооны үйл ажиллагаа, "Инвестлаб Ви Си" ХХК - гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, "Стоклаб Секьюритиз" ХХК - үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа, "Кореа Ремитанс" ХХК – Монгол, Солонгос улсуудын хооронд мөнгөн гүйвүүлгын үйл ажиллагаа, "Датапүүл Монголиа" ХХК - зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн үйлчилгээний компаниудад хувьцаа эзэмшдэг.

Энэ үнэлгээнд Сэндли ББСБ ХХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагааг хэсэгчлэн байдлаар "Монголын Финтек Групп" ХК-ийн хувьцаа эзэмшдэг дээр дурдсан бусад компаниудын үйл ажиллагаатай нэгтгэсэн, нийлүүлснээс үүсэх үр дагаврыг тооцоолоогүй бөгөөд Сэндли ББСБ ХХК-ийн бизнесийг бие даасан байдлаар үнэлсэн болно.

**Нэмэлт санхүүжилт:** Санхүүгийн байгууллагын үнэлгээ нь бусад салбарын бизнесийн үнэлгээнээс нэлээхэн онцлогтой бөгөөд ялгаатай байдаг. Бусад бизнесийн хувьд нэмэлтээр татсан хөрөнгө нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх, түүхий эдийн татлалтаа нэмэгдүүлэх, өсөлтөд шаардагдах бусад зардлыг санхүүжүүлэх зэргээр борлуулалтаа өсгөх боломжийг олгодог бол банк бус санхүүгийн байгууллагын хувьд нэмэлт хөрөнгө нь шууд зээлийн бүтээгдэхүүн болж хувирдаг онцлогтой.

Түүнчлэн, банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр бусдаас татах санхүүгийн бусад эх үүсвэрийг зохицуулах байгууллагаас тавьдаг зохистой харьцаануудын хүрээнд нэмэгдүүлэх боломжтой болдог. Өөрөөр хэлбэл, нэмэлт өөрийн хөрөнгө нь тус санхүүгийн байгууллагын зээлийн хэмжээг нэмэлт хөрөнгийг тодорхой дүнгээр үржүүлсэн дүнгээр (leverage) нэмэгдэгдүүлэх боломжийг олгодог онцлогтой. Гагцхүү санхүүгийн нэмэлт эх үүсвэр татаж гаргах зээлийн эрэлт байгаа эсэх, тус нэмэлт эх үүсвэрийг бизнесийн эргэлтэд хэрхэн үр ашигтай оруулж чадах эсэх зэрэг нь үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс болно.

Иймд энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно. Үнэлгээнд IPO-оор татах 10.0 тэрбум төгрөгийг 2022 оны 10-р сараас, "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж дүрмийн санг нэмэгдүүлэх 1.4 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө болон зээлийн багцыг 2022 оны 6-р сараас эхлэн Сэндли ББСБ-ын зээлийн эх үүсвэрт оруулж тооцов.

**Тасралтгүй байдал:** Сэндли ББС ХХК нь цаашид бизнесийн үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

**Мэдээллийн найдвартай байдал:** Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Үйлчлүүлэгч компаниас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн боловч өөрсдийн зүгээс аудитын шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

**Үнэлгээний үр дүнгийн найдвартай байдал:** Аливаа бизнесийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын найдвартай байдал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь тус компанийн ирээдүйн ашигт ажиллагааны талаарх худалдагч болон худалдан авагчийн төсөөлөл зөрөх, хүлээж байгаа эрсдэлийн түвшин ялгаатай байх зэргээс хамаарч бизнес өмчлөлийн үнэ цэн нь талуудад өөр өөр байх боломжтой юм.

Цаашилбал, бизнесийн өмчлөлийн үнэ цэн нь ирээдүйд болох үйл явдлуудаас, тухайлбал зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, инфляцын өөрчлөлт, макро эдийн засгийн үзүүлэлтүүд зэргээс хамаарч өөрчлөгддөг онцлогтой.

Үнэлгээний өдрийн байдлаар дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөө нь мөнгөн урсгалын ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдлыг улам бүр ихэсгэж байна.

Үнэлгээний тайлангийн өдрийн байдлаар Орос Украйны дайн нь ирэх жилүүдэд дэлхийн эдийн засгийн төсөөлөлд ихээхэн хэмжээний тодорхойгүй байдлыг бий болгож байна. Энэ дайн нь дэлхийн эдийн засагт дараах үндсэн 3 сувгаар дамжин нөлөөлөх боломжтой. Үүнд Орос улсад тавьсан санхүүгийн хоригийн нөлөө, ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг орно.[1]

Хэдийгээр Сэндли ББСБ ХХК-ийн үйл ажиллагаа нь дайны шууд нөлөөлөлд орох салбарт хамаарахгүй боловч нийт эдийн засгийн тодорхойгүй байдлаар дамжин дам нөлөөнд орох нь гарцаагүй.

Үнэлгээний үр дүнг хэрэглэхдээ энэ тайлангийн 5-р бүлэгт орсон ***Үнэлгээний үр дүнгийн тодруулга*** хэсгийг онцойлон анхаарч үзэхийг зөвлөж байна.

**Үнэлгээний аргачлал, орц, таамаглал:** Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, орц, таамаглалууд нь үнэлгээний өдрийн байдлаар үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангүй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

**Тайлангийн хэрэглээ:** Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараах, Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь

[1] https://www.eiu.com/n/global-economic-implications-of-the-russia-ukraine-war/



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

үнэлгээний ажлын зориулалтаас өөр зориулалтаар олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

## 3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

### Макро эдийн засгийн төлөв байдал

**Дотоодын эдийн засаг**

2022 оноос өмнөх арван жилд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийн бодит өсөлтийн дундаж 5.14% байсан ба 2012 онд хамгийн өндөр буюу 12.3%, 2020 онд -4.6% хүрч буурч байсан. ДНБ-ийн нэрлэсэн дүнгээр 2020 онд 37.5 их наяд төгрөг байсан бол 2021 онд өсөж 43.0 их наяд төгрөг болсон. 2021 онд ДНБ-ний бодит өсөлт 1.4% байсан.[2]

**Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт**




Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн үнэлгээний өдрийн байдлаарх бодит дүнг дараах хүснэгтэд харуулав[3].

**Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд**

| Үзүүлэлт | Нэгж | Дүн |
|---|---|---|
| ДНБ өсөлт | % | 1.4 |
| Ажилгүйдлийн хувь | % | 8.1 |
| Инфляцийн хувь | % | 14.2 |
| Зээлийн хүү | % | 9.0 |
| Худалдааны тэнцэл | US$ mln | 159 |
| ДНБ-д эзлэх төсвийн алдагдал | % | -11.5 |
| ДНБ-д эзлэх Засгийн газрын өр | % | 66 |

[2] Монголын статистикийн үндэсний хороо, www.1212.mn
[3] https://tradingeconomics.com/mongolia/forecast

2021 оны ДНБ-ний өсөлтийн бүрэлдэхүүнийг зарим салбараар авч үзвэл уул уурхай 1.7%-иар, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 7.2%-иар тус тус өсөж, барилга -32.7%-иар, тээвэр агуулахын үйл ажиллагаа -16.7% тус тус буурчээ. "Trading economics" байгууллагын судалгаагаар 2022 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 5.5%, 2023 онд 6% байхаар таамаглажээ.[4]

2026 он хүртэлх Монгол Улсын нэрлэсэн ДНБ, инфляцийн төсөөллийг Олон Улсын Валютын Санг 2021 оны 10-р сард тооцоолсноор доорх хүснэгтэд үзүүлэв.[5]

**Хүснэгт 2: Монгол Улсын ДНБ-ний төсөөлөл, 2022 - 2026**

| | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|---|
| Нэрлэсэн ДНБ, тэрбум төг | 41,592.2 | 48,065.3 | 54,806.4 | 61,851.8 | 69,282.7 | 77,102.4 |
| Өсөлт, % | 12.5% | 15.6% | 14.0% | 12.9% | 12.0% | 11.3% |
| Инфляци, % | 7.0% | 7.5% | 7.0% | 6.5% | 6.0% | 6.0% |

Олон улсын валютын сангийн мэдээлснээр дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 5.9% байсан бол 2022 онд 4.4%, 2023 онд 3.8% болно гэж таамаглаж байна. Энэ нь дэлхийн хоёр том зах зээл болох АНУ-ын мөнгөний нийлүүлэлтийг багасгах хатуу бодлого, Хятад улсын Ковид-19-ийн эсрэг хатуу хөл хорио болон барилгын салбар дахь санхүүгийн дарамт зэргээс ихээхэн шалтгаалж байна. Ойрын хугацаанд инфляцийн түвшин мөн өндөр хэвээр байхаар байна. Хөгжингүй орнуудын хувьд дундаж инфляцийн түвшин 2022 онд 3.9%, хөгжиж буй орнуудын хувьд 5.9% байхаар байна.[6]

ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олох орлогын эзлэх хувь жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олсон орлого 2016 онд ДНБ-ий 3.8%-ийг эзэлж байсан бол 2021 онд 5.1% хүртэл өсөн нэмэгдсэн байна.[7]

**Зураг 2: ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагааны эзлэх хувь**




**Ханш**

Монголбанкны мэдээлснээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2021 оны жилийн эцсийн байдлаар 2,849.34 төгрөг, тайлангийн өдөр буюу 2022 оны 5-р сарын 9-ний өдрийн байдлаар 3,099.90 төгрөг болсон байна.

**Инфляци**

Мөнгөний зах зээлийн хувьд Монголбанкны бодлогын хүү 2016 онд хамгийн дээд түвшин буюу 15% хүрч байсан ба аажмаар буурч 2021 оны эцэст 6.0% болсон ба 2022 оны 3-р сарын

[4] https://tradingeconomics.com/mongolia/gdp-growth-annual
[5] IMF: World Economic Outlook (WEO) Database, October 2021
[6] Дэлхийн эдийн засгийн тойм, 2022 оны 1-р сар, Олон улсын валютын сан
[7] http://1212.mn

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

24-ны өдөр 9.0% болж өсөөд байна. Инфляцийн түвшин 2022 оны 3-р сарын байдлаар улсын хувьд 14.4%, Улаанбаатар хотын хувьд 15.8% болсон нь инфляцын зорилтот 6% (+/-2%)-иас харьцангуй их байсаар байна.

### Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын өнөөгийн байдал

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны мэдээлснээр[8] 2008 онд 131 ББСБ байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 534 тусгай зөвшөөрөлтэй ББСБ байна. ББСБ нь нийт 10 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой байдаг. Үүнээс 92.9% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт 4.8 сая харилцагч бүртгүүлсэн бол нийт 1.7 сая зээлдэгч зээл авсан байна. Салбарын нийт орлого 521.3 тэрбум төгрөг, үүнээс хүүгийн орлого 421.7 тэрбум төгрөгт хүрчээ. Зээлийн жигнэсэн дундаж хүү 2021 оны эцсийн байдлаар 2.7%, дундаж зээлийн хэмжээ 1.2 сая төгрөг, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 7.0% байна.

2021 оны байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 51.6 хувиар буюу 685.2 тэрбум төгрөгөөр, 2017 оноос 215.4 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсөж оны эцэст 2.0 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Үйл ажиллагааны хувьд ангилж авч үзвэл зээлийн үйлчилгээ эрхэлж буй 496, гадаад валютын арилжаа эрхэлж буй 146, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж буй 49, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ эрхэлж буй 36 ББСБ байна.

Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд нийт 331 салбартай байна. ББСБ-ын байршлыг зураглалаар харуулбал дийлэнх нь буюу 84.5 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.

#### Финтек ББСБ-ын салбар

Финтек 28 ББСБ байгаагаас зөвхөн технологид суурилсан 11, технологи болон уламжлалт үйл ажиллагаа эрхэлдэг 17 ББСБ байна.

**Хүснэгт 3: Финтек, уламжлалт ББСБ-ын зарим үзүүлэлтийн харьцаа**

| ББСБ-ын хэлбэр | Нийт зээл | | Зээлдэгч | | 1 зээлдэгчид ногдох дундаж зээлийн хэмжээ /мян.төг/ |
|---|---|---|---|---|---|
| | Хэмжээ /тэрбум төг/ | % | Тоо | % | |
| Финтек | 308.0 | 15% | 1,349,116 | 80% | 228.3 |
| Уламжлалт | 1,704.2 | 85% | 329,023 | 20% | 5,179.4 |
| **Нийт** | **2,012.2** | **100%** | **1,678,139** | **100%** | **1,199.1** |

Салбарын нийт харилцагчдын 92.1% нь эдгээр финтек ББСБ-ын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна. Нийт зээлдэгчдийн 80% нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна. Иймд финтек ББСБ нь зээлдэгчдийн тоогоор уламжлалт ББСБ-уудын зээлдэгчдийн тооноос хэд дахин илүү байгаа нь энэ төрлийн зээлийн эрэлт хэрэгцээ, мөн зээлдэгчдийн зээлийн үйлчилгээний чиг хандлага өөрчлөгдөж байгааг илтгэн харуулж байна.

2021 оны байдлаар санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 94.4%-ийг хэвийн зээл, 1.9%-ийг хугацаа хэтэрсэн зээл, 3.7%-ийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

[8] http://www.frc.mn/resource/frc/Document/2022/02/22/fwt96cb8qasirhrw/20220210_nbfi_report_site.pdf



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨН...
2023-01-10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

Зураг 3: Финтек болон уламжлалт ББСБ-ын ялгаа




Зөвхөн технологид суурилан зээл олгодог ББСБ-уудын хувьд салбарын нийт зээлийн үлдэгдэлд бага хувь эзэлж байгаа ч олгосон болон төлөгдсөн зээлд эзлэх хувиас харахад эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт, эргэн төлөлт сайн байгаа нь харагдана.

## 4. КОМПАНИЙН ТУХАЙ

Сэндли ББСБ ХХК-ийн 98.11%-ийн хувьцаа эзэмшигч нь Монголын Финтек Групп хаалттай хувьцаат компани бөгөөд үлдсэн 1.89%-ийг ажилчид нь эзэмшиж байна. Монголын Финтек Групп ХК-ийн хувьцаа эзэмшигч нь Монголиан Мючуал Финанс Групп ХХК бөгөөд тус компанийн 100%-ийн өмчлөгч нь Сингапур улсад бүртгэлтэй Mongol Mutual Pte.Ltd компани юм.

"Монголын финтек групп" ХК нь финтек технологид суурилсан бизнес эрхлэгч өөрийн охин компаниудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай холбох, олон улсад тэдгээрийн бизнесийг таниулах, өргөжүүлэн тэлэх гүүр нь буюу "Санхүүгийн Холдинг" компани болох зорилгоор байгуулагдсан, финтек чиглэлээр ажилладаг 12 охин компанийн нэгдэл бөгөөд тэдгээрийн нэг нь дэлхийн зах зээлд гаргахаар ажиллаж байгаа олон улсын мөнгөн гуйвуулгын Sendly аппликэйшн юм. Тайлангийн өдрийн байдлаар Америк, Австрали, Япон дахь монголчуудад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлж, 15 мянга орчим идэвхтэй хэрэглэгчтэй болсон байна. Энэхүү аппаар дамжуулан өнгөрсөн хугацаанд 8.7 сая ам.доллар буюу 24.8 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний валют Монгол Улсын эдийн засагт оржээ. Ойрын хугацаанд Sendly Европын холбооны орнууд, Өмнөд Солонгосын зах зээлд үйлчилгээгээ нэвтрүүлж, гадаадад суугаа нийт монголчуудад хүрч ажиллахаар зорьж байна.

Sendly аппыг монгол мэргэжилтнүүд хөгжүүлсэн бөгөөд олон улсад өрсөлдөхүйц түвшний мөнгөн гуйвуулгын бие даасан систем хөгжүүлж дундын зуучлагчдын оролцоо, шат дамжлагыг халж шимтгэлийг хамгийн бага хэмжээнд барих, богино хугацаанд гүйлгээ хийх боломжийг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. Олон улсад өөрийн гэсэн бие даасан сүлжээг бий болгосноороо өнгөрсөн 30 жилийн турш гадаадын аль нэг мөнгөн гуйвуулгын компанийн төлөөлөгч болж энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлж ирсэн Монгол Улсын санхүүгийн бусад байгууллагуудаас анхдагч болсон онцлогтой.

Сэндли ББСБ ХХК нь 2015 оны 5-р сард банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. 2018 оноос эхлэн зорилгын дагуу үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2021 оноос одоогийн финтек зээлийн платформоор дамжуулан зээл олгож эхэлжээ. Санхүүгийн зохицуулах хорооноос зээл, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа, итгэлцэл гэсэн үйл ажиллагааны чиглэлээр тусгай зөвшөөрөл аван ажиллаж байна. Зээлийн үйлчилгээ, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанаас үндсэн орлогоо бүрдүүлж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly

**Зээлийн үйлчилгээ**

Уламжлалт зээлийн үйлчилгээнээс илүүтэйгүүр технологи дээр суурилсан зээл олголт, зээлийн эргэн төлөлтийн үйл явцыг хангаж ажилладаг. Зээлийн багцын дийлэнх хэсгийг мерчантын зээл эзэлж байна. Энэ нь томоохон худалдааны төвүүд дээр байршилтай лангууны бизнес эрхлэгчид юм. Одоогийн байдлаар 5000 гаруй мерчанттай хамтран ажиллаж байна.

Зээл олгохдоо зээлдэгчийн ажлын байр, бараа бүтээгдэхүүнд шалгалт хийж лангуун дээрх бараа болон лангууны түрээсийн эрхийг барьцаалдаг. Зээлийн эргэн төлөлтийн хувьд ихэвчлэн өдөр бүр тэнцүү төлөх байдлаар гэрээ хийдэг. Эргэн төлөлтийг зээлдэгч өөрөө хийх шаардлагагүй бөгөөд Хай Пэй Солюшн ХХК-ийн хөгжүүлсэн төлбөр тооцооны програмын тусламжтайгаар зээлдэгчийн бүртгүүлсэн арилжааны банкны картнаас өдөр бүр шууд татан авалт хийдэг. Энэ нь Сэндли ББСБ ХХК-ийн бусад банк бусуудаас ялгарах гол давуу тал болж байна. Түүнчлэн, өдөр тутмын зээлийн эргэн төлөлт нь компанид мөнгөн хөрөнгийн тасралтгүй байдал, зээл олголтын тасралтгүй байдал гэсэн давуу талуудыг олгож байна.

Сэндли ББСБ ХХК-ийн хувьд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь бага байгаа нь зээлийн эргэн төлөлт 1-2 хоног хоцрохтой зэрэгцүүлэн зээлийг эргүүлэн төлүүлэх ажиллагааг яаралтай эхлүүлдэгтэй холбоотой гэж үзэж болно.

**Мөнгөн гуйвуулга**

Тус компани нь олон улстай онлайнаар мөнгөн гуйвуулга хийх финтек технологид суурилсан "Sendly" гар утасны аппликэйшнийг 2020 оны 5 сард амжилттай нэвтрүүлсэн. Sendly аппликэйшний тусламжтайгаар дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдийн улс хоорондын мөнгөн гуйвуулга хийх хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн, мэдээллийн аюулгүй байдлын орчинд, хурдан шуурхай, хямд зардлаар хийхээр зорин ажиллаж байна.

Одоогийн байдлаар мөнгөн гуйвуулгыг АНУ-аас Монгол улс руу, Монгол улсаас АНУ руу, Австрали улсаас Монгол улс руу, Япон улсаас Монгол улс руу гэсэн чиглэлийн дагуу хийж байгаа бөгөөд тун удахгүй Солонгос болон Европын холбооны улсуудаас мөнгө гуйвуулга хийх гарцыг нээхээр шамдан ажиллаж байна. Гадаадаас шилжүүлсэн мөнгийг харилцагч Монгол Улсын арилжааны банкны дансанд хүлээн авах боломжтой.

Одоогийн байдлаар нийт 7 сая ам.долларын 15,000 гаруй мөнгөн гуйвуулгын гүйлгээ хийсэн байна. Нийт 15,248 хэрэглэгч аппликэйшнийг татсан байгаагаас идэвхитэй хэрэглэдэг 4,000 гаруй хэрэглэгчид байгаа бөгөөд өдрөөс өдөрт хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна.

**Салбар**

Хөвсгөл, Ховд, Говь-Алтай аймгаас бусад 18 аймгийн төв, 28 сум, Улаанбаатар хотод 7 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотод Нарантуул, Бөмбөгөр, Хархорин, Дэнжийн мянга гэх мэт том худалдааны төвүүдэд салбараа нээн ажиллуулж байна. Салбар бүрт 2-5 хүн ажилладаг, бүх салбар интернетэд холбогдсон, гүйлгээний өндөрлөгөөг банктай адил 24:00т автоматаар эхэлдэг.

Салбарын тоогоор Хаан банк болон Төрийн банкны дараа, ББСБ-уудын хувьд хамгийн олон салбартайгаар, өргөн хүрээг хамарч үйл ажиллагаа явуулж байгаагаараа давуу талтай. Энэ нь зээлийн төвлөрлийн эрсдлийг тархаан байршуулахад ач холбогдолтой. Орон нутагт олгож буй зээл чанаргүй болох магадлал бага байдаг. Энэ нь орон нутагт хүн амын төвлөрөл бага байдаг учраас зээлдэгчийг судлах, таньж мэдэхэд илүү хялбар байдагтай холбоотой. Олон салбартай, мөн онлайн програмын давуу талаа ашиглан зөвхөн зээлийн үйлчилгээгээр

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

зогсохгүй даатгал, үнэт цаас, онгоцны билет, хоршооны үйлчилгээг салбараараа дамжуулан хүргэн ажилладаг.

**Хүний нөөц**

Сэндли ББСБ ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар нийт 49 бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Гүйцэтгэх удирдлагын баг банк, санхүүгийн мэргэжилтэй, Сангийн яам, арилжааны банкуудад удирдах түвшний алба хашиж байсан туршлагатай, мэдлэгтэй боловсон хүчнүүд ажиллаж байна. Орон нутаг дахь салбарын захирлуудад 2016 онд Төрийн банкинд ажиллаж байсан олон жилийн туршлагатай хүмүүсийг томилон ажиллуулж байна. Хүний нөөцийн бодлогын хүрээнд идэвхжүүлэлт, урамшуулал, сургалт, эрүүл мэндийн үзлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэх мэт урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Програм хангамж, дэд бүтэц**

Хай Пэймэнт Солюшнс ХХК-ийн хөгжүүлсэн програм, аппликэйшний тусламжтайгаар зээлийн үйлчилгээ болон мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна. Хай Пэймэнт Солюшнс ХХК нь Монголбанктай шилэн кабелиар холбогдсон бөгөөд 2019 оны 10-р сарын 24-ний өдөр Монголбанкаас "Карт хүлээн авагч"-ийн тусгай зөвшөөрлийг авсан нь арилжааны банкнаас гадна энэхүү тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй цорын ганц компани болсон. Иймд, арилжааны банктай гэрээ хийх шаардлагагүйгээр зээлийн эргэн төлөлтийг тухайн харилцагчийн HiPay зээлийн аппликэйшн дээр холбуулсан данснаас шууд татаж авах боломжтой болсон. Энэ нь бусад банк болон ББСБ-уудтай харьцуулахад зээлийн эргэн төлөлтийн эрсдлийг бууруулах, эргэн төлөлтийг цаг тухайд нь сууттан авах давуу талыг олгож байна.

Монголбанк болон Монголын Хөрөнгийн Бирж-тэй шилэн кабелиар холбогдсон. Тус компани нь цахилгаан тасалдлаас хамгаалсан TIER 3 үзүүлэлтийг хангасан 3 дата төвтэй байгаа нь харилцагчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангасан бие даасан шийдэл болж байна.

**Хяналт, шалгалт**

Орон нутаг дахь хүний нөөц болон интернет, шугам сүлжээний дэд бүтцийн тал дээр маш хяналттай ажилладаг. Орон нутаг дахь оффисын үйл ажиллагаанд хяналтын аппликэйшний тусламжтайгаар шууд хяналт тавин ажиллаж байна. Бэлэн мөнгөний гүйлгээ бараг хийгддэггүй, хэрэв харилцагч бэлэн мөнгөөр зээлийн эргэн төлөлтийг хийсэн тохиолдолд тухайн өдөр бүр банкны харилцахад тушаадаг.

**Санхүүгийн үзүүлэлт**

Сэндли ББСБ ХХК нь 2018 - 2020 оны хооронд хувь нийлүүлсэн хөрөнгийн хүрээнд уламжлалт зээлийн үйл ажиллагаа эрхэлж, 2019 оноос эхлэн финтек зээл олголтын програм хангамжийн хөгжүүлэлтийг эхлүүлжээ. 2021 оны 8-р сард програм нь бүрэн ашиглалтанд орж одоогийн зээл олголт, зээлийн эргэн төлөлтийн дижитал процесс нь эхэлсэн. Толгой компанийн өрийн бичгийн санхүүжилтээр 2021 онд эздийн өмчөө нэмэгдүүлж, итгэлцлийн тусгай зөвшөөрөл авч бусад эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байна.

**Хүснэгт 4: Сэндли ББСБ-ын балансын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он**

| Балансын гол үзүүлэлтүүд (мян.төг) | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 6,005 | 33,467 | 925,009 | 1,169,363 |
| Зээл (цэвэрээр) | 1,058,381 | 1,017,134 | 663,053 | 8,600,431 |
| Чанаргүй зээл | 44,000 | 44,000 | 44,000 | 9,828 |
| **Нийт хөрөнгө** | **1,273,890** | **1,880,407** | **1,889,487** | **10,804,686** |
| Итгэлцлийн өглөг | - | - | - | 2,580,000 |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бусад эх үүсвэр | - | - | - | 826,844 |
| **Нийт өр төлбөр** | **88,739** | **467,415** | **333,839** | **3,444,195** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 1,000,000 | 1,428,500 | 1,428,500 | 6,428,500 |
| **Эздийн өмч** | **1,185,150** | **1,362,991** | **1,565,598** | **7,180,441** |

**Хүснэгт 5: Сэндли ББСБ-ын орлогын үндсэн үзүүлэлтүүд, 2018-2021 он**

| **Орлогын гол үзүүлэлтүүд (мян.төг)** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|
| Хүү, шимтгэлийн орлого | 315,763 | 119,824 | 444,601 | 1,795,964 |
| Нийт орлогод эзлэх хувь | 100% | 100% | 57% | 76% |
| Гадаад валютын арилжааны орлого | - | 339 | 286 | 69,771 |
| Нийт орлогод эзлэх хувь | 0% | 0% | 0% | 3% |
| Мөнгөн гуйвуулгын орлого | - | - | 80,149 | 260,028 |
| Нийт орлогод эзлэх хувь | 0% | 0% | 10% | 11% |
| **Нийт орлого** | **316,455** | **120,163** | **773,370** | **2,366,934** |
| Хүүгийн цэвэр орлого | 316,455 | 120,163 | 773,370 | 2,365,498 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого | 214,512 | - 226,294 | 236,097 | 650,817 |
| **Цэвэр ашиг/алдагдал** | **181,664** | **- 250,659** | **192,807** | **588,471** |

Орлогыг үндсэн 3 үйл ажиллагаанаас олдог бөгөөд хүү, шимтгэлийн орлого хамгийн их хувийг эзэлж байна. Мөнгөн гуйвуулгын хувьд програм хангамж бүрэн ашиглалтанд орж, одоогийн байдлаар хэрэглэгчдээ нэмэх, зах зээлээ тэлэх гэсэн маркетингийн стратеги барин ажиллаж байна.

Үйл ажиллагаа жигдэрсний дараах буюу 2021 оны гол харьцаануудыг харахад өр төлбөр хөрөнгө, өр төлбөр өөрийн хөрөнгийн харьцаа харьцангуй бага буюу зээлийг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр түлхүү бүрдүүлж байна. Нийт хөрөнгөд зээлийн эзлэх хувь 81%-тай байна. Сэндли ББСБ-ын хувьд хамгийн сайн үзүүлэлт нь чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 онд 0.11% байгаа нь дээр дурдсанчлан зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагааг өдөр алдахгүй эхлүүлдэгтэй холбоотой гэж үзэж болно.

**Хүснэгт 6: Сэндли ББСБ ХХК-ийн санхүүгийн гол харьцаанууд**

| **Балансын гол харьцаанууд** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|
| Өр төлбөр/Хөрөнгө | 0.07 | 0.26 | 0.18 | 0.32 |
| Өр төлбөр/Өөрийн хөрөнгө | 0.07 | 0.34 | 0.21 | 0.48 |
| Зээлийн багц/Хөрөнгө | 0.83 | 0.56 | 0.35 | 0.81 |
| Зээлийн багц/Өр төлбөр | 11.93 | 2.18 | 1.99 | 2.50 |
| Зээлийн багц/Өөрийн хөрөнгө | 0.89 | 0.75 | 0.43 | 1.20 |
| Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь | 4.16% | 4.33% | 6.64% | 0.11% |
| **Орлого, ашгийн гол харьцаанууд** | | | | |
| Үйл ажиллагааны ашгийн маржин | 67.79% | -188.32% | 30.53% | 27.50% |
| Цэвэр ашгийн маржин | 57.41% | -208.60% | 24.90% | 24.86% |
| Хөрөнгийн өгөөж ROA | 14.26% | -13.69% | 10.19% | 5.55% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж ROE | 15.33% | -18.39% | 12.38% | 8.22% |

Хүүгийн цэвэр орлого 2.4 тэрбум төгрөг байгаа боловч үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого түүнээс харьцангүй бага буюу 651 сая төгрөг байгаа нь боловсон хүчин, мэргэжлийн үйлчилгээний зардал, Хай Пэй Солюшн ХХК-ийн технологийг ашигласны шимтгэлийн зардал



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

өндөр байгаатай холбоотой байна. Хөрөнгийн өгөөж 5.6%, өөрийн хөрөнгийн өгөөж 8.2%-тай байгаа нь салбарын дунджаас доогуур байна.

## 5. ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагыг авч үзэв. Үнэлгээний нэр томъёоны тодорхойлолт болон аргачлалын талаар ерөнхий мэдээллийг Хавсралт 2-т үзүүлэв.

### Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээг Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, үйл ажиллагаандаа финтек үйлчилгээ нэвтрүүлж ажилладаг Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниудыг сонгон авч харьцуулалт хийлээ.

### Харьцуулалтад авч үзсэн компаниуд

**Инвескор ББСБ**

Инвескор ББСБ ХХК нь 2016 онд үүсгэн байгуулагдсан. 2019 оны 4-р сард Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани болсон. Нийт хувьцааны 85%-ийг Эс Ай Би Жэй Капитал ХХК, 15%-ийг олон нийт тус тус эзэмшиж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт зээлийн багцад бизнесийн зээл 40%, автомашины зээл 30%, дижитал зээл 19%, хэрэглээний зээл 11%-ийг тус тус эзэлж байна. Нийт 18 салбартай, үүнээс 16 нь Улаанбаатар хотод, 1 нь Орхон аймагт, 1 нь дижитал хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.[9]

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS (Payment Card Industry Data Security Standard) олон улсын стандартыг хангасан цахим зээл, цахим төлбөр тооцооны Покет аппликэйшныг ажиллуулдаг. Покет аппликэйшн нь дараах санхүүгийн үйлчилгээнүүдийг өөртөө багтаажээ.

| | | | |
|---|---|---|---|
| 33.7 тэрбум төгрөгийн зээлийн багцтай, 146 мянган идэвхтэй зээл | Цахим төлбөр тооцооны 500 мянга + бүртгэлтэй хэрэглэгч | 155+ нэр төрлийн купон, 150+ хамтрагч байгууллага | 211+ Мерчант байгууллага, 200+ Брэнд, 400+ салбар |
| Pocket Loan | Pocket Pay | Pocket Coupon | Pocket Zero |

Инвескор ББСБ ХК нь Киргиз улсад итгэлцэл татах, факторинг, гадаад арилжаа, баталгаа гаргах, зээл олгох чиглэлээр охин компани байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2021 онд цэвэр зээлийн багц 6.8 тэрбум төгрөгт хүрч, чанаргүй зээлийн хувь 0.3%-тай байна. Покет аппликэйшнийг Киргиз улсад нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 2-р улиралд багтаан цахим зээлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд санал болгохыг зорин ажиллаж байна.

[9] https://www.invescore.mn/mn/investor/#report



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ
БҮРТГЭВ
СЭНДЛИ ББСБ ХК Sendly 9022121175 УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-18

### Санхүүгийн үзүүлэлтүүд

Инвескор ББСБ ХХК-ийн зээлийн багц 2021 онд өмнөх оноос 82%-иар, нийт өр төлбөр 64%-иар, эздийн өмч 43%-иар, хүүгийн цэвэр орлого 31%-иар, цэвэр ашиг 65%-иар тус тус өссөн байна. Ингэснээр үйл ажиллагааны орлогын маржин 87%, цэвэр ашгийн маржин 70%, хөрөнгийн өгөөж 9%, өөрийн хөрөнгийн өгөөж 25% болсон.[10]

**Хүснэгт 7: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он**

| Балансын гол үзүүлэлтүүд (мян.төг) | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 2,297,690 | 4,440,168 | 26,588,675 | 24,638,751 |
| Зээл (цэвэрээр) | 34,868,286 | 62,301,229 | 96,409,802 | 175,508,816 |
| **Нийт хөрөнгө** | **39,015,183** | **82,322,746** | **136,044,318** | **212,222,295** |
| Итгэлцлийн өглөг | 10,374,109 | 19,933,800 | 42,209,511 | 56,477,725 |
| Бусад эх үүсвэр | 14,363,836 | 18,702,417 | 75,610,777 | 38,666,774 |
| **Нийт өр төлбөр** | **25,120,829** | **41,100,258** | **83,243,727** | **136,705,532** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 6,096,873 | 16,282,237 | 16,282,237 | 16,282,237 |
| **Эздийн өмч** | **13,894,360** | **41,222,485** | **52,800,586** | **75,516,763** |
| **Орлогын гол үзүүлэлтүүд (мян.төг)** | | | | |
| Хүүгийн цэвэр орлого | 8,221,267 | 15,167,006 | 21,094,365 | 27,564,379 |
| Үйл ажиллагааны цэвэр орлого | 8,623,334 | 15,992,633 | 14,345,311 | 24,078,727 |
| **Цэвэр ашиг/алдагдал** | **5,056,969** | **9,508,062** | **11,619,109** | **19,191,586** |

**Хүснэгт 8: Инвескор ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он**

| Балансын гол харьцаанууд | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Өр төлбөр/Хөрөнгө | 0.64 | 0.50 | 0.61 | 0.64 |
| Өр төлбөр/Эздийн өмч | 1.81 | 1.00 | 1.58 | 1.81 |
| Зээлийн багц/Хөрөнгө | 0.89 | 0.76 | 0.71 | 0.83 |
| Зээлийн багц/Өр төлбөр | 1.39 | 1.52 | 1.16 | 1.28 |
| Зээлийн багц/Эздийн өмч | 2.81 | 2.00 | 2.58 | 2.81 |
| Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь | n/a | 2.6% | 3.0% | 2.7% |
| **Орлого, ашгийн гол харьцаанууд** | | | | |
| Үйл ажиллагааны орлогын маржин | 105% | 105% | 68% | 87% |
| Цэвэр ашгийн маржин | 62% | 63% | 55% | 70% |
| Хөрөнгийн өгөөж-ROA | 13% | 12% | 9% | 9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE | 36% | 23% | 22% | 25% |

### Хувьцааны арилжаа

Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав.[11]

| | | | |
|---|---|---|---|
| 52 долоо хоног, ₮ | 2,859-4,400 | Хаалтын үнэ | 4,043 |
| Зах зээлийн үнэлгээ, ₮ | 289,995,972,474 | Дансны үнэ | 1,053 |
| Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮ | 4 тэрбум | P/E | 15.11 |
| Эргэлтэд гаргасан хувьцаа, ширхэг | 71,727,918 | P/B | 3.84 |

[10] https://www.invescore.mn/media/report_file/InvesCore_2021_consolidated_audited_for_MSE.pdf
[11] https://mse.mn/mn/company/553

**Зураг 4: Инвескор ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа**




### Ард Кредит ББСБ

Ард Кредит ББСБ ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, шинэ стратегиар ажиллаж эхэлсэн. 2019 оны 1-р улиралд хувьцаагаа олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болсон.

Монгол шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан 2019 оноос харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг хүргэж байна. 2020 онд EuroGiro олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг Монгол шуудан ХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлсэн.

2021 онд нийт зээл олголтын 71%-ийг цахим зээл, 23.3%-ийг бизнесийн зээл, 5.7%-ийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар Ард аппликэйшнийг нийт 1,094,096 хэрэглэгч татсан ба харилцагчдын тоо 1,012,184-д хүрсэн байна. 2021 онд 890,787 зээлийн хүсэлт ирсэн бөгөөд зээлийн жигнэсэн дундаж хүү 35.6% байна.

### Санхүүгийн үзүүлэлтүүд

Нийт хөрөнгө 2021 онд өмнөх оноос 163%-иар, нийт өр төлбөр 178%-иар, эздийн өмч 138%-иар, хүүгийн цэвэр орлого 19%-иар, цэвэр ашиг 238%-иар тус тус өссөн байна. Цэвэр ашгийн маржин 67%, хөрөнгийн өгөөж 5%, өөрийн хөрөнгийн өгөөж 16% байгаа нь компани 2021 онд үр ашигтай ажилласныг илтгэж байна.

**Хүснэгт 9: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он**

| Балансын гол үзүүлэлтүүд (мян.төг) | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1,123,729 | 1,873,425 | 3,249,682 | 6,956,116 |
| Зээл (цэвэрээр) | 7,545,803 | 18,058,000 | 20,300,000 | 34,177,792 |
| **Нийт хөрөнгө** | **10,471,767** | **23,093,659** | **29,655,028** | **73,387,751** |
| Бусдаас авсан зээл | 554,606 | 2,540,636 | 2,664,401 | 20,544,388 |
| Бусад эх үүсвэр | 3,858,575 | 5,130,197 | 11,506,836 | 18,189,153 |
| **Нийт өр төлбөр** | **6,714,384** | **12,401,230** | **18,401,758** | **50,782,486** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 2,100,000 | 2,800,000 | 2,800,000 | 2,800,000 |
| **Эздийн өмч** | **3,757,384** | **10,692,429** | **11,253,270** | **22,605,265** |
| **Орлогын гол үзүүлэлтүүд (мян.төг)** | | | | |
| Хүүгийн цэвэр орлого | 873,689 | 2,555,973 | 4,184,469 | 3,854,741 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр орлого | 237,327 | 2,427,775 | 1,563,757 | 4,161,452 |
| Цэвэр ашиг/алдагдал | 342,046 | 2,186,578 | 1,240,775 | 3,924,817 |

СЗХ
2023.01.13 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

ГЭРЭГЭ

**Хүснэгт 10: Ард Кредит ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он**

| **Балансын гол харьцаанууд** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|
| Өр төлбөр/Хөрөнгө | 0.64 | 0.54 | 0.62 | 0.69 |
| Өр төлбөр/Эздийн өмч | 1.79 | 1.16 | 1.64 | 2.25 |
| Зээлийн багц/Хөрөнгө | 0.72 | 0.78 | 0.68 | 0.47 |
| Зээлийн багц/Өр төлбөр | 1.12 | 1.46 | 1.10 | 0.67 |
| Зээлийн багц/Эздийн өмч | 2.01 | 1.69 | 1.80 | 1.51 |
| Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь | 4.2% | 6.5% | 9.4% | 7.00% |
| **Орлого, ашгийн гол харьцаанууд** | | | | |
| Үйл ажиллагааны орлогын маржин | 27% | 95% | 37% | 108% |
| Цэвэр ашгийн маржин | 39% | 86% | 30% | 102% |
| Хөрөнгийн өгөөж-ROA | 3% | 9% | 4% | 5% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE | 9% | 20% | 11% | 17% |

### Хувьцааны арилжаа

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав.[12]

| | | | |
|---|---|---|---|
| 52 долоо хоног, ₮ | 118.35-351.12 | Хаалтын үнэ | 220 |
| Зах зээлийн үнэлгээ, ₮ | 61,526,152,286 | Дансны үнэ | 96 |
| Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮ | 24.7 тэрбум | P/E | 14.67 |
| Эргэлтэд гаргасан хувьцаа, ширхэг | 279,753,341 | P/B | 2.30 |

**Зураг 5: Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа**




### ЛэндМН ББСБ

ЛэндМН ББСБ ХК нь 2016 онд байгуулагдсан, 2018 онд Монголын хөрөнгийн биржийн нээлттэй хувьцаат компани болсон. Нийт хувьцааны 75%-ийг Анд Системс ХХК, 25%-ийг олон нийт эзэмшиж байна. ЛэндМН ББСБ нь технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан финтек бизнес моделийг ЛэндМН аппликэйшнээр дамжуулан барьцаагүй, хямд өртөгтэй, хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээ үзүүлдэг компани юм.

[12] https://mse.mn/mn/company/550



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

2021 оны жилийн эцсийн байдлаар ЛэндМН аппликэйшн нь нийт 987,372 хэрэглэгчтэй, 182,528 зээлийн харилцагчтай болсон байна. 2021 оны зээлийн багцын 65%-ийг Улаанбаатар хотын, 35%-ийг орон нутгийн харилцагчид зээлж байна. 2021 онд нийт 867,000 удаа 183.4 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

2021 онд дэлхийн хамгийн том крипто биржийн нэг болох Binance дээр хэрэглэгчдэдээ ЛэндМН аппликэйшний тусламжтайгаар крипто арилжаанд оролцож төлбөр тооцоогоо төгрөгөөр хийх боломжийг бүрдүүлжээ.

Түүнчлэн, дэлхийн 126 орны 9000 гаруй компанийн төлбөрийн системтэй хамтран ажилладаг Thunes компанитай сүүлийн 2 жил гаруй хамтран ажиллаж байгаа бөгөөд ЛэндМН аппликэйшний хэрэглэгчдэд хамгийн хурдан, хамгийн бага шимтгэлтэйгээр Монгол улс руу мөнгөн гүйвүүлга хийх үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Монгол орон даяар буюу 21 аймаг, 9 дүүрэгт ЛэндМН аппликэйшнийг ашиглан цахим зээлийн гэрээ байгуулах боломжтой болсон. Тэрээр, 7, 14, 21, 28 хоногийн хугацаатай хамгийн ихдээ 1 сая төгрөг хүртэлх цахим итгэлцлийн "Plus итгэлцэл" нэртэй хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ажиллаж байна. Цаашид, ЛэндМН-ний загварыг Филиппин, Индонез, Япон улсуудад нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.[13]

**Санхүүгийн үзүүлэлтүүд**

Зээлийн багц 2021 онд өмнөх оноос 28%-иар, эздийн өмч 12%-иар тус тус өсч, нийт хөрөнгө 3%-иар, нийт өр төлбөр 15%-иар тус тус буурсан байна. Хүүгийн цэвэр орлого 2021 онд өмнөх онтой харьцуулахад 17%-иар буурсан бол үйл ажиллагааны орлого 12%-иар өсч, улмаар цэвэр ашиг 60%-иар өссөн байна.

**Хүснэгт 11: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд, 2018 – 2021 он**

| **Балансын гол үзүүлэлтүүд (мян.төг)** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 4,218,150 | 2,382,196 | 10,348,101 | 4,900,000 |
| Зээл (цэвэрээр) | 19,199,366 | 49,457,676 | 25,430,960 | 32,430,000 |
| **Нийт хөрөнгө** | **24,323,437** | **58,100,953** | **40,735,460** | **39,310,000** |
| Итгэлцлийн өглөг | | 13,845,212 | 10,485,907 | 15,070,000 |
| Бусад эх үүсвэр | 10,092,417 | 24,734,810 | 5,317,823 | 2,950,000 |
| **Нийт өр төлбөр** | **10,969,062** | **40,902,475** | **23,021,642** | **19,490,000** |
| Хуримтлагдсан хөрөнгө | 10,756,859 | 10,490,773 | 9,767,920 | 8,480,000 |
| **Эздийн өмч** | **13,354,375** | **17,198,478** | **17,713,818** | **19,820,000** |
| **Орлогын гол үзүүлэлтүүд (мян.төг)** | | | | |
| Хүүгийн цэвэр орлого | 6,631,385 | 13,666,841 | 11,654,292 | 9,690,000 |
| Үйл ажиллагааны цэвэр орлого | 6,222,860 | 12,048,039 | 9,293,611 | 10,420,000 |
| Цэвэр ашиг/алдагдал | 2,560,313 | 4,910,189 | 2,432,193 | 3,890,000 |

Үйл ажиллагааны орлогын маржин 37%, цэвэр ашгийн маржин 40%, хөрөнгийн өгөөж 10%, өөрийн хөрөнгийн өгөөж 20% байгаа нь компани өр төлбөрөөс илүүтэйгүүр өөрийн хөрөнгөөр зээлийн олголтыг санхүүжүүлдэг болох нь ажиглагдаж байна.

**Хүснэгт 12: ЛэндМН ББСБ-ын санхүүгийн үндсэн харьцаанууд, 2018 – 2021 он**

| **Балансын гол харьцаанууд** | **2018** | **2019** | **2020** | **2021** |
|---|---|---|---|---|
| Өр төлбөр/Хөрөнгө | 0.45 | 0.70 | 0.57 | 0.50 |

[13] https://lend.mn/ipo3.html



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| Өр төлбөр/Эздийн өмч | 0.82 | 2.38 | 1.30 | 0.98 |
| Зээлийн багц/Хөрөнгө | 0.79 | 0.85 | 0.62 | 0.82 |
| Зээлийн багц/Өр төлбөр | 1.75 | 1.21 | 1.10 | 1.66 |
| Зээлийн багц/Эздийн өмч | 1.44 | 2.88 | 1.44 | 1.64 |
| Зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь | 1.8% | 3.5% | 9.1% | 7.0% |
| **Орлого, ашгийн гол харьцаанууд** | | | | |
| Үйл ажиллагааны орлогын маржин | 41% | 41% | 26% | 37% |
| Цэвэр ашгийн маржин | 39% | 36% | 21% | 40% |
| Хөрөнгийн өгөөж-ROA | 11% | 8% | 6% | 10% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж-ROE | 19% | 29% | 14% | 20% |

**Хувьцааны арилжаа**

ЛэндМН ХК-ийн хувьцааны ханш, зах зээлийн үнэлгээ, харьцаануудын мэдээллийг 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар доор харуулав. [14]

| | | | |
|---|---|---|---|
| 52 долоо хоног, ₮ | 37.42-51.25 | Хаалтын үнэ | 40.31 |
| Зах зээлийн үнэлгээ, ₮ | 29,849,834,428 | Дансны үнэ | 26.77 |
| Нийт хоёрдогч арилжааны дүн, ₮ | 14.3 тэрбум | P/E | 7.67 |
| Эргэлтэд гаргасан хувьцаа, ширхэг | 740,506,932.00 | P/B | 1.51 |

**Зураг 6: ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа**




**Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт**

**Салбарт эзлэх хувь**

Банк бус санхүүгийн салбарын харьцуулж буй компаниудыг үнэлгээний компани болох Сэндли ББСБ ХХК-ийн санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан авч үзэв.

**Хүснэгт 13: Үндсэн үзүүлэлтээр салбарт эзлэх хувь**

| Салбарт эзлэх хувь | Инвескор | Ард Кредит | ЛэндМН | Сэндли |
|---|---|---|---|---|
| Зээл (цэвэрээр) | 9.2% | 1.8% | 1.7% | 0.5% |

[14] https://mse.mn/mn/company/545

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



| | | | | |
|---|---|---|---|---|
| Нийт хөрөнгө | 7.8% | 2.7% | 1.5% | 0.4% |
| Өөрийн хөрөнгө | 4.2% | 1.3% | 1.1% | 0.4% |
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 4.7% | 0.8% | 2.0% | 0.1% |
| Цэвэр ашиг/алдагдал | 9.1% | 1.9% | 1.9% | 0.3% |

Инвескор ББСБ дээрх санхүүгийн үндсэн үзүүлэлтүүдийн хувьд нийт зах зээлийн ойролцоогоор 9%-ийг эзэлж байна. Ард Кредит, ЛэндМН ББСБ цэвэр ашиг, алдагдлын хувьд ойролцоо буюу нийт зах зээлийн тус бүр 2%-ийг эзэлж байна. Сэндли ББСБ нь зээлийн эх үүсвэр нь ихэвчлэн өөрийн хөрөнгөөр санхүүжиж байгаа, мөн технологийн хөгжүүлэлтэнд зардал их гарсан, үйл ажиллагаа жигдрээд удаагүй байгаа зэрэг нөхцөл байдлаас шалтгаалаад одоогийн байдлаар зах зээлийн 0.1-0.5%-ийг эзэлж байна.

### Санхүүгийн зохицуулах хорооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

СЗХ-ны холбогдох журмын дагуу гаргасан 2021 оны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 14: СЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, 2021 он**

| Харьцаа үзүүлэлтүүд | Байвал зохих | Инвескор | ЛэндМН | Сэндли |
|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-иас доошгүй | 30.7% | 48.6% | 70.7% |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-иас доошгүй | 33.1% | 55.5% | 70.7% |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-иас доошгүй | 31.7% | 50.3% | 67.5% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-иас дээш | 16.2% | 29.4% | 34.0% |
| Гадаад актив, пассивын зөрүү, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | 18.0% | -11.1% | 4.7% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-иас хэтрэхгүй | 74.7% | 33.5% | 36.0% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-иас хэтрэхгүй | 38.5% | 32.3% | 0.0% |

### Сэндли ББСБ ХК-ийн давуу тал болон бусдаас ялгарах байдал

- Монголбанкнаас "карт хүлээн авагч"-ын тусгай зөвшөөрөл авсан Hipay компанитай нэг эзэмшигчийн өмчлөлд байдаг бөгөөд энэ нь арилжааны банкуудтай гэрээ хийх шаардлагагүйгээр зээлдэгчийн гэрээнд тусгасан аль ч банкны данснаас зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн оролцоо шаардлагагүйгээр татан авах боломжтой.
- Зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн шаардлагагүйгээр өдөр бүр тэнцүү дүнгээр татаж авах нь зээл чанаргүй болох магадлалыг бууруулж байна.
- Зээлийн эргэн төлөлтийг өдөр бүр татаж авдаг бизнес модель нь компанид мөнгөн хөрөнгийн тасралтгүй байдал, зээл олголтын тасралтгүй байдал гэсэн давуу талуудыг олгож байна.
- Улаанбаатар хотоос гадна 18 аймаг, 28 сумандд салбартай тул зээл олголтын эрсдлийг тархаан байршуулж чадаж байна. Орон нутаг дахь чанаргүй зээлийн хувь бага байдаг талаар компанийн удирдлагууд дурдсан.
- Улаанбаатар хот дахь гол томоохон худалдааны зах, төвүүд дээр салбар байгуулж, мерчантын зээлд, ялангуяа хүнсний үйл ажиллагаа эрхэлдэг бөөний болон жижиглэн худалдаачидтай хамтарч ажиллаж байгаа нь зээл олголтыг нэмэгдүүлж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

- Wechat pay-ийн Монгол дахь албан ёсны партнер болсон нь БНХАУ-ын жуулчид Монгол улсад аялахдаа Wechat-р гүйлгээ хийх, монгол дахь мерчантуудад төлбөрууд нь цаг тухай бүр орох, Монголын жижиг дунд, үйлдвэр эрхлэгчид Wechat дээр бараагаа борлуулах, төлбөрөө цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлнэ.
- Цаашид бүрэн автомажсан зээлийн процесс нь хүний нөөцийн зардлыг хэмнэх, үр бүтээмжийг нэмэгдүүлэх, хүнээс хамаарсан алдаа, хулгайг багасгах, зээлдэгчдийн цаг хугацааг хэмнэх зэрэг маш олон давуу талуудыг олгох болно.

### Гадаадын компаниудтай харьцуулах нь

Үнэлгээнд хамрагдсан компанитай ижил төстэй үйл ажиллгаа явуулдаг гадаадын санхүүгийн байгууллагын олон нийтэд нээлттэй мэдээлэл олдоц сайтай байна. Жишээ болгох үүднээс (бичил) санхүүгийн зах зээл харьцангүй сайн хөгжсөн Балба улсын хөрөнгийн бирж[15] дээр арилжаалагдаж буй бичил зээлийн санхүүгийн байгууллагуудаас сонгон авч хөрөнгө оруулалтын үндсэн харьцааг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 15: Гадаадын компаниудын үндсэн үзүүлэлтүүд**

| Компанийн нэр | RMDC LBSL | Sana Kisan Bikas LBSL | Nerude LBSL | Summit LBSL | First Microfinance LBSL | **Дундаж** |
|---|---|---|---|---|---|---|
| Үнэлгээ, сая $ | 107.30 | 159.62 | 54.09 | 45.55 | 61.97 | **85.71** |
| P/E | 38.86 | 30.07 | | 32.66 | 36.20 | **34.45** |
| P/B | 4.17 | 5.07 | | 8.09 | 6.16 | **5.87** |

Дээрх харьцуулалтаас үзэхэд дунджаар 85.71 сая ам.доллар буюу ойролцоогоор 250 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй бичил санхүүгийн байгууллагуудын хувьд санхүүгийн бизнесийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг үнэ, ашгийн харьцаа (P/E ratio) 30.07 – 38.86 хооронд, дундаж нь 34.45, үнэ, өөрийн хөрөнгийн харьцаа (P/B ratio) 4.17-8.09-ийн хооронд, дундаж нь 5.87 байна.

### Зах зээлийн харьцуулалтын аргын үр дүн

Сэндли ББСБ ХХК нь Монголын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа анхлан санал болгож (IPO) 10.0 тэрбум төгрөгийн хувьцааны санхүүжилт татахаар төлөвлөж байна. Тайлангийн 2-р бүлэгт тайлбарласны дагуу энэхүү үнэлгээ нь санхүүжилт орж ирсэний дараах буюу Post Money Valuation болно. Иймд зах зээлийн харьцуулалтын шинжилгээнд Сэндли ББСБ ХХК-ийн нийт эздийн өмчийн дүнг үнэлгээний өдрийн байдлаарх эздийн өмчийн дүн болох 7,144.0 сая төгрөг, IPO нэмэлт санхүүжилт 10,000.0 сая төгрөг, нийт 17,144.0 сая төгрөг байхаар авч ашиглав.

**Хүснэгт 16: Зах зээлийн харьцуулалтын шинжилгээний үр дүн**

| **Компаниуд** | **P/B** | **Харьцуулсан үнэлгээ,** *сая төгрөг* |
|---|---|---|
| Инвескор ББСБ ХК | 3.84 | 65,835.8 |
| Ард Кредит ББСБ ХК | 1.51 | 25,819.7 |
| ЛэндМН ББСБ ХК | 2.30 | 39,434.2 |
| **Дундаж** | **2.55** | **43,696.6** |

[15] http://merolagani.com



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

20 _ он _ сар _ өдөр
БҮРТГЭВ
№ 4:1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ
ГЭРЭГЭ

**Зах зээлийн харьцуулалтын шинжилгээгээр Сэндли ББСБ-ын хөрөнгийн зах зээлээс 10.0 тэрбум төгрөг татсаны дараах бизнес эмчлөлийн 100%-ийн үнэ цэн 25.8 – 65.8 тэрбум, дундаж нь 43.7 тэрбум төгрөг байх баримжаа тооцоолол гарч байна.**

Үнэлгээний компанийн бизнесийн онцлог болон үнэлгээний ажлын зорилготой уялдуулан бусад үржүүлэгчийг зах зээлийн шинжилгээнд ашиглах нь тохиромж муутай болно.

### Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан хандлагыг үнэлгээнд хэрэглэхэд тухайн бизнесийн нийт хөрөнгөөс өр төлбөрүүдийг хасах замаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргаар үнэлгээ хийхийн тулд Сэндли ББСБ ХХК-ийн биет болон биет бус бүх хөрөнгүүд, мөн өр төлбөрийн үзүүлэлтүүдийн зах зээлийн үнэ цэнийг тогтоох замаар цэвэр хөрөнгийн хэмжээг тодорхойлох шаардлагатай болно.

Сэндли ББСБ ХХК-ийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг үнэлгээний зориулалтаар дараах байдлаар хувааж үнэлэв. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгө:
   - Үндсэн хөрөнгө
   - Биет бус хөрөнгө
2. Эргэлтийн хөрөнгө:
   - Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө
   - Авлага
   - Дансны авлага
3. Өр төлбөр:
   - Өглөг, зээл, бусад зэрэг орно.

Эргэлтийн бус хөрөнгүүдийн онцлог байдлуудаас хамааран ҮОУС-д тодорхойлсон өртгийн хандлагын аргыг ашиглав. Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээнд Сэндли ББСБ ХХК-ийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүдийг хамруулав. Үнэлгээний үр дүнг дараах хүснэгтэд, үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 3-д үзүүлэв.

**Хүснэгт 17: Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ**

| Хөрөнгө | Тодорхойлолт | Тооцоолсон үнэ цэн, төгрөгөөр |
|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | 195ш тавилга, компьютер дагалдах хэрэгсэл | 221,586,362 |
| Биет бус хөрөнгө | 2ш программ хангамж | 45,322,728 |
| Нийт дүн | | 266,909,090 |

Сэндли ББСБ ХХК-ийн эргэлтийн бус хөрөнгийн нийт үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар 266,909,090 төгрөг байхаар тооцоолов.

2021 оны 4-р улирлын санхүүгийн тайланд орсон дүнгээр тус компанийн нийт эргэлтийн хөрөнгө 10,275,279,231, нийт өр төлбөр 3,457,430,799 төгрөг байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9122121175 УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

**Цэвэр хөрөнгө**

Хөрөнгөд суурилсан аргаар бизнесийг үнэлэхэд нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан цэвэр хөрөнгөд үндэслэн тооцоолов.

**Хүснэгт 18: Сэндли ББСБ ХХК-ийн цэвэр хөрөнгийн дүн**

| Үзүүлэлтүүд | Дүн, төгрөгөөр |
|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 10,275,279,231 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 266,909,090 |
| Өр төлбөр | 3,457,430,799 |
| **Цэвэр хөрөнгө** | **7,084,757,522** |

Дээрх тооцооллоор Сэндли ББСБ ХХК-ийн цэвэр хөрөнгө үнэлгээний өдрийн байдлаар 7,084,757,522 төгрөг байх тооцоолол гарч байна. Энэ аргаар Сэндли ББСБ ХХК-ийн үнэ цэнийг тодорхойлох нь үнэлгээний ажлын зорилгод тохиромж муутай. Учир нь тооцоолонд тус компанийн ирээдүйн орлого олох үйл явцад чухал нөлөө үзүүлэх IPO-оор татах санхүүжилт, компанийн менежмент, хүний нөөцийн туршлага, ур чадвар, санхүүгийн бизнесийн онцлог, шинэ технологи хөгжүүлэлт зэрэг хүчин зүйлсийг авч үздэггүйтэй холбоотой.

## Орлогын хандлагаар хийсэн үнэлгээ

Сэндли ББСБ нь IPO-оор татахаар төлөвлөж байгаа нэмэлт хөрөнгө оруулалтыг 100% компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байгаа нь тус компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шууд болон дам нөлөө өндөртэй тул олон нийтээс хөрөнгө татасны дараах үеийн орлогын хандлагаар хийсэн үнэлгээ (Post-Money valuation) нь үнэлгээний ажлын зорилго болон үнэлгээний даалгавартай нийцнэ гэж дүгнэв.

Үнэлгээнд Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity) загварыг ашиглав.

Үнэлгээнд ашигласан орц, төсөөллүүд болон үндсэн тооцооллыг доор тайлбарлав.

**Үнэлгээний үндсэн орц, төсөөллүүд**

**Зах зээлийн багтаамжийн ирээдүйн төсөөлөл**

СЗХ-ны мэдээлснээр Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудын нийт өөрийн хөрөнгө 2021 оны эцсийн байдлаар өнгөрсөн оноос 24%-иар өсөж 1.8 орчим их наяд төгрөгт хүрсэн байна. Харин нийт зээлийн хэмжээ 51.6%-иар өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбартай харьцуулахад 9.5% болж өнгөрсөн оноос 2.0 функт нэгжээр өсжээ.[5]

Сэндли ББСБ ХХК нь 2022 онд IPO-оор нийт 10.0 тэрбум төгрөгийн хувьцааны санхүүжилт, "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэж дүрмийн санг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Эдгээр нэмэлт хөрөнгө оруулалтыг татсаны дараах үеийн Сэндли ББСБ-ын нийт эздийн өмч 17.8 тэрбум төгрөг болж байгаа нь банк бус санхүүгийн байгууллагын зах зээлийн 1.0%, салбарын нийт зээлийн 1.1% орчим хувийг тус тус эзлэхээр тооцоолж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
6921121175 УЛААНБААТАР ХОТ ХТҮ001 5961565

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

Энэ нь зах зээлийн багтаамж талаас авч үзвэл Сэндли ББСБ-ын бизнес төлөвлөгөө хэрэгжих хангалттай орон зай, боломж байгааг харуулна.

**Сэндли ББСБ-ын зээлийн эх үүсвэрийн төсөөлөл**

Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн эх үүсвэр нь үндсэндээ өөрийн хөрөнгө болон бусдаас татсан эх үүсвэрээс бүрдэнэ.

Өөрийн хөрөнгө

Сэндли ББСБ-ын IPO-оор татах 10.0 тэрбум төгрөг нь 2022 оны 10-р сард зээлийн үйл ажиллагаанд бэлэн болно гэж төсөөлөн үнэлгээнд тусгав. Сэндли ББСБ нь "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргаад байна.

"Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийн 2021 оны эцсийн санхүүгийн аудитлагдсан тайланд туссанаар үнэлгээний өдрийн байдлаар тус компани нь 1,653.5 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, үүнээс мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө 791.1 сая төгрөг, зээл 490.5 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн авлага 366.9 сая төгрөг буюу нийт 1,648.5 тэрбум төгрөгийг зээлийн үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгө гэж үзэж болно. Иймд "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийн дүрмийн сан болох 1.4 тэрбум төгрөгийг 2022 оны 6-р сараас эхлэн Сэндли ББСБ-ын зээлийн эх үүсвэрт оруулж тооцов.

Сэндли ББСБ нь 2021 онд нийт 715.5 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан бөгөөд цаашид тухайн жилийн эцсийн байдлаарх хуримтлагдсан ашгийг ирэх жилийн зээлийн боломжит нийт эх үүсвэрт оруулж тооцоолов.

Бусдаас татсан эх үүсвэр

Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмын дагуу банк бус санхүүгийн байгууллагын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ итгэлцлийн үйлчилгээний хувьд өөрийн өмчийн 80% хүртэл, өрийн бичгийн хувьд 50% хүртэл, нийт 130% хүртэл байх боломжтой. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниуд нь бусдаас татан төвлөрүүлэх хөрөнгийг зохицуулах байгууллагаас тогтоосон дээд хэмжээнд тулгаж татахыг зорин ажиллаж байна. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд мэдээлснээр эдгээр компаниудын бусдаас татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийг өөрийн өмчид харьцуулсан дундаж харьцаа 2019, 2020, 2021 онуудын эцэст харгалзан 130%, 123%, 130% хэмжээтэй байна.

Сэндли ББСБ нь хувьцаат компани болсноор итгэлцлийн гэрээгээр болон өрийн бичгээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Сэндли ББСБ-ийн бусдаас татан төвлөрүүлэх хөрөнгийн нийт дүнг зохицуулах байгууллагын тогтоосон дээд хэмжээний 90%-иар буюу 117% байхаар авч үнэлгээнд тооцсон болно. Энэ нь харьцуулсан 3 компанийн Ковидын жил болох 2020 оны дундаж дүн болох 123%-иас бага байгаа тул үнэлгээний ажлын зорилгод нийцсэн харьцангуй болгоомжтой төсөөлөл гэж Үнэлгээчид үзэж байна.

**Сэндли ББСБ-ын нийт зээлийн төсөөлөл**

Нийт зээл



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
ХТҮ5561 5961048
9012117 УЛААНБААТАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

Үнэлгээний тооцоолол ирэх жилүүдийн Үйлчлүүлэгчийн нийт зээлийн хэмжээг тооцоолох зорилгоор тухайн жилийн боломжит нийт зээлийн эх үүсвэрийн хэмжээг дараах байдлаар тодорхойлов.

*Зээлийн нийт боломжит үүсвэр (t) =* *Хувьцаат капитал (t)*
*+ Бусдаас татсан эх үүсвэр (t)*
*+ Хуримтлагдсан ашиг (t-1)*

энд, *(t)* тухайн жил, *(t-1)* өмнөх жилийг илэрхийлнэ.

Дээрх тодорхойлолтоор авч үзвэл 2021 оны эцсийн байдлаар Сэндли ББСБ-ийн нийт цэвэр зээлийн үлдэгдэл нь нийт боломжит эх үүсвэрийн 93.2%-ийг эзэлж байна. Үнэлгээнд энэ харьцаа ирэх жилүүдэд хадгалагдахаар төсөөлөв.

2021 оны эцсийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Инвескор ББСБ, Ард Кредит ББСБ, ЛэндМН ББСБ компаниудын хувьд дээрх тодорхойлолтоор тооцсон харьцаанууд нь харгалзан 97%, 101%, 60% буюу хоорондоо зөрүү өндөр байгаа тул санхүүгийн төсөөлөлд Үйлчлүүлэгчийн өмнөх жилийн гүйцэтгэлд илүүтэй ач холбогдол өгч үндэслэлтэй гэж үзэв.

Хэвийн болон хугацаа хэтэрсэн зээл

2021 оны эцсийн байдлаар нийт зээлд эзлэх хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ Үйлчлүүлэгчийн хувьд 99.9%, харин харьцуулсан 3 компанийн дундаж 95.1% байсан болно. Цаашид Үйлчлүүлэгчийн зээлийн үйл ажиллагаа өргөжиж зах зээлийн дундаж үзүүлэлтэд дөхнө гэж төсөөлөв.

Цаашлаад хэвийн болон хугацаа хэтэрсэн зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээг мөн харьцуулсан 3 компанийн дундаж дүнгээр авч үнэлгээний тооцоолол ашиглав.

Эдгээр үндсэн төсөөллийг ашиглан мөн СЗХ-ны журмын дагуу зээлийн эрсдэлийн санг тооцоолж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 19: Сэндли ББСБ ХХК-ийн зээлийн үйл ажиллагааны төсөөлөл, сая төг**

| Зээлийн үзүүлэлтүүд | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт цэвэр зээл | 8,608.2 | **22,651.4** | **43,494.3** | **53,758.3** | **65,489.7** | **77,659.9** |
| Нийт эх үүсвэрт эзлэх хувь | 93.2% | 93.2% | 93.2% | 93.2% | 93.2% | 93.2% |
| Хэвийн + Хугацаа хэтэрсэн зээл | 8,598.4 | **21,546.6** | **41,372.9** | **51,136.2** | **62,295.4** | **73,871.9** |
| Нийт зээлд эзлэх хувь | 99.9% | 95.1% | 95.1% | 95.1% | 95.1% | 95.1% |
| Хэвийн | 8,491.6 | 21,050.3 | 40,419.9 | 49,958.4 | 60,860.5 | 72,170.4 |
| Нийт цэвэр зээлд эзлэх хувь | 98.8% | 97.7% | 97.7% | 97.7% | 97.7% | 97.7% |
| Анхаарал хандуулах | 106.8 | 496.3 | 952.9 | 1,177.8 | 1,434.8 | 1,701.5 |
| Нийт цэвэр зээлд эзлэх хувь | 1.2% | 2.3% | 2.3% | 2.3% | 2.3% | 2.3% |
| Чанаргүй зээл | 9.8 | 1,104.8 | 2,121.5 | 2,622.1 | 3,194.3 | 3,767.9 |
| Хэвийн бус | 9.8 | 523.8 | 706.0 | 695.8 | 721.6 | 757.6 |
| Эргэлзээтэй | - | 145.3 | 353.9 | 481.6 | 618.2 | 757.6 |
| Муу | - | 435.8 | 1,061.6 | 1,444.7 | 1,854.6 | 2,272.8 |
| Эрсдэлийн сан | 7.8 | 664.2 | 1,462.7 | 1,918.4 | 2,415.8 | 2,926.0 |



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-18

**Хөрөнгийн бусад үзүүлэлтүүдийн төсөөлөл**

Сэндли ББСБ-ийн бизнесийн онцлогоос хамаарч тус компанийн эргэлтийн бус хөрөнгө нь харьцангуй бага дүнтэй бөгөөд барилга байгууламжийг түрээсээр эзэмшиж байна. Тус компанийн компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамжийн ирэх жилүүдийн төсөөллийг компанийн менежментийн төсөөлснөөр авч үнэлгээнд ашиглав.

Хүүгийн орлогод харьцуулсан хуримтлуулж тооцсон хүүгийн авлагыг Үйлчлүүлэгчийн менежментийн тооцоолсон дүн буюу 8.3%-иар, бусад активыг 2021 оны гүйцэтгэл болох 6.7%-иар тус тус төсөөлөв.

**Сэндли ББСБ-ын орлого, зардлын үзүүлэлтүүдийн төсөөлөл**

Сэндли ББСБ-ын орлогын үндсэн бүрэлдэхүүнд зээлийн бүтээгдэхүүний хүү, шимтгэлийн орлого болон мөнгөн гүйвүүлгын орлого орж байна.

<u>Зээлийн бүтээгдэхүүний орлого</u>

Тодорхойлолтын зөрүү үүсэх эрсдэлээс сэргийлж энэхүү үнэлгээнд зээлийн хүү гэдэгт зээлийн бүтээгдэхүүний хүү болон шимтгэлийн орлогыг дундаж цэвэр зээлд харьцуулсан дүнгээр тодорхойлж хэрэглэв.

Сэндли ББСБ-ийн зээлийн сарын дундаж хүү 2021 онд 3.2% байсан ба 2022 онд 3.9% байхаар тооцоолж байна. Зээлийн сарын дундаж хүү 2021 онд харьцуулалтаар авсан 3 компани болох Инвескор ББСБ, ЛэндМН ББСБ, Ард Кредит ББСБ-ын хувьд харгалзан 3.1%, 3.7%, 4.8%, дундажаар 3.9% байсан байна.

Үнэлгээнд Сэндли ББСБ-ийн 2022 оны зээлийн сарын дундаж хүү цаашид жигд хэмжээгээр буурч 2026 он гэхэд 3.0% байхаар тооцоолов. Хэдийгээр энэ дүн нь тайлангийн өдрийн байдлаарх Үйлчлүүлэгчийн бодит гүйцэтгэл болон ирээдүйн төсөөллөөс харьцангуй бага байгаа боловч Үнэлгээчид нь дэлхийн улс төр, эдийн засагт үүссэн тодорхойгүй энэ цаг үед илүү болгоомжтой хандлага барих нь үнэлгээний ажлын зорилгод нийцтэй гэж үзсэн болно.

<u>Мөнгөн гүйвүүлгын цэвэр орлого</u>

Сэндли ББСБ нь олон улстай онлайнаар мөнгөн гүйвүүлга хийх финтек технологид суурилсан "Sendly" гар утасны аппликэйшнийг 2020 оны 5 сард амжилттай нэвтрүүлэн ажиллаж байна. Үнэлгээний өдрийн байдлаар мөнгөн гүйвүүлгыг АНУ-аас Монгол улс руу, Монгол улсаас АНУ руу, Австрали улсаас Монгол улс руу, Япон улсаас Монгол улс руу гэсэн чиглэлийн дагуу хийж байгаа бөгөөд тун удахгүй Солонгос болон Европын холбооны улсуудаас мөнгө гүйвүүлга хийх гарцыг нээхээр ажиллаж байна. 2022 оны 3-р сарын байдлаар нийт 7 сая ам.долларын 15,000 гаруй мөнгөн гүйвүүлгын гүйлгээ хийсэн ба нийт 15,248 хэрэглэгч аппликэйшнийг татаж, үүнээс идэвхитэй 4,000 гаруй хэрэглэгчидтэй болсон байна.

Сэндли ББСБ нь улс хоорондын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг амжилттай эхлүүлэн ажиллаж байгаа боловч мөнгөн гүйвүүлгын үйлчилгээнд тусгайлсан бизнес төлөвлөгөөг Үнэлгээчдэд ирүүлээгүй болно. Иймд мөнгөн гүйвүүлгын цэвэр орлогыг Үйлчлүүлэгчийн менежментийн төсөөллийн 50%-иар авч үнэлгээнд оруулав.



СЭНДЛИ ББСБ ХК

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭЗ-03

Бусдаас татсан эх үүсвэрийн зардал

Зээл, өрийн үнэт цаасны дундаж зардал болон итгэлцлийн үйлчилгээний зардлыг 2022 онд харгалзуулан сарын 1.3% болон 1.5% байхаар зах зээлийн мэдээлэлд үндэслэн авсан ба **цаашид Сэндли ББСБ-ын зээлийн хүүний төсөөлөлтэй шууд хамааралтайгаар буурахаар үнэлгээний загварт тооцоолов.**

Үйл ажиллагааны болон бусад зардал

Сэндли ББСБ-ын менежментийн багийн тооцоолсон үйл ажиллагааны болон бусад зардлын төсөөлөлд Үнэлгээчид шинжилгээ хийсэн бөгөөд уг тооцоолол нь харьцангуй бодит болсон гэж дүгнэсэн болно. Учир нь эдгээр зардал нь борлуулалт болон зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч шууд өөрчлөгдөнө гэж үзэхээс илүүтэй менежментийн бизнес төлөвлөгөөний дагуу менежментийн шийдвэрээр гардаг онцлогтой зардлууд багтаж байна.

Зээл олгохтой холбоотой банкны гүйлгээний шимтгэлийн зардал Hipay-н 1% шимтгэлийг оруулаад 2021 оны байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 1.7%-г ээлж байсан бөгөөд цаашид энэ хувийг хадгалагдахаар төсөөлөв.

**Хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувь**

Сэндли ББСБ-ын хувьцаанд хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн тооцооллыг Капитал хөрөнгийн үнэлгээний CAPM загварыг ашиглан хийж гүйцэтгэв. Харин CAPM аргыг шууд хэрэглэхэд манай улсын хөрөнгийн зах зээлийн мэдээлэл хангалттай биш тул хөгжиж байгаа орнуудад элбэг хэрэглэгддэг арга буюу хөгжсөн зах зээлтэй харьцуулж үнэлдэг аргыг хэрэглэв.[16] Аргыг товч тайлбарлавал:

$$k_e = R_f + \beta_e\, MMERP + \lambda_e CDS$$

энд,

| | |
|---|---|
| $k_e$ - | cost of equity capital |
| $R_f$ - | risk-free reference rate in a developed country |
| *MMERP* - | mature market equity risk premium |
| $\beta_e$ - | exposure to market risk |
| *CDS* - | country credit default swap rate |
| $\lambda_e$ - | exposure to country risk |

Хөрөнгө оруулагчийн шаардах өгөөжийг 21.1% байхаар дараах байдлаар тооцоолов.

Эхлээд өргөтгөсөн CAPM загварын тусламжтайгаар ам.доллараар илэрхийлсэн хорогдуулах хувийн суурь дүнг ерөнхий байдлаар тооцоолов.

| Хэмжигдэхүүн | Утга | Тайлбар |
|---|---|---|
| *Rf* = | 1.94% | 20 year US Treasury[17] |
| *MMERP* = | 4.24% | USA Equity risk premium[18] |
| *βe* = | 0.93 | Beta in Financial services (Non-bank & Insurance), USA[19] |

[16] https://scielo.conicyt.cl/scielo.php?script=sci_arttext&pid=S0719-04332016000100006#n6
[17] https://www.macrotrends.net/2522/5-year-treasury-bond-rate-yield-chart
[18] http://pages.stern.nyu.edu/~adamodar/
[19] http://pages.stern.nyu.edu/~adamodar/New_Home_Page/datafile/Betas.html



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

| | | |
|---|---|---|
| *CDS* = | 5.53% | Credit default swap of Mongolia[20] |
| *λe*= | 1 | High exposure to country risk[21] |
| ***ke(usd)* =** | **11.41%** | |

Суурь хувь дээр үнэлгээнд хамрагдсан компанийн хэмжээ, салбарын бизнесийн онцлогтой холбоотой эрсдэл, ханшийн эрсдэл зэргийг нэмж тооцоолсноор Сэндли ББСБ-ын хөрөнгө оруулагчдын шаардах өгөөжийн хувийг 21.1% байхаар тооцоолж үнэлгээнд ашиглав.

| **Хамааралдахууд** | **Утга** | **Тайлбар** |
|---|---|---|
| *Size risk premium* | 2.50% | Компанийн хэмжээтэй холбоотой эрсдэлийн нэмэгдэл |
| *Industry specific risk premium* | 1.50% | Салбарын бизнесийн онцлогтой холбоотой эрсдэл |
| *Currency risk premium* | 5.71% | 2021.12 сарын байдлаар ханшийн эрсдэл, Монголбанкны хувийн секторт шинээр олгосон ам.долларын болон төгрөгийн зээлийн зөрүү |
| **$k_{adjusted}$ =** | **21.1%** | |

Цэвэр мөнгөн урсгалын урт хугацааны өсөлтийн хувийг 5.0% байхаар авав.

**Ногдол ашгийн бодлого**

Сэндли ББСБ ХХК-ийн удирдлага нь 2023 оноос хойш тус компанийн татварын дараах цэвэр ашгийн 20%-ийг ногдол ашигт хуваарилахаар төлөвлөж байгаа тул үнэлгээнд ногдол ашгийн энэ бодлогыг оруулж тооцоолсон болно.

**Ирээдүйн цэвэр мөнгөн урсгалын төсөөлөл**

Сэндли ББСБ ХХК-ийн ирээдүйн 5 жилийн цэвэр мөнгөн урсгалын төсөөллийн үндсэн хувилбарыг дараах байдлаар тооцоолов.

**Хүснэгт 20: Сэндли ББСБ ХХК-ийн орлогын төсөөлөл, 2022 – 2026 он**

| **Орлогын үзүүлэлтүүд,** *сая төгрөг* | **2021** | **2022** | **2023** | **2024** | **2025** | **2026** |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүүгийн болон бусад орлого** | **1,795.9** | **6,940.7** | **13,934.4** | **18,160.8** | **19,299.6** | **20,198.5** |
| Мөнгөн гүйвүүлгын цэвэр орлого | 36.9 | 177.8 | 530.0 | 789.0 | 1,047.9 | 1,047.9 |
| Валютын ханшийн зөрүүний орлого | 143.4 | | | | | |
| Хүүгийн болон бусад зардал | 183.2 | 1,593.9 | 3,432.0 | 5,606.3 | 6,378.2 | 7,055.6 |
| Үйл ажиллагааны зардал | 1,131.5 | 3,410.6 | 3,957.1 | 4,633.9 | 4,658.2 | 4,681.7 |
| Болзошгүй эрсдэлийн зардал | 7.8 | 656.4 | 798.5 | 455.7 | 497.4 | 510.2 |
| Элэгдлийн зардал | 33.4 | 58.9 | 80.5 | 88.7 | 88.7 | 81.8 |
| **Татварын өмнөх ашиг(алдагдал)** | **620.4** | **1,398.7** | **6,196.1** | **8,165.1** | **8,725.0** | **8,917.0** |
| Татвар | 32.0 | 139.9 | 649.0 | 1,141.3 | 1,281.2 | 1,329.2 |
| **Татварын дараах ашиг(алдагдал)** | **588.4** | **1,258.8** | **5,547.1** | **7,023.8** | **7,443.7** | **7,587.7** |
| Ногдол ашиг | - | - | **1,109.4** | **1,404.8** | **1,488.7** | **1,517.5** |

[20] http://pages.stern.nyu.edu/~adamodar/
[21] https://archive.nyu.edu/bitstream/2451/26918/2/wpa99021.pdf

**Хүснэгт 21: Сэндли ББСБ ХХК-ийн хөрөнгийн үзүүлэлтийн төсөөлөл, 2022 – 2026 он**

| **Хөрөнгийн үзүүлэлтүүд**, *сая төгрөг* | **2021** | **2022** | **2023** | **2024** | **2025** | **2026** |
|---|---|---|---|---|---|---|
| Бусдаас татсан эх үүсвэр | 2,680.0 | 5,758.2 | 26,861.4 | 33,435.7 | 40,403.1 | 47,505.2 |
| Өөрийн хөрөнгийн эх үүсвэр | 7,144.0 | 19,802.8 | 24,240.5 | 29,859.6 | 35,814.6 | 41,884.8 |
| **Нийт эх үүсвэр** | **9,824.0** | 25,561.1 | 51,101.9 | 63,295.3 | 76,217.6 | 89,390.0 |
| Нийт зээл | 8,608.2 | 22,651.4 | 43,494.3 | 53,758.3 | 65,489.7 | 77,659.9 |
| Зээдийн өмч | 7,144.0 | 19,802.8 | 24,240.5 | 29,859.6 | 35,814.6 | 41,884.8 |

Дээрх төсөөлөлд үндэслэн Сэндли ББСБ ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 34,096,591,256 (Гучин дөрвөн тэрбум ерэн зургаан сая таван зуун ерэн нэг мянга хоёр зуун тавин зургаа) төгрөг байхаар тооцоолов.

Тооцооллыг үзүүлбэл:

**Free Cash flow to Equity Model**

| | | | |
|---|---|---|---|
| Stable Equity Reinvestment Rate | 0.0% | Cost of equity | 21.1% |
| Stable FCFE Rate | 100.0% | Stable growth rate | 5.0% |

*MNT million*

| **Free Cash Flow to Equity** | **2022** | **2023** | **2024** | **2025** | **2026** | **2027** |
|---|---|---|---|---|---|---|
| Net income | 1,258.8 | 5,547.1 | 7,023.8 | 7,443.7 | 7,587.7 | 7,967.1 |
| Regulatory capital | - | - | - | - | - | |
| Free cash flow to Equity | 1,258.8 | 5,547.1 | 7,023.8 | 7,443.7 | 7,587.7 | |
| Terminal value | | | | | 49,414.1 | |
| Total | 1,258.8 | 5,547.1 | 7,023.8 | 7,443.7 | 57,001.9 | |
| NPV, MNT | **34,096,591,256** | | | | | |

**Мэдрэмжийн шинжилгээ**

Сэндли ББСБ ХХК-ийн бизнесийн үнэлгээний үр дүнгийн мэдрэмжийн шинжилгээг үнэлгээний тооцооллын үндсэн төсөөллүүд болох Зээлийн хүүний хэмжээ, Бусдаас татах эх үүсвэр, Нийт зардлын өөрчлөлт, Хорогдуулах хувийн хувьд хийж гүйцэтгэв.

**1. Сарын зээлийн дундаж хүү, 2026 онд**

| **Хувилбарууд** | **Хэмжээ, %** | **Үнэлгээ, тэрбум төг** | **Өөрчлөлт, %** |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 2.0% | 19.0 | -44.3% |
| Хувилбар 2 | 2.5% | 26.9 | -21.1% |
| Суурь хувилбар | 3.0% | 34.1 | 0.0% |
| Хувилбар 3 | 3.5% | 41.8 | 22.6% |
| Хувилбар 4 | 3.9% | 48.4 | 41.9% |

Үнэлгээний үр дүн нь сарын зээлийн дундаж хүүний өөрчлөлтөд ойролцоогоор 1.3 мэдрэмжтэйгээр өөрчлөгдөж байна. Тухайлбал, сарын дундаж зээлийн хүү 2026 онд үнэлгээний суурь хувилбараас 0.5 нэгж хувиар буюу 16.7%-иар буурахад үнэлгээний үр дүн 21.1%-иар буурах, мөн төдий хувиар өсөхөд 22.6%-иар өсөхөөр байна.

**2. Бусдаас татах эх үүсвэр**

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 100% | 30.1 | -11.7% |
| Хувилбар 2 | 110% | 32.4 | -5.0% |
| **Суурь хувилбар** | **117%** | **34.1** | **0.0%** |
| Хувилбар 3 | 125% | 36.0 | 5.6% |
| Хувилбар 4 | 130% | 37.3 | 9.4% |

Үнэлгээний үндсэн хувилбарт Сэндли ББСБ нь бусдаас татах эх үүсвэрийг СЗХ-ноос тогтоосон дээд хэмжээний 90%-иар буюу өөрийн хөрөнгийн 117%-тай тэнцэх хэмжээний хөрөнгийг бусдаас татахаар авсан болно. Үнэлгээний үр дүн нь бусдаас татах эх үүсвэрийн өөрчлөлтөд харьцангуй бага мэдрэмжтэйгээр өөрчлөгдөж байна.

**3. Нийт зардлын хэмжээ**

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 90% | 40.3 | 18.2% |
| Хувилбар 2 | 95% | 37.1 | 8.8% |
| **Суурь хувилбар** | **100%** | **34.1** | **0.0%** |
| Хувилбар 3 | 105% | 31.1 | -8.8% |
| Хувилбар 4 | 110% | 28.2 | -17.3% |

Зардлын мэдрэмжийн шинжилгээнд хүүгийн зардал, үйл ажиллагааны зардал, болзошгүй эрсдэлийн зардлыг хамруулж үзэв. Үнэлгээний үр дүн нь нийт зардлын өөрчлөлтөд дундажаар 1.8 мэдрэмжтэй өөрчлөгдөж байна. Тухайлбал, зардал 5%-иар өсөхөд (буурахад) үнэлгээ 8.8%-иар буурч (өсөж) байна.

**4. Хорогдуулах хувь**

| Хувилбарууд | Хэмжээ, % | Үнэлгээ, тэрбум төг | Өөрчлөлт, % |
|---|---|---|---|
| Хувилбар 1 | 19.5% | 38.5 | 12.9% |
| Хувилбар 2 | 20.0% | 37.0 | 8.5% |
| **Суурь хувилбар** | **21.1%** | **34.1** | **0.0%** |
| Хувилбар 3 | 22.0% | 32.1 | -5.9% |
| Хувилбар 4 | 22.5% | 31.1 | -8.8% |

Хорогдуулах хувийг 1.1%-иар бууруулж 20.0%-иар авахад үнэлгээний үр дүн 8.5%-иар өсөж 37.0 тэрбум төгрөг, 19.5%-иар авахад 12.9%-иар өсөж 38.5 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд харин 0.9%-иар өсгөж 22.0% болгоход үнэлгээ 5.9%-иар буурч 32.1 тэрбум төгрөг болж байна. Сэндли ББСБ-ийн эздийн өмчийн шаардах өгөөжийн тооцооллын үндсэн хувилбар болох 21.1%-ийг тооцоолохдоо компанийн хэмжээ болон компанийн өөрийн эрсдэлтэй уялдуулан суурь тооцооллыг 4.0%-ийг нэмэгдүүлж авсан болно.

**Мэдрэмжийн шинжилгээний дүгнэлт**

Сэндли ББСБ ХХК-ийн үнэлгээний үр дүн нь Зээлийн хүүний хэмжээ, Нийт зардал, Хорогдуулах хувийн өөрчлөлтөд мэдрэмж өндөртэй, харин Бусдаас татах эх үүсвэрийн өөрчлөлтөд харьцангуй бага мэдрэмжтэй байна. Үнэлгээний ажлын зорилготой уялдуулан

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

2023-01-10
БҮРТГЭВ

үнэлгээний суурь хувилбарт мэдрэмж өндөр үзүүлэлтүүдийг үнэлгээний өдрийн байдлаар харьцангуй болгоомжтой хандлага барьж авсан болно.

**Үнэлгээний үр дүнгийн тодруулга**

Сэндли ББСБ ХХК-ийн үнэлгээний тооцоололд тус компани нь 1) IPO-оор олон нийтээс нийтээс 10.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн, 2) "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний дараах үеийн үнэлгээ (Post-money valuation) болно.

Үнэлгээний ажлын зорилгод нийцүүлэн Сэндли ББСБ ХХК-ийн 100% бизнес өмчлөлийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар дараах байдлаар тооцоолов.

| | *төгрөгөөр* |
|---|---|
| 100% бизнес өмчлөлийн үнэ цэн | **34,096,591,256** |
| IPO-оор татах шинэ мөнгө | 10,050,000,000 |
| Эзлэх хувь | 29.3% |

Энэхүү үнэлгээний ажлын үнэлгээний өдөр буюу үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр бөгөөд энэ нь үнэлгээний тайлангийн өдрөөс өөр өдөр болохыг анхаарна уу. ҮОУС-д заасны дагуу үнэлгээний дүгнэлт нь зөвхөн үнэлгээний өдрийн байдлаарх нөхцөл байдал, мэдээлэлд үндэслэхийг шаарддаг.

Үнэлгээний өдрөөс хойш үнэлгээний тайлан гарах өдрийн хооронд Орос Украйны дайнаас үүдэлтэйгээр дэлхийн улс төрийн нөхцөл байдал хүндэрч, эдийн засгийн ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдал цаг тутам өөрчлөгдөж байна. Иймд үнэлгээний үр дүнг хэрэглэхдээ тухайн цаг үеийн нөхцөл байдлыг харгалзаж үзэхийг Үнэлгээчид зөвлөж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022121175 УЛААНБААТАР ХОТ

## 6. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1: Сэндли ББСБ ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарууд
ХАВСРАЛТ 2: Тодорхойлолт ба үнэлгээний аргачлал
ХАВСРАЛТ 3: Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ
ХАВСРАЛТ 4: Үнэлгээчдийн сертификатын хуулбар

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

**Хавсралт 1: СЭНДЛИ ББСБ ХХК-ИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАРУУД**







СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 101/498 тоот
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тамга"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн мэдээлэл

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр "СЭНДЛИ ББСБ" ХХК

ХОЁР. Хуулийн этгээдийн өмчийн [illegible] БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, өөрчлөлтийн тэмдэглэл

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, өөрчлөлт | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Зээл | 2013.02.08 | №318 тогтоол | |
| 2 | Гадаад валютын арилжаа | 2018.02.07 | №62 тогтоол | |
| 3 | Цахим төлбөр тооцоо, мөнгө гуйвуулгын үйлчилгээ | 2018.02.07 | №62 тогтоол | |

ДӨРӨВ. Хувьцаа эзэмшигчийн тэмдэглэл

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тогтоол |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тогтоол |
| 1 | [illegible] | [illegible] | 410,000,000 | [illegible] | 2017.07.19 | [illegible] тушаал |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тушаал |
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тушаал |
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | 2017.11.21 | [illegible] тушаал |
| 1 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тушаал |
| 2 | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] тушаал |



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
[illegible] он [illegible] сар [illegible] өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

Тус компани ББСБ ХХК [illegible] 2017.11.27 [illegible]
[illegible] ББСБ ХХК [illegible] 2021.12.10 [illegible]

[illegible]. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн мэдээлэл

| № | Хаяг | Утас | Гэрчилгээ шийдвэр огноо, тоо |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, [illegible], 512 [illegible] | | |
| 2. | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, [illegible], 24 [illegible] | [illegible] | [illegible] |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

3.4B. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн мэдээлэл.

| № | Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, өөрчлөлтийн хэмжээ | Шийдвэр гарсан огноо | Шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2015.07.03 | №318 | 400,000,000 [illegible] |
| 2. | 400,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.07.18 | №377 | 800,000,000 |
| 3. | 20,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.09.27 | №427 | 820,000,000 |
| 4. | 180,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2017.11.21 | №490 | 1,000,000,000 |
| 5. | 428,500,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.05.27 | №164 | 1,428,500,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын мэдээлэл

| № | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Шийдвэрийн гарсан огноо | Шийдвэрийн шийдвэрийн дугаар | Шийдвэрийн хүчингүй болсон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1.<br>2. | Салбар-01<br>Салбар-02 | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум.<br>Дорноговь аймаг, Сайншанд сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 3.<br>4. | Салбар-03<br>Салбар-04 | Дорноговь аймаг, Замын-Үүд сум.<br>Өмнөговь аймаг, Даланзадгад сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 5.<br>6. | Салбар-05<br>Салбар-06 | Баянхонгор аймаг, Баянхонгор сум<br>Сүхбаатар аймаг, Баруун-Урт сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 7.<br>8. | Салбар-07<br>Салбар-08 | [illegible] аймаг, [illegible] сум.<br>Дундговь аймаг, [illegible] сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 9.<br>10. | Салбар-09<br>Салбар-10 | Орхон аймаг, Баян-Өндөр сум.<br>Увс аймаг, Улаангом сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 11.<br>12. | Салбар-11<br>Салбар-12 | [illegible] аймаг, [illegible] сум<br>[illegible] аймаг, [illegible] сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 13.<br>14. | Салбар-13<br>Салбар-14 | Архангай аймаг, Эрдэнэбулган сум<br>Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 15.<br>16. | Салбар-15<br>Салбар-16 | Сэлэнгэ аймаг, [illegible] сум.<br>[illegible] аймаг, [illegible] сум. | 2020.01.10<br>2020.01.10 | №05 тушаал<br>№05 тушаал | |
| 17.<br>18. | Салбар-17<br>Салбар-18 | Хэнтий аймаг, Хэрлэн сум.<br>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2020.01.10<br>2021.[illegible] | №05 тушаал<br>№164 тушаал | |
| 19. | Салбар-19<br>Салбар-2 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг | 2021.[illegible] | [illegible] тушаал | |
| 21. | Салбар-21 | Улаанбаатар хот, [illegible] дүүрэг | 2021.[illegible] | [illegible] тушаал | |
| 22. | Салбар-22 | [illegible] аймаг, [illegible] сум | [illegible] | [illegible] тушаал | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
[illegible]221121175 УЛААНБААТАР ХОТ ХТ[illegible] 5961[illegible]

БҮРТГЭВ

**Хавсралт 2: ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

**Тодорхойлолтууд**

Үнэлгээний зарим нэр томьёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томьёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

Идэвхитэй зах зээл (СТОУС 13) – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

Үнэ цэн (ҮОУС 2022) – ҮОУС 104 Үнэ Цэнийн Суурьнууд - д заасан үнэ цэнийн суурьнуудын аль нэгэнд нийцүүлэн тухайн тооцоолсон дүнгийн талаар үнэлгээчний гаргасан шууд түнгээлтын илэрхийлэл.

Үнэ цэнийн суурь (ҮОУС 2022) – Тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүд.

Өртгийн хандлага (ҮОУС 2022) – Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлага нь үнэ цэнийн үзүүлэлтийг тооцон гаргадаг.

Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ (СТОУС 13) – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

Бодит үнэ цэн (СТОУС 13) – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ юм.

Хамгийн сайн ашиглалт (СТОУС 13) – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бус хөрөнгө ашиглалт.

Орлогын хандлага (СТОУС 13) – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

Орц-мэдээлэл (СТОУС 13) – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

(a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба

(b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.

Орц мэдээлэл нь бэлэн олдоцтой буюу ажиглагдах эсвэл үл ажиглагдах байж болно.

Хөрөнгө оруулалтын зориулалттай өмч (Улаан ном 2020) – Доорх (а), (б)-оос бусад зорилгоор капиталын үнэ цэнийг өсгөх, эсвэл түрээсийн орлого олох, эсвэл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй өмч (газар, барилга, эсвэл барилгын хэсэг, эсвэл аль аль нь

(a) бараа үйлчилгээний үйлдвэрлэлт, нийлүүлэлт болон захиргааны зорилгоор ашиглаж байгаа эсвэл

(b) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах зориулалттай.

Нэгдүгээр түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Ак ахуйн нэгжийн хэмжилт хийж буй өдрөөр ашиглах боломжтой, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг (тохируулаагүй ) үнэ.

Хоёрдугаар түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Хөрөнгө, өр төлбөртэй холбоотой шууд ба шууд бусаар гаргаж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл.

Гуравдугаар түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Хөрөнгө ба өр төлбөрийн талаарх үл ажиглагдах орц мэдээлэл.



СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
ГЭРЭГЭ

Зах зээлийн хандлага [ҮОУС 2022] – Тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох (өөрөөр хэлбэл төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтээр хангадаг.

Зах зээлээр баталгаажсан мэдээлэл (СТОУС 13) – Корреляци болон бусад аргын тусламжтайгаар зах зээлд бэлэн байгаа мэдээллээр баталгаажсан буюу түүнээс гаргаж авсан орц мэдээлэл.

Зах зээлийн түрээсийн төлбөр [ҮОУС 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа түрээслүүлэгч ба түрээслэгчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр зохих түрээсийн нөхцөлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог түрээслэвэл зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Зах зээлийн үнэ цэн [ҮОУС 2022] – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө буюу өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Бэлэн олдох орц мэдээлэл [СТОУС 13] – Тодорхой үйл явдал, ажил гүйлгээний талаар олон нийтэд нээлттэй байгаа мэдээлэл гэх мэт зах зээлийн тоон мэдээг ашиглан боловсруулсан орц мэдээллийг хэлэх бөгөөд үүнд хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохын тулд зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг тусгана.

Үндсэн зах зээл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хамарсан хамгийн өндөр дүнтэй болон хамгийн олон арилжаа хийгдсэн зах зээл юм.

Үл хөдлөх өмчийн хувь оролцоо [ҮОУС 2022] – Газар ба барилгын өмчлөл, хяналт, ашиглалт буюу эзэмшлийн эрх.
Тусгай төсөөллүүд (Улаан ном 2022) – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй төсөөлөл эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.

Тусгай үнэ цэн [Улаан ном 2022] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэн.

Өргөжмөлтийн хэмнэлтийн үнэ цэн [ҮОУС 2022] – Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл хувь оролцоог нэгтгэн нийлүүлсэн бөгөөд үг нэгдсэн үнэ цэн нь тэдгээрийн тус тусын үнэ цэнүүдийн нийлбэрээс илүү байх зөрүү үр дүн.

Худалдах зориулалт бүхий өмч [Улаан ном 2022] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэн нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.

Эрсдэлийн шагнал [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн "эрсдэлийн залруулга" хэмээн нэрлэдэг.

Тооцооны нэгж [СТОУС 13 ] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд үг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижигрүүлэх СТОУС-ын хэмжүүр.

Үл ажиглагдах орц мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.

Үнэлгээний өдөр [Улаан ном 2022]– Үнэлгээчний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.

Үнэлгээний тайлангийн өдөр [Улаан ном 2022] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

**Үнэлгээний арга зүй**

Үнэлгээний ажлын зорилготой уялдуулан Үнэ цэнийн суурь-д нээлттэй чөлөөт зах зээл дээр төсөөлж буй арилжаагаар хүрч болох хамгийн их магадлалтай үнийн илэрхийллийг авав. Энэ ангилалд ҮОУС-д тодорхойлсон зах зээлийн үнэ цэн багтана.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
20 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
ГЭРЭГЭ
БҮРТГЭВ

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагуудад:

(a) Зах зээлийн хандлага,
(b) Орлогын хандлага,
(c) Өртгийн хандлага.

**Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.**

Үнэлгээний хандлага болон аргуудаас сонголт хийхдээ тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох зорилго тавина. Бүх нөхцөлд тохиромжтой нэг ч арга байхгүй. Сонголт хийхдээ хамгийн багадаа дараах хүчин зүйлсийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

(a) үнэлгээний ажлын нөхцөл болон зорилгоор тодорхойлогдсон тохиромжтой үнэ цэнийн суурь,
(b) боломжит үнэлгээний хандлага болон аргуудын давуу болон сул талууд,
(c) арга бүрийн хувьд тухайн хөрөнгийн үндсэн шинжтэй зохицолтой байдал, холбогдох зах зээлийн оролцогчид нь тухайн хандлага, аргуудыг хэр зэргээр хэрэглэдэг талаар,
(d) тухайн аргыг хэрэглэхэд шаардагдах найдвартай мэдээллийн олдоц ямар байгаа зэрэг орно.

Үнэлгээчин нь заавал нэгээс дээш тооны үнэлгээний аргыг хөрөнгийн үнэлгээнд ашиглах ёстой гэсэн шаардлага байхгүй. Ялангуяа үнэлгээчин нь аль нэг аргын нарийвчлал болон найдвартай байдалд итгэх итгэл өндөр байхад бусад аргуудыг ашиглахыг шаарддаггүй. Үнэлгээний аль нэг аргаар итгэлтэй үр дүн гаргахад үнэн зөв эсвэл ажиглагдах орц мэдээлэл хангалттай олдоцгүй үед үнэ цэнийн баримжаа дүр зураг авах зорилгоор нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл аргыг хэрэгладаг. Хэрэв нэгээс дээш тооны үнэлгээний хандлага эсвэл арга хэрэглэсэн, түүнчлэн нэг хандлагад хамаарах олон тооны аргуудыг хэрэглэсэн тохиолдолд эдгээр хандлага, аргуудад үндэслэн гаргасан үнэ цэнийн тооцоолол нь үндэслэл сайтай, олон аргаар гарсан өөр өөр үр дүнг хэрхэн нэг үнэ цэн болгосон талаар хийсэн шинжилгээг үнэлгээний тайланд тодорхой тайлбарлах шаардлагатай байдаг.
Хэрэв үнэлгээний хандлага, аргуудаар гарсан үнэ цэнийн баримжаанууд нь хоорондоо зөрүү ихтэй байвал үнэлгээчин нь яагаад ийм үр дүн гарч байгаа талаар олж мэдэж ойлгох шаардлагатай бөгөөд зөрүү өндөртэй үнэ цэнийн баримжаа дүнгүүдийг хялбараар жинлэн үнэ цэнийг тооцоолох нь тохиромжтой биш юм. Энэ тохиолдолд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийн дагуу үнэлгээний аль нэг хандлага/арга нь бусад авч үзсэн аргуудаас илүү сайн, илүү найдвартай үнэ цэнийн баримжаа дүр зураг өгөх эсэхийг дахин нягтлан судлах шаардлагатай.

Гурван хандлагын алийг нь ч хэрэглэсэн үнэлгээчин нь зах зээлийн бэлэн олдоцтой мэдээллийг боломжит дээд хэмжээнд хүргэж ашиглах ёстой. Үнэлгээнд ашигласан орц мэдээлэл болон төсөөлөл нь ямар эх сурвалжаас авснаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орц мэдээлэл, төсөөлөлд үнэлэлт дүгнэлт өгөх, үнэлгээний зорилгод хэр тохиромжтой байгааг дүгнэх шинжилгээг заавал хийх ёстой байдаг.

Үнэлгээний олон улсын стандартаас гадна Монгол Улсад бизнесийн үнэлгээ хийх аргачлалыг Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан байдаг. Энэ аргачлалд бизнесийн үнэлгээний арга, хандлагыг Үнэлгээний Олон Улсын Стандартын дагуу тайлбарлан оруулсан байна.

**Зах зээлийн хандлага**

Зах зээлийн хандлагаар бизнесийн үнэ цэнийг тогтоохдоо үнийн мэдээлэл хангалттай олдох ижил төстэй болон орлуулагч бизнестэй харьцуулах аргыг хэрэглэнэ. Энэ хандлагаар үнэлэх эхний алхам нь зах зээл хувьцаа нь арилжаалагдаж байгаа эсвэл зах зээл дээр саяхан борлогдсон үнэлгээнд хамрагдсан бизнестэй ижил төстэй бизнесийн хувьцааны үнэ эсвэл борлуулалтын үнийг авч үзэх явдал юм.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд түгээмэл ашигладаг мэдээллийн эх сурвалжид дараах мэдээллүүд орно. Үүнд:

1. Ижил төстэй бизнесийн нийтэд зориулан худалдсан бизнесийн өмчлөлийн эрхийн талаарх хөрөнгийн зах зээл буюу хувьцааны талаарх мэдээлэл



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

ГЭРЭГЭ

2. Ижил төстэй бизнесийг зах зээл дээр худалдсан ба худалдан авсан ажил гүйлгээний талаарх мэдээлэл
3. Тухайн субъектийн бизнесийн өмчлөл дэх өмнөх үеийн ажил гүйлгээний талаарх мэдээлэл
4. Эрх бүхий байгууллагын болон ижил төстэй бүтээгдэхүүний мэдээллийн сан
5. Үнэлгээчний хувийн мэдээллийн сан зэрэг орно.

Энэ хандлагаар бизнесийн үнэлгээ хийхэд харьцуулж байгаа бизнесийн үнэ цэнийн дүнг орлого, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө зэрэг суурь үзүүлэлтүүдэд харьцуулан гаргасан нэг эсвэл хэд хэдэн үржүүлэгчийг тооцно. Тухайлбал:

- Үнэ ба ашгийн харьцаа (PE Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны өгөөж
- Үнэ ба бүртгэлийн өртгийн харьцаа (Price to Book Value Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцааны бүртгэлийн өртөг
- Үнэ ба борлуулалтын харьцаа (Price to Sales Ratio) = Нэгж хувьцааны үнэ / Нэгж хувьцаанд ногдох борлуулалт

Бизнесийн үнэлгээг хийхэд хэд хэдэн үржүүлэгчийг ашигласан эсвэл хэд хэдэн аргыг хослуулан хэрэглэсэн бол үнэлгээчин тэдгээрийг ач холбогдлын хувиар жинлэж үнэлгээний дүнг тодорхойлж болно. Ижил төстэй ба тухайн бизнесийг харьцуулагдахуйц болгохын тулд шаардлагатай тохиолдолд боломжит тохируулгыг хийдэг.

Сэндли ББСБ ХХК-ийн бизнесийн онцлогтой уялдуулан Үнэ ба бүртгэлийн өртгийн харьцаа (Price to Book Value)-г ашиглав.

**Орлогын хандлага**

Орлогын хандлага гэдэг тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно.

Ирээдүйн тодорхой үеүдэд ашиг, орлогын хэмжээ тогтвортой бус, хугацааны төгсгөлд бизнес үлдэх өртөгтэй байх үед хорогдуулах мөнгөн гүйлгээний аргыг ашиглах нь оновчтой байдаг. Энэ аргаар бизнесийн үнэ цэнийг тухайн бизнесийн цэвэр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн ба хугацааны сүүлийн жилийн орлогын капиталжуулсан дүнгийн өнөөгийн үнэ цэнийн нийлбэрээр тооцно.

Ногдол ашгийн дискаунт загвар (dividen discount model) нь хувьцаа эзэмшигчдийн олж авах мөнгө нь зөвхөн ногдол ашиг гэж үздэг.

Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity) загвар нь бизнест шаардлагдах хөрөнгө оруулалтыг хийсний дараа хувьцаа эзэмшигчдэд үлдэх боломжтой цэвэр мөнгөн урсгалыг тооцоолж бизнесийн үнэ цэнийг тооцоолдог. Санхүүгийн байгууллагын хувьд энэ аргыг дараах байдлаар тодорхойлдог.

*Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал = Цэвэр орлого – Зохицуулах байгууллагаас шаардах хөрөнгө*

Энэ нь ногдол ашиг хэлбэрээр төлөгдөх боломжтой мөнгөн урсгал юм.

**Өртгийн хандлага**

Өртгийн хандлагыг мөн "Хөрөнгөд суурилсан хандлага" гэж нэрлэдэг ба энэ нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэнэ.

Өртгийн хандлагаар бизнесийг үнэлэхдээ тухайн бизнесийн биет ба биет бус бүх хөрөнгүүдийг үнэлж, үүнээс бүх өр төлбөрүүдийн зах зээлийн үнэ цэнийг хасах замаар тооцно.

Өртгийн хандлагын арга нь тухайн бизнесийн орлого олох чадварыг харуулж чаддагтүй учир тасралтгүй байх төсөөллөөр ажиллаж байгаа бизнесийн үнэлгээнд ашиглахад тохиромж муутай байдаг.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

**Хавсралт 3: ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ**

Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээнд дараах таамаглал, аргачлалыг ашиглав. Үүнд:

- Хөрөнгүүдийг анх худалдан авахдаа тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авсан.
- Худалдан авалт хийснээс хойш хугацааны үнийн өөрчлөлтийг Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн тохируулж, үнэлгээний өдрийн байдлаарх анх худалдан авах үеийн шинж чанар, элэгдэл бүхий хөрөнгийн зах зээлийн үнийг тооцоолов.
- Үндсэн хөрөнгийн үнийн өөрчлөлтийн итгэлцүүрийг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг Улаанбаатар хотын гэр ахуйн тавилга барааны үнийн индекстэй ижил байхаар авав.
- Тооцоолсон орлуулах үнээс элэгдлийн тохируулга хийн (эдийн засгийн хоцрогдол, үүрэг ажиллагааны болон биет элэгдэл) үнэлгээний өдрийн байдлаарх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолов.
- Үндсэн хөрөнгийн биет элэгдлийг тохируулахдаа Сангийн сайдын 2018 оны 207-р тушаалын хавсралт 6-р батлагдсан хөрөнгийн үнэлгээнд баримтлах норматив хугацааг баримтлан шулуун шугамын аргаар тооцов.
- Үнэлгээний өдрийн байдлаар хөрөнгүүдэд эдийн засгийн болон үүрэг ажиллагааны элэгдэл хоцрогдол байхгүй гэж үзэв.
- Биет бус хөрөнгийг үнэлэхдээ анхны өртгийг үнийн өсөлтийн итгэлцүүрээр тохируулж тооцсон.
- Биет бус хөрөнгийн үнийн өөрчлөлтийн итгэлцүүрийг Улаанбаатар хотын хэрэглээний үнийн ерөнхий индекстэй ижил байхаар авав.

*Сэндли ББСБ*
*Хөрөнгийн үнэлгээ*
*Үнэлгээний тооцоолол*
*2021.12.31-ны байдлаар*

| № | Хөрөнгийн нэр | Анхны үнэ, төг | Худалдаж авсан огноо | Үнийн өсөлтийн итгэлцүүр | Ашигласан хугацаа | Ашиглах нормативт хугацаа | Цаашид ашиглах хугацаа | Элэгдлийн тохируулга | Тооцоолсон зах зээлийн үнэ цэн, төг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **Компьютер тоног төхөөрөмж** | | | | | | | | |
| 1.1 | проекторын үнэ | 1,280,000 | 4/4/18 | 1.16 | 3.74 | 4 | 0.26 | 0.06 | 95,416 |
| 1.2 | Компьютер төхөөрөмж үнэ | 10,983,800 | 4/18/18 | 1.16 | 3.70 | 5 | 1.30 | 0.26 | 3,297,751 |
| 1.3 | wireless router үнэ | 70,000 | 5/17/18 | 1.16 | 3.62 | 4 | 0.38 | 0.09 | 7,590 |
| 1.4 | КАМЕРНЫ ҮНЭ /301/ | 535,000 | 4/12/19 | 1.11 | 2.72 | 4 | 1.28 | 0.32 | 190,204 |
| 1.5 | тоног төхөөрөмжийн үнэ | 6,500,000 | 4/15/19 | 1.11 | 2.71 | 5 | 2.29 | 0.46 | 3,306,500 |
| 1.6 | компьютерийн үнэ | 2,222,500 | 7/16/19 | 1.10 | 2.46 | 5 | 2.54 | 0.51 | 1,246,357 |
| 1.7 | КОМПЬЮТЕР /ГАНТУЯА/ | 2,187,500 | 5/18/20 | 1.08 | 1.62 | 5 | 3.38 | 0.68 | 1,594,290 |
| 1.8 | компьютерийн үнэ сод | 4,415,400 | 5/28/20 | 1.08 | 1.59 | 5 | 3.41 | 0.68 | 3,244,096 |
| 1.9 | КОМПЬЮТЕР laptop | 2,100,000 | 3/3/21 | 1.06 | 0.93 | 5 | 4.17 | 0.83 | 1,851,544 |
| 1.10 | Компьютер i7 desktop | 3,075,000 | 4/20/21 | 1.06 | 0.70 | 5 | 4.30 | 0.86 | 2,796,623 |
| 1.11 | Компьютер i5 desktop | 2,245,000 | 4/20/21 | 1.06 | 0.70 | 5 | 4.30 | 0.86 | 2,041,762 |
| 1.12 | Микрофон | 460,000 | 6/23/21 | 1.05 | 0.52 | 4 | 3.48 | 0.87 | 418,072 |
| 1.13 | сервер | 23,359,781 | 6/22/21 | 1.05 | 0.53 | 5 | 4.47 | 0.89 | 21,955,803 |
| 1.14 | 2ш компьютер | 4,718,000 | 6/30/21 | 1.05 | 0.50 | 5 | 4.50 | 0.90 | 4,435,849 |
| 1.15 | Компьютер i7 desktop | 3,075,000 | 4/20/21 | 1.06 | 0.70 | 5 | 4.30 | 0.86 | 2,796,623 |
| 1.16 | Компьютер i5 desktop | 2,245,000 | 4/20/21 | 1.06 | 0.70 | 5 | 4.30 | 0.86 | 2,041,762 |
| 1.17 | 2ш компьютер | 2,587,000 | 6/30/21 | 1.05 | 0.50 | 5 | 4.50 | 0.90 | 2,432,289 |
| 1.18 | DELL OPTIPLEX 3080 MT I5 | 2,062,000 | 8/4/21 | 1.04 | 0.41 | 5 | 4.59 | 0.92 | 1,974,077 |
| 1.19 | DELL 3080MT I5 ПРОЦЕССОР | 2,400,000 | 8/23/21 | 1.04 | 0.36 | 5 | 4.64 | 0.93 | 2,323,693 |
| 1.20 | EAGET M2 256GB SOLID | 840,000 | 9/24/21 | 1.04 | 0.27 | 4 | 3.73 | 0.93 | 814,445 |
| 1.21 | КОМПЬЮТЕРЫН ҮНЭ DELL | 2,340,000 | 9/24/21 | 1.04 | 0.27 | 5 | 4.73 | 0.95 | 2,301,438 |
| 1.22 | inspiron 3501-1605s laptop | 2,340,000 | 10/12/21 | 1.03 | 0.22 | 5 | 4.78 | 0.96 | 2,313,838 |
| 1.23 | DELL VOSTRO V5501-1525D | 2,099,000 | 10/20/21 | 1.03 | 0.20 | 5 | 4.80 | 0.96 | 2,085,041 |
| 1.24 | КОМПЬЮТЕРИЙН ҮНЭ /DELL | 3,665,000 | 10/28/21 | 1.03 | 0.18 | 5 | 4.82 | 0.96 | 3,657,229 |
| 1.25 | Switch Sport /2 ширхэг | 25,000 | 11/9/21 | 1.03 | 0.14 | 4 | 3.86 | 0.96 | 24,834 |
| 1.26 | ХАРД, РАМ НӨУТБҮҮК-д | 197,000 | 12/3/21 | 1.00 | 0.08 | 4 | 3.92 | 0.98 | 193,225 |
| 1.27 | v5501 laptop /төв/ | 2,300,000 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 5 | 5.00 | 1.00 | 2,298,741 |
| 1.28 | v5501 laptop /төв/ | 2,300,000 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 5 | 5.00 | 1.00 | 2,298,741 |
| 1.29 | 3506 laptop, төв | 2,099,000 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 5 | 5.00 | 1.00 | 2,097,851 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.44 | цайны шуугээ/хархорин | 330,000 | 9/13/21 | 1.04 | 0.30 | 10 | 9.70 | 0.97 | 332,731 |
| 2.45 | ус шугум 1ш*170.0 | 170,000 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 169,262 |
| 2.46 | хархорин БОГИНО | 189,900 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 189,076 |
| 2.47 | захирал ширээ хархорин | 495,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 500,537 |
| 2.48 | 1ш тумбочка хархорин | 120,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 121,342 |
| 2.49 | 4ш хаалт хархорин | 200,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 202,237 |
| 2.50 | 3ш ширээ хархорин | 600,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 606,712 |
| 2.51 | 15102 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.52 | бичгийн шүүгээ/нарантуул | 880,000 | 9/13/21 | 1.04 | 0.30 | 10 | 9.70 | 0.97 | 887,282 |
| 2.53 | ус шугум 1ш*170.0 | 170,000 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 169,262 |
| 2.54 | нарантуул БОГИНО | 189,900 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 189,076 |
| 2.55 | захирал ширээ нарантуул | 495,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 500,537 |
| 2.56 | 1ш тумбочка нарантуул | 120,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 121,342 |
| 2.57 | 4ш хаалт нарантуул | 200,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 202,237 |
| 2.58 | 3ш ширээ нарантуул | 600,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 606,712 |
| 2.59 | 15104 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.60 | ус шугум 1ш*170.0 дэнжийн | 170,000 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 169,262 |
| 2.61 | дэнжийн манга БОГИНО | 189,900 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 189,076 |
| 2.62 | захирал ширээ дэнжийн | 495,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 500,537 |
| 2.63 | 1ш тумбочка дэнжийн | 120,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 121,342 |
| 2.64 | 4ш хаалт дэнжийн манга | 200,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 202,237 |
| 2.65 | 3ш ширээ дэнжийн манга | 600,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 606,712 |
| 2.66 | 15103 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.67 | БАЯНЗҮРХ САЛБАР | 270,000 | 9/28/21 | 1.04 | 0.26 | 10 | 9.74 | 0.97 | 273,387 |
| 2.68 | BSB WM -7020 MWT | 189,900 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 6 | 5.75 | 0.96 | 189,076 |
| 2.69 | E-68 ШИРЭЭ 99109244 ГЯЛС | 599,000 | 9/30/21 | 1.04 | 0.25 | 10 | 9.75 | 0.97 | 606,855 |
| 2.70 | 1ш тумбочка баянзүрх | 120,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 121,342 |
| 2.71 | 4ш хаалт баянзүрх | 200,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 202,237 |
| 2.72 | 3ш ширээ баянзүрх | 600,000 | 10/11/21 | 1.03 | 0.22 | 10 | 9.78 | 0.98 | 606,712 |
| 2.73 | 15105 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.74 | НАЛАЙХ САЛБАР ХУЙЛДАГ | 153,000 | 11/30/21 | 1.03 | 0.08 | 10 | 9.92 | 0.99 | 156,252 |
| 2.75 | НАЛАЙХ САЛБАР УС | 230,000 | 12/1/21 | 1.00 | 0.08 | 6 | 5.92 | 0.99 | 226,851 |
| 2.76 | ЗАХИРАЛ ШИРЭЭ НАЛАЙХ | 400,000 | 12/17/21 | 1.00 | 0.04 | 10 | 9.96 | 1.00 | 398,467 |
| 2.77 | 15106 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.78 | БУЛГАН САЛБАР УС | 225,000 | 11/30/21 | 1.03 | 0.08 | 6 | 5.92 | 0.99 | 228,472 |
| 2.79 | БУЛГАН САЛБАР ХУЙЛДАГ | 229,500 | 11/30/21 | 1.03 | 0.08 | 10 | 9.92 | 0.99 | 234,379 |
| 2.80 | 15032 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| 2.81 | БАЯНӨЛГИЙ САЛБАР | 243,000 | 11/30/21 | 1.03 | 0.08 | 10 | 9.92 | 0.99 | 248,166 |
| 2.82 | Баянөлгий ус буцалгагч | 80,000 | 12/17/21 | 1.00 | 0.04 | 5 | 4.96 | 0.99 | 79,387 |
| 2.83 | 15033 салбарт хэрэгтэ | 2,020,500 | 12/30/21 | 1.00 | 0.00 | 10 | 10.0 | 1.00 | 2,019,947 |
| **НИЙТ** | | **82,086,300** | | | | | | | **79,059,977** |
| **3** | **Программ хангамж** | | | | | | | | |
| 3.1 | Мөнгөн гүйлгээний | | 5/31/19 | 1.11 | | | | | 40,423,974 |
| 3.2 | Поларис санхүүгийн | 4,400,000.00 | 3/5/19 | 1.11 | | | | | 4,898,754 |
| **Нийт** | | **40,890,000** | | | | | | | **45,322,728** |

он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

Хавсралт 4: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД


САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

САНГИЙН САЙД

УЛААНБААТАР ХОТ

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.01.02

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

| | |
|---|---|
| Регистрийн дугаар : | оо******90 |
| Нэр : | ГАНТУЛГА |

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

| | |
|---|---|
| Авсан огноо : | 2021-12-10 |
| Дуусах огноо : | 2024-12-10 |
| Хүчинтэй эсэх : | Хүчинтэй |
| Тусгай зөвшөөрлийн нэр : | ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ |

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татаж авч байгаа шалгуур болон хянах байдлаар QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхийг харуулах зөрчилгүй талаар өөрчлөгдөх бусад тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

Сэндли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга
СЗХ
... он ... сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02
ГЭРЭГЭ

Gantulga Donorov

on

31 October 2018

**WAS ELECTED A PROFESSIONAL MEMBER OF THE ROYAL INSTITUTION OF CHARTERED SURVEYORS**

6824290

MEMBERSHIP NUMBER

PRESIDENT OF RICS

RICS



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар [illegible]

Иргэний үгийн овог [illegible]

Иргэний овог нэр [illegible]

Иргэний үнэмлэхний дугаар

Иргэний бүртгэлийн дугаар [illegible]

Үнэлгээчний гэрчилгээний дугаар

Иргэний хаяг [illegible]

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо [illegible]

[illegible]

САНГИЙН САЙД [illegible]

УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.. оны 252 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20.. оны 12 сарын 17 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД Н.ХҮРЭЛБААТАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20... оны ... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02


САНГИЙН ЯАМ

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

САНГИЙН САЙД

УЛААНБААТАР ХОТ

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ**

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2022.05.09

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл**

| | |
|---|---|
| Регистрийн дугаар : | ЧР******61 |
| Нэр : | ХАЛИУН |

**Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл**

| | |
|---|---|
| Авсан огноо : | 2021-12-18 |
| Дуусах огноо : | 2024-12-18 |
| Хүчинтэй эсэх : | Хүчинтэй |
| Тусгай зөвшөөрлийн нэр : | ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ |

*Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болсон эсэхийг байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгуурууд хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу*



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023 оны 01 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

/Үнэлгээний дүгнэлтийн нэмэлт тодруулга/

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

СЭНДЛИ ББСБ ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ОДГЭРЭЛ ТАНАА

2023/01/09 № 23/01-05

танай 2023/01/05-ны № 14 -т

Тодруулга дүгнэлт хүргүүлэх тухай

Танай компаниас 2023 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 14 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу дараах тодруулга дүгнэлтийг хүргүүлж байна.

Тодруулбал Сэндли ББСБ нь нээлттэй бонд гаргахаар холбогдох эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрөл авахаар материалаа бүрдүүлэн өгсөнтэй холбоотой тус өрийн хэрэгслийн барьцаа хөрөнгө болох компанийн хувьцааны үнэлгээнд манай байгууллагаас 2022 оны 5-р сарын 16-ны өдөрөөр гаргасан бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн хувьцааны жишиг үнийг тогтоож болох эсэх талаар тодруулга дүгнэлт авах хүсэлтийг ирүүлжээ.

"Сэндли ББСБ" ХХК хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагаанд зориулж бид тус компанийн бизнесийн үнэлгээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хийж гүйцэтгэсэн. Бидний хийсэн үнэлгээнд үндэслэн "Сэндли ББСБ" ХХК нь 2022 оны 9 дүгээр сард анхдагч зах зээлд санал болгох нэгж хувьцааны үнийг 150.0 төгрөгөөр тогтоосон. Үнээс хойш өнөөдрийг хүртлэх хугацаанд хоёрдогч зах зээл дээр тус компанийн хувьцааны дундаж ханш 169.0 төгрөг байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор баталсан "Өрийн хэрэгслийг бүртгэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7-д заасны дагуу нээлттэй хувьцаат компани өөрийн гаргасан хувьцааны 50 хувиас хэтрэхгүйг барьцаалж болох ба үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзахаар тусгажээ.

Харин Сэндли ББСБ нь хувьцаагаа хоёрдогч зах зээлд арилжаалж эхэлснээс хойш 6 сарын хугацаа өнгөрөөгүй байгаа тул энэ журамд заасан аргачлалаар хувьцааны жинлэсэн дундаж ханшийг тогтоох боломжгүй байна.

Бид үүссэн нөхцөл байдлыг судалж үзээд дараах дүгнэлтийг гаргаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийг бүртгэх журам"-д заасан "сүүлийн 6 сарын" байх шаардлага нь үнэт цаас гаргагчийн нээлттэй компани болсноос хойших хугацаатай холбоотой шаардлага гэж үзэхээс илүүтэй нээлттэй бондын батлан даалт болох хувьцааны үнэлгээг тогтооход хэрэглэх аргачлал гэж үзэж болохоор байна.

Иймд бидний хийсэн үнэлгээний өдөр буюу 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс "Сэндли ББСБ" ХХК-ийн хувьцаа хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж эхлэх өдрийн хооронд тус компанийн хувьцааны үнийн дундаж ханшийг 150.0 төгрөг гэж үзэх боломжтой гэж дүгнэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ГАНБААТАР

Утас: +976 7000 5000
И-мэйл: info@geregepartners.mn
Вэб: www.geregepartners.mn
Хаяг: "Гэрэгэ Эстимэйт" ХХК, Эрдэм тауэр, 1004 тоот
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо
Улаанбаатар, Монгол улс

СЗХ
2023 оны 01 сарын 13 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

# ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

MDSKhanLex

**"СЭНДЛИ ББСБ" ХК-ИАС ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН**

**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ**

| | |
|---|---|
| **Хаана:** | **"СЭНДЛИ ББСБ" ХК** |
| **Хаяг:** | **Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула ренбүчи гудамж, 8/4 тоот** |
| **Утас/Факс:** | **(976) 70177700, (976) 77127700** |
| **Хаанаас:** | **"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН** |
| **Хаяг:** | **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай 2 Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот** |
| **Утас/Факс:** | **(976-11) 330048, (976-11) 330049** |
| **Огноо:** | **2022 оны 12 дугаар сарын 29-ний өдөр** |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

[illegible]

Утас: [illegible]
Факс: [illegible]
Олон улс: [illegible]

2022.12.29 № D-22/328

"СЭНДЛИ ББСБ" ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
НАР ТАНАА

## "СЭНДЛИ ББСБ" ХК-ИАС ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАН НИЙТЭД САНАЛ БОЛГОХТОЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Тус "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь (цаашид "**МДСХ**" гэх) нь "Сэндли ББСБ" ХК (цаашид "**Компани**", эсхүл "**Үнэт цаас гаргагч**", эсхүл "**ББСБ**" гэх)-ийн өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн энэхүү хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байгаа болно. Энэхүү Дүгнэлт нь тухайлан зориулж гаргасан этгээдүүдээс бусад этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хариуцлага бий болгохгүй. Дүгнэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгдсэн бөгөөд энэ нь аливаа гуравдагч этгээдэд ашигтай байх, эсхүл давуу байдлыг бий болгох мэдээлэл, баталгаа өгөх зорилгогүй болно.

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахад ирүүлсэн бүрдүүлбэр материал, баримтуудад агуулагдсан дараах асуудлаар МДСХ нь хариуцлага хүлээхгүй ба Дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

1. Дүгнэлт нь зөвхөн хууль зүйн асуудлаар хийгдсэн бөгөөд аливаа тоон мэдээлэл, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ зэрэг тусгай мэргэжлийн хүрээний мэдээллүүдийн талаар бид нарийн мэдлэггүй, тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно;
2. Дүгнэлтэд өөрөөр дурдсанаас бусад тохиолдолд бидний хийсэн ажил энэхүү Дүгнэлтийн тайлбар хэсгийн судалгаа шинжилгээний ажлын хүрээгээр хязгаарлагдаж байгаа болно;
3. Нотариатын гэрчилсэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн үйлдэл нь бодит эсэх;
4. Бусад улсын хууль тогтоомж буюу бусад эрх зүйн харьяаллын хүрээнд хийгдсэн, хуульд нийцсэн, хүчин төгөлдөр эсэх талаар;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "...санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна." гэж заасны дагуу санхүүгийн мэдээлэл, андеррайтерын судалгаа, дүгнэлт, таамаглал болон нийтэд нээлттэй мэдээллийн талаар;
6. Дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад аливаа судалгаа, шинжилгээ, асуулга хийгдээгүй болно. Тийнхүү хийгдээгүй судалгаа, шинжилгээ, асуулгын үндэс болсон аливаа мэдээлэл, бүртгэл нь бүрэн биш, шинэчлэгдээгүй, жишээ нь, тухайн баримт бичиг нь холбогдох эрх бүхий байгууллагад бүртгэгдээгүй, хувийн хэргээс устсан, алга болсон, эсхүл бусад байдлаар хувийн хэрэгт байхгүй болсон байж болно;
7. Компанийн бүх баримт бичиг, гэрээ, төлөвлөгөө, харилцаа холбоо, зөвшөөрөл, хувийн хэрэгтэй танилцсан, тэдгээрийг судалсан гэх амлалтыг энэхүү Дүгнэлттэй холбоотой бид гаргахгүй болно;
8. Дүгнэлт боловсруулах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Монгол Улсын хуулийн хүрээнд хийгдсэн бөгөөд бид өөр бусад эрх зүйн тогтолцооны холбоо, хамаарал, нөлөөллийн талаар ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

МДСХ нь Дүгнэлтэд өөрөөр тусгаагүй бол Компанийн үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан ач холбогдол бүхий гэрээ, их хэмжээ болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5% ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцүүд, дүрэм журмыг

СЭХ
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

MDSKhanLex

2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон хязгаарласан бөгөөд түүнээс бусад дүрэм, журам, байгуулагдсан гэрээг энэхүү Дүгнэлтэд оруулаагүй болно.

Мөн Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, Дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар МДСХ хариуцлага хүлээхгүй.

"Өмгөөллийн Эм Ди эс энд Хаанлекс" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор баталгаасан Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасныг удирдлага болгон Үнэт цаас гаргагч "Сэндли ББСБ" ХК, үндсэн андеррайтер "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтер "Голомт капитал ҮЦК" ХХК, аудит "Шонхор үнэлгээ аудит" ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй болохоо үүгээр мэдэгдэж байна. Харин туслах андеррайтер "Райнос инвестмент ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Цэвэгмид нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдон ажиллаж байгааг дурдах нь зүйтэй гэж үзэв.

Холбогдох хууль тогтоомжийн дагуу та бүхний мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллагад өгөхөөс бусад тохиолдолд бидний бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, ишлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно.

Дүгнэлтийг дээрх хаягласан этгээдүүдэд хүргүүлсэн өдрөөс хойш хууль тогтоомжид өөрчлөлт орсон болон бусад үйл ажиллагаатай холбогдуулан бид нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй болно.

Энэхүү албан бичиг нь Дүгнэлтийн салшгүй хэсэг байна.

Хүндэтгэсэн,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 61

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

АГУУЛГА

Удиртгал ... 5

1. Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх ... 7

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын талаар мэдээлэл ... 10

3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Хорооны баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх ... 21

4. Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх ... 31

5. Сүүлийн 3 жилийн дотор хийсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх ... 43

6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх 51

7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх ... 53

8. Үнэт цаас бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх ... 55

9. Компанийн толгой, охин, хараат, хэргэлдэх компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох ... 57

10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эрүү гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх ... 59

Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх 61



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023-01-19

MDSKhanLex

Удиртгал

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "МДСХ", эсхүл "Бид" гэх) нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "СЗХ" гэх)-ны 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр анх бүртгэгдсэн бөгөөд СЗХ-ны 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 42 тоот тогтоолоор тус бүртгэлд өөрчлөлт оруулан шинэчлэн бүртгүүлсэн Үнэт цаасны зохицуулалттай этгээд (Хавсралт 1.1)-ийн хувьд энэхүү хууль зүйн үйлчилгээг үзүүлэх эрхтэй болно.

Монгол Улсын хуулийн этгээд болох "Сэндли ББСБ" ХК (Регистрийн дугаар: 5961548), (цаашид "Компани", эсхүл "Үнэт цаас гаргагч" гэх) нь өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг бидэнээс хүсч, улмаар бид 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр "Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 1.2) байгуулан, тус гэрээний дагуу энэхүү Хууль зүйн дүгнэлт (цаашид "Дүгнэлт" гэх)-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлд заасны дагуу Компани нь өрийн хэрэгсэл гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна.

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйл (Компанийн өрийн бичиг), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 (Өрийн хэрэгсэл), 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох), 16 дугаар зүйл (Өрийн хэрэгсэл гаргах)-д заасны дагуу өрийн хэрэгсэл гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид "МХБ" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

**Хангагдсан тооцох нөхцөл**

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;
5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгаажсан;
7. Компани, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

оны сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй;
11. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх захирал нь СЗХ-ны тохиромжтой этгээдийн шаардлага хангасан, холбогдох мэдээллийг өгч зөвшөөрөл авсан;
12. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж компанийн хэлбэрээ өөрчилсний улмаас хязгаарлагдмал хариуцлагатай компани байх үед байгуулсан гэрээ, хэлцэл, баталсан журмууд нь эрх залгамжлалын дагуу хүчин төгөлдөр үйлчилнэ.

Энэхүү үнэт цаасны арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явуулна гэж бид ойлгож байна.

Бид Дүгнэлт гаргах зорилгоор Компаниас түүний Гэрчилгээ, Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон бидний хувьд шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээллийг гаргуулж судалсан болно.

Бид ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн доор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:



СЭНДЛИ ББСБ ХК
9022121 УЛААНБААТАР ХОТ ХТУ5601

***Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар.***

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн дагуу хоёр гишүүн (Монгол Улсын иргэн Л.Отгонбаатар РД: МР83072216, Б.Тамир РД: ЧК80091411)-тэйгээр үүсгэн байгуулагдаж, 2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. (Улсын бүртгэлийн дугаар: 9007001010, Регистрийн дугаар: 5961548) (Хавсралт 1.3, Хавсралт 1.14). Үнэт цаас гаргагч нь өмнө "Гео финанс" ХХК, "Гэлс кредит ББСБ" оноосон нэртэйгээр үйл ажиллагаагаа эрхэлж байсан ба "Гэлс кредит ББСБ" оноосон нэрийг "Сэндли ББСБ" ХХК болгон өөрчилснийг СЗХ-ны даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны 328 тоот тушаал (Хавсралт 1.5, Хавсралт 1.6)-аар зөвшөөрч, 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 05 дугаар шийдвэр (Хавсралт 1.7)-ээр Компанийн хувьцааг 20 дахин хуваж нэг бүр нь 50 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 128,570,000 ширхэг энгийн хувьцаатай байхаар шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн "Сэндли ББСБ ХХК-д "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон түүнтэй холбогдох бусад хэлэлцсэн асуудлыг батлах тухай" 06 тоот шийдвэр (Хавсралт 1.8) гарсан байна. Энэхүү шийдвэрээр Компани нь 28,000,000 (хорин найман мянга) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлж, тус компанийг нэгтгэх шийдвэр гаргажээ. СЗХ-ны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 282 дугаар тогтоол (Хавсралт 1.9)-оор "Сэндли ББСБ" ХХК-д "Гэгээн алтан од ББСБ" ХХК-ийг нэгтгэхийг зөвшөөрсөн.

Мөн Хорооны даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 296 дугаар тушаал (Хавсралт 1.10)-аар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,400,000,000 (нэг тэрбум дөрвөн зуун мянга) төгрөгөөр нэмэгдүүлсэн, мөн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, бүтцэд өөрчлөлт орсныг зөвшөөрсөн байна. Уг өөрчлөлтийг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 1.19).

"Сэндли ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн "Үнэт цаас нийтэд санал болгон гаргах тухай" 02 тоот шийдвэр (Хавсралт 1.11), 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн "Хувьцаагаа анх удаа нийтэд санал болгон гаргах тухай" 08 тоот шийдвэр (Хавсралт 1.12)-ээр Компанийн нь 67,000 (жаран долоон мянга) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, олон нийтэд санал болгон, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай" 413 дугаартай тогтоол (Хавсралт 1.13)-оор зөвшөөрснөөр анхдагч зах зээлийн арилжаа болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг амжилттай зохион байгуулж, Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болсныг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 1.19).

Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн улсын бүртгэлийн гэрчилгээ (Хавсралт 1.3), 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн тогтоолоор баталж, 2022 оны 12 сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн "Сэндли ББСБ" ХК-ийн дүрэм (Хавсралт 1.4)-д зааснаар зээлийн үйл ажиллагаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйлчилгээ эрхэлж байна.

Үнэт цаас гаргагч нь "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 10.1.1, 15.3.1, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай" хуулийн 6.1, 9.1-д тус тус заасны дагуу СЗХ-ны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 318 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭЛ



ээлийн үйл ажиллагаа, СЗХ-ны 2018 оны 02 дугаар 07-ны өдрийн 62 дугаар тогтоолоор гадаад валютын арилжаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, СЗХ-ны 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 441 дугаар тогтоолоор факторингийн үйлчилгээ, итгэлцлийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах (Хавсралт 6.1, 6.2, 6.3) үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/498 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.4) авсан байна.

Компанийн мэдээлэл:

| | |
|---|---|
| *Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:* | 000264577; |
| *Улсын бүртгэлийн дугаар:* | 9007001010; |
| *Регистрийн дугаар:* | 5961548; |
| *Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:* | "Сэндли ББСБ" Хувьцаат Компани /нээлттэй хувьцаат компани/; |
| *Хугацаа:* | Хугацаагүй; |
| *Хувьцаа эзэмшигчдийн тоо:* | 3293 (2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа); |
| *Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:* | 11,178,500,000 (Хавсралт 1.3, Хавсралт 1.4, Хавсралт 1.14, 1.15); |
| *Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:* | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула ренбүчи гудамж, 8/4 тоот; |
| *Гэрчилгээ олгосон сүүлчийн огноо:* | 2022.12.27; |
| *Гүйцэтгэх захирал:* | Б.Одгэрэл. |

2015 оны 05 дугаар сарын 04-ний өдөр анх улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр шинэчлэн олгосон Улсын бүртгэлийн гэрчилгээ (Гэрчилгээний дугаар: 000264577, Улсын бүртгэлийн дугаар: 9007001010, Регистрийн дугаар: 5961548) (Хавсралт 1.3) бүхий "Сэндли ББСБ" ХК нь хууль зүйн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

***Үнэт цаас гаргах тухай шийдвэрийн талаар.***

"Сэндли ББСБ" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай 22/07 тоот тогтоол (Хавсралт 1.16)-оор "Сэндли ББСБ" ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор дараах нөхцөлөөр өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

| | |
|---|---|
| Бондын арилжаа | Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд |
| Бондын төрөл | Энгийн хүүтэй бонд |
| **Бондын үнийн дүн** | **10,000,000,000 (арван тэрбум) төгрөг** |
| Нэгж бондын нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Бондын нийт тоо, ширхэг | 100,000 ширхэг |
| Бондын хугацаа | 18 сар |
| Бондын жилийн хүүгийн түвшин | 19,2% |
| Хүү төлөгдөх давтамж | Улирал тутам |
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сараас хойш Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй |
| Бондын барьцаа / баталгаа | Толгой компани нь өөрийн эзэмшилд буй үнэт цаас гаргагчийн хувьцааг холбогдох журмын дагуу барьцаалуулна. |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ
5961548

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭЭ-02



| | |
|---|---|
| Төгөн төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| Бондын хаалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

Уг тогтоол нь Компанийн тухай хуулийн 4.3 дахь хэсэг, 41.2, 41.3 дахь хэсэг, 42.1 дэх хэсэг, 55.9 дэх хэсэг, 76.1.5, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.2 дахь заалт, 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Компанийн дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.23 дахь заалтад тус тус нийцэж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.5-д "Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд бонд гаргагч компанийн хувьд энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан, энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна", 2.6-д "Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан даалж болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна", 2.7-д "Энэ журмын 2.6-д заасны дагуу батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байна" гэж тус тус заасан.

Үүний дагуу "Монголын Финтек Групп" ХК нь 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 31 тоот тогтоол (Хавсралт 1.17)-оор өөрийн эзэмшиж буй 13,000,000,000 (арван гурван тэрбум) төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Сэндли ББСБ" ХК-ийн хувьцааг бондын үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл хугацаагаар барьцаалуулахаар шийдвэрлэсэн байна.

"Сэндли ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 223,570,000 (хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг энгийн хувьцаа гаргасан, үүнээс "Монголын Финтек Групп" ХК нь 126,141,700 (нэг зуун хорин зургаан сая нэг зуун дөчин нэгэн мянга долоон зуу) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж байх тул Журмын 2.6-д заасан шаардлагыг хангана гэж үзэв (Хавсралт 1.4, 1.15, 1.19).

Мөн "Стоклаб Секьюритиз ҮЦК" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 74 тоот албан бичиг (Хавсралт 1.18)-т заасныар Компанийн хувьцааны жигнэсэн дундаж ханш нь 169.47 (нэг зуун жаран ес зууны дөчин долоо) төгрөг байна гэжээ. Хувьцааны ханш өөрчлөгдөж болно. Тус компанийн хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 сар болоогүй байгааг эс тооцвол "Монголын Финтек Групп" ХК-ийн хувьцаа барьцаалах тухай шийдвэр нь Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцэж байна.

Нэгтгэн дүгнэвэл, Компанийн өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгох тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

MDSKhanLex

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 20.1-т тус Компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна. Иймд Компанийн тухай хууль болон Компанийн дүрэм[1] үндэслэн тус Компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал, Салбарын удирдлага хариуцсан захирал, Мэдээлэл, технологи хариуцсан захирал, Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал, Мөнгөн гүйвүүлга хариуцсан захирал, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулан авч үзлээ.

Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 02 тоот шийдвэр (Хавсралт 2.1)-ээр Компанийн ТУЗ-ийг нийт 9 бүрэлдэхүүнтэйгээр сонгосон байна. 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар ТУЗ-ийн гишүүдийг эрх барих этгээдээр бүртгэсэн байна (Хавсралт 1.19).

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 5 эмэгтэй, 4 эрэгтэй сонгогдож хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж байгаа нь СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр баталсан Компанийн засаглалын кодексийн 1.4-т заасан зарчимд нийцэж байгаа бөгөөд Зөвлөхийн практикт ийнхүү хүйсийн тэнцвэрийг хангасан анхны тохиолдол болохыг онцлон тэмдэглэж байна.

Б.Наранбат нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна. Сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн, гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| ЕРДИЙН ГИШҮҮД: | | | |
| 1. | Баттулгын Наранбат<br><br>(Хавсралт 2.3) | 2003-2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд санхүүч мэргэжлээр бакалавр;<br><br>2010-2011 онд Японы гадаад худалдааны байгууллагад эдийн засагч. | 2008-2012 онд Сангийн яаманд мэргэжилтэн;<br><br>2012-2013 онд Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын хэлтэст захирал;<br><br>2013 онд Төрийн банкны Хөрөнгө зохицуулалтын газарт захирал;<br><br>2013-2016 онд Төрийн банкны |

[1] Компанийн дүрмийн 20.1: Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ
5961548

290

20 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



| | | | |
|---|---|---|---|
| | | | Санхүү хариуцсан дэд захирал;<br>2016 онд Төрийн банкны Гүйцэтгэх захирлын орлогч;<br>2016 оноос одоог хүртэл Гялс тэгрэг ХЗХ-ны үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал. |
| 2. | Мөнхтөрийн Цолмон (Хавсралт 2.4) | 2007 онд Америкийн Нэгдсэн Улсын Индианагийн их сургуульд санхүүгийн мэргэжлээр бакалавр. | Сангийн яаманд мэргэжилтэн;<br>Тээвэр дархан ХК-д Эдийн засагч;<br>2014-2016 онд Тариалан эрхлэлтийг дэмжих санд Гүйцэтгэх захирал. |
| 3. | Лхагжавын Нарантуяа<br>(Хавсралт 2.5) | 2004 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр. | 2008-2009 онд сар Зоос банк ХХК-д Мэргэжилтэн;<br>2009-2018 онд Төрийн банкинд Хуульч, Ахлах хуульч;<br>2018 оноос одоог хүртэл Хай пэймэнт солюшнс ХХК-д Хууль эрх зүй хариуцсан захирал. |
| 4. | Найдангийн Билгүүн<br>(Хавсралт 2.6) | 2009 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр Бакалавр;<br>2012 онд АНУ-ын Миссури их сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр. | 2013-2018 онд Сангийн Яаманд мэргэжилтэн;<br>2018-2021 онд Сэлүс Номадс компанид Менежер;<br>2021-2022 онд Дэлхийн банкинд Зөвлөх. |
| 5. | Батбаярын Эрдэнэ (Хавсралт 2.7) | 2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд бизнесийн удирдлагын бакалавр;<br>2014 онд Австрали Улсын Шинэ Өмнөд Уэльсийн их сургууль (UNSW)-д санхүүгийн удирдлагын мастер. | 2007-2012 онд Сангийн яамны ДАХШҮГ-т Мэргэжилтэн;<br>2014-2015 онд Сангийн яамны ЭУДАГ-т Ахлах мэргэжилтэн;<br>2015-2016 онд Төрийн банкны Хяналт шалгалтын газрын Захирал;<br>2016-2017 онд Төрийн банкны Актив, пассивын удирдлагын газрын Захирал;<br>2017 оноос одоог хүртэл |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

ХОРООНЫ ... ӨР ... БҮРТГЭВ
2023-01-10
БҮРТГЭВ
MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | | Техбокс ХХК-ийн Гүйцэтгэх захирал. |
| 6. | Нармандахын Цэвэгмэд (Хавсралт 2.8) | 2007 онд БНСУ-ын Инха Их сургуульд Эдийн засгийн ухааны бакалавр;<br><br>2009 онд БНСУ-ын КАИСТ их сургуульд Менежмент, Инженерчлэлийн магистр; | 2009-2014 онд ГАУЛИ ХХК-д Дэд захирал;<br><br>2014-2016 онд Дэу Сэкьюритис Монгол ҮЦК ХХК-д Хөрөнгө оруулалтын менежер;<br><br>2016-2021 онд Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК ХХК-д Гүйцэтгэх захирал. |
| ХАРААТ БУС ГИШҮҮД: | | | |
| 7. | Баатархүүгийн Анужин (Хавсралт 2.9) | 2008-2012 онд Британ Колумбийн Их сургуульд Байгаль орчин, тогтвортой хөгжил мэргэжлээр бакалавр;<br><br>2015-2016 онд Гренобль Бизнес сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр. | 2012-2015 онд АНУ-ийн Азийн санд Хөтөлбөрийн мэргэжилтэн;<br><br>2016-2018 онд Эрнст энд Янг Аудитод Ахлах аудитор;<br><br>2018-2021 онд Централ ТВ-д Гүйцэтгэх захирал. |
| 8. | Батмөнхийн Цэлмэг (Хавсралт 2.10) | 2003-2008 онд Ирланд улсын Ирланд Америкийн Институтэд Олон улсын бизнесийн удирдлагаар бакалавр;<br><br>2009-2011 онд Ирланд улсын Банкируудын Институтийн Хөрөнгө оруулалтын сангийн мэргэшсэн диплом;<br><br>2014-2015 онд Мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо (ACCA)-ны Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч;<br><br>2017-2018 онд Ирландын Хуульчдын холбооны Аэро/Нисэх онгоц лизинг болон санхүүгийн мэргэшсэн диплом. | 2008-2015 онд Жэй Пи Морган Хөрөнгө оруулалтын санд Татварын ахлах зөвлөх;<br><br>2015-2018 онд Эс Эм Би Си Авиэйшн Капитал Санхүү төслийн менежер;<br><br>2018-2022 онд Хас банкинд Санхүүгийн газрын захирал;<br><br>2022 оноос одоог хүртэл Ашид Ассет Менежмент ҮЦК ХХК-д Хөрөнгө оруулалт хариуцсан захирал. |
| 9. | Цэндсүрэнгийн Саруултуяа (Хавсралт 2.11) | 2003-2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн Сургуульд Бизнесийн удирдлагаар бакалавр;<br><br>2009-2011 онд Тайвань улсын Азийн их сургуульд Бизнесийн | 2007-2009 онд Голомт банкинд Судалгааны менежер;<br><br>2012-2017 онд Тайвань улсын АИС, ШУТИХ-д Төслийн судлаач; |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 1 0
БҮРТГЭВ

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | удирдлагаар магистр;<br><br>2011-2017 онд Тайвань улсын Азийн их сургуульд доктор. | 2017-2019 онд Голомт банкинд Бизнес хөгжлийн менежер;<br><br>2021 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуульд Ахлах багш. |

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг нь ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/02 тоот тогтоол (Хавсралт 2.12)-оор, Гүйцэтгэх захирал Б.Оюгэрэл нь "Гялс кредит ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот шийдвэр (Хавсралт 2.13)-ээр, Ерөнхий нягтлан бодогч Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.14)-аар, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал Х.Ичинхорлоо Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/93-1 тоот тушаал (Хавсралт 2.15)-аар, Салбарын удирдлага хариуцсан захирал П.Болорчулуун Гүйцэтгэх захирлын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Б/27 тоот тушаал (Хавсралт 2.16)-аар, Мэдээлэл, технологи хариуцсан захирал И.Түвшинзул Гүйцэтгэх захирлын 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн Б/25 тоот тушаал (Хавсралт 2.17)-аар, Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал Э.Мөнхзэлгэр Гүйцэтгэх захирлын 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн Б/68 тоот тушаал (Хавсралт 2.18)-аар, Мөнгөн гүйвүүлга хариуцсан дэд захирал Б.Нямжаргал Гүйцэтгэх захирлын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн Б/62 тоот тушаал (Хавсралт 2.19)-аар, Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал Д.Баярбат Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/29 тоот тушаал (Хавсралт 2.20), Санхүү хариуцсан захирал М.Мөнхгэрэл Гүйцэтгэх захирлын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Б/55 тоот тушаал (Хавсралт 2.21)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-д "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж заасан. Түүнчлэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам (Хавсралт 3.17)-ын 10.1-д заасны дагуу ТУЗ нь а/ Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, б/ Аудитын хороо, в/ Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой байхаар заасан. Үүний дагуу Компанийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод байгуулах тухай 22/05 тоот тогтоол (Хавсралт 2.22)-оор Аудитын хороо, Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Эрсдэлийн удирдлагын хороог байгуулсан байна.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны даргаар Б.Ануужин, гишүүнээр Б.Цэлмэг, Н.Билгүүн нар, Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны даргаар Ц.Саруултуяа, гишүүнээр Б.Ануужин, Л.Нарантуяа нар, Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Б.Цэлмэг, гишүүнээр Ц.Саруултуяа болон Б.Эрдэнэ нар тус тус томилогдон ажиллаж байгаа нь (Хавсралт 2.22) Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасан ТУЗ-ийн цалин урамшууллын, нэр дэвшүүлэх, аудитын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх шаардлагыг хангаж байна.

Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|



СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| 1. | **Балжиннямын Одгэрэл (Гүйцэтгэх захирал)**<br><br>(Хавсралт 2.23) | 2002-2006 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Санхүүгийн удирдлагын бакалавр. | 2006-2011 онд Хаан банкинд Теллер, эдийн засагч, ахлах эдийн засагч;<br><br>2011-2013 онд Хадгаламж банкинд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, орон нутгийн зээлийн хэлтсийн захирал;<br><br>2013-2016 онд Төрийн банкинд Орон нутгийн зээлийн хэлтсийн захирал;<br><br>2016-2021 онд Гэлс тэгрэг ХЗХ-нд Үйл ажиллагаа хариуцсан захирал;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал. |
| 2. | **Б Мөнхцэцэг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)**<br><br>(Хавсралт 2.24) | 2016-2021 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр бакалавр. | 2021-2022 онд Хай Пэймэнт Солюшнс ХХК-д хуулийн мэргэжилтэн;<br><br>2022 оноос одоог хүртэл Монголын Финтек Групп ХК-д хуулийн мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга. |
| 3. | **Хандхүүгийн Ичинхорлоо (Ерөнхий нягтлан бодогч)** (Хавсралт 2.25) | 1995-1999 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр;<br><br>Эдийн засгийн үндэсний дээд сургуульд Бизнесийн удирдлагын магистр. | Зоос банкны Кассын нярав, Хянагч нягтлан бодогч, Теллер, Ахлах теллер, Ерөнхий нягтлан бодогч;<br><br>Төрийн банкны Ерөнхий нягтлан бодогч, Харилцааны менежер, Мэргэжилтэн;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал. |
| 4. | **Хандхүүгийн Ичинхорлоо (Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал)** (Хавсралт 2.25) | | |
| 5. | **Пүрэвдоржийн Болорчулуун (Салбарын удирдлага хариуцсан захирал)** (Хавсралт 2.26) | 2000-2004 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Санхүүгийн удирдлагын бакалавр. | 2004-2010 онд Монгол шуудан банкны Нягтлан, Эдийн засагч, Мэргэжилтэн, Хянан шалгагч;<br><br>2010-2013 онд Хадгаламж банкны Ахлах аудитор, Ахлах менежер;<br><br>2013-2021 онд Төрийн банкны |



СЭНДЛИ ББСБ ХК
Sandly
УЛААНБААТАР ХОТ

294

СЗХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-01-10
MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | | Тооцооны төвийн захирал, Менежер.<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Салбарын удирдлага хариуцсан захирал. |
| 6. | **Нямдэлгийн Түвшинзул** (Мэдээлэл, технологи хариуцсан захирал) (Хавсралт 2.27) | 2002 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Банк санхүүгийн эдийн засагч, санхүүч мэргэжлээр бакалавр. | 2002-2003 онд Хаан банкны;<br><br>2004-2009 онд Монгол шуудан банкны;<br><br>2009-2011 онд Хадгаламж банкны;<br><br>2011-2015 онд Төрийн банкны;<br><br>2015-2017 онд Караван ХХК-ийн;<br><br>2017-2021 онд Тээвэр хөгжлийн банкны;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Мэдээлэл, технологи хариуцсан захирал. |
| 7. | **Энхжаргалын Мөнхдэлгэр** (Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал) (Хавсралт 2.28) | 2008 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Эдийн засгийн кибернетикч мэргэжлээр бакалавр. | 2008-2009 онд Финлак ХХК-ийн;<br><br>2009-2013 онд Хадгаламж банкны;<br><br>2013-2016 онд Төрийн банкны;<br><br>2016-2021 онд Гялс төгрөг ХЗХ-ны;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ны Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал. |
| 8. | **Батдоржийн Нямжаргал** (Мөнгөн гүйвуулга хариуцсан дэд захирал) (Хавсралт 2.29) | 2011 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүгийн менежментийн бакалавр;<br><br>2015 онд Pacific States University-д Бизнесийн удирдлагын магистр. | 2010-2012 онд Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-ийн;<br><br>2016-2017 онд Голомт банкны;<br><br>2018 онд Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн;<br><br>2021 оноос одоог хүртэл Сэндли ББСБ-ын Мөнгөн гүйвуулга хариуцсан дэд захирал. |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



| | | | |
|---|---|---|---|
| 9. | **Данзангийн Баярбат** (Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан дэд захирал) (Хавсралт 2.30) | 2007 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд Санхүүч мэргэжлээр бакалавр;<br><br>2016 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд Санхүүгийн менежер мэргэжлээр магистр. | 2007-2009 онд Анод банкны Эдийн засагч ;<br><br>2010-2017 онд Төрийн банкны Ахлах хяналт шалгагч;<br><br>2017-2020 онд Гялс төгрөг ХЗХ-д Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан дэд захирал. |
| 10. | **Мөнхбаатарын Мөнх-эрдэ** (Санхүү хариуцсан захирал) (Хавсралт 2.31) | 2007-2012 онд Дублины Бизнесийн Их Сургуульд Санхүү, нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр;<br><br>2018-2021 онд Корнивусын Их Сургуульд Эдийн засгийн магистр. | 2012-2017 онд Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК-д Ахлах аудитор;<br><br>2020-2021 онд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрт Санхүүгийн ажилтан;<br><br>2022 оноос одоог хүртэл Сэндли ББСБ ХК-д Санхүү хариуцсан захирал. |

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд бусад эрх бүхий албан тушаалтнуудын мэргэжил, боловсрол, эрхэлж байсан/байгаа ажлын туршлага зэргээс дүгнэвэл Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай гэж үзэж.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **№** | **Нэрс/Шаардлага** | **Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх** | **Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)*** | **Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)** | **Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)** |
| 1. | **Б.Наранбат (ТУЗ-ийн дарга)** | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430282/<br><br>(Хавсралт 2.3) | Тийм |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 21

2023-01-10
БҮРТГЭВ

MDSKhanLex

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | **М.Цолмон (ТУЗ-ийн гишүүн)** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430814/** (Хавсралт 2.4) | **Тийм** |
| 3. | **Л.Нарантуяа (ТУЗ-ийн гишүүн)** **СЗХ-ноос зөвшөөрөл хүлээгдэж байгаа* | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430825/** (Хавсралт 2.5) | **Тийм** |
| 4. | **Н.Билгүүн (ТУЗ-ийн гишүүн)** **СЗХ-ноос зөвшөөрөл хүлээгдэж байгаа* | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430824/** (Хавсралт 2.6) | **Тийм** |
| 5. | **Б.Эрдэнэ (ТУЗ-ийн гишүүн)** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430816/** (Хавсралт 2.7) | **Тийм** |
| 6. | **Н.Цэвэгмэд (ТУЗ-ийн гишүүн)** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2019.02.24-ний өдөр, Дугаар 0520841/** (Хавсралт 2.8) | **Тийм** |
| 7. | **Б.Анужин (ТУЗ-ийн хараат бус гишүүн)** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2022.05.09-ны өдөр, Дугаар 0132018/** (Хавсралт 2.9) | **Тийм** |
| 8. | **Б.Цэнмэг (ТУЗ-ийн хараат бус гишүүн)** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2021.06.19-ний өдөр, Дугаар 0131604/** (Хавсралт 2.10) | **Тийм** |
| 9. | **Ц.Саруултуяа (ТУЗ-ийн хараат** | **Үгүй** | **Үгүй*** | **Тийм /2022.12.02-ны** | **Тийм** |



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бус гишүүн) | | | өдөр, Дугаар 0431031/ (Хавсралт 2.11) | |
| 10. | Б.Олгэрэл | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430823/ (Хавсралт 2.23) | Тийм |
| 11. | Б.Мөнхцэцэг (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.08.10-ны өдөр, Дугаар 0430853/ (Хавсралт 2.24) | Тийм |
| 12. | Х.Ичинхорлоо (Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий зохицуулалт хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.05.17-ны өдөр, Дугаар 0430819 (Хавсралт 2.25) | Тийм |
| 13. | П.Болорчулуун (Салбарын удирдлага хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 14. | И.Түвшинзул (Мэдээлэл, технологи хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 15. | Э.Мөнхдэлгэр (Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 16. | Б.Намжаргал (Мөнгөн гүйвуулга хариуцсан дэд | Үгүй | Үгүй* | Тийм /2022.02.15-ны өдөр, Дугаар 0430879 | Тийм |

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | захирал) | | | (Хавсралт 2.29) | |
| 17. | **Д.Баярбат** (Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 18. | **М.Мөнхгэрэл** (Санхүү хариуцсан захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017.07.21-ний өдрийн A/195 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу Ял шийтгэгдсэн эсэх лавлагааг өнгөрсөн [illegible] Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан ял шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, [illegible] бичгийн дагуу, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан [illegible] байгаа эсэхийг бичгээр [illegible] мэдүүлэг, баталгаа, материалд үндэслэн дүгнэв.*

Б.Оюунэрдэнэ, Х.Ичинхорлоо, Б.Нямсамбуу нар компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байгаа нь компанийн засаглалын болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулах талаар зохих мэдлэг туршлагатайг харуулж байна.

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага | | | | |
|---|---|---|---|---|
| № | Шаардлага | ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс | | |
| | | Б.Анужин (Хавсралт 2.9) | Б.Цэлмэг (Хавсралт 2.10) | Ц.Саруултуяа (Хавсралт 2.11) |
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 2. | Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компанийн оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 3. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3) | Тийм** | Тийм** | Тийм** |



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ 2022 175 6951
Sendly

БҮРТГЭВ
№ 01
2023-01-10
БҮРТГЭВ-02



| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 5. | Сүүлийн 5 жилд компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 6. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 7. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй харилцагч нийлүүлэгч ба харилцагч биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 8. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 9. | Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 10. | Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |

***Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

**Компанийн Гүйцэтгэх удирдлага, Эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.**



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
MDSKhanLex

***Компанийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Сэндли ББСБ" ХК-ийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 1.4) баталсан байна. Дүрмээр нийтлэг үндэслэл, компанийн үйл ажиллагаа, компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, компанийн удирдлага, хяналтын тогтолцоо, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт, хөндлөнгийн аудит, компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл батлах, компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага, үнэт цаас худалдах, эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилан олгох, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай нийт 5 бүлэг, 24 зүйл зохицуулалтыг тодорхойлсон байна. Энэхүү дүрэм нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны 2016 оны 03-р сарын 11-ний өдрийн 71 дугаар тогтоолоор батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн болно.

**Компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах журам**

***Хөдөлмөрийн дотоод журам.*** (Хавсралт 3.1). "Сэндли ББСБ" ХК-ны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт тавих, хөдөлмөрийн бусад харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/29 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар нийт 15 бүлэг, 9 хавсралтаас бүрдэх Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, Сэндли ББСБ ХК-ийн удирдлага, зохион байгуулалт, Сэндли ББСБ ХК-ийн дотоод үйл ажиллагаа, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, ажилтныг ажилд авах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дуусгавар болгох, цуцлах, ашиг сонирхлын зөрчил, ажил хүлээлгэх, ажил олгогч, ажилтны эрх, үүрэг, ажил, амралтын цаг, чөлөө, урамшуулал, сууттгал, ажилтанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, тэтгэмж, нөхөн олговор, ажилтанд хориглох зүйл, хөдөлмөрийн сахилгын болон эд хөрөнгийн хариуцлага, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилт хяналтыг тодорхойлсон байна. Түүнчлэн журмын нэгдүгээр хавсралтаар Ярилцлагын үнэлгээний хуудас, хоёрдугаар хавсралтаар хөдөлмөрийн гэрээний загвар, гуравдугаар хавсралтаар эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ, дөрөвдүгээр хавсралтаар нууц хадгалах гэрээ, зургаадугаар хавсралтаар туршилтын хугацаанд ажиллаж буй ажилтныг үндсэн ажилтнаар томилох саналын хуудас, долоодугаар хавсралтаар тойрох хуудас, наймдугаар хавсралтаар зөрчлийн акт, есдүгээр хавсралтаар ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах саналын хуудасны загварыг тус тус баталсан байна.

Компанийн тухай хуулийн 83.1, Компанийн дүрмийн 9.8.9 дэх заалтад заасан бүрэн эрхийн дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь Хөдөлмөрийн дотоод журмыг баталсан байх ба энэхүү журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.10 дахь заалт, 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

***Ажилтагсад, хамтран ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр /ESOP/*** (Хавсралт 3.25). Компанийн ажиллагсад, хамтран ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийн зорилго нь компанийн хөгжилд хувь нэмрээ оруулж, үр бүтээлтэй ажиллаж буй ажилтан, хамтран ажиллагсдад урамшуулах, хөрөнгийн хуримтлалтай болох боломжийг олгох, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад хувьцаа эзэмшүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн н-01 тоот шийдвэрийн хавсралтаар нийт 7 зүйл, 1 хавсралтаас бүрдэх Ажиллагсад, хамтран ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг батлан мөрдүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь нийтлэг



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
2023 -01- 10
БҮРТГЭВ-02
MDSKhanLex

үндэслэл, хамрах хүрээ, баримтлах зарчим, ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх, татвар, хөтөлбөрийн дагуу хувьцаа эзэмшиж буй ажиллагсад ажлаас гарах, чөлөө авах, ажиллагсдыг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Зээлийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.2) Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалын Хавсралтаар харилцагчийн зээлийн хүсэлт хүлээн авч, судлах, зээл олгох, ашиглалтад хяналт тавих, үндсэн зээл болон хүүг төлүүлэх, зээлийн барьцааны зүйл, үнэлгээ тогтоох, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулах зорилгоор нийт 10 бүлгээс бүрдсэн Зээлийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, зээлийн шийдвэр гаргах үйл ажиллагаа, баримтлах үндсэн зарчим, зээлийн хороо, түүний хэлэлцэх асуудал, зээлдэгчид тавигдах шаардлага, зээл судлах, олгох, зээлд хяналт тавих, төлүүлэх, зээлийн хугацаа сунгах, хугацаа хэтэрсэн зээл төлүүлэх үйл ажиллагаа, зээлийн барьцааны зүйл, үнэлгээ, зээлийн бүтээгдэхүүн, судалгаа шинжилгээ, ажилтны хүлээх хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журамд Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/18-1 тоот тушаал, 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/24 тоот тушаал, 2022 оны 11-р сарын 14-ний өдрийн А/27 тоот тушаал (Хавсралт 3.2)-аар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү журам болон түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Зээлийн хорооны үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.3) Гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 тоот тушаалын Хавсралтаар Компанийн Зээлийн Хорооны бүрэлдэхүүн, ажиллах зарчим, эрх үүрэг, хурал хуралдуулах, шийдвэр гаргах үйл явц хариуцлагын тогтолцоог зохицуулах зорилгоор нийт 8 бүлгээс бүрдсэн Зээлийн хорооны ажиллах журам болон Зээлийн хорооны шийдвэрийн маягтыг хавсралтаар батлан мөрдүүлж байна. Зээлийн хорооны гишүүд болон нарийн бичгийн даргын гүйцэтгэх үүрэг, хорооны хурлын дэг болон хурлаас шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Уг журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Зээлийн бодлого.*** (Хавсралт 3.4) Харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, зээлийн үйл ажиллагаанд хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар нийт 5 бүлгээс бүрдэх Зээлийн бодлого (Хавсралт )-ыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Зээлийн бодлого нь Компанийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, барьцаа болон зээлийн багцын талаар баримтлах бодлого болон зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтын бодлогыг тодорхойлсон. Энэхүү бодлого нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох дүрэм, журамд нийцэж байна.

***Дотоод хяналтын үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.5) ББСБ-ын хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт болон хянан шалгагчийн эрх, үүргийн тодорхойлж, хяналт, шалгалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

2023-01-13
БҮРТГЭСЭН
MDSKhanLex

батлан мөрдүүлж байна. Энэхүү дотоод хяналтын үйл ажиллагааны журам нь зорилго, нэр томьёо, хамрах хүрээ, чиг үүрэг, хянан шалгагчийн ёс зүй, хянан шалгагчийн эрх, үүрэг, хориглох үйл ажиллагаа, хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл, хяналт төлөвлөлтийн ажлыг төлөвлөх үе шатууд, газар дээрх болон зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт, хариуцлагын харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь 2011 оны Засгийн газрын 311 тоот тогтоол, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна. Мөн хяналтын нэгжийн үйл ажиллагааны төрөл нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журамд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны төрөлтэй нийцсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/28 (Хавсралт 3.5) тоот тушаалаар дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажил үүргийг хавсран гүйцэтгүүлэхээр Х.Ичинхорлоог томилсон байна.

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам.*** (Хавсралт 3.6) Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тушаалын Хавсралт 2-оор Компаниар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, сэжигтэй харилцагчийг таньж мэдэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны баталсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам" зэрэг эрх бүхий байгууллагаас баталсан журам зааврыг зөрчсөн зүйл байхгүй байна.

***Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр.*** (Хавсралт 3.7) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байна гэсний дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 06 тоот тогтоолын Хавсралт 2-оор Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үнэт цаас гаргагчийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, банк бусаар дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд эрсдэлийг тодорхойлох, харилцагчид үнэлгээ өгөх, түүнд үндэслэн эрсдэлийн түвшинээр ангилах, удирдах, хянах зорилгоор нийт 6 бүлгээс бүрдсэн хөтөлбөр баталсан байна. Энэхүү хөтөлбөр нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкнаас баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/29 (Хавсралт 2.20) тоот тушаалаар "Эрсдэл, хяналт шалгалт хариуцсан ажилтан" албан тушаалыг хослон гүйцэтгүүлэхээр Д.Баярбатыг томилсон. Уг ажилтны ажлын байрны тодорхойлолтод заасныг Д.Баярбат нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.11-д заасны дагуу Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг ба энэ талаар мөн Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

***Комплаенсийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.8) Банк бус санхүүгийн байгууллагын комплаенсийн бодлого болон комплаенсийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх хүрээнд ББСБ-д учирч болзошгүй комплаенсийн эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/10 тоот тушаалын хавсралт №3-аар батлагдсан нийт 7 бүлгээс бүрдэх Комплаенсийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү Комплаенсийн үйл ажиллагааны журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, ББСБ-ын



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

комплаенсийн үйл ажиллагаа, комплаенсийн ажилтны эрх хэмжээ, тайлагнах, комплаенсийн үйл ажиллагааны хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журамд нийцсэн байна.

***Мөнгөн гуйвуулгын журам.*** (Хавсралт 3.9) Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээгээр харилцагч Гадаад улсаас Монгол улс руу, Монгол улсаас гадаад улс руу мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 3-р сарын 24 өдрийн А/10 тоот тушаалын 4-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү мөнгөн гуйвуулгын журам нийтлэг зүйл, журмын нэр томьёо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчилгээний нөхцөл, төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга илгээх, хүлээн авах, шилжүүлэх, гүйлгээг буцаах, валютын ханш, Тест гүйлгээ, тайлан, мэдээ, эрхийн түвшин буюу мэдээллийн аюулгүй байдал, хариуцлага, хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

***Итгэлцлийн үйлчилгээний журам.*** (Хавсралт 3.10) Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу итгэлцлийн үйлчилгээтэй холбогдсон "Сэнлли" Банк бус санхүүгийн байгууллага болон итгэлцэл үүсгэгч талуудын хоорондын харилцааг зохицуулах зорилгоор Компанийн 2022 оны 3 -р сарын 24 өдрийн Гүйцэтгэх захирлын А/10 тоот тушаалын 5 дугаар хавсралтаар нийт 8 бүлгээс бүрдэх Итгэлцлийн үйлчилгээний журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү итгэлцлийн үйлчилгээний журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, итгэмжлэгчийн эрх, үүрэг, итгэмжлэгдэгчийн эрх, үүрэг, итгэлцлийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах, дуусгавар болох, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

***Факторингийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.11) Факторингийн үйл ажиллагааны журмыг зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгэгчээс мөнгөн төлбөрийн үүргийн шаардах эрхийг шилжүүлэн авах, эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах харилцааг зохицуулах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалт, түүний үйл ажиллагааны бүрдэл, хяналт, хариуцлага, бусад харилцааг зохицуулсан байна. Шаардах эрхээ шилжүүлэх зохицуулалтын тухайд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль болон Иргэний хуулийн Эдийн бус хөрөнгө олж авах 122 дугаар зүйл, Шаардах эрхээ шилжүүлэх 123 дугаар зүйлд нийцсэн байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн 5 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн зааврын дагуу Факторингийн авлагын бүртгэл, Факторингийн авлагын эрсдэлийн сан /ФАЭС/-ийн бүртгэл, Факторингийн тооцоогоор үүсэн авлагын ангиллыг өөрчлөлтийн бүртгэлийг хийхээр тусгасан байна.

***Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.12) Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн гуравдагч этгээд буюу үүрэг гүйцэтгүүлэгчид баталгаа гаргах зорилгоор компанийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, баталгааны төрөл, ангилал, баталгаа гаргахад баримтлах ерөнхий нөхцөл, төлбөрийн баталгаа гаргах, баталгааны нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, баталгааны дагуу төлбөр гүйцэтгэх, баталгааг цуцлах, дуусгавар болгох, тайлан мэдээ, баталгааны үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагыг зохицуулсан нийт 11 бүлэг, 4 хавсралтаас бүрдэнэ. Журам нь Иргэний хуулийн 234 дүгээр зүйл, 457 дугаар зүйлд нийцсэн ба тус журамд заасан банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгааны дүн нь Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хуульд заасан дүнтэй нийцэж байна.



304

СЗХ
он ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



***Гадаад валютын арилжааны журам***. (Хавсралт 3.13) Гүйцэтгэх захирлын 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/14 тоот тушаалын хавсралтаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу компанийн салбаруудад гадаад валютыг арилжаалах, энэхүү үйл ажиллагаанаас ашиг олох болон уг арилжаанд оролцох албан тушаалтнуудын эрх, үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдон гарах бусад харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Гадаад валютын арилжааны журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, журмын нэр томьёо, арилжаа хийхэд мөрдөгдөх зарчим, самбарын болон дотоод ханш, ханш зарлах, түүнийг мөрдөх, арилжааг хязгаарлах, арилжааг хийж гүйцэтгэх, арилжааны орлого хуваарилах, арилжааны гүйлгээ болон хяналт, хариуцлага зэргийг зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зарчим болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журам***. (Хавсралт 3.14) Гадаад улсад албан ёсоор амьдарч, хөдөлмөр эрхэлж буй Монгол Улсын иргэн Монгол Улсад байршилтай орон сууцыг худалдан авахад зориулан зээлийн хүсэлтийг хүлээн авч, судалгаа шинжилгээ хийх, зээл олгох тухай шийдвэр гаргах, зээлийн зарцуулалт, эргэн төлөлтөд хяналт тавих, зээлийг төлүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 01-ний өдрийн А/05-01 тоот тушаалын 1-р хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар зээлийн тодорхойлолт, зориулалт, нэр томьёо, зээл олгох нөхцөл, барьцааны зүйлд тавигдах шаардлага, зээлдэгчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, зээлийн судалгаа шинжилгээ, зээл олголт, зээлийн хувийн хэрэг, зээлийн төлбөр хүлээн авах, зээлийг төлүүлэх, зээлийн хяналттай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн байна.

***Хөрөнгийн үнэлгээний заавар***. (Хавсралт 3.15) ББСБ-ын зээлийн үйлчилгээнд хөрөнгө барьцаалах үндэслэл, барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх аргачлалыг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Компанийн гүйцэтгэх захирлын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 17/05 тоот тогтоолын хавсралтаар нийт 6 бүлгээс бүрдэх Хөрөнгийн үнэлгээний заавар (Хавсралт 3.1)-ыг батлан мөрдүүлсэн байна. Энэхүү заавар нь нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн үнэлгээ хийх арга, аргачлал, бусад, хариуцлага гэсэн үндсэн зохицуулалтаас бүрдэх ба зааврын хавсралтаар Зээлийн барьцаа хөрөнгө болох тээврийн хэрэгсэл, орон сууц (орон сууц, амины сууц, хашаа байшин, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж)-ны үнэлгээг тодорхойлох хүснэгтийн загварыг баталсан байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.11-т зааснаар зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбогдсон журмыг Санхүүгийн Зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батлахаар зохицуулсан боловч СЗХ-ноос энэ талаар журам хараахан батлагдаагүй байна http://www.frc.mn/frc/o/c/78/d/gc/8387. ББСБ-аас олгосон зээлийн гэрээний барьцаа хөрөнгийг хэрхэн үнэлэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй тул үнэлгээ хийх аргачлал, үндэслэл нь аливаа хуулийн зөрчилгүй гэж үзэв.
Зааврын үндэслэлийг хянан үзвэл, энэ зааврын зорилт нь Сэндли ББСБ-ын зээлийн барьцаа хөрөнгөд үнэлгээ хийх, барьцаанд авах үндэслэлийг тогтоож, МУ-ын Үндсэн хууль, Иргэний хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Хадгаламж зээлийн ББСБ-ын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан, заавар журмыг мөрдөж ажиллах, холбогдох арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахаар заасан.

***Нийгмийн хөгжлийн санг байгуулах, зарцуулах журам***. (Хавсралт 3.16) Нийгмийн хөгжлийн санг бүрдүүлэх болон зарцуулахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2022 оны 2-р сарын 14-ний өдрийн А/06-01 тоот тушаалын хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журмаар нийтлэг үндэслэл, нийгмийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт,



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



хуваарилалт, нийгмийн хөгжлийн сангийн зарцуулалт, үүрэг хариуцлагатай холбоотой 4 бүлэг харилцааг зохицуулсан байна.

**Компанийн засаглалын бодлого, журам**

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** (Хавсралт 3.17) ТУЗ, түүний чиг үүрэг, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх нөхцөл, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, үүрэг, хариуцлага, гишүүдийн үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн дотоод үйл ажиллагаа, гишүүдийн цалин, урамшуулал олгох зэрэг ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор нийт 15 бүлэг 7 хавсралтаас бүрдсэн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 22/03 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан байна.

Журмын 2.3-т ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т заасан хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байна гэсэн шаардлагад нийцэж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар бүлэгт ТУЗ нь цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, аудитын хороо, эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороотой байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороотой байх гэсэн шаардлагад нийцсэн байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.1-д "ТУЗ-ийн хурлаар тухайн жилийн ТУЗ-ийн хурлын товыг батлах бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал хийж болно..." гэж заасан нь Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-т Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно, Компанийн дүрмийн 8.8-д "ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, Компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар нэмэлт хурал хуралдуулж болно" гэж зохицуулсантай нийцэж байна.

Нэгтгэн дүгнэвэл, энэхүү журам нь Компанийн тухай хуульд нийцэж байна.

***Эрсдэлийн удирдлагын бодлого.*** (Хавсралт 3.18) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар компанийн хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх зорилгоор нийт 12 бүлгээс бүрдсэн эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, бодлогын зорилт, үндсэн зарчим, эрсдэлийн төрөл, эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх үе шат, эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, зээлийн, зах зээлийн, үйл ажиллагааны, хөрвөх чадварын, нэр хүндийн, стратегийн болон комплаенсийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийн шинжилгээ ба тайлагналт болон хяналт хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
5961548
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
2023 -01- 10
MDSKhanLex

***Хүний нөөцийн бодлого.*** (Хавсралт 3.19) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 08 тоот шийдвэрийн хавсралтаар мэргэжлийн болон харилцааны чадвар чадавхтай өндөр бүтээмжтэй хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, компанийн өмнөө тавьсан зорилго зорилтод хүрэхэд дэмжин ажиллах хүсэл эрмэлзэлтэй ажилтныг төлөвшүүлэх, ажлын гүйцэтгэл сайн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажилтан бүрийн хувийн ур чадварыг бүрэн нээж хөгжүүлэн оновчтой үр бүтээлтэй ашиглах компанийн хүний нөөцийн менежментийн үндсэн чиглэл, баримтлах үндсэн зарчим, эрхэмлэх зүйлсийг тодорхойлох, компанийн амжилтад оруулсан хувь нэмрээ шударгаар үнэлүүлэн урамшуулан шагнагдах, албан тушаал ахих нөхцөлүүдийг бүрдүүлэх зорилгоор нийт 11 бүлгээс бүрдсэн хүний нөөцийн бодлогыг баталсан байна. Энэхүү бодлогод удиртгал буюу бодлогын зорилго, үндсэн чиглэл, зарчмууд, үйл ажиллагаанд мөрдлөг болгох зүйлс, ажилтнуудад тавих шаардлага, нэр томьёо, хүний нөөцийн стратеги, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлүүд, хүний нөөцийн төлөвлөлт, ур чадварын тогтолцоо, ажлын байрны шинжилгээ ба тодорхойлолт, хүний нөөцийн бүрдүүлэлт, хүний нөөцийн сонголт, карьер хөгжлийн төлөвлөлт, хүний нөөцийн сургалт, хөгжүүлэлт, гүйцэтгэлийн удирдлага, цалин хөлс урамшуулал нийгмийн халамж, хөдөлмөрийн сахилга ба хариуцлага зэргийг тусгаж өгсөн байна.

***Ёс зүйн дүрэм.*** (Хавсралт 3.20) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 09 тоот шийдвэрийн хавсралтаар компани, түүний бүх ажилтанд Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон компанийн дотоод дүрэм, журмаар тодорхойлсон зорилт, эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 7 бүлгээс бүрдсэн Ёс зүйн дүрмийг баталсан байна. Энэхүү дүрэмд нийтлэг үндэслэл, нэр томьёоны тодорхойлолт, ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, зөрчлийг мэдээлэх, шийдвэрлэх, хяналт, хариуцлага, бусад зэргийг тусгасан байна.

***Хороодын ажиллах журам.*** (Хавсралт 3.21) Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/02 тоот шийдвэрийн хавсралтаар хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актив пассивын удирдлагын хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны хэлбэр, зохион байгуулалт, хэлэлцэх асуудал, шийдвэр гаргалт болон гишүүдийн үүрэг хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 5 бүлэг, 6 хавсралтаас бүрдсэн Хороодын ажиллах журмыг баталсан байна. Энэхүү журамд ерөнхий зүйл, хүний нөөцийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо, актив пассивын удирдлагын хороо, хяналт хариуцлагын талаар тусгасан байна.

***Ногдол ашгийн бодлого.*** (Хавсралт 3.22) Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлох зорилгоор Ногдол ашгийн бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/03 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, ногдол ашиг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Ногдол ашгийн бодлого нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Салбар, нэгжийн үйл ажиллагааны журам*** (Хавсралт 3.23) Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/15 тоот тушаалын хавсралтаар салбарын бүтэц зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлгээс бүрдсэн Салбар,



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02



нэгжийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журамд нийтлэг үндэслэл, салбарын бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны бүтэц бүрэлдэхүүн, салбарын үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнал, зээлийн үйл ажиллагаа, мөнгөн гүйвуулгын үйл ажиллагаа, валют арилжааны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, кассын үйл ажиллагаа, аюулгүй ажиллагаа, хяналт, хариуцлагын талаар тусгасан байна.

Компани нь доор дурдсан нийт 54 салбар (Хавсралт 3.24)-ын үйл ажиллагааг тус журмаар зохицуулж байна. Үүнд:

| Салбарын байршил | Салбарын тоо |
|---|---|
| Улаанбаатар (Чингэлтэй дүүрэг 2, Баянзүрх дүүрэг 2, Сонгинохайрхан дүүрэг 1, Налайх дүүрэг 1) | 6 |
| Архангай аймаг | 3 |
| Баянхонгор аймаг | 1 |
| Баян-Өлгий аймаг | 1 |
| Булган аймаг | 1 |
| Говьсүмбэр аймаг | 2 |
| Дархан-Уул аймаг | 2 |
| Дорноговь аймаг | 4 |
| Дорнод аймаг | 3 |
| Дундговь аймаг | 2 |
| Завхан аймаг | 2 |
| Орхон аймаг | 1 |
| Өвөрхангай аймаг | 5 |
| Өмнөговь аймаг | 3 |
| Сүхбаатар аймаг | 4 |
| Сэлэнгэ аймаг | 6 |
| Увс аймаг | 3 |
| Хэнтий аймаг | 4 |
| Төв аймаг | 1 |
| **Нийт** | **54** |

***Цалин урамшууллын бодлого.*** (Хавсралт 3.26) Компанийн цалин, урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багийн болон компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны суурь зарчмыг тодорхойлох зорилгоор Цалин урамшууллын бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Энэхүү бодлого нь нийтлэг үндэслэл, үндсэн чиглэл, зарчим, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын баг, компанийн ажилтнуудын цалин урамшуулал тогтоох нөхцөлийг тодорхойлж, журмын биелэлтэд хяналт тавих, сайжруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэ бодлого нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Залгамж халааны бодлого.*** (Хавсралт 3.27) Компанийн удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангах зорилгоор Залгамж халааны бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-03



тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Тус бодлогоор нийтлэг үндэслэл, бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэрэг харилцааг зохицуулсан байна.

***Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам.*** (Хавсралт 3.28) Компанийг эрх бүхий байгууллагад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх нөхцөлийг тодорхойлох зорилгоор энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/03 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Журам нь нийтлэг үндэслэл, нэр томъёо, хугацаат тайланг нийтэд мэдээлэх, тухай бүр нээлттэй мэдээлэх мэдээллийг тодорхойлох, компанийн талаар мэдээлэл авах, нийтэд мэдээлсэн мэдээллийн архивыг бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаа, мэдээллийг нээлттэй болгоход тавигдах хязгаарлалт, хориглох зүйлс болон бусад нөхцөлийг зохицуулсан байна. Журам нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээ хүргэх журам.*** (Хавсралт 3.29) Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдээллийг СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 22/03 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Журам нь нийтлэг үндэслэл, хурал хуралдуулах шийдвэр гаргах, хурлын зар хүргэх, хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах болон бусад нөхцөлийг зохицуулсан байна. Журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журам.*** (Хавсралт 3.30) Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох компанийн үйл ажиллагаа дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/09 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна. Журам нь нийтлэг үндэслэл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, бүртгэх, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлох, компани дахь сонирхлын зөрчлийг зохицуулах, журамд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх, болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Журам нь Компанийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой журмууд***

Компани нь ISO/IEC 27001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байгаатай холбоотойгоор дараах журмуудыг баталсан.

| № | Журмын нэр | Дугаар | Огноо | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1. | Мэдээллийн аюулгүй байдлын бодлого (Хавсралт 3.31) | 22/09 Хавсралт 5 | 2022.12.27 | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 2. | Мэдээллийг хадгалах, хамгаалах, нөөцлөх журам (Хавсралт 3.32) | А/28 Хавсралт 2 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 3. | Мэдээлэл, мэдээллийн технологийн системийн нууцын журам (Хавсралт 3.33) | А/28 Хавсралт 1 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

MDSKhanLex

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4. | Мэдээлэл, мэдээллийн технологийн систем, сүлжээнд хандах хандалтыг хянах журам (Хавсралт 3.34) | А/28 Хавсралт 3 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 5. | Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам (Хавсралт 3.35) | А/28 Хавсралт 5 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 6. | Мэдээллийн аюулгүй байдалд шалгалт хийх журам (Хавсралт 3.36) | А/28 Хавсралт 4 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 7. | Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийн үед ажиллах журам (Хавсралт 3.37) | А/28 Хавсралт 3 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 8. | Сүлжээ, сүлжээнд холбогдох тоног төхөөрөмжийн аюулгүй байдлын журам (Хавсралт 3.38) | А/28 Хавсралт 6 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 9. | Байр, байшингийн аюулгүй байдлын заавар (Хавсралт 3.39) | А/28 Хавсралт 8 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |
| 10. | Бизнесийн мэдээлэл, мэдээллийн системийн үйл ажиллагааны тасралтгүй байдлын болон гэнэтийн аюулаас сэргээх төлөвлөгөө (Хавсралт 3.40) | А/28 Хавсралт 7 | 2022.12.27 | Гүйцэтгэх захирал |

Эдгээр журмуудыг олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад аливаа зөрчил илрээгүй болно.

Нэгтгэн дүгнэвэл, Компанийн дүрэм, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, СЗХ-оос баталсан журамд нийцсэн байна.

СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамнд бүртгэгдсэн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Шинэчилсэн кодексийн 1.4 (хүйсийн тэнцвэрийг хангах), 1.5 (чиглүүлэх сургалт) 5.3 (байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хэрхэн удирдаж байгааг тайлбарлах) зэрэг болон бусад шинэ нөхцөл, шаардлагыг харгалзан уг кодексийн хэрэгжилтийг хангах талаар тусгай төлөвлөгөө гаргах ажиллахыг Үнэт цаас гаргагчид зөвлөж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№

2023 -01- 10
БҮРТГЭВ



Бид тус Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий доор дурдсан гэрээг дараах ангиллын дагуу хянасан болно.

1. Үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж буй гэрээ, хэлцэл
2. Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл
3. Гэрээний загварууд
4. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөнтэй холбоотойгоор байгуулсан гэрээ, хэлцэл
5. Нээлттэй өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой байгуулсан гэрээ, хэлцэл
6. Зээлийн гэрээ
7. Репо зээлийн гэрээ
8. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ

***1. Үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж буй гэрээ, хэлцэл:***

***Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ /Контракт/.*** Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл нь 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр (Хавсралт 2.8)-ээр томилогдсон. Компанийн тухай хуулийн 83.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбаттай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г (Хавсралт 4.1)-г 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинэчлэн байгуулсан байна. Энэхүү гэрээг хугацаагүй байгуулсан бөгөөд гэрээгээр гэрээний зүйл, гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, цалин олгох, ажил дүгнэх, шагнах, урамшуулах нөхцөл, нууцлал, оюуны өмч, гэрээг дуусгавар болгох, цуцлах, хариуцлага тооцох, эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх үндсэн болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна. Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээ нь 2022 оны 01-р сарын 01-ээс хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд хамаарах тул тус зохицуулалтад тавьсан шаардлагад нийцсэн байна.

***Түрээсийн гэрээ /Баянзүрх дүүрэг/*** (Хавсралт 4.2). "Гэлс кредит" ББСБ болон Монгол Улсын иргэн нар нь 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдөр №2021/07 тоот түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 64-р байрны V1 тоот хаягт байрлах үйлчилгээний зориулалттай 85.68м2 талбай бүхий ажлын байрыг 1 жилийн хугацаанд 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийг дуустал Түрээслэгчид түрээсээр эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад нийцсэн ба Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлжээ. Гэрээний 6.1 дэх хэсэгт гэрээг дуусгавар болсноос хойш гэрээг цуцлах талаар талууд санал ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар 1 удаа сунгагдсанд тооцно гэж заасны дагуу гэрээ хэрэгжиж байна.

***Түрээсийн гэрээ /Налайх дүүрэг/.*** (Хавсралт 4.3) "Гэлс кредит"ББСБ болон Монгол Улсын иргэн нар нь 2021 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр 2021/08 түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Налайх дүүрэг 2-р хороо, Жаргалант Д.Даваажав гудамж 13-р байр 1 давхарт хаягт байрлах үйлчилгээний зориулалттай (бие даасан өмчлөх эрхийн гэрчилгээгүй талбай) 290 кв.м талбай бүхий ажлын байрыг 1 жилийн хугацаанд 2022 оны



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
оны сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10



11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Гэрээний 6.1 дэх хэсэгт гэрээг дуусгавар болохоос хойш гэрээг цуцлах талаар талууд санал ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар 1 удаа сунгагдсанд тооцно гэж заасны дагуу гэрээ хүчинтэй байна.

***Түрээсийн гэрээ /Чингэлтэй дүүрэг/.*** (Хавсралт 4.4). Үнэт цаас гаргагч болон Монгол Улсын иргэн нар нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула Ринбүчи гудамж 8/4 тоот хаяг байрлах үйлчилгээний зориулалттай 1 давхрын 200мкв талбайн 100 мкв талбайг 3 жилийн хугацаанд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад нийцсэн ба Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлжээ.

***Түрээсийн гэрээ /Хархорин салбар/.*** (Хавсралт 4.5) "Гялс кредит" ББСБ болон "Кондитер-Улаанбаатар" ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр 2 тоот түрээсийн гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 17-р хороо, 1-р хороолол, Москвагийн гудамж 43/А байр 2-р давхрын 50 кв.м талбай бүхий Ү-2201019587 дугаартай түрээсийн объектыг 1 жилийн хугацаанд 2023 оны 05 дугаар 01-ний өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Павильон түрээслэх түрээсийн гэрээ /Дэнжийн 1000/.*** (Хавсралт 4.6) "Гялс кредит"ББСБ болон "Мөнгөт Цахир Трейд" ХХК нь 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдөр 2021/0219 тоот Павильон түрээслэх түрээсийн гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Дэнжийн 1000 үйлчилгээний төвд 2 байрлах, 14-р павильон 1 жилийн хугацаанд 2022 оны 03 дугаар 17-ны өдрийг хүртэл Түрээслэгчид ашиглуулах, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуульд нийцсэн байна. Гэрээний 2.2-д "Түрээсийн гэрээг 1 жилээр сунгах ба гэрээний сунгалт хэсэгт Талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар гэрээг сунгасанд тооцно" гэжээ. Ийнхүү гэрээний хавсралтад заасан сунгалтын хэсэгт 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл 1 жилээр сунгаж талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан байх тул гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

***Түрээсийн гэрээ /Наранхуул салбар/*** (Хавсралт 4.7). "Гялс кредит" ББСБ болон "Нар-мон" ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ШЗ-8 тоот түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч нь Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, 14-р хороолол, Намьянжугийн гудамж, 51-р байр, 3-р давхрын 44 мкв талбай бүхий амины байр оффисын 1 жилийн хугацаанд 2023 оны 05 дугаар 16-ны өдрийг хүртэл түрээсийн талбайн тодорхой хэсгийг эзэмшиж, ашиглах, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Түрээсийн гэрээ*** (Хавсралт 4.8). "Сэндли ББСБ" ХХК болон Монгол Улсын иргэн нар нь 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Түрээсийн гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгч



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



нь Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40, 50 мянгат /15171/, Бакула Ринбүчи гудамж 8/4 тоотод байршилтай 000157457 тоот гэрчилгээний дугаартай, Улсын бүртгэлийн Ү-2202006293 дугаартай үйлчилгээний зориулалттай 124мкв талбайтай, 4 дүгээр давхар мөн өмчлөлийн 000157456 тоот гэрчилгээний дугаартай, Ү-2202017941 дугаартай үйлчилгээний зориулалттай 200мкв талбайн 1 давхарын 100мкв талбайг 3 жилийн хугацаанд 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл Түрээслэгчид эзэмшүүлж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Иргэний хуулийн хорин долоодугаар бүлэгт заасан агуулгад нийцсэн ба Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т заасны дагуу зохих ёсоор 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлжээ.

Холбогдох түрээсийн гэрээний үндсэн дээр ББСБ-ын хөдөө орон нутгийн салбар үйл ажиллагаагаа явуулдаг ба дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг түрээсийн гэрээнүүд хүчин төгөлдөр талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

***Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ.*** Компани нь Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай Танилт, нэвтрэлтийн системд холбогдож, мэдээллийг хүлээж авахтай холбоотой үүсэн харилцааг зохицуулахаар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 2022/01, "Танилт, нэвтрэлтийн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ" (Хавсралт 4.9)-г 3 жилийн хугацаатайгаар 2025 оны 12 дугаар сарын 14-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулжээ. Энэхүү гэрээнд Нийтлэг үндэслэл, Талуудын эрх үүрэг, Гэрээний хугацаа, Гэрээний төлбөр, Давагдашгүй хүчин зүйлс, Талуудын хүлээх хариуцлага, Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх, Бусад зүйлс, Хавсралт гэсэн 9 зүйл, 1 хавсралтаас бүрдсэн байна.

"ХУР" системээр дамжуулан мэдээлэл хүлээн авах ажиллагаа нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглах үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журамд нийцсэн байна. Энэхүү гэрээ хэлэлцээрийн төвшин байгаа ба гарын үсгийн баталгаажуулах ажил дутуу байгаа талаар Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

***Хамтын ажиллагааны гэрээ*** (Хавсралт 4.11). ББСБ нь Монголбанкны ажиллуулж буй зээлийн мэдээллийн санд болон зээлдүүлэгчид байгаа иргэд, аж ахуй нэгжийн зээл, хүлээж буй болзошгүй үүрэг, үнэт цаас, бусад актив, аливаа өр төлбөр болон холбогдох бусад мэдээллийг харилцан солилцохтой холбоотой харилцааг зохицуулахаар Монголбанктай 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 0619/281 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээ нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 28.3 дахь хэсэгт нийцсэн байна.

***Программ хангамж түрээсээр ашиглах гэрээ*** (Хавсралт 4.12). ББСБ нь ГрэйпСити Монгол ХХК-тай харилцагч, харилцагчийн данс, хугацаат хадгаламж, барьцаа хөрөнгө, зээл, монголбанкны зээлийн мэдээллийн сан руу мэдээлэл илгээх, дотоодын данс, балансын гадуурх данс, ерөнхий дэвтэр, МОСТ платформын интерфэйс буюу поларис суурь системийг түрээсээр ашиглах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагаадах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг зохицуулахаар 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ЛА-21/50 тоот "Программ хангамж түрээсээр ашиглах гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажил, техникийн шаардлага, төслийн үе шат ба хугацаа, төслийн хяналт ба хэрэгжилт, гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл, нэвтрүүлэлтийн дараах засвар үйлчилгээ, төслийн баг, талуудын эрх, үүрэг, хариуцлага, мэдээллийн нууцлал, оюуны өмч ба зохиогчийн эрх, хэвлэн нийтлэх, маргаан шийдвэрлэх, гэрээ дуусгавар болгох, цуцлах харилцааг зохицуулсан нь Иргэний хуулийн 31-р бүлэг, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35.1.2 дахь хэсэг, 37.2 дахь хэсэгт нийцсэн байна.



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

MDSKhanLex

*Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээ* (Хавсралт 4.13). ББСБ нь "Бүрэн Скор ЗМС" ХХК-тай 2022 оны 7-р сарын 04-ний өдөр байгуулсан БХЗ/021-22 тоот бүхий Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээгээр Мэдээлэл нийлүүлэгч нь зээлдэгчийн мэдээллийг Үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд нийлүүлэх, Үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн сангаас зээлийн мэдээлэл болон зээлийн түүхийн мэдээлэл бүхий зээлийн лавлагаа, мэдээлэл авах, үйлчилгээний хөлс төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээнд талуудын эрх үүрэг, хариуцлага, гэрээний хугацаа түүнийг цуцлах, дуусгавар болгох журам болон гомдол маргаан шийдвэрлэх журмыг тусгасан нь Зээлийн мэдээллийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А-231 дугаар тушаалын хавсралтаар баталсан Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах журмын 14.4 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

*Хэрэглэгчийн гэрээ* (Хавсралт 4.14). ББСБ нь зээлийн мэдээллийн үйлчилгээ авах, зээлийн мэдээллийг ашиглах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөлс төлөх төлбөртэй холбогдон үүсэх бусад харилцаа, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахаар "Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Г961-22 тоот Хэрэглэгчийн гэрээг байгуулсан байна. Гэрээ нь Зээлийн мэдээллийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

*Санамж бичиг* (Хавсралт 4.15). Хөүм моргейж корпорэйшн ХХК-ийн Гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэд эх орондоо орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх төсөл дээр хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулсан Техбокс ХХК, Хөүм моргейж корпорэйшн ХХК-нуудтай Санамж бичгүүд байгуулж ажилсан байна. Эдгээр санамж бичиг нь хэлцлийн хувьд сонирхлын зөрчилтэй боловч аливаа үүрэг хүлээсэн шинжгүй байх тул сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцон оруулаагүй болно. Тус компаниудтай санамж бичиг байгуулах, цаашилбал төсөлтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах бүрэн эрхийг Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот тогтоол (Хавсралт 4.16)-оор олгосон нь хуульд нийцсэн байна.

*Андеррайтер болон Зөвлөх үйлчилгээний гэрээ* (Хавсралт 4.17). Компанид шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татан төвлөрүүлэх зорилгоор андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай 2022 оны 11-р сарын 25-ны өдөр S-22/240 тоот Андеррайтер болон Зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээгээр нийтлэг үндэслэл, үнэт цаас, итгэлцлийн бүтээгдэхүүн гаргахад андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигч, түүний үүрэг, маргаан шийдвэрлэх, бусад харилцааг зохицуулсан нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцсэн байна.

***2. Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл:***

| № | Нөгөө тал | Огноо | Гэрээний нэр, агуулга |
|---|---|---|---|
| 1. | Австрали улсын Flexewallet Pty Limited | 2020.04.02 | Flexewallet түншлэлийн үйлчилгээний гэрээ / Flexewallet affiliate services agreement/ нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хооронд шилжүүлэх, шилжүүлгийн талаар мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |
| 2. | Япон Улсын City express money transfer Japan Co.Ltd., | 2021.06.22 | Мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн гэрээ нь Үйлчлүүлэгчээс мөнгөн хөрөнгийг цуглуулж, улс, хооронд шилжүүлэх, шилжүүлгийн талаар |



СЭНДЛИ ББСБ ХК
9022111
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10



| | | | |
|---|---|---|---|
| | | | мэдээлэл өгөх, холбогдох шимтгэл, төлбөртэй холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |
| 3. | "XXX" Компани | 2019.05.16 | Sub-marketing partner agreement нь мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн маркетингийн үйл ажиллагаатай холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |
| 4. | Tenpay Payment Technologies Co., Ltd. | 2021.11.11 | Wechat төлбөрийн улс хоорондын үйлчилгээг ашиглан төлбөр тооцоо хийх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой талуудын харилцааг зохицуулсан. |

Дээр дурдсан хамтын ажиллагааны гэрээ хэлцэлд гадаад улсын хууль тогтоомж, шүүх, арбитрын харьяаллыг сонгосон байна.

***3. Гэрээний загварууд:***

МДСХ нь тус ББСБ-ын үндсэн үйл ажиллагаанд ашигладаг дараах гэрээний загвар баримт бичгүүдийг хянасан бөгөөд хууль зөрчсөн авдал нарээгүй ба гэрээний тал, нөхцөлүүдээс хамаарч өөрчлөгдөх боломжтой болно. Үүнд:

| Баримт бичгийн нэр | Огноо, Дугаар, тайлбар |
|---|---|
| Цахим зээлийн эрх нээх гэрээний загвар (Хавсралт 4.18) | - |
| Орон сууцны зээлийн гэрээний загвар (Хавсралт 4.19) | Орон сууц худалдан авах зээлийн үйл ажиллагааны журмын хавсралт |
| Цахим зээлийн эрх гэрээний загвар /мерчант/ (Хавсралт 4.20) | - |
| Зээлийн шугамын гэрээний загвар (Хавсралт 4.21) | - |
| Нууц хадгалах гэрээ (Хавсралт 4.22) | Хөдөлмөрийн дотоод журмын хавсралт |

***ББСБ-ын баталгааны гэрээ /Төлбөрийн баталгаа гаргах/.*** (Хавсралт 4.23) Компанийн харилцагчтай байгуулдаг ББСБ-ын баталгааны гэрээний загварын дагуу Компани нь үүрэг гүйцэтгэгчийн хүсэлтээр төлбөрийн баталгаа гаргах, үүрэг гүйцэтгэгч нь ББСБ-ын баталгаанд шимтгэл төлөх, төлбөрийн нэхэмжлэх ирсэн тохиолдолд баталгааны үнийн дүнтэй тэнцэх хэмжээний зээл олгох төлбөр гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү баталгааны гэрээний загварыг хянаж үзэхэд гэрээний зүйл, баталгааны дүн, хугацаа, шимтгэл, ББСБ-ын баталгаа гаргах, төлбөр гүйцэтгэх, зээл олгох, үүрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, гэрээ дуусгавар болох түүнийг цуцлах нөхцөлүүд, баталгаа, маргаан шийдвэрлэх, хууль хэрэглэх, бусад зүйл гэх 9 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хуулийн 457-р зүйлд нийцсэн байна. Түүнчлэн Төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмын 3-р хавсралтаар ББСБ-ын баталгааны нэмэлт гэрээний загварыг баталсан бөгөөд тус загвараар Баталгааны гэрээний гол нөхцөлд өөрчлөлт оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна.

***Зээлийн эрх нээх гэрээний загвар. /Төлбөрийн баталгаа гаргах/*** (Хавсралт 4.24) Компанийн харилцагчтай байгуулдаг зээлийн эрх нээх гэрээний загварын дагуу ББСБ нь Зээлдэгчид зээлийн эрх нээж зээл олгох, түүний хугацаа, хүүгийн хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад ББСБ-ын зүгээс хяналт тавих, зээлийг буцаан төлүүлэх, Зээлдэгч нь ББСБ-ын зээлийн нөхцөлийг хүлээн



СЭНДЛИ ББСБ ХК
9022121175
УЛААНБААТАР ХОТ ХТУ5601 5555

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

2023 -01- 10
БҮРТГЭВ



зөвшөөрч, зээлийг авах, зээлийг буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү зээлийн эрх нээх гэрээний загварыг харахад гэрээний зүйл, гэрээний нөхцөл, зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн эрх үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, баталгаа зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлах, үүргийн гүйцэтгэлийг хангах, бусад зүйл гэх 8 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

***Барьцааны гэрээний загвар. /Төлбөрийн баталгаа гаргах/*** (Хавсралт 4.25). Компанийн харилцагчтай байгуулдаг барьцааны гэрээний загварын дагуу ББСБ, Үүрэг гүйцэтгэгчийн хооронд байгуулсан Зээлийн эрх нээх гэрээний дагуу Үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр ирүүлсэн нэхэмжлэхээр хийх төлбөрийн хугацаа болоход үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, төлбөрийн баталгаа гаргах, баталгааны төлбөрт шаардлагатай дүнгээр зээл олгосон тохиолдолд эрсдэлийг багасгах зорилгоор барьцаалах хөрөнгийг сонгох, тэдгээрийг үнэлэх, чанарыг тодорхойлох, барьцаалсан хөрөнгийг хадгалах хамгаалах, барьцаалуулагч баталгааны төлбөр, түүний эрсдэлийг шимтгэл, баталгааны төлбөрт шаардлагатай дүнгээр олгох зээл, түүний хүүгийн төлбөр, зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг хугацаандаа төлөгдөөгүй тохиолдолд талуудын хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү барьцааны гэрээний загварыг харахад нийтлэг үндэслэл, барьцааны зүйл, барьцаалуулагчийн эрх, үүрэг, ББСБ-ын эрх үүрэг, бусад зүйл гэх 5 бүлэг зохицуулалтыг тусгасан нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.

***Хөдөлмөрийн гэрээний загвар*** (Хавсралт 4.26). Компанийн хөдөлмөрийн дотоод журмын хавсралтаар ажил олгогч, ажилтны хооронд үүсэх хөдөлмөрийн болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулж буй "Сэндли ББСБ" ХК, /"Ажил олгогч"/-ын ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварыг баталжээ. Энэхүү загвар нь гэрээний зүйл, гэрээний гол нөхцөл, хугацаа, ажлын цаг, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, цалин ба нэмэгдэл хөлс олгох, нууцлал, оюуны өмч, гэрээг дуусгавар болох, цуцлах, хариуцлага хүлээлгэх, эд хөрөнгийн бүрэн хариуцлага болон бусад нөхцөлийг тогтоосон нийт 13 зүйл бүлэг зохицуулалтаас бүрдэж байна. Хөдөлмөрийн гэрээний загвар нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.

***Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар*** (Хавсралт 4.27). Компани нь ажилтанд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх зорилгоор байгуулдаг энэхүү гэрээний загвар нь нийтлэг үндэслэл, компанийн эрх, үүрэг, ажилтны эрх, үүрэг, хариуцлага, бусад зүйл гэсэн 5 бүлэг бүхий зохицуулалтаас бүрдсэн байна. Гэрээг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн харахад аливаа хуулийн зөрчил илрээгүй.

***4. Үнэт цаас гаргагч нь нэлээнгүй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөнтэй холбоотойгоор байгуулсан гэрээ, хэлцэл:***

***Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ.*** (Хавсралт 4.28) Үнэт цаас гаргагч нь 2022 оны 05 дугаар сарын 02-ний өдөр үнэт цаасны компани буюу андеррайтеруудтай хамтран Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгаа хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа буюу СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8-р зүйлд заасан хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд гүйцэтгэх, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхтэй холбогдон гарах харилцаа зохицуулсан дөрвөн талт гэрээ Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээг "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Стоклаб Секьюритиз ҮЦК" ХХК нартай байгуулжээ. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1, 8.2-д нийцсэн байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023 -01- 10
БҮРТГЭВ



***Бүртгэлийн гэрээ*** (Хавсралт 4.29). Үнэт цаас гаргагч нь 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Монголын хөрөнгийн биржтэй "Бүртгэлийн гэрээ" байгуулсан. Гэрээ нь Нийтлэг үндэслэл, Үйлчилгээний хөлс, Биржийн эрх, үүрэг, Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг, Хариуцлага, Бусад гэсэн 6 бүлэгтэй. Гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журамд нийцсэн байна.

***Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбоотой төлбөр гүйцэтгэх гэрээ*** (Хавсралт 4.30). Үнэт цаас гаргагч нь 2022 оны 9 дугээр сарын 23-ны өдөр Үнэт цаасны төлөрсөн хадгаламжийн төвтэй уг гэрээг байгуулсан. Гэрээ нь Нийтлэг үндэслэл, Хадгалуулсан үнэт цаасны нэр, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлс, Гэрээний хугацаа, Үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх, Хадгалуулагчийн эрх, үүрэг, Хадгалагчийн эрх, үүрэг, Талуудын хариуцлага, Гэрээ дуусгавар болох буюу түүнийг цуцлах, Бусад гэсэн 9 бүлэгтэй. Гэрээ нь Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцсэн байна.

***5. Нээлттэй өрийн хэрэгсэл гаргалттай холбоотой байгуулсан гэрээ, хэлцэл:***

***Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ*** (Хавсралт 4.31). ББСБ-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон завсар үеийн санхүүгийн тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын ажлыг хийж, гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар "Шонхор Үнэлгээ Аудит" ХХК-тай 2022 оны 12-р сарын 26-ны өдөр 22/110 тоот Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан байна. Тус гэрээнд ажлын хүрээ, талуудын харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлага, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг заасан байна. Гэрээ нь Иргэний хууль, Компанийн тухай хууль болон Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлд тус тус нийцсэн байна.

***Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ*** (Хавсралт 4.32). "Сэндли ББСБ" ХК-ийн МХБ-ээр олон нийтэд нээлттэй гаргах бондын төсөлд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг "Өлзий энд Ко Капитал ҮЦК" (үндсэн андеррайтер), "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК (туслах андеррайтер)-тай 2022 оны 12-р сарын 22-ны өдөр байгуулсан АГ 22/23 дугаартай гэрээгээр зохицуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг, дотоод мэдээлэл эзэмшигч, түүний үүрэг, маргаан шийдвэрлэх, бусад нөхцөлийг тодорхойлсон 8 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан байна.

Гэрээний 2.1, 2.3 дахь зүйлд зааснаар андеррайтер нь үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг зохион байгуулах, бондыг нээлттэйгээр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгох ажлыг зохион байгуулахдаа хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулах, бондыг тогтоосон үнийн аргаар санал болгон арилжаалах, үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбогдон гарах маркетинг сурталчилгааны ажил, танилцуулах аяна андеррайтеруудтай хамтран ажиллахаар тохиролцсон байна.

Үндсэн болон туслах андеррайтер (http://www.frc.mn/o/198521 http://www.frc.mn/o/6717 http://www.frc.mn/o/198494) нь үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй бөгөөд Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын 22-ны өдрийн 22/07 тоот тогтоол (Хавсралт 1.16)-ын дагуу гэрээ байгуулжээ. Гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3, 41.5 дахь хэсэг, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭСЭН

MDSKhanLex

***Бондын гэрээ*** (Хавсралт 4.33). ББСБ нь өрийн хэрэгсэл (цаашид "Бонд" гэх) гаргахтай холбогдуулан бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдах, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүргээ гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК (Үндсэн андеррайтер), "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Голомт Капитал ҮЦК" ХХК (туслах андеррайтер)-тай 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр №БОГ 22/01 тоот Бондын гэрээг байгуулсан байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын зохицуулалтад нийцсэн байна.

***Барьцааны гэрээ*** (Хавсралт 4.34). "Монголын Финтек групп" ХК нь ББСБ-ийн 2022 оны 12 сарын 22-ны өдөр байгуулсан "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх 22/23 тоот гэрээтэй холбогдон Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр №БГ-22/27 тоот Барьцааны гэрээг байгуулсан байна.

***6. Зээлийн гэрээнүүд:***

***"Монголын финтек групп" ХХК болон "Гэлс кредит ББСБ" ХХК нарын хооронд 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулагдсан Зээлийн шугамын гэрээ*** (Хавсралт 4.35)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Зээл олгох валют: төгрөг
- Зээлийн хугацаа: 24 сар

Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 87-р зүйлийн 87.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл, мөн Компанийн тухай хуулийн 89-р зүйлийн 89.1 дэх хэсэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд нэгэн зэрэг хамаарч байна. Компанийн тухай хуулийн 92.5 дахь хэсэгт "Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд ... түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ хуулийн 92.3-т заасны дагуу батлуулах шаардлагагүй" гэж заасан байдаг.

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 09 (Хавсралт 4.36) тоот "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоолоор уг зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Олгэрэлд олгосон байна. "Монголын финтек групп" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранбат гарын үсэг зурсан байна. Компанийн тухайн үеийн санхүүгийн тайлангийн мэдээллээс үзвэл энэхүү зээлийн шугамын гэрээний үнийн дүн нь хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас их буюу их хэмжээний хэлцэл гэж үзэхээр байна. Энэхүү тогтоол нь 88.1 дэх хэсэгт заасан их хэмжээний хэлцэл хийх журамд нийцсэн ба Сэндли болон түүний толгой компани болох "Монголын финтек групп" ХХК-ийн хооронд 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн шугамын гэрээ нь хүчин төгөлдөр байна.

Энэ гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн таа ба түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд хамаарч байгаа болно.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022121
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ 3-02

MDSKhanLex

***Капитрон банк болон "Сэндли ББСБ" ХХК нарын хооронд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулагдсан 3096-2022/59 тоот Зээлийн гэрээ /зээлийн шугам/.*** (Хавсралт 4.37)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг
- Зээлийн зориулалт: эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Нэмэгдүүлсэн хүү: үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 12 сар
- Хариуцлага: Зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нь зээлийн төлбөрийг энэ гэрээний Хавсралтад заасан хуваарийн дагуу тухай бүр төлөхөөр банктай ..... энэхүү хуваарийн дагуу зээл, түүний хүү төлөгдөөгүй бол зээл хугацаандаа төлөгдөөгүй гэж үзэх үндэслэл болно /5.1/
- Эргэн төлөлт: зээлийн гэрээний хугацаанд сарын 15-ны өдөр

Гэрээнд зээлийн дүн, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл олгох, эргэн төлөх хэлбэр, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, баталгаа ба зөвшөөрөл, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3096-2022/59 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Капитрон банктай 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан 3096-2022/59 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ байгуулжээ.

Энэ гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд хамаарч байгаа болно.

***Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер.*** (Хавсралт 4.38) Компани нь "Мони Маркет Фанд" ХХК-тай мөнгөн хөрөнгийн чөлөөт эх үүсвэрийн хэрэгцээтэй үед хуулийн этгээдээс зээл авах, зээл олгохтой холбоотой харилцааг зохицуулах ерөнхий тохиролцоотой холбоотой Зээл олгоход зуучлах, репо хэлцэл хийх мастер гэрээг 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээгээр репо арилжааны нөхцөл, гүйлгээ, хариуцлагыг зохицуулсан нь Иргэний хуулийн 281 дүгээр зүйл болон 451 дүгээр зүйлд заасан ерөнхий шаардлага, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д нийцсэн байна. Үнэт цаас гаргагч нь уг арилжаанд зээл авах байдлаар оролцдог байна.

***Худалдаа Хөгжлийн банк болон "Сэндли ББСБ" ХХК нарын хооронд 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан №ЗЭНГ/СС221202003-1 тоот Зээлийн эрх нээх гэрээ.*** (Хавсралт 4.39)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: Зээлийн үйлчилгээ, бусад санхүүгийн үйлчилгээг санхүүжүүлэх
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Нэмэгдүүлсэн хүү: үндсэн хүүгийн 20 хувь
- Зээлийн хугацаа: 12 сар
- Хариуцлага: Гэрээний хугацаа дуусахад зээлдэгч зээл, түүний хүүг бүрэн төлөөгүй буюу ... барьцаа, баталгааны гэрээнд заасны дагуу барьцааны зүйлийг захиран зарцуулах журмаар худалдан борлуулж, зээл, түүний хүүгийн төлбөрийг барагдуулна. /8.1/



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

Энэхүү гэрээгээр зээл олгох, түүний хугацаа, үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү, нэмэгдүүлсэн хүүний хэмжээг тогтоох, зээлийн зарцуулалтад хяналт тавих, зээл, түүнийг хүүг буцаан төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан зээлийн дүн 1,000,000,000 төгрөгийг 2,170,000,000 төгрөг болгож 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр №ЗЭНГ/CC221202003-1-1 тоот Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ байгуулсан. Зээлийн эрх нээх гэрээ, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах нэмэлт гэрээ байгуулагдсантай холбоотойгоор үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгон Худалдаа Хөгжлийн банктай 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр №ЗБ-CC221202003-1-1 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.40)-г байгуулсан байна.

Энэ гэрээ нь Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнд хамаарч байгаа болно.

***7. Репо зээлийн гэрээнүүд:***

Үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар одоогоор хэвийн хэрэгжиж байгаа 4 репо зээлийн гэрээ, тэдгээр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг тус тус байгуулсан байна. Үүнд:

| № | Гэрээ байгуулагч тал | Зээлийн гэрээний огноо, дугаар | Зээлийн хугацаа | Зээлийн үнийн дүн /төгрөг/ | Барьцаа |
|---|---|---|---|---|---|
| 1. | Мони Маркет Фанд ХХК | 2022.12.01, 20221201-36-19/14-69 (Хавсралт 4.41) | 42 хоног | 500,000,000 | Мони Маркет Фанд ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр B-20221201-36-19/14-69 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.42). |
| 2. | Мони Маркет Фанд ХХК | 2022.12.20, 20221220-36-20/14-70 (Хавсралт 4.43). | 28 хоног | 100,000,000 | Мони Маркет Фанд ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр B-20221220-36-20/14-70 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.44). |
| 3. | Мони Маркет Фанд ХХК | 2022.12.20, 20221220-36-21/14-71 (Хавсралт 4.45). | 28 хоног | 80,000,000 | Мони Маркет Фанд ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр B-20221220-36-21/14-71 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.46). |
| 4. | Мони Маркет Фанд ХХК | 2022.12.23, 20221223-36-22/14-72 (Хавсралт 4.47). | 28 хоног | 80,000,000 | Мони Маркет Фанд ХХК-тай 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр B-20221223-36-22/14-72 тоот барьцааны гэрээ байгуулжээ (Хавсралт 4.48). |



СЭНДЛИ ББСБ ХК

2022 оны 12-р сарын 26-ны өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаанаас үзэхэд Худалдаа хөгжлийн банк, Капитрон банктай байгуулсан зээлийн шугамын гэрээнүүд нь хэвийн (Хавсралт 4.49) ангилалд байна.

Одоогоор дээр дурдсан зээлийн гэрээнээс өөр хүчин төгөлдөр үйлчилж буй зээлийн гэрээ байхгүй, тэдгээр гэрээний үүргийн гүйцэтгэл хэвийн хэрэгжиж байгаа ба сүүлийн 3 жилд байгуулсан бусад бүх зээлийн гэрээ зохих ёсоор хэрэгжиж дууссан болохыг Компанийн Гүйцэтгэх захирлын албан бичгээр мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

**Өрийн хэрэгсэл.**

Компани нь нээлттэй, хаалттай өрийн хэрэгсэл гаргаагүй болно (Хавсралт 12.1).

***8. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:***

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний 5 хувь нь 2022 оны 6 сараас хойш тасалбар болгох өдрийн байдлаар 391,425,000 төгрөгөөс дээш, 2022 оны 6 сараас өмнөх 321,425,000 төгрөгөөс дээш, 2021 онд 71,425,000 төгрөгөөс дээш, 2020 онд 71,425,000 төгрөгөөс дээш, 2019 оны 06 сараас хойш 71,425,000 төгрөгөөс дээш, 2019 оны 6 сараас өмнө 50,000,000 төгрөгөөс дээш үнийн дүн) бүхий үүрэг хүлээсэн нийт 8 гэрээ байгуулсан.

Тэдгээрээс дээр дурдсан зарим гэрээ, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг оруулан доор дурдсан нийт 7 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байгаа талаар Компанийн Гүйцэтгэх захирал 2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн албан бичиг (Хавсралт 12.1)-ээр бидэнд мэдэгдсэн.

| № | Гэрээний дугаар | Гэрээний огноо | Гэрээний нэр | Үнийн дүн /төгрөг/ | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | ЗГ/211027 | 2021.10.27 | Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.50) | 110,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 2. | - | 2021.07.05 | Зээлийн шугамын гэрээ гэрээ ([illegible] үзнэ үү) | 5,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 3. | 3096-2022/59 | 2022.04.15 | Зээлийн шугамын гэрээ гэрээ ([illegible] үзнэ үү) | 1.500.000.000 | Хэрэгжиж байгаа |
| 4. | ИГ22/01 | 2022.01.28 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.51) | 656,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 5. | ИГ18/02 | 2021.12.06 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.10) | 100,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 6. | ИГ18/01 | 2021.10.10 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 5-аас дэлгэрэнгүй танилцана уу) | 2,450,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 7. | СО-22/04 | 2022.05.02 | Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ ([illegible] үзнэ үү) | 1,000,000,000 | Хэрэгжиж дууссан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8. | №ЗЭНГ/С С22120200 3-1, №ЗЭНГ/С С22120200 3-1-1 | 2022.12.05, 2022.12.06 | Зээлийн эрх нээх гэрээ ([illegible] дэлгэрэнгүйг үзнэ үү.) | 2,170,000,000 | Хэрэгжиж байгаа |

Дээр дурдсан гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзэв.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан түүний үйл ажиллагаандголлох эсвэл холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн байна.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

5. [illegible]

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй доор дурдсан хэлцлүүдийг өргөлсөнийг хянав.

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний агуулга | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй аль болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1. | "Монголын финтек групп" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 09 тоот "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" шийдвэрээр зөвшөөрөл олгосны дагуу Компани нь өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор толгой компаниасаа зээл авах, түүнийг буцаан төлөхтэй холбоотой харилцааг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр 5 тэрбум төгрөгийн Зээлийн шугамын гэрээ (Хавсралт 4.32) байгуулсан. | Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 2. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Hi-Pay" аппликэйшнаар дамжуулан ББСБ-аас зээлдэгч нарт олгосон зээлийн мөнгөн хөрөнгийг "Hi-Pay" дансанд шилжүүлэх, бүртгэл хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Н-21/11 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.2)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 3. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу гэрээгээр тохиролцсон нууц мэдээллийг | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022 ... УЛААНБААТАР ХОТ ... 5961568

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 18
БҮРТГЭВ



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглах, хадгалах, түгээхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Н-21/12 тоот Нууцлалын гэрээ (Хавсралт 5.3)-г байгуулсан. | | | |
| 4. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу "Hi-Pay" аппликэйшн болон QR-аар дамжуулан бараа, үйлчилгээний төлбөрийг хүлээн авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр 21-01/38 тоот Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг (Хавсралт 5.4)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 5. | "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 04 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.1)-оор зөвшөөрөл олгосны дагуу Компани нь өөрийн цахим үйлчилгээгээр дамжуулан нөгөө талын Автопэй үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, автоматаар бараа, үйлчилгээний төлбөр авахтай холбоотой харилцааг зохицуулахаар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр S21-01/01 тоот Мерчанттай "Автопэй" үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.5)-г байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 6. | "Монн маркет финанс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.6)-оор зөвшөөрөл олгосны дагуу репо зах зээлд платформоор дамжуулан оролцох, бусад ББСБ-аас зээл авахтай холбоотой харилцааг зохицуулах 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр М-МГ21/16 тоот Зээл авахад зуучлах, репо зээлийн мастер гэрээ | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



СЭНДЛИ ББСБ ХК
9022121175 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

MDSKhanLex

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | (Хавсралт 5.7, Хавсралт 4.37)-г байгуулсан. Мөн энэхүү гэрээнд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ББСБ нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөн зарим нөхцөлийг өөрчилж нэмэлт өөрчлөлт (Хавсралт 5.8) оруулсан байна. | | | |
| 7. | "Техбокс" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 10 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.9)-оор Зээлдэгч ББСБ-аас авсан зээлийн хөрөнгөөр Худалдаа эрхлэгчээс бараа худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулах 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдөр 03 тоот Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.10)-г байгуулсан | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж дууссан |
| 8. | "Техбокс" ХХК болон "Хай пэймэнт солюшнс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 07 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.11, 5.12)-оор зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Техбокс ХХК-тай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.11)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 9. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Үндэсний ухаалаг шийдэл" | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.13)-г байгуулжээ. | | | |
| 10. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Зочил технологи" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.14)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжихгүй байгаа |
| 11. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Цэцэгт мэндчилгээ" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрө л олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.15)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжихгүй байгаа |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ
5961348

СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Моду лабс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.13)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.16)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 13. | "Хай пэймэнт солюшнс" ХХК болон "Ундрам Хан Хангай" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.12)-аар "Хай пэймэнт солюшнс" ХХК, түүний мерчант байгууллагуудтай хамтран ажиллах зорилгоор гэрээ байгуулах зөвшөөре л олгосон. "Хай пэймэнт солюшнс" ХХК нь Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээг Мерчанттай байгуулсан ба энэхүү гэрээнд ББСБ нэмэлт оролцогч тал болсонтой холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Мерчант /ЦМХА/-тай хамтран ажиллах гэрээнд ББСБ нь оролцогч болсон нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 5.17)-г байгуулжээ. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 14. | "Датапуул Монголиа" ХХК | Компанийн ХЭХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 22 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" шийдвэр (Хавсралт 5.18) ээр зөвшөөрөл олгосны дагуу Компани нь зэргэлдээ компанийн мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдахтай холбоотой харилцаа 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдөр | Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭВ
2023 -01- 10
БҮРТГЭ



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2,450,000,000 төгрөгийн Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 5.19) байгуулсан. Зах зээлийн нөхцөл байдлын улмаас хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үр ашгийн хүүг багасгаж 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр НГ18/01-1 тоот Нэмэлт гэрээ байгуулжээ (Хавсралт 5.19). | | | |
| 15. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.6)-оор зөвшөөрөл олгосны дагуу нийт 10 удаа[2]-гийн Репо зээлийн гэрээг "Мони маркет фанд" ХХК-тай байгуулсан байна. Ийнхүү энэхүү Репо зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахаар тухай бүр Барьцааны гэрээ байгуулсан байна (Хавсралт 5.21). | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж дууссан |
| 16. | "Мони маркет фанд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.6)-оор зөвшөөрөл олгосны дагуу 2022 оны 10 сараас хойш нийт 4 удаагийн Репо зээлийн гэрээ, түүний барьцааны гэрээг Мони маркет фанд ХХК-тай байгуулсан. *(Андеррайтерийн зөвлөх гэрээний 4 дүгээр хэсгээс үзнэ үү)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 17. | "Райнос инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/10 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.22)-оор зөвшөөрөл олгосны дагуу Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээг "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай байгуулсан. *(Андеррайтерийн зөвлөх гэрээний 4 дүгээр хэсгээс* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

[2] 20220609-36-3/14-33, 20220922-36-15/14-56, 20220906-36-14/14-53, 20220809-36-12/14-45, 20220728-36-11/14-41, 20220708-36-10/14-40, 20220706-36-8/14-39, 20220706-36-7/14-38, 20220610-36-6/14-34, 20221004-36-16/14-60 дугаартай Репо зээлийн гэрээ, Барьцааны гэрээнүүд багтана.



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үзнэ үү.) | | | |
| 18. | "Райнос инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/10 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.22)-оор зөвшөөрөл олгосны дагуу Бондын гэрээг "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай байгуулсан. *(Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 4 дүгээр хэсгээс үзнэ үү.)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |
| 19. | "Райнос инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22/10 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай" тогтоол (Хавсралт 5.22)-оор зөвшөөрөл олгосны дагуу Андеррайтер үйлчилгээ үзүүлэх гэрээг "Райнос инвестмент ҮЦК" ХХК-тай байгуулсан. *(Дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 4 дүгээр хэсгээс үзнэ үү.)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 31 хэлцэл хийсэн бөгөөд тус гэрээнүүдээс 11 нь хэрэгжиж дууссан, 20 нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж байгаа, ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Түүнчлэн, дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 20 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Сонирхлын зөрчилтэй зарим хэлцэл хийх зөвшөөрлийг ХЭХ-аар шийдвэрлэсэн ба тухайн үед нэг хувьцаа эзэмшигчтэй байсан тул Компанийн хуулийн дагуу хурлын тэмдэглэл шаардахгүй гэж үзлээ.

***Их хэмжээний хэлцлийн талаар:***
Компанийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангаар актив нь 10,275,279,231.14 төгрөг байна. Компанийн тухай хуулийн 87-д заасны дагуу их хэмжээний хэлцэл нь сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% дараах байдлаар байна.

- **2019 оны хэлцэл - 318,472,439.6425 төгрөгөөс дээш (2018 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 1,273,889,758.57)**
- **2020 оны хэлцэл - 350,919,852.745 төгрөгөөс дээш (2019 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 1,403,679,410.98)**
- **2021 оны хэлцэл - 452,301,983.58 төгрөгөөс дээш (2020 оны санхүүгийн тайлан нийт 1,809,207,934.32)**
- **2022 оны хэлцэл - 2,568,819,807.785 төгрөгөөс дээш (2021 оны санхүүгийн тайлан нийт 10,275,279,231.14)**

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ

MDSKhanLex

Компанийн их хэмжээний хэлцлийн хувьд Дээрх хүснэгтийн 1, 14-д дурдсан хоёр хэлцэл нь одоогоор хэрэгжиж байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй болохыг Компанийн гүйцэтгэх захирал (Хавсралт 12.1) бидэнд мэдэгдсэн.

Үнэт цаас гаргагч нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах талаар Компанийн тухай хуульд заасан журмыг мөрдөж ажилласан гэж дүгнэв.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, оюуны өмчийн эрх, патент, барааны [illegible] хүчин төгөлдөр эсэх, [illegible] [illegible] хангах [illegible] гаргагчийн үйл ажиллагаанд нь болзошгүй нөлөөлөл болохуйц нөхцөл бий эсэх

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 318 дугаар тогтоол (Хавсралт 6.1)-оор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ 101/498 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.1), 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 62 дугаар тогтоолоор Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 6.2), мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 441 дүгээр тогтоолоор Банк бус санхүүгийн санхүү факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг (Хавсралт 6.3) тус тус авсан. Эдгээр нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.1 дэх заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1-д заасан тусгай зөвшөөрөл авах шаардлагыг нийцэж байна.

Компанийн нэр дээр байх дээрх Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчинтэй эсэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаар бид 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Д-22/318 тоот албан бичиг Санхүүгийн зохицуулах хороонд илгээсэн боловч дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариу ирээгүй байна.

Компанийн хэрэглээ компани болох "Хай пэймэнт солюшнс" ХХК-д цахим мөнгө гаргах төлбөрийн үйлчилгээ зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар олгосон. Уг зөвшөөрлийн үндсэн дээр ББСБ болон "Хай пэймэнт солюшнс" ХХК нар тогтмол хамтран ажилдаг байна (Хавсралт 6.13, 6.14).

Компанийн СЗХ-оос авсан дээр дурдсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүд нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр, түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүсээгүй байна.

***Оюуны өмч***

Оюуны өмчийн газрын барааны тэмдгийн гэрчилгээ болон Оюуны өмчийн газрын барааны тэмдгийн цахим бүртгэлийн 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хайлтаар (Хавсралт 6.5, 6.6, 6.7, 6.8)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК ("Гэлс кредит ББСБ" ХХК)-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй. Компанийн нэр дээр дараах барааны тэмдгийг бүртгүүлсэн байна:

| № | Утга /тэмдэг/ | Мэдүүлгийн дугаар | Улсын бүртгэлийн дугаар | Хүчинтэй хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | Sendly | 40-2020-0025416 | 40-0022102 (Хавсралт 6.9) | 2030.01.22 |



СЭНДЛИ ББСБ ХК
9022121175
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
оны сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭЛ-02



| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | sendly | 40-2020-0026084 | 40-0022687 (Хавсралт 6.10) | 2030.05.13 |
| 3. | send | 40-2020-0027152 | 40-0025585 (Хавсралт 6.11) | 2030.10.20 |
| 4. | syndly | 40-2021-0028919 | 40-0024867 (Хавсралт 6.12) | 2031.06.23 |
| 5. | Сэндли | 40-2022-0031344 | 40-0026807 (Хавсралт 6.6) | 2032.06.13 |
| 6. | Сэнд | 40-2022-0031343 | 40-0026806 (Хавсралт 6.6) | 2032.06.13 |
| 7. | Sendly | 40-2022-0031345 | 40-0026808 (Хавсралт 6.6) | 2032.06.13 |

**Дээрх 7 барааны тэмдгийн өмчлөх, эзэмших эрх нь хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр эрхээ хэрэгжүүлэхэд бодитой нөлөөлж болох нөхцөл илрээгүй талаар Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).**

***Домэйн нэр.*** **Компанийн www.sendly.mn домэйн нэр нь 2027 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл хүчинтэй байна (Хавсралт 6.15).**

**Дээр дурдсаны дагуу Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээх зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бий болоогүй байна.**



СЭНДЛИ ББСБ ХК
9022121175
УЛААНБААТАР ХОТ

***Үнэт цаас.***

Компани нь Англи Улсад үүсгэн байгуулагдсан охин компанийн хувьцааг эзэмшдэг ба аливаа өөр үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус Компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).Үүнд:

| "СЭНДЛИ ББСБ" ХК | | | |
|---|---|---|---|
| **№** | **Хувьцаа эзэмшигчдийн нэрс** | **Эзэмших хувь** | **Зээлийн гэрээний дагуу барьцаалагдсан эсэх** |
| 1 | Мон ремит лимитед компани (Хавсралт 7.4) | **100%** | **Үгүй** |

Охин компани нь Англи улсад төлбөрийн үйлчилгээтэй холбоотой тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эрхэлж байна[3]. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Охин компанийн хувьцааг худалдах тухай" 09 тоот шийдвэр (Хавсралт 7.5)-ээр Компанийн 100%-ийн охин компани болох Англи улсад бүртгэлтэй "Мон ремит" компанийн хувьцааг худалдахаар шийдвэрлэсэн. Хувьцаа шилжүүлэх ажил дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэлэлцээрийн түвшинд байна.

***Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө.*** (Хавсралт 7.1)

| **№** | **Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн төрөл** | **Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр, дугаар** | **Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх** |
|---|---|---|---|
| 1. | Банкны данс, бусад эдийн бус хөрөнгө | ХААН Банк дахь 5176387172 тоот данс болон бусад банк дахь харилцах, мөнгөн хадгаламжийн дансдын орлого, 150 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК-тай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20221223-36-22/14-72 тоот Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.47), №В-20221223-36-22/14-72 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 4.48)-ний дагуу барьцаалсан. |
| 2. | Хэвийн зээлийн багц | Сэндли ББСБ ХХК-ийн 2022/02/28-ний өдрийн 2122 зээлдэгчийн мерчантын хэвийн зээлийн багц | Капитрон банк ХХК-тай байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 3096-2022/59 дугаар Зээлийн шугамын гэрээ, 3096 2022/59 тоот Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцаалсан. |
| 3. | Банкны данс, бусад эдийн бус хөрөнгө | ХААН Банк дахь 5176387172 тоот данс болон бусад банк дахь харилцах, мөнгөн хадгаламжийн дансдын орлого, | "Мони Маркет Фанд" ХХК-тай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 20221220-36-20/14-70 тоот Репо зээлийн гэрээ (Хавсралт |

[3] Payment services / electronic money status https://register.fca.org.uk/s/firm?id=0010X00004T6zgQQAR

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



| | | | |
|---|---|---|---|
| | | 150 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | 4.43), №B-20221220-36-20/14-70 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 4.44)-ний дагуу барьцаалсан. |
| 4. | Авлага, төлбөрийн бусад эрхүүд | Ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө | "Худалдаа Хөгжлийн банк"-тай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн №ЗЭНГ/CC221202003-1 тоот Зээлийн гэрээ (Хавсралт 4)-ний үүргийн гүйцэтгэл хангах зорилгоор барьцаалсан. |
| 5. | Банкны данс, бусад эдийн бус хөрөнгө | ХААН Банк дахь 5176387172 тоот данс болон бусад банк дахь харилцах, мөнгөн хадгаламжийн дансдын орлого, 750 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК-тай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 20221201-36-19/14-69 тоот Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.41), №B-20221201-36-19/14-69 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 4.42)-ний дагуу барьцаалсан. |
| 6. | Банкны данс, бусад эдийн бус хөрөнгө | ХААН Банк дахь 5176387172 тоот данс болон бусад банк дахь харилцах, мөнгөн хадгаламжийн дансдын орлого, 120 сая төгрөгийн үлдэгдэл дүн бүхий хэвийн зээлийн багц | "Мони Маркет Фанд" ХХК-тай байгуулсан 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 20221220-36-21/14-71 тоот Репо зээлийн гэрээ (Хавсралт 4.45), B-20221220-36-21/14-71 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 4.46)-ний дагуу барьцаалсан. |

**Дүгнэлт гаргах өдрийн байдлаар дээр дурдсанаас өөр Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө байхгүй байна.**

**Компанийн санхүүгийн тайлан болон Гүйцэтгэх захирлын бичигт заасныг үзвэл Үнэт цаас гаргагчийн хэвийн зээлийн багцын дүн 16.3 тэрбум төгрөг байна (Хавсралт 12.1).**

***Тээврийн хэрэгсэл.*** Компани нь 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нийт 11 тээврийн хэрэгслийг өмчилдөг (Хавсралт 7.2) бөгөөд эдгээр нь аливаа байдлаар барьцаалагдаагүй байна. Компани нь эдгээр 11 тээврийн хэрэгслийг бүгдийг нь фидуцийн гэрээний дагуу өмчилж байгаа бөгөөд компанийн өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгсэл байхгүй байна. (Хавсралт 12.1)

***Газар эзэмших эрх.*** Компани нь аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй болохыг Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 12.1)

***Үл хөдлөх эд хөрөнгө.*** УБЕГ-ын Эд хөрөнгийн бүртгэлийн 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн албан бичиг (Хавсралт 7.3)-ээр Компани нь аливаа үл хөдлөх хөрөнгө өмчилдөггүй (Хавсралт 12.1).



СЭНДИ ББСБ ХК
Sendly
9022121175 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ

2023-01-10



[illegible]

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулж авсан баримт материалтай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан огноо, оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргах шийдвэр /үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох үнэ, нөхцөл, татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт г.м/;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл;
- Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл;
- Нээлттэй хүрээнд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;
- Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээлэл;
- Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого;
- Тухайн үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд оролцож байгаа зохицуулалттай этгээд, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй (үндсэн андеррайтер, аудит, хууль, үнэлгээний байгууллага) этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай талаар.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, зээлжих зэрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн судалгаа, төлөвлөгөө зэрэгт агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, санхүүгийн төсөөлөл, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүхэн замнал, ололт, амжилт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, бизнесийн төлөвлөгөө, үнэт цаас захиалга авах, худалдах, арилжих нөхцөл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд МДСХ дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгасан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.**



СЭНЛЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



[illegible]

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 2290002005073 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 1.18), 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2290002005092 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 1.19)-г гаргуулан судалсан.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Монгол улсад бүртгэлтэй "Сэндли ББСБ" ХК-ийн дэлгэрэнгүй лавлагаа, Үнэт цаас эзэмшигчдийн судалгаанаас харахад (Хавсралт 1.19, Хавсралт 1.18) уг компанийн хувьцааг 3293 хүн, хуулийн этгээд эзэмшиж байна. Компанийн хувьцааны хяналтын багцыг буюу 56.42% хувийг "Монголын финтек групп" ХК эзэмшиж байна (Хавсралт 1.18, 1.19).

"Монголын финтек групп" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 41 тоот хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр батлагдсан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй дүрмээс үзвэл тус компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 76.6%-ийг Монгол Улсын хуулийн этгээд "Монголиан мючуал финанс групп" ХХК, үлдсэн хувьцааг Компанийн бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна (Хавсралт 9.1, Хавсралт 9.2).

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн саналын эрхтэй энгийн хувьцааны 0.77%-ийг "Радикс технологи" ХХК, 8.95%-ийг "Сэндли Эмплойе" ХХК, 29.97%-ийг олон нийт буюу бусад жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна (Хавсралт 1.19). "Радикс технологи" ХХК-ийн дүрмийн 5.2.1-д зааснаар нийт гаргасан энгийн хувьцааны 22%-ийг "Монголиан мючуал финанс групп" ХХК эзэмшиж байгаа (Хавсралт 9.6, Хавсралт 9.7). "Сэндли Эмплойе" ХХК-ийн дүрмийн 7.1-т зааснаар компанийн цорын ганц хувьцаа эзэмшигч нь "Монголиан мючуал финанс групп" ХХК байна (Хавсралт 9.8, Хавсралт 9.9).

"Монголиан мючуал финанс групп" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан, дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй дүрмийн 6.2-д зааснаас үзвэл, тус компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 100%-ийг Сингапур улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд болох Монгол Мючуал Пте. Лтд эзэмшиж байна. (Хавсралт 9.3, Хавсралт 9.4)

"Монгол Мючуал" Пте. Лтд-ийн хувьцааг доор дурдсан хувьцаа эзэмшигчид /хувь хүмүүс/ эзэмшиж байна. (Хавсралт 9.5) Үүнд:

| № | Овог, нэр/ Хуулийн этгээдийн нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | Баттулгын Наранбат | 70% |
| 2 | Мөнхтөрийн Цолмон | 30% |

Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн өндөр бүхий хувь хүн (хүмүүс) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Дээрх бүх анализын үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар "Монгол Мючуал" Пте. Лтд-ийн 70 хувийг эзэмшигч, Сэндли ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга Баттулгын Наранбат, "Монгол Мючуал" Пте. Лтд-ийн 30 хувийг эзэмшигч, Сэндли ББСБ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн Мөнхтөрийн Цолмон нар нь хамтдаа "Сэндли ББСБ" ХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч гэж үзэв.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



***Эцсийн өмчлөгч***

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг алдаа хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байх үүрэгтэй.

Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзэхэд, Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчөөр "Монголын финтек групп" ХК-ийг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна (Хавсралт 1.19). Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д "эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг ойлгоно гэж заасан. "Монголын финтек групп" ХК-ийг эцсийн өмчлөгчөөр бүртгэсэн нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасны эцсийн өмчлөгч нь "...хүн" байна гэсэнтэй нийцэхгүй байна.

Зөвлөхийн зүгээс Компанийн хяналтыг хэрэгжүүлэгчийн талаар хийсэн дээр дурдсан дүн шинжилгээг үндэслэн Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь Монгол Улсын иргэн Баттулгын Наранбат гэж үзэж болохоор байна.

Энэхүү дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022121 ... 5961048
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

[illegible]

***Эрүүгийн хэрэг***

Бид Үнэт цаас гаргагч эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагааг шалгаж авахаар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Д-22/319 тоот албан бичгийг Цагдаагийн Ерөнхий Газар Мэдээлэл, Дүн Шинжилгээ, Шуурхай Удирдлагын Албанд хүргүүлсэн боловч дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариу ирээгүй байна. Харин тус байгууллагын өмнө бидэнд ирүүлж байсан 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 86/470 (Хавсралт 10.1) тоот албан бичигт заасанаас үзвэл, "Сэндли ББСБ" ХХК-ийг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас шалгахад мэдээлэл бүртгэгдээгүй байна" гэжээ.

***Иргэний хэрэг***

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 1/3616 тоот албан бичиг (Хавсралт 10.2)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байгаагүй байна. Түүнчлэн Гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 12.1)-т дурдсанаар сүүлийн 3 жилийн хугацаанд 3 иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцож байсан бөгөөд үүнээс иргэн Г.И-д холбогдох 591,869,589 төгрөгийн үнийн дүн бүхий "Сэндли ББСБ" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагатай 1 иргэний хэрэг Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 4/1941 тоот Тодорхойлолт (Хавсралт 10.3)-д тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Бид Улаанбаатар хотын худалдааны танхимын дэргэдэх Улаанбаатар үндэсний ба олон улсын эвлэрүүлэн зуучлах арбитрт Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцож, шийдвэрлэгдсэн эсхүл одоо хянагдаж байгаа иргэний маргаан байгаа эсэх талаар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Д-22/322 тоот албан бичиг илгээсэн боловч дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариу ирүүлээгүй байна.

***Захиргааны хэрэг***

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 3049 тоот албан бичиг (Хавсралт 10.4)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилийн хугацаанд оролцож байгаагүй байна.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

***Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа, шинжилгээ***

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн зарим хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 01/2141 тоот албан бичиг (Хавсралт 10.5)-т тусгаснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.6-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийг зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоогоогүй байна. Мөн 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчид Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр захиргааны шийтгэл оногдуулж байгаагүй байна.
- "Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо"-ноос 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гаргасан 2022/50 тоот албан бичиг (Хавсралт 10.6)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь "Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо" -ны гишүүн бөгөөд гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж хариуцлага хүлээж байгаагүй байна.
- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр гаргасан 02/1858 тоот албан бичиг (Хавсралт 10.7)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК нь 2022 оноос "Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ"-г байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй байна.
- Монголын хөрөнгийн биржийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр гаргасан 01/704 тоот албан бичиг (Хавсралт 10.8)-т тусгаснаар "Сэндли ББСБ" ХК-ийн үнэт цаасыг 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Биржид бүртгэсэн бөгөөд Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дүгнэж, илгээхээр мэдэгдсэн талаар дурдсан.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд аж ахуйн үйл ажиллагааны эрүүгийн хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй байна.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР

СЗХ
он … сар … өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -01- 10
БҮРТГЭВ

MDSKhanLex

[illegible]

Компани нь 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад 7,553,605.31 төгрөгийн илүү төлөлттэй, 2,492,061.25 төгрөгийн дутуу төлөлттэй (Хавсралт 11.1) байна.

Компанийн зүгээс дээр дурдсан дүн бүхий татварын үлдэгдлийг компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц "их хэмжээний өр" гэж үзэхээргүй байна (Хавсралт 12.1).

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 12-р сарын 26-ны өдрийн Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт (Хавсралт 11.2)-д заасанаар Үнэт цаас гаргагч нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй, 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар Гаалийн ерөнхий газрын тодорхойлолтоор гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 11.3), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гаргасан Тодорхойлолт (Хавсралт 11.4)-оор шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанид гааль, нийгмийн даатгал, татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги оногдуулаагүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй байна (Хавсралт 12.1).

**ХҮНДЭТГЭСЭН,**

**"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН**

**ГИШҮҮН, ХУУЛЬЧ**

**Д.ДҮГЭРЖАВ**



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

/Хуулийн нэмэлт дүгнэлт/

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

MDSKhanLex

2023-01-10

2023.01.09 № 23/01

**"СЭНДЛИ ББСБ" ХК,**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТАНАА**

## ХУУЛЬ ЗҮЙН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

**Энэхүү дүгнэлт нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.5, 11.4-т дурдсаны дагуу "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ээс 2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн Д-22/328 албан бичгээр хүргүүлсэн "Сэндли ББСБ ХК-иас өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн хууль зүйн дүгнэлт" (цаашид "Хууль зүйн дүгнэлт" гэх)-ийн салшгүй хэсэг болно.**

**Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай 22/07 тоот тогтоолд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор энэхүү нэмэлт дүгнэлтийг гаргаж байна.**

**Энэхүү нэмэлт дүгнэлтэд ашигласан нэр томьёо нь Хууль зүйн дүгнэлтэд тодорхойлсонтой ижил болно.**

***Нэг. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх талаар.***

**"Сэндли ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 01 тоггоол (Хавсралт 1.1)-ын нэгдүгээр хавсралтаар нийтэд санал болгон гаргах нээлттэй бондын нөхцөлд дараах өөрчлөлтийг оруулжээ.**

| | |
|---|---|
| Бондын үнийн дүн | **8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөг** |
| Бондын нийт тоо, ширхэг | **85,000** |
| Хүүгийн төлбөр тооцоолох аргачлал | **Жилийн хүүг 365 хоногоор тооцох ба бондын хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 3 сарын дараах мөн өдөр төлнө. Хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх бөгөөд энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй ба дараагийн хүүг мөн өдрөөс эхлэн тооцно.** |
| **Бондыг эргүүлэн худалдан авах үнэ** | **Бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн нийлбэр дүн байна.** |
| **Бондын барьцаа** | **Бондын эргэн төлөлтийн баталгааг тус компанийн толгой "Монголын финтек групп" ХК-ийн эзэмшилд буй 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг буюу 16,8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцаагаар бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангана.** |
| Бондын батлан даалт | **"Монголын финтек групп" ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийн** |

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023 -01- 10

| | |
|---|---|
| | үнийн дүн бүхий Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргана. |

Мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар бонд эргүүлэн худалдан авах нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж, баталжээ (Хавсралт 1.1).

| | |
|---|---|
| Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Компани нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бонд эзэмшигчийн хүсэлтийн дагуу Бондыг зах зээлийн үнээр эргүүлэн худалдан авна. |
| Бондыг эргүүлэн худалдан авах үнэ | Бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүгийн нийлбэр дүн байна. |
| Бондыг эргүүлэн худалдан авах хугацаа | Компани нь бонд эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд Бондын үнийн дүнгээс хамааран дараах хугацаанд бондыг эргүүлэн худалдан авна.<br>- 50,000,001 (тавин сая нэг) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бол Бонд эзэмшигч мэдэгдэл илгээснээс хойш ажлын 10 хоногийн дараа;<br>- 50,000,000 (тавин сая) хүртэл төгрөгийн үнийн дүнтэй бол мэдэгдэл ирүүлсэн тухайн өдөр. |
| Бондын татвар | Бонд гаргагч нь Бонд эзэмшигчийн бондтой холбоотойгоор олсон хүүгийн орлогын үнийн дүнгээс татварт ногдох 5 хувийг суутган шилжүүлж, Бонд эзэмшигчийн нэрийн өмнөөс төсөвт шилжүүлэн тайлагнана. |
| Арилжааны шимтгэл | Бондыг худалдах, худалдан авах арилжааны шимтгэлийг талууд тус бүрдээ хариуцна. |

Энэхүү тогтоол нь агуулгын хувьд Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6, 49 дүгээр зүйлийн 49.5, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйл, "Сэндли ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, СЗХ-ны өрийн хэрэгслийн журмын 7 дугаар зүйлийн 7.1.5-д тус тус нийцсэн байна.

Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7, 49 дүгээр зүйлийн 49.1, 76 дугаар зүйл 76.1.7, 76.1.18, "Сэндли ББСБ" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.2, 8.6.12, 8.6.15, 8.6.23 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.2, 2.8.3, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд энэхүү тогтоолыг гаргажээ.

Иймд, "Сэндли ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 01 тоот тогтоол нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

***Хоёр. "Сэндли ББСБ" ХК-ийн хувьцаа барьцаалах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх талаар.***

Нэхэмжлэгдэх... 

Нэгтгэсэн бондын үнийн дүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор "Монголын Финтек Групп" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын 31 тоот Хувьцаа барьцаалуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулсан буюу 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоолоор өөрийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 хүртэлх энгийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгосон үнэ буюу 150 (нэг зуун тавь) төгрөгөөр үнэлэн нийт 16,8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцааг барьцаалахаар шийдвэрлэжээ (Хавсралт 1.2).

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -01- 10

Монголын Хөрөнгийн Бирж нь 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Нэмэлт баримт бичиг, тайлбар тодруулга ирүүлэх тухай" 01/11 тоот албан бичиг болон 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хийсэн уулзалтаар "Сэндли ББСБ" ХК-ийн хувьцааны барьцааны үнэлгээг дахин нягтлах тухай мэдэгджээ (Хавсралт 1.8).

"Сэндли ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 223,570,000 (хоёр зуун хорин гурван сая таван зуун далан мянга) ширхэг хувьцааг гаргасан ба үүнээс "Монголын Финтек Групп" ХК-ийн барьцаалж буй хувьцаа нь 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг бөгөөд барьцаалж буй хувьцааны хэмжээ нь Компанийн гаргасан энгийн хувьцааны 50% байх (Хууль зүйн дүгнэлтийн Хавсралт 1.15) тул тус хувьцаа барьцаалах шийдвэр нь СЗХ-ны өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2.6-д заасан шаардлагыг хангах байна.

Энэхүү "Монголын Финтек Групп" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоол (Хавсралт 1.2) нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.18 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хамаарах бөгөөд тус тогтоол нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16.3, Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5, Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэг болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

*Гурав. Барьцааны гэрээ, бондын гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар.*

*Барьцааны гэрээ.* Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тогтоол (Хавсралт 1.1)-ын дагуу бондын нөхцөлд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан №БГ-22/27 тоот Барьцааны гэрээнд өөрчлөлт оруулжээ.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 22/07 тоот (Хууль зүйн дүгнэлтийн Хавсралт 1.16), 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот тогтоол (Хавсралт 1.1)-оор тус тус шийдвэрлэсэн Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан нэг талаас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн үндсэн андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, нөгөө талаас барьцааны зүйлийн өмчлөгч "Монголын Финтек Групп" ХК нар нь 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр БГ-23/01 тоот Барьцааны гэрээ (Хавсралт 1.3) байгуулсан байна.

Энэхүү Барьцааны гэрээний 2.3-д "Энэхүү гэрээний 2.2-д заасан барьцааны зүйлийн үнэлгээг талууд "Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн гаргасан хөдлөнгийн хөрөнгийн бус үнэлгээний тайлан болон 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн нэмэлт тодруулга албан бичиг (хавсралт 2)-т үндэслэсэн болно" гэж заажээ. Мөн гэрээнд барьцааны нөхцөл, хугацаа, барьцааны зүйлийг бүртгүүлэх, чөлөөлөх, тусгаарлах нөхцөлийг тодорхойлжээ.

Иймд, тус хувьцаа барьцаалах гэрээ нь Иргэний хуулийн 156 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Үнэт цаас барьцаалах тухай журамд тус тус нийцсэн байна.

*Бондын гэрээ.* Бондын нөхцөл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Бонд гаргагч болон андеррайтер нар нь 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан БОГ 01 тоот бондын гэрээний нөхцөлийг өөрчилж, 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр БОГ 23/01 тоот гэрээгээр шинэчлэн байгуулсан байна (Хавсралт 1.4). Тус гэрээнд бондын нөхцөлийг шинэчлэн баталсан тогтоол (Хавсралт 1.1)-д нийцүүлэн өөрчилсөн байх ба бонд эргүүлэн худалдах, худалдан авах нөхцөлийг оруулжээ. Холбогдох өөрчлөлт болон бондын гэрээ нь Үнэт цаас гаргагчийн шийдвэр, СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3.6, 3.7 дахь зохицуулалтад тус тус нийцсэн байна.

*Дөрөв. Барьцаа хөрөнгийн үнэлгээ*

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

2023-01-10
БҮРТГЭВ-02

Барьцаа хөрөнгийн үнэлгээний талаар бид дүгнэлт гаргаагүй болно.

***Тав. Батлан даалтын гэрээ болон холбогдох шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар.***

**"Монголын Финтек Групп" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот "Батлан даалт гаргах тухай" тогтоол (Хавсралт 1.6)-оор "Монголын Финтек Групп" ХК нь "Сэндли ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл ("Бонд")-ийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргасан байна. Энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 76.1.17-д заасан ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарч буй бөгөөд хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн гэж үзэв.**

**Батлан даалтын гэрээг нэг талаас "Монголын Финтек Групп" ХК /Батлан даагч/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранбат, "Сэндли ББСБ" ХК ("Бонд гаргагч" эсхүл "Үүрэг гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл, нөгөө талаас "Өлзий Энд Ко Капитал ҮЦК" ХХК /Андеррайтер/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нар нь 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр БД-23/01 тоот Батлан даалтын гэрээ (Хавсралт 1.5) байгуулжээ.**

**Тус гэрээгээр Үүрэг гүйцэтгэгч буюу "Сэндли ББСБ" ХК бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Андеррайтерийн мэдэгдлийг үндэслэн Батлан даагч нь бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг үл маргах журмаар шилжүүлэхээр талууд тохиролцсон байна. Энэхүү Батлан даалтын гэрээ нь СЗХ-ны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам, Монгол Улсын Иргэний хуулийн 45 дугаар бүлгийн зохицуулалтад тус тус нийцсэн байна.**

**Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын 02 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоол (Хавсралт 1.7)-оор "Монголын Финтек Групп" ХК-тай батлан даалтын гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосон байх тул Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баримталсан гэж дүгнэв.**

***Зургаа. Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн тоо өөрчлөгдөх тухайд***

**2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн Хууль зүйн дүгнэлтийн 5 дугаар бүлэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж байна.**

**Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд дараах хэлцлийг нэмж оруулав.**

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хуулийн шаардлага хангасан эсэх | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|---|
| 20. | "Монголын Финтек Групп" ХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02 тоот "Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай" тогтоол (Хавсралт 1.7)-оор зөвшөөрөл олгосны дагуу толгой компани болох "Монголын Финтек Групп" ХК-тай Батлан даалтын гэрээ байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хангасан | Хэрэгжиж байгаа |

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
5961548
УЛААНБААТАР ХОТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | (Хавсралт 1.5) | | | |

Иймд, нэмэлт дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо нэгээр нэмэгдэж 32 хэлцэл байгуулсан бөгөөд тус гэрээнүүдээс 11 нь хэрэгжиж дууссан, 21 нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж байна.

Энэхүү нэмэлт дүгнэлтээр Хууль зүйн дүгнэлтийн их хэмжээний хэлцлийн талаарх тооцооллыг шинэчлэн хүргүүлэв.

***Их хэмжээний хэлцлийн талаар:***

Компанийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангаар актив нь 28,106,294,000 төгрөг байна. Компанийн тухай хуулийн 87-д зааснаар их хэмжээний хэлцэл нь сүүлийн балансын активын нийт дүнгийн 25% дараах байдлаар байна.

- 2019 оны хэлцэл - 318,472,439.6425 төгрөгөөс дээш (2018 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 1,273,889,758.57)
- 2020 оны хэлцэл - 350,919,852.745 төгрөгөөс дээш (2019 оны санхүүгийн тайлан нийт хөрөнгө 1,403,679,410.98)
- 2021 оны хэлцэл – 452,301,983.58 төгрөгөөс дээш (2020 оны санхүүгийн тайлан нийт 1,809,207,934.32)
- 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацааны хэлцэл - 2,568,819,807.785 төгрөгөөс дээш (2021 оны санхүүгийн тайлан нийт 10,275,279,231.14)
- 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших хугацааны хэлцэл - 7,026,573,500 төгрөгөөс дээш (2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлан нийт 28,106,294,000)

***Долоо. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх, өөрчлөлтөд орсон хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх талаар.***

Компани нь нээлттэй бондын нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай тогтоол, барьцаа, бондын гэрээ болон түүнд хамаарах шийдвэрт өөрчлөлт оруулсан, Үнэт цаас гаргагчийн толгой компаниас батлан даалт гаргах тухай шийдвэр гаргаж, батлан даалтын гэрээ байгуулах зэргээр Бондын танилцуулгад өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн, өөрчлөгдсөн хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв болно.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ　　　　Д.ДҮГЭРЖАВ

СЗХ
он сар өдөр
ХАВСРАЛТ-1
№ 01

Бондын гэрээ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10

**БОНДЫН ГЭРЭЭ**

| | | |
|---|---|---|
| **2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр** | **№ БОГ 23/01** | **Улаанбаатар хот** |

Энэхүү Бондын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн,

Нэг талаас: Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Монгол Улс , Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,50 мянгат, Бакула ринбүчигийн гудамж, 8/4 тоот орших "Сэндли ББСБ" ХК [Регистрийн дугаар: 5961548] (цаашид "**Бонд гаргагч**" гэх)- ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Б. Одгэрэл;

**Нөгөө талаас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн:**

Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити центр, 10 давхар 1003 тоот хаягт орших "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК (Регистрийн дугаар: 5183855, цаашид "**Үндсэн андеррайтер**" гэх)-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нар;

(цаашид тус бүрт нь "**Тал**", хамтад нь "**Талууд**" гэх) харилцан тохиролцсоны дагуу энэхүү Гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

## 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1. Өрийн хэрэгсэл (цаашид "**Бонд**" гэх) гаргахтай холбогдуулан бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдах, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүрэх гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.

1.2. Гэрээг талууд бичгээр байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр хэрэгжинэ.

## 2. БОНДЫН НӨХЦӨЛ

2.1. Бонд гаргагч нь дараах нөхцөлөөр энгийн хүүтэй бонд гарган нийтэд санал болгоно. Үүнд:

| | | |
|---|---|---|
| 2.1.1. | Үнэт цаасны төрөл | Нээлттэй өрийн хэрэгсэл (энгийн хүүтэй бонд) |
| 2.1.2. | Олон нийтэд санал болгох нийт дүн | 8'500'000'000.0 (Найман тэрбум таван зуун сая) төгрөг |
| 2.1.3. | Бондын нэрлэсэн үнэ | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| 2.1.4. | Тоо ширхэг | 85,000 (наян таван мянга) ширхэг |
| 2.1.5. | Хүү (жилийн буюу 365 хоног) | 19.2% (арван ес аравны хоёр хувь) |
| 2.1.6. | Хугацаа | 18 (арван найман) сар |
| 2.1.7. | Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| 2.1.8. | Үндсэн төлбөрийн төлөлт | Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 18 дах сарын мөн өдөр төлнө. Хэрэв |



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ
5961548

| | | |
|---|---|---|
| | | амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө. |
| 2.1.9. | Бондыг хугацаанаас өмнө буцаан худалдах Бонд эзэмшигчийн эрх | Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа Бондыг үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах эрхтэй. |
| 2.1.10. | Бондын барьцаа | "Монголын финтек групп" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 31 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын дагуу өөрийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) ширхэг энгийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгосон үнэ буюу 150 (нэг зуун тавь) төгрөгөөр үнэлэн нийт 16.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцааг бондын хүү ба үндсэн төлбөрийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор холбогдох журмын дагуу Андеррайтерт барьцаалуулахаар шийдвэрлэсэн болно. |
| 2.1.11. | Бондын эргэн төлөлт хийгдэх | Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс өдрөөс хойш 18 сарын дараа мөн өдөр (хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр) |
| 2.1.12. | Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. |
| 2.1.13. | Андеррайтерийн хөлс | Андеррайтертай байгуулах гэрээний үндсэн дээр тодорхойлно |
| 2.1.14. | Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2023 оны I улирал |
| 2.1.15. | Бондын хадгалалт, төлбөр тооцоо | "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК |
| 2.1.16. | Хүүгийн төлбөр тооцоолох аргачлал | Жилийн хүүг 365 хоногоор тооцох ба бондын хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 3 сарын дараах мөн өдөр төлнө. Хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх бөгөөд энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй ба дараагийн хүүг мөн өдрөөс тооцно. |

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02

2.2. Бондыг олон нийтэд санал болгохдоо бондын төлбөрийн эрсдэлийг бууруулах зорилгоор Бонд гаргагч нь хөрөнгө барьцаалуулах, батлан даалт, баталгааны аль нэгийг, эсхүл хамтад нь гаргаж болно.

2.3. "Сэндли ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон гаргах нийт 8,500,000,000.0 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор толгой компани буюу "Монголын финтек групп" ХК-ийн эзэмшлийн 111,785,000 (нэг зуун арван нэгэн сая долоон зуун наян таван мянга) хүртэлх энгийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгосон үнэ буюу 150 (нэг зуун тавь) төгрөгөөр үнэлэн нийт 16.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцааг Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д бондын үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл холбогдох журмын дагуу барьцаалуулна.

2.4. Бонд гаргагч нь энэхүү гэрээний 3.1-д заасан нөхцөл бий болсон тохиолдолд Андеррайтераас бичгээр тавьсан шаардлага болон холбогдох бүхий л шаардлагатай нотлох баримт буюу тухайн үед бонд гаргагчийн хүлээх үүргийн хэмжээг тодорхойлсон ҮЦТХТ-ийн бичиг хүлээн авснаас хойш ажлын 5 (тав) хоногийн дотор Барьцаалуулагч нь нийтэд санал болгох бондын нөхцөлийн дагуу Бонд гаргагчийн бондыг эргэн төлөлттэй холбоотой бүх өр төлбөрийг төлж барагдуулах үүргийн дагуу, үл маргах журмаар Үндсэн андеррайтерийн Үнэт цаасны хадгаламжийн төв дэх 57-272 дугаартай дансанд барьцаа хөрөнгийг шилжүүлнэ.

2.5. Барьцаалагчийн эрх нь Барьцаа хөрөнгийн гэрээ байгуулагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд 2.1-д заасан нөхцөл бүхий бондын үүргийн гүйцэтгэх хангагдах хүртэл хүчин төгөлдөр байна.

2.6. Бонд гаргагч нийтэд санал болгон гаргах бондын үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд Гэрээний 2.3-т заасан Барьцааны гэрээний дагуу Бонд эзэмшигчдийн шаардлагыг хангана.

2.7. Бонд гаргагч нь Гэрээний 2.3-д заасан хувьцаа барьцаалахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр, гэрээг Үндсэн андеррайтерт гаргаж өгнө.

2.8. Бонд нь энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлгүй байна.

2.9. Бондын дагуу төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад дурдсаны дагуу зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэхэд зарцуулна.

## 3. ТӨЛБӨРИЙН ТАСАЛДАЛ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙД ТООЦОХ НӨХЦӨЛ

3.1. Бонд гаргагч нь бондын хүүгийн болон үндсэн төлбөрөө хугацаандаа гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэх, эсхүл 1 болон түүнээс дээш удаа дараалан бондын хүүгийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд төлбөрийн тасалдал (дефолт) болсонд тооцно. Төлбөрийн тасалдал болох нөхцөл үүссэн бол Барьцаалуулагч энэхүү гэрээний 2.3, 2.4-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндэслэл болно.

3.2. Барьцаагаар хангагдах үүрэг нь нийтэд санал болгох бондын үнийн дүн (арван тэрбум төгрөг), хамаарах хуримтлагдсан хүү болон алданги (өдөрт гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%)-ийн нийлбэр дүнгээс хэтрэхгүй.

3.3. Төлбөрийн чадваргүй болох нөхцөлийг хуульд заасныар тодорхойлно.Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан дарааллыг баримтлах бөгөөд ямар ч тохиолдолд бондын хүү, үндсэн төлбөрийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас өмнө тэргүүн ээлжинд барагдуулна. Бонд гаргагчийн толгой компанийн эзэмшилд буй 126,141,700 ширхэг энгийн хувьцаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 413 тоот тогтоолын дагуу тусгаарлагдсан байгаа бөгөөд уг тусгаарлалтын хугацаа дуусахаас ажлын 3 хоногийн өмнө Үндсэн андеррайтер нь холбогдох барьцааны гэрээний дагуу тусгаарлуулах албан хүсэлтийг



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022127
5961548
УЛААНБААТАР ХОТ

БҮРТГЭВ
№ 01

холбогдох шийдвэр болон гэрээний хамт ҮЦТХТ-д хүргүүлж, бондын үүргийн гүйцэтгэл хангагдах хүртэл тусгаарлуулна.

## 4. БОНД ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ

4.1. Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа бондыг нэрлэсэн үнээр Бонд гаргагчид эргүүлэн худалдах, хуримтлагдсан хүүг тооцуулан авах эрхтэй. Ингэхдээ бондын нийлсэн үнийн дүнгээс хамааран Бонд гаргагч болон Үндсэн андеррайтерт дараах хугацаанд урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

4.1.1. 50,000,001 (тавин сая нэг) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бол ажлын 10 хоногийн өмнө;

4.1.2. 50,000,000 (тавин сая) хүртэл төгрөгийн үнийн дүнтэй бол ажлын 1 хоногийн өмнө;.

4.2. Энэхүү гэрээний 4.1-д заасан хүсэлтийн дагуу бондыг буцаан худалдан авахдаа Бонд гаргагч нь хүүгийн орлогын татварыг суутган авч, Бонд эзэмшигчийн өмнөөс төсөвт төлнө.

4.3. Гэрээний 4.1-д заасан бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах, худалдан авах арилжааны холбогдох шимтгэлийг талууд тус бүрдээ хариуцна.

4.4. Бондын нөхцөлд заасныг Бонд эзэмшигч хүсэлт гаргаагүй тохиолдолд Бонд гаргагч нь бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах эрхгүй.

## 5. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Бонд гаргагчийн эрх, үүрэг

5.1.1. Андеррайтер, бонд эзэмшигчээс хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;

5.1.2. Андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшинг тогтоох;

5.1.3. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хугацаанд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх, энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;

5.1.4. Бонд гаргагчийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд бондын үүргийн гүйцэтгэлийг барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч Хөрөнгө оруулагчийн хүү болон үндсэн төлбөрийг баргадуулах;

5.1.5. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;

5.1.6. Бонд гаргагчийн үйл ажиллагаа, санхүү болон бусад бодит байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар мэдээлэх;

5.1.7. Андеррайтер шаардсаны дагуу бонд гаргалттай холбоотой мэдээллийг гаргаж өгөх;

5.1.8. Хууль тогтоомжид болон энэхүү гэрээнд заасан мэдээллийг цахим шуудан, эсхүл олон нийтийн хэрэглээр дамжуулан, хугацаанд нь Бонд эзэмшигчид мэдээлэх;

5.1.9. Санхүүгийн зохицуулах хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дараах хугацаанд Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

- Улирлын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 10-ны дотор, аудитын тайланг 3 дугаар сарын 10-ны дотор;
- Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл, төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон, зээлдүүлэгч болон хөрөнгө оруулагчийн өмнө нэмэлт үүрэг үүссэн, хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон, эрх бүхий этгээд бонд гаргагчийн хөрөнгийг



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

битүүмжилсэн эсхүл хураасан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой шинэчлэл, сунгалт, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болсон, Бонд гаргагч гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан бол тухайн үйл явдал болсноос ажлын 3 өдрийн дотор;

5.1.10. Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа бондыг эргүүлэн худалдах хүсэлт гаргасан тохиолдолд "Нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай" тогтоол болон холбогдох журмын дагуу худалдан авах үүрэгтэй.

5.1.11. Бондын нөхцөл, холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон, бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын бий болсон тохиолдолд нэн даруй Андеррайтер, олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авах;

5.1.12. Бондын танилцуулгад Баталгаа гаргагч, Батлан даалт гаргагч, Барьцаалуулагчийн талаар тодорхой, үнэн зөв, бүрэн, мэдээллийг тусгах, мэдээллээр хангах;

5.1.13. Бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ, цаашид хуульд заасан хугацаанд хадгалах;

5.1.14. Хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Бонд эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах;

5.1.15. Хууль тогтоомжид заасан бусад.

5.2. Андеррайтерийн эрх, үүрэг

5.2.1. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай Бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авах;

5.2.2. Бондын танилцуулгыг боловсруулах, анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдах болон байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

5.2.3. Хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;

5.2.4. Бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих;

5.2.5. Хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг зохих ёсоор хоёрдмол утгагүй танилцуулах;

5.2.6. Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хууль, холбогдох журам, зохицуулалтын шаардлагыг хангаж ажиллах, Бонд худалдан авагчийг судлах, таних;

5.2.7. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол барьцааны эрхээ хэрэгжүүлэх, үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

5.2.8. Барьцааны гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад.

5.3. Бонд эзэмшигч буюу Хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг

5.3.1. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр бонд худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах;

5.3.2. Бондыг биржээс чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах;

5.3.3. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Бонд гаргагчийн мэдээллийг авах, бондын хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах;

5.3.4. Бондын үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Бонд гаргагчаас шаардах;



СЭНЛЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 1 0

5.3.5. Бонд эзэмшигч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 сарын дараа бондыг Бонд гаргагчид эргүүлэн худалдах, бондын үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүг төлөхийг Бонд гаргагчаас шаардах эрхтэй.

5.3.6. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол Бонд эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах;

5.3.7. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн бондын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтой тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргах;

5.3.8. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан бондын төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан бондыг Андеррайтер худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;

5.3.9. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу өрийн хэрэгслийн хүүгийн орлогоос татварыг суутгахыг Бонд гаргагчид зөвшөөрөх;

5.3.10. Хууль тогтоомжид заасан бусад.

5.4. Энэхүү Гэрээгээр тохиролцсоноос бусдаар Бонд гаргагчид тусгайлан хориглох буюу заавал хэрэгжүүлэх тусгай нөхцөл тогтоогоогүй болно.

## 6. БУСАД ЗҮЙЛ

6.1. Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хуулиар зохицуулагдах бөгөөд маргаан, зөрчилдөөн үүссэн нөхцөлд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд боломжгүй нөхцөлд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.2. Энэхүү гэрээгээр талуудын хооронд байгуулагдсан 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн БОГ-22/01 дугаартай Бондын гэрээг хүчингүй болгох, шинэчлэн байгуулсанд тооцохоор талууд тохиролцов.

6.3. Энэхүү Гэрээг гурван хувь үйлдсэн ба талууд болон Санхүүгийн зохицуулах хороонд хадгалагдах хувь тус бүр нь хууль зүйн бүрэн хүчин төгөлдөр баримт болно.

6.4. Энэхүү Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

6.5. Гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний пар хүрээг засварлах, өөрчлөх болон үүнтэй холбоотойгоор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гагцхүү бичгээр үйлдэн Талууд гарын үсэг зурж баталгаажуулна.

*Талууд энэхүү Гэрээнд заасан нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон гарын үсэг зурж, баталгаажуулав.*

| БОНД ГАРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ "СЭНДЛИ ББСБ" ХК | ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ: "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК |
|---|---|
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. ОДГЭРЭЛ | ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ӨЛЗИЙБАЯР |

ХАВСРАЛТ-2 Барьцаа, батлан даалт гаргагчийн тогтоол, гэрээ

/Хувьцаа барьцаалуулах тухай тогтоол/

МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

22 . 12 . 22 № 31 Улаанбаатар хот

*Хувьцаа барьцаалуулах тухай*

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, "Монголын финтек групп" ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компанийн охин компани болох "Сэндли ББСБ" ХК-ийн нийтэд санал болгон Монголын хөрөнгийн бирж дээр гаргах нийт 10'000'000'000.0 (Арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор компанийн эзэмшиж буй 13'000'000'000.0 (Арван гурван тэрбум) төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Сэндли ББСБ" ХК-ийн хувьцааг үндсэн андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-д үнэт цаасны үндсэн болон хүүгийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэл хугацаатайгаар холбогдох журмын дагуу барьцаалуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Компанийг төлөөлж Хувьцааны барьцааны гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Наранбат)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА М.ЦОЛМОН

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 06 өдөр | № 01 | Улаанбаатар хот

***Тогтоолд өөрчлөлт оруулах тухай***

**Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсгүүд, "Монголын финтек групп" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:**

**1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "Хувьцаа барьцаалуулах тухай" 31 тоот тогтоолын 1 дэх хэсэгт дараах өөрчлөлтийг оруулсугай.**

**1.1. "...Монголын хөрөнгийн бирж дээр гаргах нийт 10'000'000'000.0 (арван тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн..." гэснийг "... Монголын хөрөнгийн бирж дээр гаргах нийт 8'500'000'000.0 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн..." хэмээн өөрчлөх;**

**1.2. "...компанийн эзэмшиж буй 13'000'000'000.0 (Арван гурван тэрбум) төгрөг хүртэлх үнэлгээ бүхий "Сэндли ББСБ" ХК-ийн хувьцааг..." гэснийг "компанийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 111,785,000 хүртэлх энгийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгосон үнэ буюу 150 (нэг зуун тавь) төгрөгөөр үнэлэн нийт 16,8 тэрбум үнэлгээ бүхий энгийн хувьцааг..." хэмээн өөрчлөх.**

**2. Бондын нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Барьцааны гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Наранбат/-д үүрэг болгосугай.**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.ЦОЛМОН

MONGOLIAN FINTECH GROUP
УЛААНБААТАР ХОТ

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

/Барьцааны гэрээ/

**БАРЬЦААНЫ ГЭРЭЭ**

2023 оны 01 сарын 09 өдөр | № БГ-23/01 | Улаанбаатар хот

Энэхүү "Барьцааны гэрээ" (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын иргэний хуулийн 156 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, бусад хууль, дүрэм, журмыг үндэслэн нэг талаас, "**ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК**" ХХК [УБД: 9011125147], [РД: 5183855] -ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б. Өлзийбаяр (цаашид "Барьцаалагч" гэх),

нөгөө талаас, "**МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП**" ХК [УБД: 9008001006], [РД: 6692257] -ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б. Наранбат, (цаашид "Барьцаалуулагч", хамтад нь "Талууд", дангаар нь "Тал" гэх) нар доор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү гэрээгээр Барьцаалагч нь Барьцаалуулагчийн охин компани болох "Сэндли ББСБ" ХК ("Бонд гаргагч") болон холбогдох талуудтай 2022 оны 12 сарын 22-ны өдөр байгуулсан АГ-22/23 дугаартай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ", 2023 оны 01 сарын 09-ний өдрийн БОГ – 23/01 дугаартай "Бондын гэрээ" -тэй холбогдуулж Бонд гаргагчийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй санал болгох бонд ("Бонд" эсхүл "Өрийн хэрэгсэл")-ын хүү болон үндсэн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**ХОЁР. БАРЬЦААНЫ НӨХЦӨЛ**

2.1 Барьцаалуулагч нь барьцаалах эдийн бус хөрөнгийг өмчлөгч буюу барьцаалах хууль ёсны эрхтэй болохоо албан ёсоор нотолсон болно.

2.2 Барьцаалуулагч нь энэхүү гэрээний 1.1-т заасан үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож дараах эдийн бус хөрөнгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын 31 дугаартай тогтоол, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын 01 дугаартай тогтоол (хавсралт 1, 1в)-д үндэслэн барьцаалж байна.

**Барьцааны зүйл:** Барьцаалуулагчийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн нийтэд санал болгон гаргах нийт 8'500'000'000.0 (найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл ба түүний хүү болон өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой бусад зардлын үүргийн гүйцэтгэлийг хангах зорилтоор компанийн эзэмшиж буй доорх хувьцааг үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д үнэт цаасны үндсэн болон хүүгийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэл хугацаатайгаар холбогдох журмын дагуу барьцаалуулна.

| № | Барьцаа хөрөнгийн нэр | Барьцаалуулагчийн нэр | Тоо, ширхэг | Нэгжийн үнэ ₮ | Барьцаа хөрөнгийн үнийн дүн ₮ | Үүргийн гүйцэтгэл хангуулах хувь | Барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийн дүн ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "Сэндли ББСБ" ХК-ийн энгийн хувьцаа | "Монголын финтек групп" ХК | 111,785,000 | 150 | 16,767,750,000 | 70% | 11,288,000,000 |

2.3. Энэхүү гэрээний 2.2-д заасан барьцааны зүйлийн үнэлгээг талууд "Тэрэгэ эстимэйт"ХХК-ийн гаргасан хөндлөнгийн хараат бус үнэлгээний тайлан болон 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн нэмэлт тодруулга албан бичиг (хавсралт 2)-т үндэслэсэн болно.

2.4. Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ нь өрийн хэрэгслийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт, хүү, алданги, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-01-10

хураамж, нэхэн төлүүлэх шүүхийн зардал, Барьцааны зүйлийг хадгалуулахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр болон үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Барьцаалагчид учирсан бусад бүх хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

2.5. Барьцаалуулагчийн эзэмшиж буй 2.2-т дурдсан хэмжээний хувьцааг бондын үндсэн болон хүүгийн төлбөрийн барьцаа болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд тусгаарлуулах бөгөөд Бонд гаргагч бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд буцаан төлөөгүй буюу үүргийн гүйцэтгэл хангагдаагүй тохиолдолд барьцааны шаардлагыг хангах тухай мэдэгдлийг Барьцаалуулагчид бичгээр хүргүүлэх бөгөөд Барьцаалуулагч нь Барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлж, Барьцаалагчийн Үнэт цаасны хадгаламжийн төв дэх 57-272 дугаартай дансанд шилжүүлэх хүсэлтийг ҮЦТХТ-д ажлын 1 хоногт багтаан албан бичгээр хүргүүлнэ. Барьцаалагч бондын үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд хувьцааг худалдан борлуулж үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангуулах эрхтэй.

2.6. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар барьцаалсан хөрөнгийг худалдсан үнийн дүн нь хөрөнге оруулагчдад борлуулсан өрийн хэрэгсэл болон түүний хүү, барьцаалагчид учирсан бусад хохирлыг нөхөн төлүүлэхэд хүрэлцэхгүй бол Барьцаалуулагчийн бусад эд хөрөнгөөс гаргуулах эрхийг Барьцаалагч эдэлнэ. Талууд тохиролцож бусад хөрөнгөөс гаргуулж чадаагүй тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

2.7. Барьцаалагч нь энэхүү гэрээний 2.2-т дурдсан барьцааны хөрөнгийг шалгах, тухайн эд хөрөнгийн бүртгэл, хяналтыг хариуцаж байгууллагад байгаа (байх ёстой) баримт бичгийг үндэслэн эд хөрөнгийн өмчлөл, хөдөлгөөний талаар лавлагаа авах, энэхүү гэрээний биелэлтэд хяналт тавих эрх, үүрэгтэй бөгөөд Барьцаалуулагч нь түүнд энэхүү хяналт хэрэгжүүлэх бүх нөхцөлийг бүрдүүлнэ. Хэрэв уг үйл ажиллагаанд барьцаалагчид аливаа саад тотгор учруулах болон худал мэдээлэл өгсөн бол энэхүү гэрээг ноцтой зөрчсөн гэж үзэх ба үүнтэй холбогдсон бүх зардлыг Барьцаалуулагч тал бүрэн хариуцна.

2.8. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон гэнэтийн ослын улмаас барьцаалсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд учирсан хохирлыг Барьцаалуулагч тал бүрэн хариуцна. Энэ нь хөрөнгө оруулагчдад борлуулсан өрийн хэрэгсэл, түүний үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг төлөх гэрээний нөхцөлд ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

2.9. Хөрөнгө оруулагчдад борлуулсан бондын төлбөр тооцоог, тухайлбал бондын үндсэн төлбөр, хүүг төлүүлэхтэй холбогдон гарсан зардал зэргийг бүрэн төлж дууссанаар барьцаалагдсан хөрөнгийг захиран зарцуулах эрх Барьцаалуулагч талд шилжинэ.

2.10. Барьцаалуулагчийн эзэмшиж буй "Сэндли ББСБ" ХК-ийн 126,141,700 ширхэг энгийн хувьцаа нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 413 тоот тогтоолын дагуу тусгаарлагдсан байгаа бөгөөд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн системээс шалтгаалан давхар тусгаарлах боломжгүй тул уг тусгаарлалтын хугацаа дуусахаас ажлын 3 хоногийн өмнө Барьцаалуулагч нь энэ барьцааны гэрээний дагуу тусгаарлуулах албан хүсэлтийг холбогдох шийдвэр болон гэрээний хамт ҮЦТХТ-д хүргүүлж бондын үүргийн гүйцэтгэл хангагдах хүртэл тусгаарлуулна. Барьцаалуулагч нь энэхүү үйл ажиллагааг урьдчилан ҮЦТХТ-д мэдэгдэж, зөвшөөрөл (хавсралт 3) авсан болно.

2.11. Барьцаалагч нь барьцааны зүйлийг Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим санд энэхүү гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор бүртгүүлнэ.

2.12. Бондын үндсэн ба хүүгийн төлөлт бүрэн төлөгдсөн нөхцөлд барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлөх тухай албан бичгийг үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор ҮЦТХТ-д хүргүүлж, Барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлүүлж, хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим бүртгэлээс хасах арга хэмжээ авна.

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

2023-01-10

## ГУРАВ. БАРЬЦААНЫ ХУГАЦАА

3.1. Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

3.2. Гэрээ нь Барьцаалуулагч нь биржээр нээлттэй гаргасан бондын үүргийг гүйцэттэлийг бүрэн хангасан, эсхүл тус гэрээний үүргийг бүрэн гүйцэтгээгүйгээс ут гэрээнд заасан үндэслэлээр гэрээг дуусгавар болгож тус үүргийг Барьцааны зүйлээр хангаснаар Гэрээ дуусгавар болно.

## ДӨРӨВ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

4.1 Давагдашгүй хүчин зүйлс (тухайлбал, үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

4.2 Энэхүү гэрээний 4.1-д заасны улмаас барьцаа хөрөнгөд хохирол үүсэн тохиолдолд бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг барьцаалуулагчийн бусад эд хөрөнгөнөөс гаргаж барагдуулна.

4.3 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүсэн болон дууссан талаар талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

## ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1. Энэхүү гэрээнээс үүдэлтэй аливаа маргаан гарвал Талууд хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжит бүхий л арга хэмжээг авна. Хэрэв ут арга хэмжээ нь зохих үр дүнд хүрэхгүй бол хуульд заасны дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.2. Энэхүү гэрээгээр талуудын хооронд байгуулагдсан 2022 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн БГ-22/27 дугаартай Барьцааны гэрээг хүчингүй болгож, шинэчлэн байгуулсанд тооцохоор талууд тохиролцов.

5.3. Энэхүү гэрээнд талууд тохиролцон нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

5.4. Гэрээг Монгол хэл дээр, ижил хүчинтэй 5 хувь үйлдэх ба Барьцаалагчид 1 хувь, Барьцаалуулагчид 1 хувь, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд 1 хувь, Санхүүгийн Зохицуулах Хороонд, Монголын хөрөнгийн биржид 1 хувь тус тус хадгалагдана.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Барьцаалагч: | Барьцаалуулагч: |
|---|---|
| "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК -ИЙГ ТӨЛӨӨЛЖ: | "МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП" ХК -ИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
| Гүйцэтгэх захирал Б.ӨЛЗИЙБАЯР | Гүйцэтгэх захирал Б. НАРАНБАТ |
| ............................ | ............................ |

СЭНДЛИ ББСБ ХК Sendly 9022121175 УЛААНБААТАР ХОТ

СЭХ он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-18 БҮРТГЭВ

/Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай тогтоол/

Сэндли

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 05 -ны өдөр № 02 Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, "Сэндли ББСБ" ХК ("Компани")-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Сэндли ББСБ" ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл ("Бонд") -ийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор өөрийн толгой компани болох "Монголын финтек групп" ХК-тай Батлан даалтын гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсантай холбоотойгоор "Монголын финтек групп" ХК болон Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК нартай байгуулах Батлан даалтын гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

/Батлан даалтын тогтоол/

МОНГОЛЫН ФИНТЕК ГРУПП

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

23 01 06 02

**Батлан даалт гаргах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, "Монголын финтек групп" ХК ("Компани")-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани нь өөрийн охин компани болох "Сэндли ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох 8,500,000,000 (Найман тэрбум таван зуун сая) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл ("Бонд")-ийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргасугай.

2. Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор "Сэндли ББСБ" ХК-тай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1-д дурдсантай холбоотойгооор "Сэндли ББСБ" ХК болон Үндсэн андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-тай байгуулах Батлан даалтын гэрээнд компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Наранбат)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
М.ЦОЛМОН

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 11

2023-01-10
БҮРТГЭВ-02

/Батлан даалтын гэрээ/

**БАТЛАН ДААЛТЫН ГЭРЭЭ**

2023 оны 01 сарын 09 | № 60-23/01 | Улаанбаатар хот

Энэхүү "Батлан даалтын гэрээ"-г /цаашид "Гэрээ" гэх/

Нэг талаас 6692257 тоот регистрийн дугаартай Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бизнес 34 центр, А корпус, 1 тоот хаягтай "Монголын финтек групп ХК /цаашид "Батлан даагч" гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Наранбат;

Нөгөө талаас 5183855 тоот регистрийн дугаартай Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, 5-н давхар хаягт байрлах "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК /цаашид "Андеррайтер" гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр;

Нөгөө талаас 5961548 тоот регистрийн Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 40,50 мянгат, Бакула ренбүчигийн гудамж, 8/4 тоот хаягт байрлах "Сэндли ББСБ" ХК (цаашид "Бонд гаргагч" эсхүл "Үүрэг гүйцэтгэгч" гэх)-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл, нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монгол Улсын Иргэний хуулийн 45 дугаар бүлгийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

## НЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

1.1. Батлан даагч талын гаргаж буй батлан даалт нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

1.1.1. **Батлан даалтын төрөл:** Бондын батлан даалт. "Сэндли ББСБ" ХК /цаашид "Үүрэг гүйцэтгэгч" гэх/-ийн гаргаж буй 8'500'000'000.0 (Найман тэрбум таван зуун сая) төгрөг хүртэлх үнийн дүнтэй бондын үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлтөд батлан даалт гаргана.

1.1.2. **Батлан даалтын дээд хэмжээ:** 8'500'000'000.0 (Найман тэрбум таван зуун сая) төгрөг хүртэлх дүнтэй бондын үндсэн төлбөр болон тус бондын хүүгийн төлбөр.

1.1.3. **Алданги:** Батлан даалт гаргагч энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.01%-тай тэнцэх хэмжээний алдангийг төлнө.

1.1.4. **Батлан даалтын хүчинтэй хугацаа:** Үүрэг гүйцэтгэгч нь бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэл.

1.2. Батлан даалт хэрэгжих нөхцөл:

1.2.1. Үүрэг гүйцэтгэгч нь бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Андеррайтерийн мэдэгдлийг үндэслэн Батлан даагч нь бондын үндсэн болон хуваарьт төлбөрийг бонд эзэмшигчдийн дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.

1.2.2. Андеррайтер энэ гэрээний 1.2.1-д заасан мэдэгдлийг бичгээр энэ гэрээнд заасан хаягаар хүргүүлснээр мэдэгдлийг хүргүүлсэнд тооцох бөгөөд Батлан даагч нийнхүү хүлээн авсан өдөр батлан даалтаар хүлээсэн төлбөрийг төлөх үүрэгтэй.

СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ ХТҮ5601 5961548
sendly

1.2.3. Бондын үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдэх хуваарьт өдөр тухайн төлбөр хийгдээгүй тохиолдолд тухайн өдөртөө багтаан мэдэгдлийг Андеррайтераас Батлан даагчид хүргүүлнэ.

1.3. Батлан даалт дуусгавар болох нөхцөл:

1.3.1. Үүрэг гүйцэтгэгч бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа төлбөрийн үүргээ бүрэн биелүүлснээр эсхүл Үүрэг гүйцэтгэгч бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа төлбөрийн үүргээ бүрэн биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд тухайн үүргийг Батлан даагч бүрэн биелүүлж холбогдох төлбөрийг төлж барагдуулснаар;

1.4. Бусад нөхцөл

1.4.1. Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

1.4.2. Гэрээг адил хүчинтэй таван эх хувь үйлдэх бөгөөд тал тус бүрд нэг хувь, зохицуулагч байгууллагуудад хоёр хувийг тус тус хадгална.

1.4.3. Гэрээтэй холбоотой аливаа асуудлыг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН**

| | |
|---|---|
| **Батлан даагч:** "Монголын финтек групп" ХК-ийг төлөөлж **Гүйцэтгэх** захирал Б.Наранбат | Андеррайтер: "Өлзий энд Ко капиталҮЦК" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх **захирал** Б.Өлзийбаяр |
| **Үүрэг гүйцэтгэгч:** "Сэндли **ББСБ**" **ХК-ийг төлөөлж** Гүйцэтгэх захирал Б.Одгэрэл | |

Сэндли ББСБ ХК - Үнэт цаасны танилцуулга

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХАВСРАЛТ-3

Улсын бүртгэлийн гэрчилгээ

2023-01-10
БҮРТГЭВ-02

## МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000264577

2015.05.04
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9007001010
/ Хувийн хэргийн дугаар /

5961548
/ Регистрийн дугаар /

Сэндли ББСБ — Хувьцаат компани /нээлттэй ХК/
/ Хуулийн этгээдийн нэр, хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01 | 2015.04.30 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 6611 | Зээлийн үйл ажиллагаа |
| 6499 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ |
| 6419 | Гадаад валютын арилжаа /2018.02.07-2018.02.07/ |
| 66110 | Факторингийн үйлчилгээ |
| 09902 | Төлбөрийн баталгаа гаргах |
| 64300 | Итгэлцлийн үйлчилгээ |

| Хугацаагүй | 12 | 11,178,500.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / өмчлөгчийн тоо / | / дүрмийн сангийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр / |

Улаанбаатар, Чингэлтэй, 2-р хороо, 40, 50 мянгат/15171/, Бакула ринбүчи гудамж, 8/4 тоот,
Утас1: 70177700, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /гэмдэг/ — Ч.БАТЗОРИГ /гарын үсэг/

*Гэрчилгээ дахин олгосон* 2022 он 12 сар 27 өдөр

СЭНДЛИ ББСБ ХК — УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Балжинням овогтой Одгэрэл-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | 2021.05.27 | М.Монголжин |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | 2022.12.27 | Б.Баярмаа |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022175 УЛААНБААТАР ХОТ

ХАВСРАЛТ-4 Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/498

2015 оны 07 сарын 03 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 сарын 03 өдрийн 318 дугаар тогтоолоор "СЭНДЛИ ББСБ" ХХК -д Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЗХ 2021.01.13 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ

*(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)*

**МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**ТЗ 101/498 ТООТ**
**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"СЭЙДЛИ ББСБ" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2015.07.03 | №318 тогтоол | |
| 2. | Гадаад валютын арилжаа | 2018.02.07 | №62 тогтоол | |
| 3. | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 2018.02.07 | №62 тогтоол | |
| 4. | Факторинг | 2021.10.13 | №441 тогтоол | |
| 5. | Итгэлцэл | 2021.10.13 | №441 тогтоол | |
| 6. | Төлбөрийн баталгаа гаргах | 2021.10.13 | №441 тогтоол | |
| | | | | |
| | | | | |
  Дараах нөхцлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгана (БҮЦБИБО):

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг;

- Тодорхойлон заасан өдрүүдэд зөвхөн төлөгдөөгүй үлдсэн үндсэн төлбөр ба хүү төлөлтийн мөнгөн урсгалыг хүлээн авах санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлтэй байх;

  Бусад санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг (БҮЦАА).

  Дээр дурдсанаас үл хамааран, Групп санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед дараах ангиллыг сонгон бүртгэж болно:

- Групп тодорхой шалгуурыудыг хангасан тохиолдолд буцаах сонголттойгоор өмчийн хэрэглүүр дэх хөрөнгө оруулалтыг дараа үеүдэд хэмжихдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор тусгана.

- Групп өрийн хэрэглүүрээрх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртөг эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад иж бүрэн орлогоор бүртгэх зарчмыг сонгосон байсан боловч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тайлагнах нь илүү тохиромжтой, бүртгэлийн нийцгүй байдлыг арилгана гэж үзэж байвал бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлыг тусгаж болно.

Группын санхүүгийн хөрөнгө нь хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгөөс бүрдэж байна.

*Хорогдуулсан өртөг болон үр ашигт хүүгийн арга*

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг тооцолон, хүүгийн орлогыг хугацааны туршид хуваарилах арга юм.

Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгөөс бусад (анхлан хүлээн зөвшөөрөхдөө үнэ цэнэ нь буурсан хөрөнгө) санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
5961649
УЛААНБААТАР ХОТ

зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан)-ийг санхүүгийн ерийн гэрээний хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй тэнцүү байхаар үнэ цэнийн бууралтын нөөцийг хасахын өмнөх төлбөрийг ерийн хугацаа эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хуваарилахад хэрэглэдэг хүүгийн хувь юм. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан ерийн хэрэглүүрийг анхлан хорогдуулан бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, анхны дүн ба дуусгавар болох үеийн дүнгийн хооронд үүссэн аливаа зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан тооцсон хорогдуулгыг нэмж аливаа алдагдлын нөөцийг тохируулсан дүнгээр тодорхойлогдоно. Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь аливаа алдагдлын нөөцөөр тохируулаагүй дүн байна.

Хүүгийн орлогыг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь дараа үеүдэд тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор тусгах эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжигдэх ерийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан бүртгэлд тусгадаг. Худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд, дараа үед үнэ цэнэ буурсан зээл ба авлагаас бусад, санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан авлага ба зээлийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээл ба авлагын үнэ цэнийн бууралт бий болсон санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүүний түвшинг ашиглан аливаа алдагдлын нөөцийг багтаасан цэвэр дансны дүнгээс хүүний орлогыг тооцно.

Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болох үед үр ашигт хүүгийн түвшинг ашиглан санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээс хүүгийн орлогыг тооцно.

Групп худалдаж авсан эсвэл бий болгосон үнэ цэнийн бууралт бүхий зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн гэрээний мөнгөн урсгалыг тооцоолох үед ирээдүйн нийт хугацаанд хүлээгдэж буй авлага ба зээлийн алдагдлыг оруулан тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг ашиглан хүүгийн орлогыг тооцоолон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлагналын үеүдэд, үнэ цэнэ буурсан зээл ба авлагын санхүүгийн хэрэгслийн эрсдэл буурч, үнэ цэнийн бууралтгүй болсон тохиолдол цэвэр дансны дүнгээс тооцно.

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба "санхүүгийн болон бусад орлого хүүгийн орлого" хэсэгт ангилна.

### 2.10.2. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн өмчийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтанд хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөн бүртгэдэг. Тухайн санхүүгийн хэрэгслийг хүлээгдэж буй алдагдлын дүн анх хүлээн зөвшөөрч бүртгэснээс хойш эрсдэлийн өөрчлөлтийг үнэлж тайлант хугацаа болгонд шинэчилнэ.

Групп дансны авлагад нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдлыг тооцоолон бүртгэдэг. НББОУС 39-ийн дагуу үнэ цэнийн бууралттай авлагаас бусад дансны авлагын үлдэгдэл нь 400 сая төгрөгөөс давсан бөгөөд даатгагдаагүй авлагыг тусгайлан үнэлж, үлдсэн авлагын дүнг хугацаа хэтэрсэн хоногт үндэслэн багцын аргаар тооцсон. Эдгээр санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо

СЗХ
2023-01-10
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-01-10
БҮРТГЭВ



алдагдлын түүхэн мэдээллийг зээлдэгчдэд тусгайлан тодорхойлсон хүчин зүйлс, үндсэн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, одоогийн болон ирээдүйг таамаглаж буй мэдээллийг тайлагналын өдрөөр харгалзан тохируулсан матрицыг ашиглан тооцоолж болох бөгөөд уг тооцоололд тохиромжтой гэж үзвэл мөн мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үзэж болно.

Нийт хугацааны туршид хүлээгдэж буй алдагдал нь санхүүгийн хэрэглийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид гарах бүхий л боломжит дефолт үйл явдлаас үүсэх алдагдлыг илэрхийлнэ.

### *Зээл ба авлагын эрсдлийн мэдэгдэхүйц өсөлт*

Санхүүгийн хэрэглийн зээлийн эрсдэл нь анх бүртгэлд тусгаснаас хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ Групп анх бүртгэлд тусгасан өдрийн санхүүгийн хэрэглээс үүссэн эрсдлийг, тайлант өдрөөрх эрсдлийн дүнтэй харьцуулдаг. Энэхүү үнэлгээг хийхдээ Групп үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц тоон болон чанарын мэдээллийн аль алиныг нь харгалзан үзэх ба эдгээр нь түүхэн туршлага болон өндөр хүчин чармайлт, өртөг шаардахааргүйгээр олж авах боломжтой ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд байна.

Ирээдүйг таамаглаж буй мэдээлэл нь Группын зээлдэгчийн үйл ажиллагаа эрхэлдэг салбарын ирээдүйн хэтийн төлвийг агуулсан, эдийн засгийн шинжээчийн тайлангаас авсан мэдээлэл болон санхүүгийн шинжээч, засгийн газрын байгууллага, холбогдох судалгааны байгууллага, бусад ижил төстэй байгууллагаас гаргасан мэдээллүүд болон Группын үндсэн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн бодит болон урьдчилан таамагласан янз бүрийн гадаад эх сурвалжийн мэдээллүүдийг авч үздэг.

Зээл ба авлагын эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ дараах мэдээллийг харгалзан үзнэ:

- Санхүүгийн хэрэглийн гадаад (хэрэв байгаа бол) эсвэл дотоод зээл ба авлагын үнэлгээний бодит эсвэл хүлээгдэж буй мэдэгдэхүйц бууралт;
- Тухайн санхүүгийн хэрэглийн гадаад зах зээлийн эрсдлийн үзүүлэлтүүдийн бууралт. Үүнд: ижил төстэй хэрэглүүрийн өгөөжийн түвшин ихээхэн ялгаатай байх, зээл ба авлагын эрсдлийг солилцох гэрээний үнэ эсвэл шаардагдах цаг хугацаа болон үргэлжлэх байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөсөө бага байх зэрэг юм;
- Одоо байгаа эсвэл урьдчилан таамагласан бизнест нөлөөлж болохуйц сөрөг өөрчлөлт, зээлдэгчийн өрийг эргэн төлөх чадварыг бууруулж болзошгүй нөлөөлөх санхүүгийн эсвэл эдийн засгийн нөхцөл байдлууд;
- Зээлдэгчийн үйл ажиллагааны бодит эсвэл хүлээгдэж буй үр дүнгийн мэдэгдэхүйц бууралт;
- Зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэглүүдийн зээлийн эрсдлийн мэдэгдэхүйц өсөлт;
- Зээлдэгчийн хууль эрх зүй, эдийн засаг, технологийн орчинд гарч буй бодит буюу хүлээгдэж буй томоохон сөрөг өөрчлөлтүүд нь төлбөрийн үүргээ биелүүлэх чадварыг мэдэгдэхүйцээр бууруулах.

Дээрх үнэлгээний үр дүнгээс үл хамааран Групп анх бүртгэлд тусгаснаас хойш гэрээний төлбөр 30 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн үед санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж үзнэ. Хэрвээ зээл ба авлагын



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
9022121175 УЛААНБААТАР ХОТ ХУ6601-5961548

СЭХ
2023 оны 03 ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



эрсдэл мэдэгдэхүйцээр нэмэгдээгүйг илтгэх үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц нотолгоо байгаа тохиолдолд эрсдлийг мэдэгдэхүйцээр нэмэгдсэн гэж үзэхгүй байж болно.

Хэрэв санхүүгийн хэрэгсэл нь тайлант өдрөөр эрсдлийн түвшин бага гэж тодорхойлогдсон бол дээр дурдсанаас үл хамааран Групп санхүүгийн хэрэгслийн зээл ба авлагын эрсдэл анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш мэдэгдэхүйц өсөлт гараагүй гэж үздэг. Санхүүгийн хэрэгсэл нь дараах нөхцөлд зээл ба авлагын эрсдэл бага гэж тодорхойлогдоно:

- Санхүүгийн хэрэгсэл нь эргэн төлөгдөхгүй байх эрсдэл багатай,
- Зээлдэгч ойрын хугацаанд гэрээний мөнгөн урсгалын үүргийг биелүүлэх бүрэн чадавхитай,
- Урт хугацаанд эдийн засгийн болон бизнесийн нөхцөл байдалд гарах сөрөг өөрчлөлт нь зээлдэгч гэрээний мөнгөн урсгалын үүргээ биелүүлэх чадварыг бууруулж болзошгүй боловч энэ нь заавал бууруулна гэж тооцохгүй байж болно.

Хэрэв Группын хөрөнгө нь дэлхийн түвшинд танигдсан зээл ба авлагын үнэлгээний тодорхойлолттой нийцсэн эсвэл хөндлөнгийн үнэлгээний мэдээллийн олдоц хомс тохиолдолд, дотооддоо "хэвийн" гэж үнэлсэн санхүүгийн хөрөнгийг эрсдэл багатай гэж үзнэ. Хэвийн" гэсэн үнэлгээ нь оролцогч тал санхүүгийн хувьд өндөр чадавхтай бөгөөд өнгөрсөн хугацаанд хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй үүрэг үүсээгүй байхыг хэлнэ.

Групп зээл ба авлагын эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг тодорхойлоход ашигласан шалгуурууд нь зээл ба авлагын төлөгдөх хугацаа хэтрэхээс өмнө эрсдлийн мэдэгдэхүйц өсөлтийг тодорхойлох үр ашигтай үзүүлэлтүүд гэдгийг тогтмол хянадаг ба шаардлагатай тохиолдолд өөрчилдөг.

*Дефаултын тодорхойлолт*

Групп дотоод удирдлагын зорилгоор түүхэн туршлагад үндэслэн зээл ба авлагын эрсдлийн дараах шалгууруудын аль нэгийг нь хангасан санхүүгийн хөрөнгүүд нь нөхөгдөх боломжгүй болсон үед үүнийг дефаулт үйл явдал гэж үздэг:

- Зээлдэгч гэрээнд заасан санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдийг зөрчсөн тохиолдолд; эсвэл

- Зээлдэгчийн талаар дотооддоо боловсруулсан эсвэл гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь зээлдэгч бусад зээлдүүлэгчдэд болон Групп-д зээл ба авлагаа бүрэн эргүүлэн төлөх магадлал багатайг илэрхийлж буй тохиолдолд (Группын эзэмшиж буй барьцаа хөрөнгийг харгалзан үзэхгүй).

Дээрх шалгуураас үл хамааран Группын санхүүгийн хөрөнгийн төлбөр төлөх хугацаа 90 хоногоос дээш хугацаагаар хэтэрсэн бол дефаулт үйл явдал гэж үзнэ. Хэрвээ гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй болсныг батлах үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц мэдээлэл байгаа бол дээрх тодорхойлолтонд хамаарахгүй байж болно.

*Зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгүүд*

Нэг болон түүнээс дээш үйл явдал тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээн авахаар тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагын үнэ цэнийн бууралттай гэж үзнэ. Дараах



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
20 . сар 13 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -01- 10
БҮРТГЭВ



тодорхойлолтууд нь санхүүгийн хөрөнгийн зээл ба авлагын үнэ цэнэ буурсан илэрхий нотолгоо болох юм:

a) Гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, тухайлбал эргэн төлөлтийг төлбөрийн хугацааг хэтрүүлэх эсвэл төлөх чадамжгүй болох
b) Үнэт цаас гаргагч эсвэл зээлдэгч талд томоохон хэмжээний санхүүгийн хүндрэл үүссэн;
c) Зээлдэгчийн санхүүжүүлэгч нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлаас үүссэн эдийн засгийн болон гэрээний шалтгааны улмаас зээлдэгчидтэй тохирсон үүрэг амлалтаа хэрэгжүүлэх боломжгүй болох;
d) Зээлдэгч нь дампуурлаа зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин бүтцийн өөрчлөлт хийх магадлалтай болсон;
e) Санхүүгийн хүндрэлээс болж тухайн санхүүгийн хөрөнгийн идэвхтэй зах зээл байхгүй болох.

*Бүртгэлээс хасах*

Групп санхүүгийн хөрөнгийг зээлдэгч нь томоохон санхүүгийн хүндрэлд орсон ба зээлдэгчийн татан буулгах эсвэл дампуурах үйл явц эхэлсэн, авлага төлөгдөх хугацаа 2 жилээс дээш хугацаагаар хэтэрсэн зэрэг үйл явдлын аль нэг нь бий болсон үед буюу авлагын эргэн төлөлт хийгдэх бодит боломж байхгүй болсон үед бүртгэлээс хасна. Бүртгэлээс хасагдсан санхүүгийн хөрөнгийг Группын бодлогын дагуу авлага цуглуулах үйл явц хийгдэж, хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч болно. Бүртгэлээс хасагдсан авлага нь эргэн төлөгдсөн тохиолдолд тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд тусгана.

*Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг хүлээн зөвшөөрөх, хэмжих*

Хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь төлбөр төлөгдөхгүй байх магадлал, алдагдал үүсэх магадлал болон эрсдэлд өртөх боломжтой зээл ба авлагын дүнгийн үржвэр юм. Төлбөр төлөгдөхгүй байх магадлал болон алдагдал үүсэх магадлалын үнэлгээ нь ирээдүйг таамаглаж буй мэдээллээр залруулагдсан түүхэн мэдээлэлд үндэслэгддэг.

Тайлагналын өдрийн байдлаар дансны үнээрээ толилуулагдсан эрсдэлтэй зээл ба авлагын санхүүгийн хөрөнгийг Группын зээлдэгчийн ирээдүйд шаардагдах санхүүжилтийн хэмжээ болон ирээдүйг таамаглаж буй мэдээллүүд ашиглан тодорхойлно.

Тайлангийн өдөөрх эрсдэлд өртөх магадлалтай зээл ба авлага нь тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнээрээ илэрхийлэгдсэн.

Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдал нь гэрээний дагуу Группын хүлээн авах эрх бүхий нийт мөнгөн урсгал болон Группын хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн гүйлгээг үр ашигт хүүгийн аргаар дискаунтчилсан дүнгийн зөрүүгээр тооцоологддог.

Хэрэв өмнөх тайлант үед санхүүгийн хэрэгслийн алдагдлын нөөц сан нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлаар хэмжигдсэн хэдий ч тайлант жилийн эцэст нийт хугацаанд хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлын шалгуурыг хангахгүй бол Групп хялбарчилсан аргачлал ашигласан хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийн хувьд тайлант жилийн эцсээрх 12 сарын хүлээгдэж буй зээл ба авлагын алдагдлыг тооцоолдог.

Групп бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ 5961568

СЗХ
2021 .. сар 13 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -01- 10



хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтаас бусад бүх санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдал болон буцаалтыг үнэ цэнийн бууралтын нөөц сангийн дансаар дамжуулан тэдгээрийн дансны үнийг залруулж, ашиг алдагдлаар бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь тухайн жилийн бусад иж бүрэн орлогоор хэмждэг өрийн хэрэгслээрх хөрөнгө оруулалтын алдагдал нь бусад иж бүрэн орлогоор бүртгэгдэж, хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэж, тус дүнгээр санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулж тайлагнадаггүй.

#### 2.10.3. Санхүүгийн хөрөнгийг данснаас хасах

Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд данснаас хасна: санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн. Хэрэв Групп нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Групп-д үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээр үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ. Хэрэв Групп нь шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн ихэнхийг өөртөө хадгалсаар байгаа бол санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасахгүй ба санхүүгийн хөрөнгөөр барьцаалсан зээлийн өрийг бүртгэнэ.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

### 2.11. Өрийн ба өмчийн хэрэгсэл

#### 2.11.1. Өр төлбөр эсвэл өмчийн хэрэгслээр ангилах

Өрийн болон өмчийн хэрэгслийг тэдгээрийн гэрээгээр хүлээсэн нөхцлийн бодит байдал ба санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтонд үндэслэн өр эсвэл өмчийн хэрэгслээр ангилдаг.

#### 2.11.2. Өмчийн хэрэгсэл

Группын бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хасагдсан хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

#### 2.11.3. Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Группын санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

➢ Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож, холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр (үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт урамшууллыг багтаасан) -ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -01- 10
БҮРТГЭВ



шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

- **Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах**

Групп нь санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дууссан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасч буй санхүүгийн өр төлбөрийн дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

## 2.12. Орлого хүлээн зөвшөөрөлт

Группын орлого нь дараах үндсэн эх үүсвэрээс бүрддэг.

a) Үйлчилгээний орлого;
b) Хүүгийн орлого
c) Бусад орлого.

### 2.12.1. Үйлчилгээний орлого

Групп гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед уг гүйцэтгэлээр дамжуулан харилцагч үр өгөөж хүртэх болон хяналтыг нэгэн зэрэг шилжүүлэн авснаар борлуулалтын орлогыг үйлчилгээ үзүүлж буй хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

Гүйцэтгэлийн үүргийн ахиц дэвшлийг гарцын аргаар хэмжих бөгөөд тодорхой өдөр хүртэл харилцагчид шилжүүлсэн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг Группын гэрээний дагуу шилжүүлэхээр амласан үлдсэн бараа, үйлчилгээнд ногдох дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

### 2.12.2. Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж нь Групп-д орох өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааралтайгаар үндсэн өрийг үр ашигт хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Үр ашигт хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм.

### 2.12.3. Бусад орлого

Бусад орлого нь бизнесийн хэвийн бус нөхцөлд үүссэн бөгөөд эдийн засгийн өгөөжийг найдвартай хэмжих боломжтой, үүнийг Групп хүртэх магадлалтай үед бусад орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

## 2.13. Түрээс

Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэл болон өгөөжийг түрээслэгчид шилжүүлж байвал уг түрээсийг санхүүгийн түрээсээр тайлагнадаг. Бусад бүх түрээсийг үйл ажиллагааны түрээсээр тайлагнадаг.

### 2.13.1. Түрээслүүлэгч

Үйл ажиллагааны түрээсийн орлогыг түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан бүртгэдэг. Түрээсийн гэрээ байгуулах үед гарсан нэмэлт



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ



зардлуудыг түрээсийн хөрөнгө оруулалт дээр нэмж бүртгэж, түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулдаг.

2.13.2. Түрээслэгч

Групп-д томоохон түрээсийн гэрээ байхгүй. Үйл ажиллагааны түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээстэй холбоотой болзошгүй төлбөрийг тэдгээрийг гарсан жилд зардлаар бүртгэдэг. Үйл ажиллагааны түрээсийн гэрээний дагуу урамшуулал авсан бол түүнийг өр төлбөр гэж бүртгэдэг ба түрээсийн хугацаанд шулуун шугамын арга ашиглан түрээсийн өглөгийг бууруулж, зардлаар бүртгэдэг.

2.14. Гадаад валютын ажил гүйлгээ

Группын бие даасан компани бүрийн хувьд санхүүгийн тайлагнал бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн. Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлангийн хэсэгт тусгадаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөр нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотойгоор, Группын гадаад үйл ажиллагааны хөрөнгө болон өр төлбөрийг тайлант хугацаа бүрийн эцсийн өдрийн ханшаар Төгрөг рүү хөрвүүлсэн. Тайлант хугацааны турш дахь орлого болон зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ ажил гүйлгээ үүссэн өдрийн ханшийг ашигласан. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг бусад иж бүрэн орлогын тайланд тусган өөрийн өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэнэ.

2.15. Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг нэгтгэсэн иж бүрэн орлогын тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Группын үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

2.16. Зээлийн зардал

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг санхүүжүүлэхээр хүлээж буй зээлийг сул чөлөөтэй үед нь богино хугацаагаар хүү олох хөрөнгө оруулалтанд ашигласан бол олсон хүүг капиталжуулах хүүгийн зардлыг бууруулж бүртгэнэ.

Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
20.. оны .. сарын .. өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ-02



## 2.17. Ажилчдын тэтгэмж

Групп нь тайлант хугацаанд ажилчдад олгох цалингийн зардлаас төлсөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр өрийг бүртгэдэг. Түүнчлэн ойрын хугацаанд мөнгөн шагнал олгох, ашиг хуваах хөтөлбөрийн хүрээнд төлөх дүнгээр өр бүртгэдэг. Ингэхдээ ажилчдынхаа үзүүлсэн үйлчилгээний үр дүнд иймэрхүү төлөхөөр хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хүлээсэн бөгөөд холбогдох өрийн дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой бол өрийн санг бүртгэдэг.

Богино хугацаат тэтгэвэр, тэтгэмжийг ажилчид үйлчилгээ үзүүлсэн үед дискаунтлаагүй суурьтаар хэмжиж, зардлаар хүлээн зөвшөөрдөг.

## 2.18. Нөөц

Групп нь өнгөрсөн үйл явдлын улмаас хуулиар үүрэг хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд энэхүү үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөжийг зарцуулах өндөр магадлалтай бөгөөд үүрэг хариуцлагыг бодитоор хэмжих боломжтой бол нөөцийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Бүртгэлд тусгагдсан нөөцийн дүн нь үүссэн өрийг төлөх барагдуулахад шаардагдах мөнгөн дүнгийн хэмжээг тайлант жилийн эцсийн байдлаар тухайн өртэй холбоотой нөхцөл байдал, эрсдэлийг харгалзсан тооцоолсон удирдлагын хийж чадах хамгийн сайн тооцоололд үндэслэдэг. Одоогийн үүссэн өрийг барагдуулахад хэрэгтэй тооцоолж буй мөнгөн гүйлгээнд үндэслэн нөөцийг хэмждэг ба түүний дансны дүн нь тэдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог.

Нөөцийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн өгөөжийг бүтдийг нь эсвэл заримыг нь гуравдагч тал нөхөн төлөх магадлалтай ба хэрэв нөхөн төлөх нь тодорхой болсон бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг найдвартай хэмжих боломжтой үед түүнийг авлага хэмээн бүртгэнэ.

Нөөцийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин хянах ба тайлант хугацааны эцэст хамгийн сайн тооцооллыг тусгаж залруулдаг. Эдийн засгийн өгөөжийг шилжүүлж өр төлбөрийг барагдуулах шаардлагагүй болсон үед нөөцийг буцаана.

## 2.19. Болзошгүй өр төлбөр ба хөрөнгө

Аж ахуйн нэгжийн бүрэн хяналтаас гадуурх нэг болон түүнээс дээш ирээдүйн үйл явдал тохиолдох, эс тохиолдохоос хамаарч үүсэх эсэх нь тодорхойлогддог тул болзошгүй өр ба болзошгүй хөрөнгийг бүртгэдэггүй. Эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийн гадагш урсгал гарах магадлал маш бага биш л бол бүх тохиолдолд болзошгүй өр төлбөрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд нэмж тодруулна.

## 2.20. Холбоотой тал

Групп болон Группын толгой компани болон түүнтэй холбоотой этгээдүүдийн хооронд нөөц, ажил үйлчилгээ эсвэл үүрэг хариуцлага шилжүүлэхдээ төлбөр нэхэмжилсэн эсэхээс үл хамааран тэдгээрийн хооронд хийгдсэн ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ гэнэ. Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Групп-тэй холбоотой гэж үзнэ;

- Группыг шууд эсвэл хамтран хянадаг;
- Группын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
- Группын болон Группын толгой компанийн удирдах ажилтан;



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.01.13
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



Хэрэв дараах нөхцлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Групп-тэй холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон Групп нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм.
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол
- Хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол
- Тухайн аж ахуйн нэгж нь Групп эсвэл Групп-тэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө байгаа бол
- Тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан дор байх
- Группыг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан

## 2.21. Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

### 2.21.1. Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Группын санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Группын тухайн жилийн татварын өрийг тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

### 2.21.2. Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог болохоч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвил болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлөхгүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө ба өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг. Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод нэгтгэсэн санхүүгийн



СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
оны сарын өдөр
БҮРТГЭВ
№ 0



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ

байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлангийн өдрийн байдлаар Групп хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР

СЭХ
... оны ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭВ



## 3. МӨНГӨН ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| **Бэлэн мөнгө** | | |
| Төгрөг | | 4,982,142.1 |
| Доллар | - | - |
| **Бэлэн мөнгөний үлдэгдэл** | - | **4982142.1** |
| **Банкин дахь харилцах дансны мөнгө** | | |
| Төгрөг-Банк | | 2,656,428.9 |
| Доллар Банк | - | - |
| **Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | **2,656,428.9** |
| **Нийт дүн** | - | **7,638,571.0** |

## 4. ДАНСНЫ АВЛАГА

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | Дансны авлага | НАХ | Дансны авлага (цэвэр) |
|---|---|---|---|
| **Эхний үлдэгдэл** | | | |
| Нэмэгдсэн | | | 8,904,090.2 |
| Хасагдсан | - | | |
| **Эцсийн үлдэгдэл** | - | - | **8,904,090.2** |

**Монголын Финтек групп ХК-ийн 20,000.0 мянган төгрөгийн, Сендли ББСБ ХХК-ийн харилцагчид олгосон зээлийн үлдэгдэл 8,857,866.9 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 230.0 мянган төгрөгийн, Сток Лаб секьюрити ХХК-ийн 4,093.6 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК-ийн 3,368.0 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК-ийн 18531.7 мянган төгрөгийн, нийт 8,904,090.2 мянган төгрөгийн авлагатай гэж нэгтгэгдсэнээс харилцагчид олгосон зээлийн үлдэгдэл 8,857,866.9. бусад дансны авлага 46,223.3 мянган төгрөгөөр тайлагнасан байна.**

## 5. БУСАД АВЛАГА

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| **Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн** | | 455,267.3 |
| **Нийт дүн** | - | **455,267.3** |

**2021 оны тайлант хугацаанд Монголын Финтек группын 142,000.0 мянган төгрөгийн, Сендли ББСБ ХХК-ийн 2,189.2 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 46,894.9 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК-ийн 264,183.3 мянган төгрөгийн нийт 455,267.3 мянган төгрөгийн холбоотой талаас авах авлагатай байна.**



СЭНДЛИ ББСБ ХК
Sendly
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023 оны 01 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ-02

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд (*2021 оны 12 дугаар сарын 31*)

## 6. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

(мянган төгрөгөөр)

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Бусад санхүүгийн хөрөнгө | | 2,450,000.0 |
| **Нийт дүн** | - | **2,450,000.0** |

Тайлант онд Даталуун ХХК-д 2,450,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

## 7. БАРАА МАТЕРИАЛ

(мянган төгрөгөөр)

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Түүхий эд материал | - | - |
| Бэлэн бүтээгдэхүүн | - | - |
| Бараа | | |
| Хангамжийн материал | | 61,455.7 |
| **Нийт дүн** | - | **61,455.7** |

Сэндли ББСБ ХХК-ийн 10,205.7 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 2,623.5 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК-ийн 48,626.7 мянган төгрөгийн нийт 61,455.7 мянган төгрөгийн хангамжийн материалын үлдэгдэлтэй байна.

## 8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

(мянган төгрөгөөр)

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | | 366,773.8 |
| **Нийт дүн** | - | **366,773.8** |

Сэндли ББСБ ХХК-ийн 106,263.5 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 101,228.4 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК 265.5 мянган төгрөг, Инвест Лаб Ви Си ХХК-ийн 158,996.5 мянган төгрөгийн нийт 366,773.8 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн байна.

## 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

(мянган төгрөгөөр)

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Тавилга, эд хогшил | | 170,202.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (17,053.0) |
| Машин тоног төхөөрөмж | | 23,500.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (283.3) |
| Компьютер, бусад хэрэгсэл | | 1,758,863.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (251,505.2) |
| **Нийт дүн** | - | **1,683,724.5** |



СЭНДЛИ ББСБ ХК
sendly
9022121175 УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2023 сар 01 13 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



## 10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Компьютерийн програм хангамж | - | 648,369.5 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Патент | | 1,195,794.2 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Барааны тэмдэгт | | 26.0 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Тусгай зөвшөөрөл | | 100,000.0 |
| Хуримтлагдсан хорогдол | | |
| Бусад биет бус хөрөнгө | | 40,890.0 |
| Хуримтлагдсан хорогдол | | (1,105.0) |
| **Нийт дүн** | - | **1,983,974.7** |

## 11. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | - | 1,219,030.0 |
| **Нийт дүн** | - | **1,219,030.0** |

Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 107,600.0 мянган төгрөгийн, Кориа ремитанс ХХК-ийн 256,500.0 мянган төгрөгийн, ИнвестЛаб Ви Си ХХК-ийн 854,930.0 мянган төгрөгийн нийт 1,219,030.0 мянган төгрөгийн урт хугацаат хөрөнгө оруулалтыг охин компаниуддаа хийсэн байна.

## 12. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Дансны өглөг | | 2,536,347.8 |
| ХХОАТ-ын өглөг | | 13,200.3 |
| ЭМ, НДШ-ийн өглөг | | 3,273.0 |
| Цалингийн өглөг | | 4,154.7 |
| **Нийт дүн** | - | **2,556,975.8** |

Монголын Финтек групп ХК-ийн 1,873,440.7 мянган төгрөгийн, Хай Пэймэнт солюшнс ХХК-ийн 317,016.3 мянган төгрөгийн, Хөүм моргейж корпорэйшн ХХК-ийн 53,386.7 мянган төгрөгийн, Сток Лаб секьюрити ХХК-ийн 3,443.6 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК-ийн 110,915.2 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК-ийн 178,145.3 мянган төгрөгийн нийт 2,536,347.8 мянган төгрөгийн дансны өглөгтэй байна.



СЭНДЛИ ББСБ ХК
sendly
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-10
БҮРТГЭВ



## 13. БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Богино хугацаат зээл | - | 97,300.0 |
| Урьдчилж орсон орлого | - | 163,024.1 |
| Мөнгөн гүйвуулга бусад өглөг | - | 734,293.2 |
| Бондын өр төлбөр | | 6,380,214.0 |
| **Нийт дүн** | **-** | **7,374,831.3** |

Сэндли ББСБ 100,000.0 мянган төгрөгийн 3 сарын хугацаат зээл авсан бөгөөд тайлант онд 97,300.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Инвест Лаб Ви Си ХХК-д байгууллагуудаас Hi charge /зээврийн цэнэглэгч/ үйлчилгээний 163,024.1 мянган төгрөгийн орлого урьдчилж орсон байна.

Сэндли ББСБ хувь хүмүүст өгөх мөнгөн гүйвуулгын 734,293.2 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Монголын Финтек групп ХК 3,794,000.0 мянган төгрөгийн, Сэндли ББСБ 2,510,340.0 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК 75,874.0 мянган төгрөгийн нийт 6,380,214.0 мянган төгрөгийн бонд гарган бондын өглөгөөр бүртгэж, тайлагнасан байна.

## 14. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Урт хугацаат зээл | - | 4,776,957.3 |
| **Нийт дүн** | **-** | **4,776,957.3** |

Хай Пэймэнт Солюшн ХХК 4,590,000.0 мянган төгрөгийн, Инвест Лаб Ви Си ХХК 186,957.3 мянган төгрөгийн урт хугацаат зээлийн үлдэгдэлтэй байна.

## 15. ЭЗДИЙН ӨМЧ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Өмч: а) төрийн | - | - |
| б) хувийн | | |
| в) хувьцаат | | 10,527,877.2 |
| **Нийт дүн** | **-** | **10,527,877.2** |

Монголын Финтек групп ХК 6,519,022.4 мянган төгрөгийн, Сэндли ББСБ 6,254,930.5 мянган төгрөгийн, Хай Пэймэнт Солюшн ХХК 3,500,000.0 мянган төгрөгийн нийт 10,527,877.2 мянган төгрөгийн эздийн өмчтэй байна.



СЭНДЛИ ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

## 16. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Нэмж төлөгдсөн капитал | - | 4,047,898.3 |
| **Нийт дүн** | - | **4,047,898.3** |

Монголын Финтек групп ХК 3,791,461.3 мянган төгрөгийн, Инвест Лаб Би Си ХХК 256,437.0 мянган төгрөгийн нэмж төлөгдсөн капитал гэж тайлагнасан байна.

## 17. ХУРИМТЛАГДСАН АШИГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | | 2021 |
|---|---|---|
| Тайлант үеийн ашиг (алдагдал) | | 2,600,898.9) |
| Өмнөх үеийн ашиг (алдагдал) | | (1,920,763.8) |
| **Нийт дүн** | - | **(4,521,662.7)** |

Холбоотой компаниудын өмнөх үеийн хуримтлагдсан ашгийг тэгштгэх замаар хуримтлагдсан ашиг бүртгэж тайлагнасан байна.

## 18. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого | | 4,650,258.6 |
| **Нийт дүн** | - | **4,650,258.6** |

Сэндли ББСБ 2,303,001.3 мянган төгрөгийн, Хай Пэймэнт Солюшн ХХК 329,533.1 мянган төгрөгийн, Гэлс Пропертиз ХХК 14,903.1 мянган төгрөгийн, Мастер шийдэл ХХК-ийн 33,970.7 мянган төгрөгийн, Инвест Лаб Би Си ХХК-ийн 1,968,845.5 мянган төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.

## 19. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | 1,967,994.6 |
| **Нийт дүн** | - | **1,967,994.6** |

Сэндли ББСБ 164,391.0 мянган төгрөгийн, Гэлс Пропертиз ХХК 9,559.6 мянган төгрөгийн, Инвест Лаб Би Си ХХК-ийн 1,794,044.0 мянган төгрөгийн борлуулалсан бүтээгдэхүүний өртөгтэй ажилласан байна.

## 20. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

*(мянган төгрөгөөр)*

| Зардлын төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | | 1,597,664.1 |
| ААН-ээс төлсөн НДШ-ийн зардал | | 161,907.2 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | | 555,576.6 |
| Түрээсийн зардал | | 351,896.6 |
| Тээврийн зардал | | 14,521.1 |
| Зар сурталчилгааны зардал | | 491,923.7 |
| Бусад зардал | | 2,045,397.5 |
| **Нийт дүн** | | **5,238,576.8** |

## 21. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

*(төгрөгөөр)*

| Төрөл | 2020 | 2021 |
|---|---|---|
| Тайлант үеийн орлогын татварын зардал | | 44,286.6 |
| **Орлогын татварын зардал (орлого)-ын нийт д** | | **44,286.6** |

Сэндли ББСБ 44,014.8 мянган төгрөгийн, Гялс Пропертиз ХХК 271.3 мянган төгрөгийн орлогын албан татварыг төлж тайлагнасан байна.

## 22. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

| № | Үзүүлэлт | Ажил гүйлгээний утга | Өглөг | Хөрөнгө оруулалт | Авлага | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сандли ББСБ ХХК | Дүрмийн сан нэмэгдүүлсэн гүйлгээ | 2,450,000.0 | 5,000,000.0 | | 7,450,000.0 |
| | | Зээлийн санхүүжилтээр | 6,653,900.0 | | | 6,653,900.0 |
| 2 | Хэй пэймент солюшинс ХХК | Үйл ажиллагааны зардалд зарцуулсан | 2,663,673.0 | | | 2,663,673.0 |
| | | Дүрмийн сан нэмэгдүүлсэн гүйлгээ | | 1,000,000.0 | | 1,000,000.0 |
| 3 | Гялс Төгрөг ХЗХ | | | | -16,278,065.0 | -16,278,065.0 |
| 4 | Монголын финтек ХХК | Бондын санхүүжилтээр орж ирсэн | 14,653,900.0 | | -14,400,000.0 | 253,900.0 |
| 5 | Стоклаб ХХК | Үйл ажиллагааны зардалд зарцуулсан | 95,822.6 | 800,000.0 | | 895,822.6 |

"Монголын финтек групп" ХК болон түүний охин компаниуд
нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд *(2021 оны 12 дугаар сарын 31)*

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Инвест лав ХХК | Хөрөнгө оруулалт, дүрмийн сан нэмэгдүүлсэн | 854,930.0 | 2,000,000.0 | | 2,854,930.0 |
| 7 | Мастер шийдэл ХХК | Үйл ажиллагааны зардалд зарцуулсан | 173,549.0 | | | 173,549.0 |
| 8 | Хоум моргейж ХХК | Үйл ажиллагааны зардалд зарцуулсан | 155,100.8 | | | 155,100.8 |
| 9 | Кореа ремитанс ХХК | Солонгос улсад мөнгөн гүйвүүлга хийх барьцаа хөрөнгө | 300,000.0 | 600,000.0 | | 900,000.0 |
| 10 | Датапүүл ХХК | Итгэлцэл байршуулсан | | 5,000,000.0 | -2,450,000.0 | 2,550,000.0 |
| 11 | Арт кредит ХХК | Үйл ажиллагааны зардалд зарцуулсан | | 0.0 | 0.0 | 0.0 |
| | **Нийт** | | **28,001,076.4** | **14,400,000.0** | **33,128,066.7** | **9,273,009.7** |

## 23. ОХИН КОМПАНИУДЫН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛГАА

| № | Охин компаниудын нэр | Эрхлэх үйл ажиллагаа |
|---|---|---|
| 1 | Сэндли ББСБ ХХК | Зээлийн үйлчилгээ |
| | | Олон улсын мөнгөн гүйвүүлга |
| 2 | Хай пэймент соллюшнс ХХК | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| | | Програм хангамж |
| 3 | Гялс пропертиз ХХК | Менежментийн зөвлөгөө өгөх |
| 4 | Стоклаб секьюритиз ҮЦК ХХК | Брокерийн үйл ажиллагаа |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 5 | Инвестлаб Ви Си ХХК | Бизнесийн зөвлөгөө өгөх |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 6 | Мастер шийдэл ХХК | Двтгэлын зуучлалын үйлчилгээ |
| 7 | Хай лоялти ХХК | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| | | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 8 | Хоум моргейж ХХК | Санхүүгийн тайлан гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх |
| | | Хөрөнгө итгэмжлэн удирдах |
| | | Бизнесийн зөвлөгөө өгөх |
| 9 | Кореа ремитанс ХХК | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| 10 | Датапүүл ХХК | Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх |
| | | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа |
| 11 | Арт кредит ХХК | Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ |
| | | Үл хөдлөх хөрөнгийн худалдаа |

СЗХ 2021.01.1_ он сар өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-10 БҮРТГЭВ-02



## 24. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ТАЛААР

1. Нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл зарим компаниудад ихээхэн хэмжээгээр үлдэгдэлтэй гарсан байна. Үүнийг тодруулбал: Датапүүл ХХК 2540.0, Монгол финтек групп ХК 698.8, Стоклаб секьюритиз ХХК 596.3, Инвестлаб Ви Си ХХК 393.0, Кореа ремитанс ХХК 262.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийт касст дахь мөнгөний 96.8 хувийг эзэлж байна.

2. Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар гарсан авлага, өглөгийн үлдэгдлийг зарим компаниудын нь тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.

Аудитаар нийт 4825.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4825.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; мөн хуулийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно".20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.9-д "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг; мөн хуулийн 18.2.-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн, өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллаж байгаа боловч касст дах бэлэн мөнгөний дээд үлдэгдлийн хэмжээг зааж өгөөгүй байна.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ЗАХИРАЛ, АУДИТОР Д.РЭНЦЭНХАНД

АХЛАХ АУДИТОР П.СОСОРБУРАМ

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР Б.АЛТАНЦЭЦЭГ

**2022 ОНЫ 04 ДУГААР САРЫН 11-НЫ ӨДӨР**



СЭНДЛИ ББСБ ХК Sendly УЛААНБААТАР ХОТ